ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА
/2019 оны жилийн эцэс/

2020 оны 1 дүгээр сар 14

**Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго.**

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар батагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явц, үр дүнд 2019 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, зорилтыг хүрэх түвшинтэй нь харьцуулан, хэрэгжилтийн түвшинг тогтоох, үр дүнг үнэлэх, дүгнэлт, зөвлөмж гаргах, яамны удирдлагыг бодит мэдээллээр хангах, цаашид төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

**Хоёр.Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй.**

Монгол Улсын хууль, Улсын Их Хурал болон УИХ-ын байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын тогтоол, хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын захирамж, албан даалгавраар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд гарсан шийдвэр заалтыг хяналтад авч, яамны нэгжүүдийн 2019 оны жилийн эцсийн байдлаар ирүүлсэн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Уул уурхайн хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны А/122 дугаар тушаалаар баталсан, "Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний зорилт, арга хэмжээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнг үнэлэх журам"-ыг тус тус удирдлага болгов.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн цахим хуудсанд байршуулсан шийдвэр, заалтыг 2020 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн байдлаар тасалбар болгон Геологи, эрдэс баялгийн, Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн түүний нөөцийн, Уул уурхайн, Хүнд үйлдвэрийн, Нийтлэг асуудал гэсэн ангилал тус бүрээр хэрэгжилтийг гаргуулж үнэлгээг хийв.

**Гурав.Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн.**

2019 оны жилийн эцсийн үнэлгээг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний www.unelgee.gov.mn цахим системд байршуулсан нийт 109 шийдвэрийн 157 заалтын хэрэгжилтийг **90,6** хувийн биелэлттэй дүгнэв. Үүнд:

- Геологи, эрдэс баялгийн бодлогын хүрээнд 15 шийдвэрийн 17 заалтын хэрэгжилт 89,6%,
- Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн болон түүний нөөцийн талаарх бодлогын 21 шийдвэрийн 34 заалтын хэрэгжилт 94,7%,
- Уул уурхайн бодлогын 41 шийдвэрийн 61 заалтын хэрэгжилт 92,1%,
- Хүнд үйлдвэрийн бодлогын 10 шийдвэрийн 11 заалтын хэрэгжилт 81,0%,
- Нийтлэг асуудлын 22 шийдвэрийн 34 заалтын хэрэгжилт 96,7%-ийн тус тус биелэлттэй, 14 заалтын биелэлтэд үнэлгээ өгөөгүй. Үнэлгээгүй эдгээр зүйл заалт хүчингүй болсон, хэрэгжилт тооцох хугацаа болоогүй байна. Нэгдүгээр хүснэгт.

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ НЭГТГЭЛ

/2019 оны жилийн эцэс/

Нэгдүгээр хүснэгт

| Салбар, чиглэлийн нэр | Хяналтанд авсан тоо | | Хэрэгжилтийн явц /хувиар/ | | | | | Үнэлгээ /%/ |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | шийдвэр | зүйл заалт | 100% | 70% | 30% | 0% | Үнэлээ гүй | |
| **НЭГ. ГЕОЛОГИ, ЭРДЭС БАЯЛГИЙН БОДЛОГО** | | | | | | | | |
| Засгийн газрын тогтоол | 10 | 12 | 11 | | 1 | | | 94.2 |
| ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | 5 | 5 | | 2 | 2 | | 1 | 85.0 |
| ГЭББ-ын дүн | 15 | 17 | 11 | 2 | 3 | | 1 | 89.6 |
| **ХОЁР. ГАЗРЫН ТОС, ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮН БОЛОН ТҮҮНИЙ НӨӨЦИЙН ТАЛААРХ БОДЛОГО** | | | | | | | | |
| Монгол Улсын хууль | 1 | 3 | 2 | 1 | | | | 90.0 |
| УИХ-ын тогтоол | 1 | 1 | 1 | | | | | 100.0 |
| ҮАБЗ-ийн зөвлөмж, тэмдэглэл | 1 | 1 | 1 | | | | | 100.0 |
| Засгийн газрын тогтоол | 5 | 11 | 10 | 1 | | | | 97.3 |
| Ерөнхий сайдын захирамж | 1 | 1 | 1 | | | | | 100.0 |
| ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | 12 | 17 | 13 | 4 | | | | 93.0 |
| ГТГТББТНТБ-ын дүн | 21 | 34 | 28 | 6 | | | | 94.7 |
| **ГУРАВ. УУЛ УУРХАЙН БОДЛОГО** | | | | | | | | |
| Монгол Улсын хууль | 3 | 3 | 3 | | | | | 100.0 |
| Их хурлын тогтоол | 1 | 2 | 1 | 1 | | | | 85.0 |
| УИХ-ын Байнгын хорооны тогтоол | 3 | 4 | 2 | 2 | | | | 85.0 |
| ҮАБЗ-ийн хуралдааны тэмдэглэл | 1 | 1 | 1 | | | | | 100.0 |
| Засгийн газрын тогтоол | 18 | 30 | 20 | 7 | | | 3 | 92.2 |
| Ерөнхий сайдын захирамж | 3 | 3 | 1 | | | | 2 | 100.0 |
| ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | 12 | 18 | 11 | 3 | 3 | | 1 | 82.4 |
| ЗГ-ын албан даалгавар | | | | | | | | |
| УУБ-ын дүн | 41 | 61 | 39 | 13 | 3 | | 6 | 92.1 |
| **ДӨРӨВ. ХҮНД ҮЙЛДВЭРИЙН БОДЛОГО** | | | | | | | | |
| Монгол Улсын хууль | 1 | 1 | | | | | 1 | |
| УИХ-ын тогтоол | 1 | 1 | 1 | | | | | 100 |
| Засгийн газрын тогтоол | 2 | 3 | | 3 | | | | 70 |
| Ерөнхий сайдын захирамж | 2 | 2 | 2 | | | | | 100 |
| ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | 4 | 4 | 2 | 1 | 1 | | | 75 |
| ХҮБ-ын дүн | 10 | 11 | 5 | 4 | 1 | | 1 | 81 |
| **ТАВ. НИЙТЛЭГ АСУУДАЛ** | | | | | | | | |
| Монгол Улсын хууль | 1 | 1 | | 1 | | | | 70.0 |
| УИХ-ын тогтоол | 1 | 1 | 1 | | | | | 100.0 |
| Ерөнхийлөгчийн зарлиг | 1 | 2 | 2 | | | | | 100.0 |
| Засгийн газрын тогтоол | 11 | 14 | 12 | 2 | | | | 95.7 |
| Ерөнхий сайдын захирамж | 1 | 1 | 1 | | | | | 100.0 |
| ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | 5 | 8 | 8 | | | | | 100.0 |
| ЗГ-ын албан даалгавар | 2 | 7 | 1 | | | | 6 | 100.0 |
| Нийтлэг асуудлын дүн | 22 | 34 | 25 | 3 | | | 6 | 96.7 |
| **Эрх зүйн баримт бичгийн дүн** | **109** | **157** | **108** | **28** | **7** | | **14** | **90.6** |

Хэрэгжилт гаргаж дүгнэсэн 157 заалтын 108 заалт буюу 68,7% бүрэн биелсэн, 28 заалт буюу 17,8% хэрэгжих шатанд буюу 70 хувийн биелэлттэй, 7 заалт буюу 4,4% нь хэрэгжилт хангалтгүй буюу 30 хувийн тус тус хэрэгжилттэй, үнэлгээ өгөөгүй 14 заалт 8,9%-ийг эзэлж байна. Хоёрдугаар хүснэгт.

ҮНЭЛГЭЭ ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ТӨРЛӨӨР
/2019 оны жилийн эцэс/

Хоёрдугаар хүснэгт

| | | Бүгд | МУ-ын хууль | УИХ-ын тогтоол | УИХ-ын байнгын хорооны тогтоол | Ерөн хийлег чийн зарлиг | ҮАБЗ-ийн зөвлөмж, тэм дэглэл | ЗГ-ын тогтоол | ЕС-ын захи рамж | ЗГ-ын хурал дааны тэмдэг лэл | Засгийн газрын албан даал гавар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хяналтанд авагдсан шийдвэрийн тоо | | 109 | 6 | 4 | 3 | 1 | 2 | 46 | 7 | 38 | 2 |
| Заалтын тоо | | 157 | 8 | 5 | 4 | 2 | 2 | 70 | 7 | 52 | 7 |
| Үнээс | Биелсэн 100% | 108 /68,7%/ | 5 | 4 | 2 | 2 | 2 | 53 | 5 | 34 | 1 |
| | Хэрэгжих шатанд 70.0% | 28 /17,8%/ | 2 | 1 | 2 | | | 13 | | 10 | |
| | Хэрэгжилт хангалтгүй 30.0% | 7 /4,4%/ | | | | | | 1 | | 6 | |
| | Хэрэгжээгүй 0% | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| | Дүгнэгдээгүй | 14 /8,9%/ | 1 | | | | | 3 | 2 | 2 | 6 |
| | Үнэлгээ | 90,6 | 91,4 | 94,0 | 85,0 | 100 | 100 | 93,1 | 100 | 85,6 | 100 |

Эрх зүйн актын хэрэгжилтийг төрлөөр нь авч үзвэл:

- Монгол Улсын 6 хуулийн 8 заалтаас бүрэн хэрэгжсэн 5, хэрэгжих шатанд 2, хэрэгжилтийн дундаж 91,4%-тай,
- Улсын Их Хурлын 4 тогтоолын 5 заалтаас бүрэн хэрэгжсэн 4, хэрэгжих шатанд 1, хэрэгжилтийн дундаж 94,0%-тай,
- УИХ-ын Байнгын хорооны 3 тогтоолын 4 заалтаас бүрэн хэрэгжсэн 2, хэрэгжих шатанд 2, хэрэгжилтийн дундаж 85,0%-тай,
- Ерөнхийлөгчийн 1 зарлигийн 2 заалт бүрэн хэрэгжсэн хэрэгжилтийн дундаж 100%-тай,
- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2 шийдвэрийнй 2 заалт бүрэн хэрэгжсэн, хэрэгжилтийн дундаж 100%-тай,
- Засгийн газрын 46 тогтоолын 70 заалтаас бүрэн хэрэгжсэн 53, хэрэгжих шатанд 13, хэрэгжилт удаашралтай 1, хэрэгжилтийн дундаж 93,1%-тай
- Ерөнхий сайдын 7 захирамжийн 7 заалтаас бүрэн хэрэгжсэн 5, хэрэгжилтийн дундаж 100%-тай,
- Засгийн газрын хуралдааны 38 тэмдэглэлийн 52 заалтаас бүрэн хэрэгжсэн 34, хэрэгжих шатанд 10, хэрэгжилтийн дундаж 85,6%-тай,
- Засгийн газрын 2 албан даалгаврын 7 заалтаас 1 заалт бүрэн хэрэгжсэн, хэрэгжилт тооцох хугацаа болоогүй 6 заалт, хэрэгжилтийн дундаж 100%-ийн тус тус биелэлттэй байна.

**Дөрөв. Дүгнэлт.**

1. ЗГХЭГ нь 2019 оны жилийн эцсийн байдлаар харьцангуй цөөн буюу 109 шийдвэрийн 157 заалтыг хяналтанд оруулсан нь өмнөх жилүүдээс буурсан /*2016 оны жилийн эцэст 289 шийдвэрийн 416 заалт, 2017 оны жилийн эцэст 156 шийдвэрийн 226 заалт, 2018 оны жилийн эцэст 162 шийдвэрийн 237 заалт*/, өмнө хүргүүлсэн тайлангаас шийдвэр, заалтыг хяналтаас хасах талаар арга хэмжээ авч ажилласан байна.

2. Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм батлах /*Газрын тосны тухай хууль*/, уул уурхайн олборлолт, боловсруулалтаас үүсэх хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах журам батлах /*Хог хаягдлын тухай хууль*/ заалтын хэрэгжилт удаашралтай байна.

3. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх талаар яамны холбогдох нэгжүүд үр дүнтэй ажлууд хийж байгаа боловч хийсэн ажлынхаа биелэлтийг удаадаг /*Газрын тосны хэлтэс, Хүнд үйлдвэрийн хэлтэс*/, ажлын гол үр дүнг товч тодорхой, баримт нотолгоотой биелэлт ирүүлдэггүй, өмнө гаргасан биелэлтээ шинэчилдэггүй, үр дүнг бус үйл явц тайлагнах байдал байсаар байна /*бүх нэгжүүд*/.

4. Яамны эрхлэх асуудалд хамааралгүй буюу хэрэгжилт гаргахад хүндрэлтэй /*Монгол баатарлаг туульсаа дээдлэн дэлгэрүүлэх тухай Ерөнхийлөгчийн 2019 оны 13 дугаар зарлиг*/, тухайн шийдвэр хүчингүй болсон /*Үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль хүчингүй болсон*/, тухайн асуудал шүүхээр эцэслэн шийдэгдээгүй /*Гацууртын орд*/, зэрэг 14 заалтад үнэлгээ өгөөгүй.

5. ЗГ-ын 2019.10.15-ны өдрийн 44 дүгээр тэмдэглэлээр өгөгдсөн үүргийн утга агуулгыг системд оруулаагүй, уг шийдвэрийг яаманд ирүүлээгүй тул биелэлтийг ерөнхий утгаар оруулав.

6. Гацууртын алтны үндсэн ордын асуудал шүүх байгууллагын түвшинд маргаантай, эцэслэн шийдвэр эцэслэн гараагүй байгаа тул энэ талаар батлагдсан тогтоол шийдвэрийн биелэлтэд үнэлгээ өгөөгүй болно.

7. Салбарт баримтлах бодлогын баримт бичгийг баталсан тогтоолын биелэлт гаргахад бэрхшээлтэй байна. "Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлог"-ыг баталсан УИХ-ын 2015 оны 62 дугаар тогтоол, "Гурван тулгуурт хөгжлийн бодлого"-ыг баталсан ЗГ-ын 2018 оны 36 дугаар тогтоол, ЗГ-ын 2019 оны 317 тогтоолоор батлагдсан, "Алтны бичил уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй мөнгөн усны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр" нь өөрөө урт болон дунд хугацаанд хэрэгжих томоохон зорилтуудыг агуулж байх бөгөөд батлагдсан бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнах үйл ажиллагаа нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр журмаар зохицуулагдаж байгааг анхаарч хяналтаас хасах нь зүйтэй байна.

8. Зэсийн баяжмал боловсруулах, нүүрснээс шингэн түлш үйлдвэрлэх, нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх төслүүдийн хэрэгжилт хангалтгүй, удаашралтай, бодит үр дүн гарахгүй байна.

9. Нэг удаагийн зохицуулалттай шийдвэрүүд хяналтаас хасагдахгүй байгааг анхаарах нь зүйтэй.

**Тав. Санал, зөвлөмж.**

1. Удаашралтай ажлуудыг эрчимжүүлэх, он удаан жил хэрэгжилт хангагдахгүй байгаа шийдвэр, заалтыг хүчингүй болгох, дараагийн шийдвэрийг гаргуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах.

2. Төрийн захиргааны удирдлагын газар хяналтанд авагдаж буй шийдвэрийг тухай бүрт нь хариуцах нэгж, албан хаагчийг эзэнжүүлэх.
3. "Эрдэнэс монгол" зэрэг салбарын төрийн өмчит компани, ТӨҮГ-уудаас холбогдолтой шийдвэрийн хэрэжилтийг гаргуулж авах.
4. Холбогдох нэгжүүд ЗГХЭГ-т хүргүүлэх тайлангийн боловсруулалт, чанарт анхаарах, мэргэжилтний боловсруулсан тайлан, мэдээллийг харьяалах нэгжийн дарга нар хянаж ирүүлэх.
5. Дотоод нэгжүүд биелэлтийг тогтоосон хугацаанд гаргах, шинэчилж ирүүлж байх,
6. Холбогдох нэгжүүд дүгнэгдээгүй, удааширсан шийдвэрийн хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллах шаардлагатай байна.
7. Хяналтаас хасуулах нийт 80 заалтыг 2019 оны жилийн эцсийн тайлангийн хамт хүргүүлэх.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд хийсэн үнэлгээний тайлан 57 хуудас.

Хянасан:
ХШҮДАГ-ын дарга Г.Ганхүү

Үнэлгээ хийж тайлан, танилцуулга боловсруулсан:

Шинжээч Б.Баяржаргал

Ахлах мэргэжилтэн Д.Болортуяа

Мэргэжилтэн Н.Цогтбаяр

Г.Батнайрамдал

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

2020.01.14

| Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам | | | | | | |
| 2019 оны жилийн эцэс | | | | | | |
| 2020 оны 1 сарын 13 өдөр | | | | | | |
| **Шийдвэрийн д/д** | **Заалтын д/д** | **Шийдвэрийн нэр, огноо, дугаар** | **Холбогдох заалтын агуулга** | **Хэрэгжилтын явц** | **Үнэлгээ, (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал)** | **Тасарсан болон удааширч байгаа шалтгаан** |
| МУ-ын хууль | | | | | | |
| 1 | 1 | Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай (шинэчилсэн найруулга) 2013-01-31 Дугаар 2013.01.31 | 10.1. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэрийн болон хадгалах байр, агуулах дахь аюулгүй ажиллагааны журмыг геологи, уул уурхайн болон батлан хамгаалахын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мэргэжлийн хяналтын төв байгууллагатай хамтран батална. | Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм"-ийг Засгийн газрын 2019.08.07-ны өдрийн 313 дугаар тогтоолоор батлуулсан. | 100 /хуулийн заалт хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай/ | |
| | 2 | | 8.1.3. газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланд тавих шаардлага; газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын анхдагч болон үр дүнгийн тайланд тавих шаардлага; газрын тосны орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тавих шаардлага; гэрээлэгчийг сонгон шалгаруулах тухай; газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын талбайг буцаан өгөх, хүлээн авах; газрын тос, уламжлалт бус газрын тосны чиглэлээр мэргэжлийн зэрэг олгох журмыг батлах; | "Газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланд тавих шаардлага"-ын төслийг боловсруулах ажлыг MINIS төслөөс санхүүжүүлэхээр тохиролцон, ажлын даалгаврыг боловсруулан MINIS төсөлд хүргүүлээд байсан болович тодорхой шалтгааны улмаас санхүүжилт хийгдэх боломжгүй болсон. Иймд тус журмыг боловсруулахад шаардлагатай суурь судалгаа хийх, олон улсын туршлага, мөрдөж буй арга аргачлалын харьцуулсан судалгаа хийж, манай орны нөхцөлд тохирсон арга, аргачлалын төсөл боловсруулах эрдэм шинжилгээ, судалгааны зөвлөх үйлчилгээ үзүүлэх тендерийн төсвийг УУХҮ-ийн сайдын 2020 оны төсвийн багцад суулган батлаад байна. "Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын анхдагч болон үр дүнгийн тайланд тавих шаардлага" журмыг Уул уурхайн сайд /хуучин нэрээр/-ын 2015.03.10-ны 49 дүгээр тушаалаар, "Газрын тосны орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тавих шаардлага" журмыг мөн Уул уурхайн сайдын 2015.09.04-ний өдрийн 197 дугаар тушаалаар тус тус баталсан ба Захиргааны ерөнхий хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018.01.10-ны өдрийн А/07 дугаар тушаалаар батлан мөрдөж байна. "Гэрээлэгчийг сонгон шалгаруулах тухай журам"-ыг мөн Уул уурхайн сайд /хуучин нэрээр/-ын 2014 оны 202 дугаар тушаалаар, "Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын талбайг буцаан өгөх, хүлээн авах" журмыг сайдын 2015.09.04-ний өдрийн 196 дугаар тушаалаар баталсан. Мөн Захиргааны ерөнхий хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018.01.10-ны өдрийн А/06-р тушаалаар батлан мөрдөж байна. "Газрын тос, уламжлалт бус газрын тосны чиглэлээр мэргэжлийн зэрэг олгох журам"-ыг Уул уурхайн сайд /хуучин нэрээр/-ын 2015.03.12 | 100 /нийт 6 шаардлага, журам батлаж мөрдүүлэхээс 5-ыг баталж хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа ба нэг шаардлагын төслийг боловсруулсан. Хяналтаас хасуулах саналтай/ | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2 | 3 | ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ 2014-07-01 Дугаар 2014_06 | 8.1.8. газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг нөхөн сэргээх ажлын үр дүнг хүлээн авах журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах; | Журмыг УУХҮСайд болон БОАЖСайд нарын 2018.02.22-ны өдрийн А/50, А/31 дугаар хамтарсан тушаалаар батлан, Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэдэх Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 2018.03.06-ны өдрийн 3870 дугаарт бүртгүүлсэн. /Хэрэгжилт-100%/ | 100 /журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран баталсан тул хяналтаас хасуулах/ | |
| | 4 | | 8.1.9. газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм батлах; | Хуулийн тус заалтын хэрэгжилтийг хангах хүрээнд ОХУ-ын “Газрын тос, байгалийн хийн үйлдвэрлэлийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм”-ийн орчуулгад тулгуурлан “Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм”-ийн төслийг боловсруулсан. Захиргааны ерөнхий хууль батлагдсантай холбогдуулан тус дүрмийн төслийг төрийн болон иргэний нийгмийн байгууллагуудад танилцуулж, санал шүүмж авах хэлэлцүүлгийг Нээлттэй нийгэм форумтай хамтран 2018.03.21-ний өдөр зохион байгуулсан ба дүрмийн төсөлтэй холбоотой тодорхой санал, шүүмжүүдийг ирүүлсэн. | 70 | Стандартчилал хэмжил зүйн газрын стандартчиллынүндэсний зөвлөлийн 2018 оны 06-р сарын 21-ны өдрийн 27-р тогтоолоор MNS ISO 45001:2018 “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоо-Шаардлага, хэрэглэх заавар” стандартыг баталж, 2018 оны 7 дугаар сарын 16-ны өдрөөс мөрдөж эхэлсэнтэй холбоотойгоор тус дүрмийн төслийг нөхцөл шаардлагад нийцүүлэн шинэчлэн боловсруулах шаардлагатай болсон тул зөвлөх үйлчилгээний тендерийг УУХҮ-ийн сайдын 2020 оны багцад тусган батлуулаад байна. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 3 | 5 | АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ<br>2015-02-18<br>Дугаар 2015 | 472.2.. Энэ хуулийн 472.1-д заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээг Засгийн газар батална. **47.6** | АМТХ-ийн төслийн үзэл баримтлалыг хууль зүй дотоод хэргийн яамаар батлуулж яамдаас санал авсны үндсэн дээр Засгийн газрын 2018.10.24-ний хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжүүлж 2019.03.26-ны өдрийн УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн уг хуулийн төслийг батлуулсан. Засгийн газрын 2019.09.04 өдрийн 342 дугаар тогтоолоор Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг тооцох, төлбөр ногдуулах, тайлагнах, төлөх журам", "Гадаадын зах зээлд борлуулсан нүүрс, төмрийн хүдэр, төмрийн хүдрийн баяжмалд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулах борлуулалтын үнэлгээ тооцох журам"-ыг тус тус батлуулсан. Төлбөрийн хувь хэмжээнд 2019.11.22 өдрийн АМТХ-д нэмэлт өөрлөлт оруулсан. | 100 /АМНАТ-ийн хувь хэмжээг шинэчлэн тогтоосон тул хяналтаас хасуулах саналтай/ | |
| 4 | 6 | МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ<br>2015-02-18<br>Дугаар 47.2 | 47.2. 472.2.Энэ хуулийн 472.1-д заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээг Засгийн газар батална. | АМТХ-ийн төслийн үзэл баримтлалыг хууль зүй дотоод хэргийн яамаар батлуулж яамдаас санал авсны үндсэн дээр Засгийн газрын 2018.10.24-ний хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжүүлж 2019.03.26-ны өдрийн УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн уг хуулийн төслийг батлуулсан. | ДАВХАРДСАН | |
| 5 | 7 | Үйлдвэрлэлийг дэмжих тухай<br>2015-07-09<br>Дугаар 2015.07.09 | 6.1.1.. "6 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх 6.1.1. Үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлах, хэрэгжилтийг хангах;" | 2019.11.13-ны өдөр батлагдсан Үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулиар Үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль 2020.01.01-ний өдрөөс хүчингүй болсон. | /-/ хууль хүчингүй болсон тул хяналтаас хасуулах саналтай. | 2019.11.13 өдөр Засгийн газрын тусгай сангийн тухай хууль батлагдаж, Үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль хүчингүй болсон. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 6 | 8 | Хог хаягдлын тухай /Шинэчилсэн найруулга/<br>2017-05-12<br>Дугаар 2017.05.12 | 8.6.2.. 8.6.Хог хаягдлын талаар уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 8.6.2. Уул уурхайн олборлолт, боловсруулалтаас үүсэх хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах журам баталж, хэрэгжилтэд хяналт тавих; | Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019.02.19-ны өдрийн А/35 дугаар тушаалаар Уул уурхайн олборлолт, боловсруулалтаас үүсэх хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах журам"-ын төсөл боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, журмын төслийн анхны хувилбарыг Уул уурхайн хэлтэс, Газрын тосны хэлтсийн холбогдох мэргэжилтнүүдтэй хамтран боловсруулж, ажлын хэсгийн гишүүдээс санал авахаар 2019.06.24-ний өдөр хүргүүлсэн. Мөн журмын төсөл боловсруулахтай холбогдуулан 21 аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрууд болон нэр бүхий 26 уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарт үйл ажиллагаа эрхлэгч ААНБ-уудаас шаардлагатай мэдээлэл ирүүлэх тухай албан бичиг хүргүүлсний дагуу 2019.10.24-ний өдрийн байдлаар 16 аймаг, 14 ААНБ-аас холбогдох мэдээлэл ирүүлснийг нэгтгэн боловсруулж байна. Мөн журмын төслийн анхны хувилбарт санал авахаар нэр бүхий 22 ААНБ болон БОАЖЯ, ЗТХЯ, МХЕГ, СЯ, БХБЯ, ЭМЯаманд тус тус хүргүүллээд байна. Журмын төсөл 2019.10.25-ны өдрийн байдлаар БОАЖЯ, ЗТХЯ, СЯ болон 3 ААНБ-аас санал ирүүлээд байна. Мөн журмын төсөлд олон нийтээс санал авах зорилгоор УУХҮЯ-ны болон АМГТГ-ын албан ёсны вэб хуудаст 2019.09.19-ний өдөр байршуулсан. Ирүүлсэн саналыг журмын төсөлд тусган, журмын төслийн нөлөөллийн шинжилгээний ажлыг хийж гүйцэтгэн ажиллаж байна. /Хэрэгжилт-70 хувь/ | 70 | |
| УИХ-ын тогтоол | | | | | | |

| | | | |
|---|---|---|---|
| | 9 | | 1.2.б. б/хувьцааны 10 хүртэлх хувийг 2010 оны 6 дугаар сарын 30-ны өдөр ба түүнээс өмнө улсын бүртгэлд бүртгэгдэн үйл ажиллагаа явуулж байгаа, татвар төлсөн үндэсний аж ахуйн нэгжүүдэд адил тэнцүү хэмжээгээр, нэрлэсэн үнээр худалдах; |

| | | |
|---|---|---|
| 2010 оны 6 дугаар сарын 30-ны өдөр ба түүнээс өмнө улсын бүртгэлд бүртгэгдэн үйл ажиллагаа явуулж байгаа, татвар төлсөн үндэсний аж ахуй нэгжүүдэд хувьцааны 10 хүртэлх хувийг худалдаж, нийт 29.2 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн. Гэвч хувьцааг ОУ-ын зах зээлд гаргах зэрэг хөдөлгөөн хийгдээгүй, аж ахуй нэгжүүд удаа дараа хүсэлт гаргасан учраас Засгийн газрын 2013 оны 132, 409 дүгээр тогтоолоор нийт 21.3 тэрбум төгрөгийг буцаан ААН-үүдэд шилжүүлсэн, 1 сая төгрөг авах хүсэлт гаргасан эмзэг бүлгийн хэсэг иргэдэд 1.7 тэрбум төгрөгийг олгож, 6.2 тэрбум төгрөг үлдсэн бөгөөд хувьцаа худалдсанаас төвлөрсөн хөрөнгийг арилжааны банкинд хадгалсаны хүүгийн төлбөр 1.7 тэрбум төгрөгийн хамт нийт 7.9 тэрбум төгрөгийг Хүний хөгжил сангийн тухай хуулийн 3.1.1-т заасны дагуу тус санд төвлөрүүлсэн. Засгийн газрын 2017 оны 154 дүгээр "Эрдэнэс Монгол" ХХК болон түүний охин компанийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Сангийн яам, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн мэдээлэлтэй, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-ийн бүртгэл дэх хувьцаа эзэмшийгчийн мэдээллийг тулгаж бүртгэсэн дүнгээр нийт 486 аж ахуйн нэгж 7,065,038 ширхэг хувьцаа буюу "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн нийт хувьцааны 0.05 хувийг эзэмшиж байна. | 100 /тогтоолын заалтыг хэрэгжүүлсэн тул хяналтаас хасуулах саналтай/ | |

| | | | |
|---|---|---|---|
| 7 | 10 | Таван толгойн нүүрсний ордыг ашиглах зарим асуудлын тухай<br>2010-07-07<br>Дугаар 02_2010_39 | 1.2.в. хувьцааны 30 хүртэлх хувийг гадаад, дотоодын хөрөнгийн биржээр худалдаж шаардлагатай хөрөнгө оруулалтыг татах;<br>*УИХ-ын 2012 оны 18 дугаар тогтоолоор уг дэд заалтын "30 хүртэлх хувийг" гэснийг "20 хүртэлх хувийг" гэж өөрчилсөн.* |

| | | |
|---|---|---|
| Засгийн газрын 2012 оны 181 дүгээр тогтоолоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг иргэн, аж ахуйн нэгжийн хооронд худалдах, худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хүрээнд тус компанийн 1072 хувьцааг 1 сая төгрөгтэй дүйцүүлэн тухайн хувьцааны нэрлэсэн үнийг 933 төгрөгөөр тогтоосон. Харин Засгийн газрын 2016 оны 316 дугаар тогтоолоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааны хоёрдахь зах зээлийн арилжаа эхлэх хүртэл хугацаанд дээрх хувьцааг саналын эрхгүй, Засгийн газарт нэрлэсэн үнээр нь худалдахаас бусад тохиолдолд аливаа хэлбэрээр захиран зарцуулахгүй байх нөхцөлтэйгээр иргэдэд эзэмшүүлэх, үндэсний аж ахуйн нэгжид худалдах ажлыг зохион байгуулах нь зүйтэй гэж үзсэн. Тус яамаас “Тавантолгойн ордын талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их хурлын тогтоолын төслийг боловсруулж, 2018 оны 6 дугаар сарын 29-ны өдрийн 73 дугаар тогтоолоор батлуулсан. Уг тогтоолд Улсын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоолын 1 дэх заалтын 2 дахь дэд заалтын “б”, “в”-д заасны дагуу стратегийн ач холбогдол бүхий Тавантолгойн нүүрсний ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьцааны 30 хүртэлх хувийг гадаад, дотоодын хөрөнгийн биржээр арилжаалан, шаардлагатай хөрөнгө оруулалтыг татсаны үндсэн дээр Тавантолгойн ордын үнэ цэнийг өсгөх хүрээнд холбогдох дэд бүтцийн болон шаардлагатай бусад төсөл, хөтөлбөрийн тодорхой хэсгийг санхүүжүүлэхийг Засгийн газарт үүрэг болгосон. Улсын Их хурлын тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд тус яамнаас “Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолыг төслийг боловсруулж, 2019 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн 296 дугаар тогтоолоор батлуулсан. Уг тогтоолоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн иргэд, аж ахуйн нэгжийн | 100 /төрийн захиргааны төв байгууллагын зүгээс авч хэрэгжүүлэх арга хэмжээг бүрэн авсан тул хяналтаас хасуулах саналтай/ | |

| | | | |
|---|---|---|---|
| 8 | 11 | Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай<br>2015-02-17<br>Дугаар 2015_36 | 11. 11/энэ тогтоолын 1 дэх заалтын 10 дахь дэд заалтад заасан нэгдсэн бодлогын агуулгад нийцсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах.<br>*10/цахилгаан эрчим хүч, ган, нүүрснээс синтетик байгалийн хий үйлдвэрлэж, экспортлох асуудлаар нэгдсэн бодлого боловсруулж 2015 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор Улсын Их Хуралд танилцуулах* ; |

| | | | |
|---|---|---|---|
| | УИХ-ын 2015 оны 6 дугаар сарын 19-ны өдрийн 62 дугаар тогтоолоор батлуулсан. Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогын бичгийн 4.2.3.6, УИХ-ын 2015 оны 36 дугаар тогтоолын 1 дэх заалтын 10 дахь дэд заалтад заасан нэгдсэн бодлогын агуулгад нийцсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд МУ-ын Засгийн газрын 2016 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 107 дугаар тогтоолыг үндэслэн УУХЯ-ны сайдын 2016 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн А/43 тоот тушаалаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны дэргэд "Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр барих" төсөл хэрэгжүүлэх нэгж байгуулан ажиллаж байна. Тус төслийн нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэл (НТЭЗҮ) болон Байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээг Дэлхийн банкны санхүүжилтээр Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл (УУДБХОДТ)-ийн хүрээнд боловсруулсан. БНХАУ-ын Ухуан инженеринг компанийн (Wuhuan engineering) боловсруулсан төслийн НТЭЗҮ-ийг 2017 оны 5 дугаар сард Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцэн баталсан бол Дэлхийн банкны стандарт, шаардлагад нийцсэн Байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний эцсийн тайланг Монгол Улсын "Грийн трендс" ХХК боловсруулан 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдөр УУХҮЯ-д хүлээлгэн өгснөөр тус төслийн санхүүжилт, хөрөнгө оруулалтыг татах, гэрээ хэлцэл хийхэд шаардлагатай олон улсын банк санхүүгийн байгууллагын шаардлагыг хангасан үндсэн баримт бичиг бэлэн болоод байна. Төсөл дээр хамтран ажиллах сонирхолтой гадаад хөрөнгө оруулагчдын зөвлөсний дагуу төслийг бага хөрөнгө оруулалтаар үе шаттайгаар хэрэгжүүлж НТЭЗҮ-д | 100 /төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого УИХ-ын 2015.06.19 өдрийн 62 дугаар тогтоолоор батлагдсан, бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан ажиллаж байгаа тул хяналтаас хасуулах саналтай/ | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 9 | 12 | Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2016-11-17 Дугаар 2017 №69 | 1.2.2. түүхий нефтийн экспортоос нөөц ашигласны төлбөрийг тооцож авах, борлуулалтын орлогыг Монгол Улсад бүртгэлтэй арилжааны банкаар дамжуулан гүйцэтгэх хуулийн шаардлагыг бүтээгдэхүүн хуваах гэрээнд тусгах гэрээ хэлцлийг хийж, дүнг Улсын Их Хуралд танилцуулах. | Засгийн газрын 2018.01.03-ны өдрийн 5 дугаар тогтоолоор "Газрын тосны нөөц ашигласны төлбөр, тусгай зөвшөөрлийн төлбөрийг төлөх, хуваарилах, зарцуулах журам"-ыг батлуулсан. Газрын тосны борлуулалтын орлогоос нөөц ашигласны төлбөрийг тооцож 2017 онд 31.7 тэрбум төгрөг, 2018 онд 33.5 тэрбум төгрөгийг тус тус улсын төсөвт төвлөрүүлсэн. Засгийн газрын 2015 оны 03 дугаар сарын 104 дүгээр тогтоолоор батлагдсан, Бүтээгдэхүүн хуваах гэрээний загварын 15 дугаар зүйлийн 15.1.2-т Газрын тосны тухай хуулийн 11.2.6-ийн "хөрөнгө оруулалт, борлуулалтын орлоготой холбоотой гүйлгээг Монгол Улсад бүртгэлтэй арилжааны банкаар дамжуулан гүйцэтгэх бөгөөд уг гүйлгээг санхүүгийн тайланд ил тод, нээлттэй бүрэн тусгах" заалтыг тусган баталгаажуулсан. Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдахаас өмнө байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдийг дээрх загварт нийцүүлэн шинэчлэх ажлыг зохион байгуулж, гэрээлэгчидтэй хэлэлцээр хийн, газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулж буй нэр бүхий 11 компанитай байгуулсан БХГ-г шинэчлэн, Газрын тосны тухай хуулийн 11.2.6 дахь заалтыг гэрээнд тусган батлаад байна. /Хэрэгжилт-50%/ | 100 /Уг тогтоолын холбогдох заалт нь нэг удаагийн үйлчлэлтэй, 2017 оны санхүүгийн жил дуусгавар болсон байх тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ/ | |
| 10 | 13 | Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 2017-11-14 Дугаар 2017_69 | 1.. 1/Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуульд бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагч нарын багцад "сахилга, хариуцлага, ажлын үр дүнг урамшуулах" зориулалтаар батлагдсан хөрөнгийг зарцуулахтай холбогдуулан төрийн албан хаагчийн сахилга, хариуцлага, үйл ажиллагааны үр дүн болон хөдөлмөрийн гэрээг хагас, бүтэн жилээр үнэлж, дүгнэх, ажлын бүтээмж, гүйцэтгэлийн үр дүнд үндэслэн урамшуулах тогтолцоог бий болгох, энэ талаар холбогдох журам баталж мөрдүүлэх; | Төрийн албан хаагчийн сахилга, хариуцлага, үйл ажиллагааны үр дүн болон хөдөлмөрийн гэрээг хагас, бүтэн жилээр үнэлж, дүгнэх, ажлын бүтээмж, гүйцэтгэлийн үр дүнд үндэслэн урамшуулах тогтолцоог Төрийн албаны тухай хууль Төрийн албаны зөвлөлөөс баталсан дүрэм журамд нийцүүлэн дотоод журамдаа тусган, хэрэгжүүлж ажиллаж байна. 2019 оны жилийн эцсийн байдлаар сахилгын шийтгэл авсан хүн байхгүй байна. | 100 /хуулийн заалтыг хэрэгжүүлсэн, хууль нь нэг удаагийн үйлчлэлтэй байх тул хяналтаас хасуулах саналтаай/ | |
| УИХ-ын байнгын хорооны тогтоол | | | | | | |

| | | | |
|---|---|---|---|
| 11 | 14 | Засгийн газарт чиглэл өгөх тухай<br>2011-01-19<br>Дугаар 2011_01 | II.1.1. МУ-ын Их Хурлын 2009 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн 57 дугаар тогтоолын 3 дахь заалтын биелэлтийг хангах, АМТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль шинээр батлагдсантай холбогдуулан дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг МУ-ын Засгийн газар /С.Батболд/-т чиглэл болгосугай<br>Эрх зүйн орчныг бүрдүүлэх замаар анхны хөрөнгө оруулалтаа нөхсний дараа төрийн эзэмшлийн хувьцааны хэмжээг 50-иас доошгүй хувьд хүргэж нэмэгдүүлэх асуудлаар хөрөнгө оруулагч талтай байгуулсан гэрээний нөхцөлийг сайжруулах талаар хэлэлцээ хийж шийдвэрлэх |

| | | |
|---|---|---|
| 2015 оны 5 дугаар сарын 18-ны өдөр Монгол Улсын Засгийн Газар (Эрдэнэс Оюу Толгой ХХК) болон Туркойс Хилл Ресурсес Лимитед, Ти Эйч Ар Оюу Толгой Лтд, Оюу Толгой Нидерланд Би Ви, Рио Тинто Интернэшнл Холдингс Лимитед болон Оюу Толгой ХХК-ийн хооронд Оюу толгой төслийн 2 дахь шат буюу Далд Уурхайн Бүтээн байгуулалтын,санхүүжилтийн гэрээг байгуулсан. Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын ажил хэвийн явагдаж байна. Мөн Улсын Их хурлын даргын 2018 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 57 дугаар захирамжаар Оюу Толгой ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний хэрэгжилтийг шалгаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Тус яамнаас уг ажлын хэсгийн хүрээнд байгуулагдсан дэд ажлын хэсэгт холбогдох албан тушаалтнууд ажиллаж, холбогдох санал, дүгнэлтийг боловсруулан Улсын Их хурлын даргын 2018 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 57 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт хүргүүлсэн. Ажлын хэсэг холбогдох санал, дүгнэлтийг нэгтгэн Оюу толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай" Улсын Их хурлын тогтоолын төслийг боловсруулж, 2019 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 92 дугаар тогтоолоор батлуусан. Уг тогтоолын 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт "Оюу толгой төслөөс хүртэх Монголын талын үр өгөөжийг Хөрөнгө оруулалтын гэрээ болон 2010 оны техник, эдийн засгийн үндэслэлийн тооцоолold заасанаар нэрлэсэн үнээр 53 хувиас бууруулахгүй байх хүрээнд Монголын талын эзэмшлийн 34 хувийн хувьцаа эзэмшлийг бүтээгдэхүүн хуваах нөхцөл, эсвэл ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулах хувилбаруудыг судлан шийдвэрлэх, шаардлагатай тохиолдолд холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах тухай санал боловсруулан | 100 /яамны зүгээс авч хэрэгжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн/ | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 12 | 15 | Шалгалтын мөрөөр авах зарим арга хэмжээний тухай 2015-04-08 Дугаар 2015-04-08-10 | 1.5. Засгийн газарт болон "Эрдэнэс таван толгой" ХК, "Эрдэнэс монгол" ХХК-д эдийн засгийн байнгын хороо, Үндэсний аудитын газрын хамтарсан шалгалтын ажлын хэсгээс өгсөн чиглэл, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авах | УИХ-ын Эдийн засгийн Байнгын хороо, Үндэсний аудитын газраас "Эрдэнэс Тавантолгой" ХК, "Эрдэнэс Монгол" ХХК-д өгсөн чиглэл, зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар холбогдох чиглэл өгч ажилласан. Тухайлбал, Тавантолгойн Цанхийн Зүүн уурхайн гэрээт олборлолтын ажлын хөлс болон нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийн үнийг бүрэн төлж барагдуулах талаар шуурхай арга хэмжээ авч ажиллах тухай албан тоот /2015.04.28-ны 1/1004/-ыг "Эрдэнэс Тавантолгой" ХК-д хүргүүлсэн. "Эрдэнэс-Тавантолгой" ХК нийт 45.8 сая тонн нүүрс олборлож, 4.6 их наяд төгрөг буюу 2.1 тэрбум ам.долларын борлуулалтын орлоготой ажилласнаас 2017, 2018 онд 3.1 их наяд төгрөг, үүнээс 2018 онд 1.99 их наяд төгрөгийн орлоготойгоор 2010 оноос хойш үүссэн гадаад, дотоод өр төлбөрийг бүрэн төлж барагдуулсан. 2018 онд улсын төсөвт 510 тэрбум төгрөг төвлөрүүлж, компанийн цэвэр ашгийг 720 тэрбум төгрөгт хүргэсэн. 2016 оны 1-р улиралд Чалко компанид нэг тонн нүүрсийг 24.97 ам.доллар нийлүүлж байсан бол 2017 оны 1-р улиралд 59.33 ам.доллар, 2018 оны 2-р улиралд 61.0 ам.доллар, 2019 оны 1-р улирлаас 63.32 ам.доллар болгож нэмэгдүүлснээр үнийг 2.5 дахин өсгөсөн. | 100 /зөвлөмжийн хэрэгжилтийг хангасан тул хяналтаас хасуулах саналтай/ | |
| | 16 | | 3. Оюу толгой ордыг ашиглахтай холбогдуулан хувь нийлүүлэгчдийн хооронд нягтлан бодох бүртгэлийн стандартын зөрүү, уул уурхайн салбарт хуримтлуулсан туршлагын ялгаа зэргээс хамааран үл ойлголцол, хууль тогтоомжийн зөрүү зэргийг арилгах, олон улсын болон Монгол Улсын холбогдох стандарт, дүрэм журмыг нэг мөр болгож цэгцлэх, олон нийтийг үнэн зөв, бодитой мэдээллээр хангах | Хүдрийн далд уурхайн аюулгүй байдлын дүрэм"-ийг шинэчлэн боловсруулж Уул уурхай сайд, Хөдөлмөрийн сайдын 2015 оны 11 дүгээр сарын 19-ны өдрийн 229/А/232 дугаар хамтарсан тушаалаар батлуулж мөрдүүлэн ажиллаж байна. Ингэснээр Оюутолгойн далд уурхайн бүтээн байгуулалтын ажлыг олон улсын стандарт шаардлагад нийцсэн дүрмийн дагуу явуулах боломж бүрдсэн. Мөн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг Монгол Улсад мөрдөж байгаа холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж байна. | 100 /яамны зүгээс авч хэрэгжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн/ | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 13 | 17 | Чиглэл өгөх тухай<br>2015-05-29<br>Дугаар 2015_09 | 4. Оюу толгой ордыг ашиглахад Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм, журмыг гуйвуулалтгүй мөрдүүлэх, цаашид Монгол Улсын томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар анхаарч ажиллах | Оюу толгойн ордыг ашиглах талаар холбогдох хууль (Монгол Улсын Үндсэн хууль, Ашигт малтмалын тухай, Компанийн тухай, Хөрөнгө оруулалтын тухай, Газрын хэвлийн тухай, Байгаль орчны багц хууль гэх мэт) , тогтоомж ("Оюу толгой ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний тухай" УИХ-ын 2009 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн 57 дугаар тогтоол), дүрэм (Хүдрийн далд уурхайн аюулгүй байдлын дүрэм), журмыг (Төрийн болон орон нутгын өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай) мөрдүүлж, бараа, ажил, үйлчилгээг Монгол Улсад мөрдөж байгаа холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж байна.<br>Улсын Их хурлын даргын 2018 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 57 дугаар захирамжаар Оюу Толгой ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний хэрэгжилтийг шалгаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Тус яамнаас уг ажлын хэсгийн хүрээнд байгуулагдсан дэд ажлын хэсэгт холбогдох албан тушаалтнууд ажиллаж, холбогдох санал, дүгнэлтийг боловсруулан Улсын Их хурлын даргын 2018 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 57 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт хүргүүлсэн.Улсын Их хурлын даргын 2018 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 57 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг холбогдох санал, дүгнэлтийг нэгтгэн Оюу толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай" Улсын Их хурлын тогтоолын төслийг боловсруулж, 2019 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 92 дугаар тогтоолоор батлуусан.Уг тогтоолын 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Монгол Улсын Засгийн газар болон Айвенхоу майнз Монголиа Инк ХХК, Айвенхоу майнз Лтд, Рио Тинто Интернэшнл Холдингс Лтд компани хооронд 2009 оны 10 дугаар сарын 06-ны өдөр байгуулсан Хөрөнгө | 100 /яамны зүгээс авч хэрэгжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн/ | |
| Ерөнхийлөгчийн зарлиг | | | | | | |
| 14 | 18 | Монгол баатарлаг туульсаа дээдлэн дэлгэрүүлэх тухай<br>2019-01-29<br>Дугаар 2019_13 | 3.. Баатарлаг туульсаа дээдлэн хамгаалах, бүртгэн судлах, өвлөн уламжлуулах, түгээн дэлгэрүүлэх, олон улсад сурталчлан таниулах, туульч, өвлөн уламжлагч, өв тээгчид болон судлаачдыг урамшуулах үйл ажиллагааг дэмжиж ажиллахыг төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтанд үүрэг болгосугай. | УУХҮС Д.Сумъяабазар Монголын геологи ба ашигт малтмал" хэмжээ 8 боть бүтээл бүтээн Төрийн соёрхол хүтсэн нэр бүхий 8 эрдэмтдийг хүлээн авч хүндэтгэл үзүүлж үнэ бүхий зүйлээр 2019.01.17-ны өдөр шагнаж урамшуулсан. | 100 /яамны эрхлэх асуудалд хамааралгүй тул хяналтаас хасуулах саналтай/ | |
| | 19 | | 4.. Монгол баатарлаг туульсынхаа агуулга, ач холбогдлыг таньж ойлгох, дэмжин дэлгэрүүлэх, өв соёлоо хүндэтгэн дээдлэх, хадгалах, уламжлуулан хамгаалах үйлсэд идэвх санаачлагтай оролцохыг тбрийн ба төрийн бус байгууллага, иргэд олон нийт, эрдэмтэн судлаачид, шинжлэх ухааны ба хэвлэл мэдээллийн байгууллагуудад уриалсугай. | УУХҮС Д.Сумъяабазар Монголын геологи ба ашигт малтмал" хэмжээ 8 боть бүтээл бүтээн Төрийн соёрхол хүтсэн нэр бүхий 8 эрдэмтдийг хүлээн авч хүндэтгэл үзүүлж үнэ бүхий зүйлээр 2019.01.17-ны өдөр шагнаж урамшуулсан. | 100 /яамны эрхлэх асуудалд хамааралгүй тул хяналтаас хасуулах саналтай/ | |
| ҮАБЗ-ийн зөвлөмж | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 15 | 20 | Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг эрчимжүүлэх тухай<br>2014-10-20<br>Дугаар 2014_52/30 | 2.5. Нүүрсийг гүн боловсруулах /шингэрүүлэх, хийжүүлэх/, нүүрсний давхаргын метан хийг олборлох технологийг нэвтрүүлж, цэвэр түлш үйлдвэрлэхэд төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрийг сонгон хэрэгжүүлэх | Засгийн газрын 2014 оны 3 дугаар сарын 07-ны өдрийн 74 дүгээр тогтоолоор “БНХАУ-ын Синопек корпорацитай хамтран нүүрсийг хийжүүлэх технологи нэвтрүүлэх төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий” төслийн нэгжийг Уул уурхай яамны дэргэд байгуулсан. Төслийн нэгж БНХАУ-ын Синопек компанитай хамтран хийсэн, Багануурын уурхайг түшиглэн 1-3 тэрбум шоо метр синтетик хий үйлдвэрлэх үйлдвэр барих техник, эдийн засгийн урьдчилсан судалгаагаар Багануурын нүүрс нь чанарын хувьд хангалттай сайн биш, үйлдвэрийг Багануурын нүүрсний уурхайг түшиглэн барих нь эдийн засгийн хувьд үр ашиггүй болохыг тодорхойлсон. Мөн урьдчилсан ТЭЗҮ-д үндэслэн Цайдамнуурын болон Эрдэнэцогтын уурхай дээр тус бүр жилийн 8 тэрбум шоо метр хүчин чадалтай үйлдвэр барих нарийвчилсан ТЭЗҮ-ийн судалгааг хийх байсан боловч санхүүжилт шийдэгдээгүй учир зогссон. Ингээд Засгийн газрын 2016 оны 2 дугаар сарын 29-ны өдрийн 131 дугаар тогтоолоор тус төслийн нэгжийг татан буулгасан. БНСУ-ын КОГАЗ, Австралийн Голден Хорд болон Нордик Гео Солюшн, Элгэн зэрэг компаниудын хийсэн судалгааны тайланд Таван Толгойн ордын нүүрсний давхаргын метан хийн нөөцийг урьдчилсан төсөөллөөр 40 сая.тн буюу 4.7 тэрбум шоо метр гэж тогтоосон байдаг. Номгон-IX талбайд нүүрсний давхаргын метан хийн хайгуул, судалгааны ажил хийж гүйцэтгэх тухай Бүтээгдэхүүн хуваах гэрээг Австрали улсын хөрөнгө оруулалттай “Жи Өү Эйч” ХХК-ийн хооронд 2018.09.18-ны өдөр байгуулсан. Гэрээлэгч компани 2019 онд 1.99 сая ам долларын хөрөнгө оруулалтаар 2 хэмжээст чичирхийллийн судалгаа, 500-1000 м хайгуулын өрөмдлөгийн ажил хийж гүйцэтгэхээр төлөвлөснөөс 2019.11.30-ны байдлаар 210 тууш км 2 хэмжээст | 100 /төрийн захиргааны төв байгууллагын зүгээс шаардлагатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн, / | хэрэгжилт удаашралтай, нүүрснээс түлш гаргаж авах, давхаргын метан хий гаргаж авах талаар дорвитой ажил хийгдээгүй, тодорхой үр дүн хүрээгүй, сүүлийн 3 жилийн хугацаанд ахиц гараагүй байна. Иймд зөвлөмжийн томёоллыг өөрчлөх, тодорхой болгох талаар ҮАБЗ-д санал хүргүүлэх нь зүйтэй. |
| ҮАБЗ-ийн хуралдааны тэмдэглэл | | | | | | |
| 16 | 21 | Тавантолгойн нүүрсний ордыг ашиглах талаар<br>2010-05-18<br>Дугаар 2010_24/11 | 5. Тавантолгойн уурхайн ашиглалт, дэд бүтэц барьж байгуулах асуудлыг "Өмнийн говь" төсөлтэй уялдуулан Улсын Их Хуралд оруулах. | Тус яамнаас Тавантолгойн ордын талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их хурлын тогтоолын төслийг боловсруулж Засгийн газрын 2018 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаан, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2018 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаар тус тус хэлэлцүүлж, Улсын Их хурлын 2018 оны 6 дугаар сарын 29-ны өдрийн 73 дугаар тогтоолоор батлуулсан. Уг тогтоолын төсөлд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийг тусгасан болно. | 100 /заалтын биелэлт хангагдсан тул хяналтаас хасуулах саналтай/ | |
| ЗГ-ын тогтоол | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 17 | 22 | Таван толгойн ордын талаар авах зарим арга хэмжээний тухай 2014-08-20 Дугаар 2014_268 | 1.д. Хөрөнгө оруулагч нь улсын төсөвт төлөх татвар, хураамж, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг хариуцахаас гадна борлуулалтын орлогын тодорхой хувийг Хөрөнгө оруулж хамтран ажиллах гэрээний төлбөрт төлөх, шаардлагатай тохиолдолд нэмж төлөх борлуулалтын орлогын тодорхой хэсгийг урьдчилан төлөхөөр хэлэлцэх; | Тавантолгой нүүрсний ордод 2014 онд зарласан хөрөнгө оруулагчийг шалгаруулах уралдаант шалгаруулалтад БНХАУ-ын "Чайна Шенхуа Энержи" ТӨК (цаашид "Шеньхуа" гэх), Японы "Сумитомо корпораци" болон Монголын "Mongolian Mining Corporation" (цаашид "ММС" гэх) компанийн хамтарсан консорциум шалгарсан. Засгийн газраас өргөн мэдүүлсэн "Тавантолгойн нүүрсний ордыг хөгжүүлэх талаар авах арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Тавантолгойн ордыг хөгжүүлэхтэй холбоотой хөрөнгө оруулалтын гэрээ болон хавсралт гэрээнүүдийг Монгол Улсын Их Хурлаар хэлэлцэх эсэхийг шийдвэрлэх талаар дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын даргын 2015 оны 101 дүгээр захирамжаар байгуулсан. Ажлын хэсгийн ахлагчаар УИХ-ын гишүүн Л.Эрдэнэчимэг ажилласан. Ажлын хэсэг Консорциумтай байгуулахаар төлөвлөж байсан "Хамтын ажиллагааны гэрээ", "Хөрөнгө оруулалтын гэрээ", "Ухаа худаг-Гашуун Сухайт чиглэлд төмөр замын суурь бүтцийг барих-өмчлөх-ашиглах-шилжүүлэх гэрээ"-г судлан дүгнэлт гаргаж, саналыг Засгийн газарт буцаах шийдвэр гаргасан. Ажлын хэсгийн саналыг дараах байдлаар судлаж, Засгийн газрын 2012 оны 05 дугаар сарын 30-ийн өдрийн 181 дүгээр тогтоол болон 2014 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 268 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болгох нь зүйтэй гэж үзсэн. Ингэснээр тус компанийн 1072 хувьцаа эзэмшиж байгаа иргэдийн хууль ёсны эрх ашиг хангагдаж, 2010 онд зарласан Таван толгойн нүүрсний ордыг ашиглах уралдаант шалгаруулалтын хураангуй жагсаалтанд багтсан 6 компанийг дахин хууль, тогтоомжид нийцүүлэн сонгох боломж нээлттэй үлдэнэ гэсэн дүгнэлт гаргасан. Монгол Улсын Ерөнхий сайдын 2016 оны 104 дүгээр захирамжаар | 100 /хяналтаас хасуулах саналтай/ | |
| 18 | 23 | Гаалийн тарифын зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай 2014-09-18 Дугаар 2014_306 | 2. Гаалийн тарифтай холбоотой бодлогын асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийн өмнө Гаалийн тарифын зөвлөлөөр хэлэлцүүлж байхыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосугай. | Гаалийн тарифын зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай шийдвэр гарснаас хойш хуучнаар УУЯ, өнөөгийн УУХҮЯ-аас гаалийн тарифтай холбоотой асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлээгүй болно. | /-/ хэрэгжилт тооцох хугацаа болоогүй | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 19 | 24 | Хөрөнгө гаргах тухай<br>2015-04-20<br>Дугаар 2015_159 | 1. Гацууртын алтны ордыг ашигласны улмаас Төв аймгийн Борнуур сумын нутаг дэвсгэрт орших түүх, соёлын үл хөдлөх дурсгал болох Хүннүгийн үеийн Бороогийн сууринд үзүүлж болзошгүй нөлөөллийг судалж, мэргэжлийн дүгнэлт гаргахад зориулан 57,241,000.0 (тавин долоон сая хоёр зуун дөчин нэгэн мянган) төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас гаргахыг Сангийн сайд Ж.Эрдэнэбатад зөвшөөрч, орд ашиглалтад орсон тохиолдолд уг хөрөнгийг төсөвт буцаан төвлөрүүлэхийг Уул уурхайн сайд Р.Жигжидэд даалгасугай. | Ерөнхий сайдын 2015 оны 02 дугаар сарын 24-ны өдрийн 55 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийн хүрээнд Төв аймгийн Борнуур сумын нутаг дэвсгэрт орших түүх, соёлын үл хөдлөх дурсгал болох Хүннүгийн үеийн Бороогийн сууринд үзүүлж болзошгүй нөлөөллийг Шинжлэх ухааны академийн Палеонтологи, Геологийн хүрээлэн судалж тайлан гарган 2016 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн Т/16 дугаартай албан бичгээр палеонтлогийн хайгуул судалгааны ажлын дүгнэлтийг Гацууртын ордын ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшигч "Сентерра гоулд Монголиа ХХК-д хүргүүлсэн байна. Энэхүү судалгааны дүгнэлтэд "палеонтологийн олдвор зөвхөн Голоцены сэвсгэр хурдсаас илрэх магадлалтай харин бусад палезойн хурдсууд ямарч олдвор агуулаагүй гэдгийг дурдсан байна. Холбогдох зардлыг Сентерра гоулд Монголиа ХХК-тай байгуулах орд ашиглах гэрээний төсөлд тусгасан бөгөөд Гацууртын алтны орд ашиглах асуудал шүүхээр эцэслэн шийдэгдээгүй учир төслийн үйл ажиллагаа тодорхойгүй хугацаагаар хойшлогдож байна. | 100 /яамны түвшинд холбогдох арга хэмжээг авсан тул хяналтаас хасуулах саналтай/ | хэрэгжилт удааширсан, орд ашиглах үйл ажиллагаа зогссон, шүүхийн маргаантай байна. |
| 20 | 25 | Албан татварыг хэсэгчлэн төлүүлэх тухай<br>2015-05-18<br>Дугаар 2015_190 | 2. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан төслүүдийг хэрэгжүүлж байгаа “Монголын алт” ХХК-тай гурвалсан гэрээ байгуулж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Ж.Эрдэнэбат, Уул уурхайн сайд Р.Жигжид, Барилга, хот байгуулалтын сайд Д.Цогтбаатар нарт даалгасугай. | Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан төслүүдийг хэрэгжүүлж байгаа "Монголын алт" ХХК-тай байгуулах гурвалсан гэрээний төсөл одоогоор тус яаманд ирээгүй байна. УИХ-ын 2014 оны 54 дүгээр тогтоолоор тус ордод төр хувь эзэмших шаардлагагүй гэсэн шийдвэр гаргасан бөгөөд Монгол Улсын Засгийн газар болон "Монголын алт" ХХК, "Эрдэнэс Цагаансуварга" ХХК-ийн хооронд 2015 оны 11 сард тус ордыг түшиглэн байгуулах Баяжуулах үйлдвэрийн Хөрөнгө оруулалтын гэрээнд гарын үсэг зурсан. /ХБНГУ-аас "Монголын алт" ХХК-д олгох зээлийн санхүүжилтэд Монгол Улсын Засгийн газраас баталгаа гаргасан/ | 100 /хөрөнгө оруулалтын гэрээг байгуулж, тогтоолын хэрэгжилт хангагдсан тул хяналтаас хасуулах саналтай / | |
| 21 | 26 | Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн эргэлтийн цэг, солбицол батлах тухай<br>2016-04-04<br>Дугаар 2016_196 | 3. Ухаахудаг-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барих хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу зохих дэмжлэг үзүүлж ажиллахыг Уул уурхайн сайд Р.Жигжид, Өмнөговь аймгийн Засаг дарга Д.Бадраа нарт үүрэг болгосугай. | Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд заасанаар /11.2.5.харьяалах нутаг дэвсгэрт нь хамаарах түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох;/ Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрхэд түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг олгож байна. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам дээрх хуулийн хүрээнд бодлогын дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.<br>/Биелэлт 100 хувь, ХЯНАЛТААС ХАСУУЛАХ/ | 100 /яамны түвшинд дэмжлэг үзүүлж ажилласан тул хяналтаас хасуулах саналтай/ | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 22 | 27 | “Шивээ-овоо” ХК-ийн техник, технологийг шинэчлэхэд шаардагдах санхүүжилтийг шийдвэрлэх тухай<br>2016-04-18<br>Дугаар 2016_219 | 2. “Шивээ-Овоо” ХК-ийн үйл ажиллагааг тогтворжуулж, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч, зээлийн эргэн төлөлтөд хяналт тавьж ажиллахыг Уул уурхайн сайд Р.Жигжид, Эрчим хүчний сайд Д.Зоригт нарт үүрэг болгосугай. | Эрчим хүчний сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд нарын 2019 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 52/А/25 дугаар хамтарсан тушаалаар Шивээ овоогийн уурхайн үйл ажиллагаа, санхүү, эдийн засгийн байдалд үнэлэлт, дүгнэлт өгч, холбогдох санал дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдаж, ажилласан.<br>Мөн Засгийн газрын 2019 оны 10 дугаар сарын 2-ны өдрийн ээлжит хуралдаанаар Багануур, Шивээ-Овоогийн уурхайн өвөлжилтийг хангах тухай асуудлыг хэлэлцэж, хуралдааны 42 дугаар тэмдэглэлийг гаргасан.<br>Уг тэмдэглэлийн 1-д Багануур, Шивээ-Овоогийн нүүрсний уурхай, дулааны станц хооронд үүссэн өр, авлагын асуудлыг шийдвэрлэх, уурхай болон дулааны станцын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангахад шаардлагатай байгаа санхүүжилт, эргэлтийн хөрөнгийн зээлийн асуудлаар Хөгжлийн банканд зохих журмын дагуу хандаж шийдвэрлэхийг Эрдэнэс Монгол ХХК-д даалгасан. | 100 /яамны зүгээс дэмжлэг үзүүлж ажилласан тул хяналтаас хасуулах саналтай/ | |
| 23 | 28 | Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицол батлах тухай<br>2016-08-03<br>Дугаар 2016_14 | 3. Энэ тогтоолын 2 дугаар зүйлд заасны дагуу түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах хуулийн этгээдэд хууль тогтоомжийн дагуу зохих дэмжлэг үзүүлж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, Дорноговь аймгийн Засаг дарга Т.Энхтүвшин нарт даалгасугай. | Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд заасанаар /11.2.5.харьяалах нутаг дэвсгэрт нь хамаарах түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох;/ Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрхэд түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг олгож байна. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам дээрх хуулийн хүрээнд бодлогын дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.<br>/Биелэлт 100 хувь, ХЯНАЛТААС ХАСУУЛАХ/ | 100 /яамны зүгээс дэмжлэг үзүүлж ажилласан тул хяналтаас хасуулах саналтай/ | |
| 24 | 29 | Журам батлах тухай<br>2017-02-22<br>Дугаар 2017_61 | 2. Энэхүү журмын хэрэгжилтийг зохион байгуулж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол нарт даалгасугай. | “Үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон үйл ажиллагааны журам” болон “Үүсмэл орд ашиглах үйл ажиллагаанд тавих шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журам”-ын төслийг Засгийн газрын 2017 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, “Журам батлах тухай” Засгийн газрын 2017 оны 61 дүгээр тогтоолоор батлуулсан. Мөн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны А/93 дугаар тушаалаар Ажлын хэсгийг байгуулж Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрийн хэлтсийн даргын 2017 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 613 дугаар шийдвэрээр 2017 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн UN-000001 дугаартай үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрлийг “Ачит Ихт” ХХК-д олгосон. Мөн ЭБМЗ-ийн 2017 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдаанаар “Ачит Ихт” ХХК-ийн Үүсмэл ордын нөөцийн тайланг хэлэлцэж, холбогдох шийдвэрийг гаргасан. Мөн Бороогийн алтны үндсэн ордод үйл ажиллагаа явуулж байгаа "Бороо Гоулд" ХХК-ийн зүгээс өөрийн уусгалтын талбай дахь ядуу агуулгатай хүдрийн овоолгыг үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрлийн үндсэн дээр ашиглах хүсэлтийг ирүүлээд байна. Уг асуудлыг холбогдох байгууллага /АМГТГ/ судлаж байна. | 100 /үүсмэл ордтой холбогдох журмын хэрэгжилт, түүнд тавих хяналтыг хэрэгжүүлж ажиллаж байгаа тул хяналтаас хасуулах саналтай/ | |

| | | | |
|---|---|---|---|
| | 30 | | 2. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулахад хөрөнгө оруулж хамтран ажиллах хөрөнгө оруулагчийг сонгох, хөрөнгө оруулагчтай байгуулах гэрээний талаар хэлцэл хийх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулан ажлын явц, үр дүнг Засгийн газарт тухай бүр танилцуулж байхыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайхан нарт даалгасугай. |

Зэсийн баяжмал боловсруулах

| | | | | |
|---|---|---|---|---|
| | Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих төслийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, уг төслийг хэрэгжүүлэгч нэгжид дэмжлэг үзүүлэх зорилгоор төслийн хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулахад хууль, санхүүгийн гадаад, дотоодын зөвлөхийг сонгон шалгаруулах тендерийг 2018.08-10 сард зохион байгуулсан. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих төслийн хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах хууль, санхүүгийн зөвлөх үйлчилгээний гэрээг 2018.11.27-ны өдөр "Өмгөөллийн Монгол өмгөөлөгч" ХХН-тэй байгуулж, тайланг ирүүлсэн. Тус зөвлөх үйлчилгээний дагуу Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих төслийн хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулж, хөрөнгө оруулагчтай байгуулах гэрээний төсөл, эрх зүйн баримт бичиг боловсруулж Сангийн сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдийн хамтарсан тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг хүлээн авсан. Мөн хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах бэлтгэл ажлын хүрээнд УУХҮЯ-ны дэргэдэх "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах төсөл" хэрэгжүүлэх нэгж үйлдвэрийн урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулан УУХҮЯ-ны дэргэдэх "Эрдэс баялагийн мэргэжлийн зөвлөл"-өөр 2018.08.14- ний өдөр хэлэлцүүлэн дүгнэлт гаргуулсан. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны багцад Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулах зардлыг тусгуулж, зөвлөх үйлчилгээний тендерийн шалгаруулалтыг зохион байгуулж байна. /Хэрэгжилт-70%/ | 70 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 25 | 31 | Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эрчимжүүлэх тухай<br>2017-03-15<br>Дугаар 2017_88 | 3. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн нийт хувьцааны 10-аас доошгүй хувийг хөрөнгө оруулалтын зардал гаргахгүйгээр төр үнэ төлбөргүй эзэмших асуудлыг зөвшөөрч, төрийн төлөөллийг зохих журмын дагуу хэрэгжүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, Сангийн сайд Б.Чойжилсүрэн нарт даалгасугай. | Засгийн газрын 2017 оны 03 дугээр сарын 15-ны өдрийн "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эрчимжүүлэх тухай" 88 дугаар тогтоолоор үйлдвэрийн нийт хувьцааны 10-аас доошгүй хувийг хөрөнгө оруулалтын зардал гаргахгүйгээр төр үнэ төлбөргүйгээр эзэмших, Үйлдвэрийг Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт байгуулахаар шийдвэрлэсэн.<br>Төсөл хэрэгжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд Төслийн нэгжээс Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулан УУХҮЯ-ны дэргэдэх "Эрдэс баялагийн мэргэжлийн зөвлөл"-өөр 2018.08.14-ний өдөр хэлэлцүүлэн хүлээн авах шийдвэр гаргуулсан. Мөн "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих төсөл"-ийн Байгаль орчны ерөнхий үнэлгээний тайланг мэргэжлийн байгууллагаар хийлгэн 2018.05.20-нд хүлээн авсан бөгөөд уг тайланг БОАЖЯ хянан үзэж 2018.11.27-ны өдрийн 13/8361 дугаартай албан бичгээр дүгнэлт гаргуулсан. Мөн Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих зорилгоор Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дэвсгэрт орших 466 га газрыг үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалтын төсөл хэрэгжүүлэх зориулалтаар "Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай" тогтоолын төслийг боловсруулж Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлсэн. Барилга, хот байгуулалтын яам нь тогтоолын төсөлд яамдаас санал авч, 2018.12.12-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар уг асуудлыг хэлэлцүүлэн дэмжигдсэн.<br>Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих төслийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, уг төслийг хэрэгжүүлэгч нэгжид дэмжлэг үзүүлэх зорилгоор төслийн хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулахад хууль, санхүүгийн гадаад, дотоодын | 70 | |
| 26 | 32 | Тогтоол хүчингүй болгох тухай<br>2017-03-20<br>Дугаар 2017_96 | 4. Хөндлөнгийн аудитын дүгнэлтийг үндэслэн Гашуунсухайт-Ганцмод чиглэлийн боомтын төмөр замын төсөлд зарцуулсан хөрөнгийг Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төсөлд оруулах нийт хөрөнгө оруулалтад нь багтаан тооцуулах талаар хөрөнгө оруулахыг сонирхож байгаа этгээдтэй хэлэлцээ хийж тохиролцохыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат, Сангийн сайд Б.Чойжилсүрэн нарт тус тус даалгасугай. | Гашуун Сухайтын Төмөр Зам" ХХК-д оруулсан хувь хөрөнгийн хэмжээг татан авах ажлыг хэрэгжүүлэх ажлын хэсэг байгуулагдан ажиллаж, холбогдох дүгнэлтийг "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлд танилцуулсан. ТУЗ-өөс хувь хөрөнгөө татан авах ажлыг гүйцэтгэхийг даалгасан тогтоолыг 2017 оны 05 дугаарсарын 25-нд гаргасан. Үүний дагуу "Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт" аудитын шалгалт хийлгэх зардлыг шийдвэрлэж өгөх тухай хүсэлтийг хүргүүлээд байна. | 70 | |
| 27 | 33 | Хөрс хамгаалах өдөртэй болох тухай<br>2017-05-24<br>Дугаар 2017_149 | 3.. Энэ тогтоолын 2 дугаар зүйлд заасан арга хэмжээг улсын болон тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж, жил бүрийн 12 дугаар сард нэгтгэн дүгнэж байхыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, Эрүүл мэндийн сайд А.Цогцэцэг, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ж.Батсуурь, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. | Жил бүрийн 5 дугаар сарын эхний 7 хоногийн Бямба гарагийг "Хөрс хамгаалах үндэсний өдөр" болгон тэмдэглэн өнгөрүүлэх бөгөөд АМГТГ-тай хамтран зохион байгуулан ажиллаж байна. | 100 хяналтаас хасуулах | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 28 | 34 | "Эрдэнэс Монгол" ХХК болон түүний охин компанийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2017-05-30 Дугаар 2017_154 | 1.. "Эрдэнэс Монгол" ХХК-ийн үйл ажиллагааг сайжруулж, Оюутолгой, Тавантолгой зэрэг стратегийн ач холбогдол бүхий ордын үр ашгийг иргэн бүрт хүртээмжтэй болгох зорилгоор "Эрдэнэс Монгол" ХХК-ийн дүрэм болон стратегийг шинэчлэн боловсруулж батлуулах, шаардалгтай бол холбогдох зарим хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулан шийдвэрдүүлэх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, "Эрдэнэс Монгол" ХХК-ийн ТУЗ /Б.Даажамба/-д даалгасугай. | "Эрдэнэс Монгол" ХХК-ийн үйл ажиллагааг сайжруулж, Оюутолгой, Тавантолгой зэрэг стратегийн ач холбогдол бүхий ордын үр ашгийг иргэн бүрд хүртээмжтэй болгох зорилгоор "Эрдэнэс Монгол" ХХК-ийн дүрэм болон стратегийг шинэчлэн боловсруулж батлуулах, шаардлагатай бол холбогдох зарим хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Зам тээврийн яам, Эрчим хүчний яам, Үндэсний хөгжлийн газар, Эрдэнэс Монгол ХХК, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК, Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн төлөөллийг оролцуулан байгуулаад байна.<br>Ажлын хэсэг нь "Эрдэнэс Монгол" компанийн үйл ажиллагааны цар хүрээг өргөжүүлэх, уул уурхайг дагасан дэд бүтцийн бүтээн байгуулалтын болон нэмүү өртөг шингэсэн боловсруулах үйлдвэрлэлийн төслийг хөгжүүлэх чиглэлээр дунд хугацааны стратеги, үйл ажиллгааны төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж батлуулах, үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий Дэд ажлын хэсгийг байгуулж ажиллуулсан байна. Эрхлэх асуудлын хүрээнд төрийн өмчит "Эрдэнэс Тавантолгой" ХХК нь Засгийн газрын хэрэг эрхлэх газрын шууд харъяаны "Эрдэнэс Монгол" компанид хамаардаг байсан билээ. Засгийн газрын 2018 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийг УУХҮЯ-ны мэдэлд шилжүүлэхээр шийдвэрлэсэн. Тус яаманд Эрдэнэс Тавантолгой ХК-иас уг компанийн 15 жилийн стратеги, төлөвлөгөөг боловсруулж, 2019 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 01/2706 тоот | 100 /хяналтаас хасуулах саналтай/ | |
| 29 | 35 | Хэрлэн гол дээр урсацын тохируулга хийх төслийн тухай 2017-08-17 Дугаар 2017_232 | 1.. Өмнийн говьд байгуулагдах томоохон бүтээн байгуулалт, үйлдвэрлэл, дэд бүтцийн болон бусад төслүүдийн усан хангамжийн асуудлыг шийдвэрлэх "Хэрлэн гол дээр урсацын тохируулга хийх төсөл"-ийг хэрэгжүүлэхэд шаардагдах техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийлгэх ажлыг шуурхай зохион байгуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж нарт даалгасугай. | "Хэрлэн гол дээр урсацын тохируулга хийх төсөл"-ийн техник эдийн засгийн үндэслэл болон байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийхэд шаардагдах санхүүжилтийг шийдвэрлүүлэх асуудлаар 2019 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр "Санал хүргүүлэх тухай" 01/2473 тоот албан тоотыг Сангийн яаманд хүргүүлсэн. Мөн уг төслийн ТЭЗҮ болон БОНБҮ хийлгэхэд шаардлагатай санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр зөвлөлдөх уулзалт, ярилцлагыг салбарын мэргэжилтнүүд, компаниудын төлөөлөл болон Байгаль орчин аялал жуулчлалын яамны Газар зохион байгуулалт, усны нэгдсэн бодлого зохицуулалтын газрын дарга Ш.Мягмар, тус яамны ТЗУГ-ын дарга, СТБГ-ын дарга, ГУУБХЗГ-ын дарга, УУХ-ын дарга, ХҮГТБХЗГ-ын дарга, ХҮХ-ийн дарга, мэргэжилтнүүдийг оролцуулан 2019.11.15-ны өдөр зохион байгуулсан бөгөөд уулзалт ярилцлагаас гарсан саналын дагуу санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх санал боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхээр ЗГ-ын тогтоолын төсөл, танилцуулга боловсруулан ажиллаж байна./Хэрэгжилт-70 хувь/ | 70 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 30 | 36 | Хэрлэн гол дээр урсацын тохируулга хийх төслийн тухай<br>2017-08-17<br>Дугаар 2017_232 | 1,. Өмнийн говьд байгуулагдах томоохон бүтээн байгуулалт, үйлдвэрлэл, дэд бүтцийн болон бусад төслүүдийн усан хангамжийн асуудлыг шийдвэрлэх "Хэрлэн гол дээр урсацын тохируулга хийх төсөл"-ийг хэрэгжүүлэхэд шаардагдах техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийлгэх ажлыг шуурхай зохион байгуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж нарт даалгасугай. | ДАВХАРДСАН | | |
| 31 | 37 | "Эрдэнэт үйлдвэр" хязгаарлагдмал хариуцлагатай компанийг нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлж, нийт хувьцааны тодорхой хэсгийгиргэдэд эзэмшүүлэх тухай<br>2018-01-10<br>Дугаар 2018_10 | 1,. "Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газрыг нээлттэй хувьцаат компани болгон өөрчлөн зохион байгуулах, нийт хувьцааны тодорхой хувийг Монгол Улсын нийт иргэдэд эзэмшүүлэх асуудлыг боловсруулан Засгийн газарт оруулж хэлэлцүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т тус тус даалгасугай. | Эрдэнэт үйлдвэр ХХК 2019 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн Засгийн газрын 90 дүгээр тогтоолоор Төрийн өмчит улсын үйлдвэрийн газар болгохоор шийдвэр гаргасан. Эрдэнэт үйлдвэрийн талаар авах зарим арга хэмжээ болон 2031 он хүртэл хөгжүүлэх үндсэн чиглэлийг 2019 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 224 дүгээр тогтоолоор батлуулсан. Уг тогтоолыг үндэслэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар 2019 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 262 дугаар тогтоолоор "Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ыг 2031 он хүртэл хугацаанд хөгжүүлэх үндсэн чиглэл"-ийг баталсан. | 70 | |
| 32 | 38 | "Гурван тулгуурт хөгжлийн бодлого" батлах тухай<br>2018-02-06<br>Дугаар 2018_19 /42/ | 3,. "Гурван тулгуурт хөгжлийн бодлого"-д тусгасан өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд, бодлогын хэрэгжилтийг уялдуулан зохицуулж, гүйцэтгэлийн явцыг нэгтгэн жил бүрийн I улирал бagтаан Засгийн газарт танилцуулж байхыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатарт тус тус даалгасугай. | Зорилт 1. Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх, дагалдах дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлэх, тусгай зөвшөөрөл эзэмшигч ААН-ийн хувьцааны тодорхой хэсгийг гадаад, дотоодын хөрөнгийн биржээр арилжиж, санхүүжилтийг шийдвэрлэх тухай "Тавантолгойн ордын талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолын төслийг боловсруулж, УИХ-ын 2018 оны 06 дугаар сарын 29-ны өдрийн 73 дугаар тогтоолоор батлуулсан. Уг тогтоолд Улсын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоолын 1 дэх заалтын 2 дахь дэд заалтын "б", "в"-д заасны дагуу стратегийн ач холбогдол бүхий Тавантолгойн нүүрсний ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьцааны 30 хүртэлх хувийг гадаад, дотоодын хөрөнгийн биржээр арилжаалан шаардлагатай хөрөнгө оруулалтыг татсаны үндсэн дээр Тавантолгойн ордын үнэ цэнийг өсгөх талаар шуурхай арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт үүрэг болгосон. Мөн 2019 оны Төсвийн тухай хуульд "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн орлогоос Ирээдүйн өв санд тодорхой хэмжээний хөрөнгийг хуримтлуулж хувьцааны ногдол ашиг олгох талаар тусгагдсан.<br>Зорилт 2. УУХҮЯ, Монголын уул уурхайн үндэсний ассоциацитай хамтран 2019.06.20-ны өдөр "Хариуцлагатай уул уурхайн сайн дурын кодекс"-т нэгтгэх "Хариуцлагаар нэгд" аяныг эхлүүлсэн. Энэхүү санаачлагын зорилго нь Хариуцлагатай уул уурхайн жишиг шаардлага ба үнэлэх аргачлалын хүрээнд талууд хариуцлагатай уул уурхайн сайн жишгүүдийг дэмжих нэвтрүүлэх юм. Аяны нээлтэд Монголын уул уурхайн үндэсний ассоциаци, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, Аспайр Майнинг" ХХК, "Багануур" ХК, "Саусгоби сэндс" ХХК, "Оюу толгой" ХХК, "Терра Энержи" ХХК, "Энержи Ресурс" ХХК-ийн удирдлагууд оролцож | 100 /бодлогын баримт бичигт УУХҮЯ-ны эрхлэх асуудлаар батлагдсан 37 арга хэмжээний хэрэгжилтийг гаргаж холбогдох журмын дагуу тайланг ҮХГ-т хүргүүлэн ажиллаж байна. ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ/ | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 33 | 39 | “Багануур” ХК, “Шивээ-Овоо” ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2018-05-16 Дугаар 2018_132 | 2.. 2018-2020 онд өсөн нэмэгдэж байгаа эрчим хүчний хэрэглээтэй уялдуулан “Багануур” ХК, “Шивээ-Овоо” ХК-ийн үйлдвэрлэлийн найдвартай, хэвийн үйл ажиллагааг тасралтгүй хангах, хүчин чадлыг нэмэгдүүлэх, техник, технологийн шинэчлэл зайлшгүй хийх хөрөнгө оруулалтад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг судлан шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Бат-Эрдэнэ)-д даалгасугай. | Эрчим хүчний сайдын 2018 оны 110 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн хүрээнд Багануур, Шивээ-Овоогийн уурхайн үйлдвэрлэлийн найдвартай, хэвийн үйл ажиллагааг тасралтгүй хангах, хүчин чадлыг нэмэгдүүлэх, техник, технологийн шинэчилэл зайлшгүй хийх хөрөнгө оруулалтад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг судалж, цаашид авах арга хэмжээний талаар холбогдох санал, дүгнэлт боловсруулж, Сангийн яам болон ЗГХЭГ-т хүргүүлсэн. Эрчим хүчний сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд нарын 2019 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 52/A/25 дугаар хамтарсан тушаалаар Шивээ овоогийн уурхайн үйл ажиллагаа, санхүү, эдийн засгийн байдалд үнэлэлт, дүгнэлт өгч, холбогдох санал дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдаж, ажилласан. Мөн Засгийн газрын 2019 оны 10 дугаар сарын 2-ны өдрийн ээлжит хуралдаанд Багануур” ХК, “Шивээ-Овоо” ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2018 оны 132 дугаар тогтоолын хэрэгжилтийг танилцуулж, хуралдааны 42 дугаар тэмдэглэлийг гаргасан. Уг тэмдэглэлийн 1-д Багануур, Шивээ-Овоогийн нүүрсний уурхай, дулааны станц хооронд үүссэн өр, авлагын асуудлыг шийдвэрлэх, уурхай болон дулааны станцын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангахад шаардлагатай байгаа санхүүжилт, эргэлтийн хөрөнгийн зээлийн асуудлаар Хөгжлийн банканд зохих журмын дагуу хандаж шийдвэрлэхийг Эрдэнэс Монгол ХХК-д даалгасан. | 100 /яамны түвшнээс дэмжлэг үзүүлж ажилласан тул хяналтаас хасуулах саналтай/ | |
| | 40 | | 5.. “Багануур” ХК-ийн орд газрын тусгай зөвшөөрөлтэй холбоотойгоор хууль хяналтын байгууллагад хянагдаж байгаа маргаантай асуудлыг эцэслэн шийдвэрлүүлэх чиглэлээр эрчимтэй ажиллаж, тус орд газрын хилийн заагийг шинэчлэн тогтоохыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Х.Хэрлэн нарт даалгасугай. | Багануурын нүүрсний ордын маргаантай байгаа “Алтай Гянт” ХХК-ийн эзэмшиж байсан 12959A лицензтэй талбайд 430.2 сая тонн буюу ордын нийт нөөцийн 53% ногдож байна. Ордын хил заагийг тогтоох ажил Ажлын хэсгийн хүрээнд хийгдсэн. | 100 /яамны түвшнээс дэмжлэг үзүүлж ажилласан тул хяналтаас хасуулах саналтай/ | |
| | 41 | | 2.. “Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгасугай. | Монгол Улсын Засгийн газрын 2018.06.06-ны өдрийн 169 дүгээр тогтоолоор баталсан “Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар 2027 он хүртэл баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019.08.08-ны өдрийн A/163 дугаар тушаалаар баталсан ба хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. /Хэрэгжилт-100%/ | 100 /хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталсан тул хяналтаас хасуулах саналтай/ | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 34 | 42 | Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого батлах тухай 2018-06-06 Дугаар 2018_169 | 3.. "Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого"-ын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээг Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлд, түүнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг улсын болон орон нутгийн төсөвт тусгаж, гадаадын зээл, тусламжид хамруулах, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шийдвэрлэх замаар санхүүжүүлж ажиллахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай. | Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд "Газрын тосны бүтээгдэхүүний чанарын хяналтын тогтолцоог сайжруулж, Евро-5 стандартын шаардлага хангасан газрын тосны бүтээгдэхүүний импортыг нэмэгдүүлэх" заалтыг тусгуулан хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж байна. Тус яамны зүгээс Евро-5 стандартын шаардлага хангасан газрын тосны бүтээгдэхүүний импорт, хэрэглээг нэмэгдүүлэхийг дэмжсэн эрх зүйн орчин бүрдүүлэх чиглэлээр Онцгой албан татварын хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл, Агаарын тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төслийг тус тус боловсруулан СЯ, БОАЖЯ-нд тус тус хүргүүлсэн. Мөн манай улсын газрын тосны бүтээгдэхүүний гол ханган нийлүүлэгч ОХУ-ын Роснефть компанийн төлөөлөлтэй 2019 оны 10 дугаар сард уулзалт зохион байгуулан, Евро-5 стандартын шатахууны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх талаар хэлэлцсэн ба энэ талаарх албан бичгийг тус компанид явуулсан. /Хэрэгжилт-20%/ | 100 /2019 оны ЭЗНХҮЧ-д Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн хүрээнд хийгдэх дэд бүтцийн ажлын явц, Евро-5 стандартын шаардлага хангасан шатахууны нэмэгдэх хувь хэмжээний саналыг оруулж батлуулан ажиллаж байна. Хяналтаас хасуулах саналтай/ | |
| 35 | 43 | Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийг эрчимжүүлэх тухай 2018-08-08 Дугаар 2018_242 | 6.. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийг хэрэгжүүлэх "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн төрд ногдохоос бусад хувьд хөрөнгө оруулах этгээдийг урьдчилгаа төлбөр, боомт ашиглалт, дамжуулан тээвэрлэлт хийх боломжтой гадаадын хөрөнгө оруулагч нараас судлан, хэлэлцээ хийж, үр дүнг 2018 онд багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт даалгасугай. | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Эрдэнэс Тавантолгой ХК иуд хамтран Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийг хэрэгжүүлэх "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн төрд ногдох хэсэгт хөрөнгө оруулалтын хувь хэмжээг тохиролцож, Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 304 дүгээр тогтоолоор батлуулсан болно. | 100 /тогтоолын хэрэгжилт хангагдсан тул хяналтаас хасуулах саналтай/ | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 36 | 44 | “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай<br>2018-08-08<br>Дугаар 2018_245 | 1.. Тавантолгойн нүүрсний ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьцааны 30 хүртэлх хувийг гадаад, дотоодын хөрөнгийн биржээр үе шаттайгаар арилжаалахтай холбогдсон бэлтгэл ажлыг хангахад шаардагдах мэргэжлийн өндөр ур чадвар, туршлага, техник, технологи шаардсан үйлчилгээг үзүүлэх чадвартай гүйцэтгэгчийн тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу шуурхай зохион байгуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт, холбогдох гэрээг байгуулан хэрэгжүүлж ажиллахыг “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх захирал Б.Ганхуяг нарт тус тус даалгасугай. | Улсын Их Хурлын 2019 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн чуулганы хуралдаанаар батлагсан Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 10 дахь хэсэгт “Засгийн газар, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дотоодын болон олон улсын санхүүгийн зах зээл дээр үнэт цаас гаргах, арилжаалах, олон улсын зах зээл, банк, санхүүгийн байгууллагаас арилжааны нөхцөлтэй зээл авахтай холбоотой үйлчилгээ худалдан авах харилцааг энэ хуулиар зохицуулахгүй” гэж тусган батлуулсан.<br>Энэхүү хуулийн зохицуулалт 2019 оны 6 дугаар сарын 01_ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлнэ.<br>Мөн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын болон Компаний гүйцэтгэх захирлын тушаалаар ажлын хэсэг, компанийн бүтцэд хувьцаа (IPO) хариуцсан газар, нэгжийг байгуулан ажиллаж байна.<br>Хувьцаа (IPO) гадаад зах зээлд арилжих хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Үүнд:<br>•Тавантолгойн ордын өргөтгөсөн нөөцийн нэгтгэл тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, бүртгүүлсэн байна. Энэхүү нөөцийн нэгтгэл тайлангаар Тавантолгойн ордын нүүрсний нөөцийг 300 сая тонноор нэмэгдүүлсэн болно. Нэмэгдэж батлагдсан нөөцөд тулгуурлан ордыг иж бүрэн ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж эхлээд байна.<br>•Засгийн газрын 2018 оны 242 дугаар тогтоолоор Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замыг ажлыг эрчимжүүлэх үүрэг бүхий Төрийн өмчийн тавин нэгээс доошгүй хувийн оролцоотой “Таван толгой төмөр зам” ХХК-ийг байгуулсан болно.<br>•Засгийн Газрын 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн | 70 | |
| 37 | 45 | Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах зарим талбайн солбицол батлах тухай<br>2018-10-03<br>Дугаар 2018_301 | 3.. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгасугай. | “Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх төсөл”-ийн Багц 3 буюу Хашаатын даваа-Толбо нуур чиглэлийн 60км хатуу хучилттай автозамын барилгын ажлын үед замын далан, гүүр болон бусад туслах материалаар ашиглах түгээмэл тархацтай ашигт малтмал болох дайрганы чулуу, элс шавар зэрэг ашигт малтмалыг ашиглах талбайн хил заагийг энэхүү тогтоолоор зааж өгсөн байна. Энэхүү замын барилгын ажилд дээрх талбайгаас түгээмэл тархацтай ашигт малтмалуудыг ашиглаж буй бөгөөд 2018 оны жилийн эцсийн байдлаар замын ажлын гүйцэтгэл 56%-тай, байна. Урьдчилсан байдлаар Хашаатын даваа-Толбо нуур чиглэлийн 60 км хатуу хучилттай авто замыг 2019 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр Улсын комисс хүлээн авсан. | 100 /яамны зүгээс дэмжлэг үзүүлж ажилласан тул хяналтаас хасуулах санaлтай/ | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 38 | 46 | Газрын тосны бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэх тухай<br>2018-10-24<br>Дугаар 2018_322 | 2.. Энэ тогтоолын хавсралтад заасан газрын тосны бүтээгдэхүүний компаний нөөцийг 2019 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн дотор бүрдүүлэх арга хэмжээ авч, нөөцийн бүрдүүлэлт, бүтээгдэхүүний чанарт хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д. Сумъяабазар, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Х.Хэрлэн нарт даалгасугай. | Засгийн газрын 2018 оны 322 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж, компанийн нөөц бүрдүүлэх үүрэг хүлээсэн аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулж, нөөцийн бүрдүүлэлтэд хяналт тавьж ажиллах чиглэлийг АМГТГ-т хүргүүлсэн. АМГТГ нь 2019.01.29-ний өдөр тус тогтоолын жагсаалтад хамрагдсан газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөл эзэмшигч нэр бүхий 26 аж ахуйн нэгжтэй 116,5 мянган тонн газрын тосны бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэх талаар гэрээг байгуулж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. 2019 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар улсын хэмжээнд дунджаар газрын тосны бүтээгдэхүүний ердийн хэрэглээний 26 хоногийн нөөцтэй байгаа бөгөөд үүнээс А-80 автобензин 47, Аи-92 автобензин 28, дизелийн түлш 23, ТС-1 онгоцны түлш 19 хоногийн нөөцтэй байна. /Хэрэгжилт 100%/ | 100 /тогтоолын уг заалт нь нэг удаагийн үйлчлэлтэй, заагдсан хугацаанд нөөц бүрдүүлэлт, чанарт хяналт тавьж ажиллан 2020 онд компанийн нөөц бүрдүүлэх тухай ЗГ-ын 2019 оны 11 сарын 19-ний 409 дүгээр тогтоолыг батлуулсан тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ./ | |
| | 47 | | 3.. Газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий тосоор найдвартай хангах асуудлаар холбогдох байгууллага, компанитай уулзалт, хэлэлцээр хийж, шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Х.Хэрлэн нарт үүрэг болгосугай. | Дорноговь аймгийн Алтанширээ суманд баригдах газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий тосоор хангах асуудлын хүрээнд АМГТГ-аас ажлын хэсэг байгуулан газрын тосны ашиглалт, олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа "Петрочайна Дачин Тамсаг" ХХК болон "Доншен газрын тос (Монгол)" ХХК-тай 2 удаагийн уулзалт зохион байгуулж, уг асуудлыг шийдвэрлэн ажиллаж байна. /Хэрэгжилт-80%/ | 70 | |
| | 48 | | 4.. Газрын тос боловсруулах үйлдвэрийн түүхий тос дамжуулах хоолойн техник, технологийн шийдлийг сонгох, санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх талаар санал боловсруулж танилцуулахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт даалгасугай. | Ерөнхий сайдын 2019 оны 118 дугаар захирамжаар газрын тос боловсруулах үйлдвэрт шаардлагатай дотоодын түүхий тосыг тээвэрлэх дэд бүтцийн оновчтой хувилбарыг тодорхойлох, шаардлагатай тооцоо судалгааг хий, техник технологийн шийдэл, хөрөнгө оруулалтын талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Энэхүү захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг гурван удаа хуралдаж, үйлдвэрт шаардлагатай түүхий эдийг тээвэрлэх дэд бүтцийн боломжит хувилбаруудын талаар мэдээ мэдээлэл, тооцоо судалгаа, хөрөнгө оруулалт, техник технологийн шийдлийг тодорхойлох зорилгоор холбогдох байгууллагуудаас баримт материалуудыг цуглуулсан. Ажлын хэсгийн зүгээс их хэмжээний түүхий тосыг хол зайд тээвэрлэхэд тохиромжтой дэд бүтцийн хувилбар болох төмөр зам болон дамжуулах хоолойн тээвэрлэлтийг манай нөхцөлд тохирох боломжтой гэж үзэн эдийн засгийн үр ашгийн харьцуулсан судалгааг Монголын логистикийн холбоо ТББ-аар хийж гүйцэтгүүлэн тайланг Засгийн газрын 2019.12.18-ний өдрийн хуралдаанаар танилцуулж холбогдох шийдвэрийг гаргуулаад байна. | 100 /ажлын хэсэг байгуулж санал дүгнэлтийг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэр гаргуулсан тул хяналтаас хасуулах саналтай/ | |

| | | | |
|---|---|---|---|
| 39 | 49 | Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай<br>2018-10-24<br>Дугаар 2018_323 | 5.. Бүгд Найрамдах Энэтхэг Улсын хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлэх “Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төслийн менежментийн зөвлөх компанийг сонгон шалгаруулах ажлыг эрчимжүүлж, төслийн үе шатны ажлуудыг шуурхай зохион байгуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгасугай. |

| | | |
|---|---|---|
| Төслийн менежментийн зөвлөх компаниар шалгарсан Энэтхэгийн “Инженерс Индиа Лимитэд” төрийн өмчит компани болон “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК нар зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээг 2019.05.13-ны өдөр байгуулсан. Төслийн менежментийн зөвлөх “Инженерс Индиа Лимитэд” компанитай газрын тос боловсруулах үйлдвэрийн инженерчлэл, ерөнхий зураг төслийн үндсэн өгөгдлүүдийг тохиролцох, зөвлөх үйлчилгээний ажлыг эхлүүлэх уулзалтыг 2019.06.08-14-ний өдрүүдэд Энэтхэг улсын Нью Дели хотод зохион байгуулж, төслийн менежментийн багтай танилцаж, төслийн дараагийн шатны ажлуудыг төлөвлөсөн. Үүнд: Үйлдвэрийн технологийн болон дагалдах байгууламжуудын байршил, хүчин чадал, иргэний барилга, шугам хоолойн трасс, бамбарын систем, ногоон бүс, зам талбай, хашаа хамгаалалт бүхий үйлдвэрийн ерөнхий дэвсгэр зургийг эцэслэн баталж, технологи, техникийн нөхцөлүүд, талбайд хийгдэх нарийвчилсан судалгаа, ус хангамжийн системийн талаар санал солилцож, төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөөг урьдчилсан байдлаар тохиролцсон. - Энгийн болон вакуум нэрлэгийн байгууламжийн зураг төслийн үндэслэлийн Хэсэг “А”-г хянаж, баталсан. - Зураг төслийн үндэслэлийн Хэсэг “Б”-г батлахаар ажиллаж байна. - Үйлдвэрийн талбайд баригдах захиргаа, сургалт, аюулгүй ажиллагааны барилга байгууламжууд, агуулах, засврын цех, гал команд, ажилчдын хоолны газрын хэмжээ, барих материал, байрлах ажилчдын тоог тохиролцсон. - Үйлдвэрийн төлөвлөлтийн ажлын үе шат ахих тусам судалгааны ажлын түвшин нэмэгдэж байгаатай холбогдуулан үйлдвэрийн талбайд хийгдэх геотехникийн болон геофизикийн судалгааны ажлын даалгаврыг “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК боловсруулж Зөвлөх | 100 /зөвлөх компанийг шалгаруулсан, төслийн үе шатны ажлуудыг зохион байгуулан ажиллав/ | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 50 | | 6.. Үйлдвэрийн байршил хүртэлх дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын явц, гүйцэтгэл, зээлийн хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т, төсөл хэрэгжүүлэгч компанийг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт тус тус даалгасугай. | Засгийн газрын 2018.01.03-ны өдрийн "Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 02 дугаар тогтоолоор боловсруулах үйлдвэрийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг Монгол Улсын Хөгжлийн банкны зээлээр санхүүжүүлж, төмөр зам, автозам, цахилгаан дамжуулах агаарын шугам, үйлдвэрийн талбайн газар шорооны ажлуудыг 2018 оны эхний хагас жилд багтаан эхлүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Зам, тээвэр хөгжлийн сайд, Эрчим хүчний сайд, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт даалгасан. Үйлдвэр байгуулахад шаардлагатай гаднах дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлууд болох "Сайншанд-Газрын тос боловсруулах үйлдвэр" чиглэлийн 27 км салаа төмөр зам, 18.2 км цахилгаан хангамжийн 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, 110/10 кВ-ын 6.3 МВ-ын суурилагдсан хүчин чадал бүхий дэд станц болон 16.63 км хатуу хучилттай автозам барих төслүүдийн барилга угсралтын ажлыг энд Дорноговь аймгийн Алтанширээ суманд нэг жилийн өмнө буюу 2018 оны 6 дугаар сарын 22-ны өдөр эхлүүлж байсан. Эдгээр бүтээн байгуулалтыг Батлан хамгаалах яам, Барилга, хот байгуулалтын яам, "Улаанбаатар төмөр зам" ХХН, "Цахилгааны дамжуулах үндэсний сүлжээ" ТӨХК зэрэг байгууллагууд амжилттай гүйцэтгэж, төлөвлөсөн хугацаандаа улсын комисст хүлээлгэн өгч ашиглалтад оруулаад байна. "Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл"-ийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад зориулан "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК болон Монгол Улсын Хөгжлийн банк хооронд ирээдүйд бий болох хөрөнгийг барьцаалан буцаан төлөх нөхцөлтэйгөөр 2018.04.13-ны өдрийн БГ-МГТ-ИХ 2018-44 дугаар "Барьцааны гэрээ" болон мөн өдрийн ЗГ-МГТ-3 2018-43 | 100 /дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын явцад байнгын хяналт тавьж, дэд бүтцийн байгууламжуудыг байнгын ашиглалтанд хүлээн авсан тул хяналтаас хасуулах саналтай/ | |
| 40 | 51 | Гадаадаас 2019 онд авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тогтоох тухай<br>2018-12-12<br>Дугаар 2017_377 | 3.. Аж ахуйн нэгж, байгууллагын гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтнийг эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамруулж байхыг ажил олгогчид, үзлэгийг зохион байгуулахыг Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэлд үүрэг болгосугай. | Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.6 дахь заалтын дагуу гадаадаас ажиллах хүч оруулж ирэх хүсэлт ирүүлсэн нийт 64 ААН-ийн нийт 81 удаагийн хүсэлтийг, холбогдох материалын хамт судлан БНХАУ, Австрали, ХБНГУ, ӨАБНУ, БНЭУ, Канад, Финлянд, Их Британи, Япон, зэрэг Улс орноос нийт 2517 хүнийг түр хугацаанд Монгол Улсад хөдөлмөр эрхлүүлэх талаар санал боловсруулж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газарт уламжилсан. | 100 /УУХҮЯ-ны зүгээс холбогдох арга хэмжээг авсан ба, үзлэгийг зохион байгуулах чиг үүрэг тус яаманд хамааралгүй тул хяналтаас хасуулах саналтай/ | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 41 | 52 | 2019 оныг “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил” болгох тухай 2019-01-16 Дугаар 2019_23 | 3. Хавсралтаар төлөвлөгөөг оруулав.. “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг эрхлэх ажлын хүрээ, харьяа нутаг дэвсгэртээ зохион байгуулж, ажлын тайланг улирал тутам Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлж байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. Жич: Хавсралтаар оруулсан “ИРГЭН ТӨВТЭЙ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖИЛ”-ИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-ний дагуу өөрийн нэр заасан ажлыг хүснэгтээр гаргаж тайлагнана. | "Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил" болгох тухай Засгийн газрын 2019 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан 20 арга хэмжээний биелэлтийг холбогдох нэгжүүдээс гаргуулан улирал бүр ЗГХЭГ-т хүргүүлж, ХЭГ-ын unelgee.gov.mn сайтад байршуулж ажиллав. | 100 /тогтоолын үйлчлэлийн хугацаа дуусгавар болсон тул хяналтаас хасуулах саналтай/ | |
| 42 | 53 | Дүрэм батлах тухай 2019-01-23 Дугаар 2019_33 | 2.. Байгууллагын дотоод журмыг энэ тогтоолоор баталсан дүрэмд нийцүүлэн баталж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг төсвийн шууд захирагч нарт даалгасугай. | УУХҮЯ-ны ТНБД-ын 2016 оны Б/52 дугаар тушаалаар баталсан хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг 2019 оны А/12 тушаалаар байгуулан 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөх төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга болон түүнд үндэслэн гарсан бусад шийдвэртэй уялдуулж 2019.08.30-ны өдрийн А/144 дүгээр тушаалаар батлуулсан бөгөөд 2019.12.20-ны өдрийн А/218 дугаар тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулав. | 100 /дүрэмд нийцүүлэн дотоод журмыг батлан хэрэгжүүлж байгаа тул хяналтаас хасуулах саналтай/ | |
| 43 | 54 | 2019 оныг “Эх оронч худалдан авалтын жил” болгох тухай 2019-01-30 Дугаар 2019_59 | 3.. Энэ тогтоолын 2 дугаар зүйлд заасан төлөвлөгөөнд тусгасан ажлын хүрээнд нарийвчилсан төлөвлөгөө гаргаж, эрхэлсэн салбар, харьяа нутаг дэвсгэртээ хэрэгжилтийг зохион байгуулж, тайланг хагас болон жилийн эцсийн байдлаар Аж үйлдвэржилтийн бодлогын зөвлөлд хүргүүлэхийг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгосугай. | Тогтоолын 2 дугаар зүйлд заасан төлөвлөгөөнд тусгасан ажлын хүрээнд нарийвчилсан төлөвлөгөөг УУХҮ-ийн сайдын 2019.03.17-ны өдрийн А/123 дугаар тушаалаар батлуулж харьяа байгууллагуудад хүргүүлэн, төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас жил, III улирлын байдлаар гаргаж ЗГХЭГ-т тайлагнасан. | 100 /тогтоолын хэрэгжилтийг хангаж ажилласан, тогтоолын үйлчлэлийн хугацаа дуусгавар болсон тул хяналтаас хасуулах саналтай/ | |
| 44 | 55 | Төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай 2019-03-21 Дугаар 2019_111 | 2.. Бүх шатны төсвийн байгууллага, төрийн буюу орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг тогтоосон хувь хэмжээгээр ажиллуулах, ажиллуулаагүй тохиолдолд зохих төлбөрийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлэх арга хэмжээ авч ажиллахыг төсвийн шууд захирагч нарт үүрэг болгосугай. | МУ-ын Ерөнхийлөгчийн 128 дугаар зарлигийн дагуу бичил уурхай дахь хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийг таслан зогсоох, хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор УУХҮСайдын “Хүний эрх, хүүхдийн эрхийг хамгаалах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжиж ажиллах тухай” 2018 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 06 тоот албан даалгаврыг 2018 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 03/3384 тоот албан бичгээр орон нутгийн Засаг дарга, холбогдох газар нэгж, агентлаг болон салбарын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ААНБ-уудад хүргүүлсэн. Албан даалгаврын хэрэгжилтийг хангах зорилгоор ГУУХҮ-ийн салбарын нийгмийн зөвшлийн 2019-2020 оны хамт /тариф/- ын хэлэлцээрийн 2.12 дахь заалтад “Аж ахуйн нэгж бүр Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр заалтыг хэрэгжүүлж ажиллуулна” гэсэн заалтыг нэмж тусган баталгаажуулж ХНХЯ-наас 2019 оны 04 дүгээр сарын 04ний өдөр бүртгэсэн. | 70 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 45 | 56 | Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын талаар авах зарим арга хэмжээний тухай 2019-03-21 Дугаар 2019_112 | 3.. Авто замын барилгын ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох асуудлыг зохих журмын дагуу Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт үүрэг болгосугай. | Түгээмэл тархацтай ашигт малмалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, Засгийн газрын 2014 оны 222 дугаар тогтоолоор баталсан "Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах тусгай журам"-ын 1.3.2, 1.4-т заасныг тус тус үндэслэн тус яамнаас Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт олгох хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжих Гачууртын уулзвараас Налайх Чойрын уулзвар хүртэлх 20.9 км авто замын өргөтгөл, шинэчлэлт, Азийн хөгжлийн банк, Европын сэргээн босголт, хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар хэрэгжих Улаанбаатар-Дархан чиглэлийн 202.4 км авто замын өргөтгөл, шинэчлэлтийн бүтээн байгуулалтын ажилд тус тус шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлуудыг Засгийн газрын хуралдааны 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 184 дүгээр тогтоолоор батлуулсан.<br>Энэхүү 2 чиглэлийн авто замын бүтээн байгуулалтын ажилд шаардлагатай түгээмэл тархацтай ашигт малтмалын борлуулалтын үнэлгээг 1000 төгрөг, нөөц ашигласны төлбөрийг холбогдох хуулийн дагуу 2.5%-аар тооцож төлбөр авахаар зохицуулсан.<br>Тогтоол батлагдсантай холбогдуулан Гачууртын уулзвараас Налайх Чойрын уулзвар хүртлэх 20.9 км авто замын бүтээн байгуулалтад ашиглах 3 карьер, Дарханы чиглэлд хийгдэх бүтээн байгуулалтын ажилд ашиглах 8 карьерын байршлыг тогтоосон. Мөн бүтээн байгуулалтын ажилд шаардлагатай түгээмэл тархацтай ашигт малтмалын талбай нэмэх саналыг ЗТХЯ-аас ирүүлснийг судалж Засгийн газрын тогтоолд нэмэлт оруулсан. | 100 /яамны зүгээс дэмжлэг үзүүлж ажилласан тул хяналтаас хасуулах саналтай/ | |
| 46 | 57 | Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2019-04-03 Дугаар 2019_129 | 1.. Монгол Улсад газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийн хүрээнд үйлдвэрийн ажилчдыг орон сууцаар хангах зорилгоор Дорноговь аймгийн Сайншанд хотын нутаг дэвсгэрт барих 550 айлын орон сууцны хотхоны бүтээн байгуулалтын ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Батлан хамгаалахын сайд Н.Энхболд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг нарт даалгасугай. | Хотхон нь 550 айлын орон сууц, оффис-үйлчилгээний цогцолбор болон ногоон байгууламжаас бүрдэхээр төлөвлөж байгаа бөгөөд уг төслийг хэрэгжүүлэхэд зориулж Дорноговь аймгийн Сайншанд суманд 8,4 мегаваттын цахилгаан станц болон цэвэр, бохир усны шугам сүлжээнд холбогдсон 11 га газрыг "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-нд 15 жилийн хугацаатайгаар эзэмшүүлэх тухай А/206 тоот захирамжийг Дорноговь аймгийн Засаг дарга 2019.02.20-ны өдөр гаргасан ба хотхоны бүтээн байгуулалтын ажлыг 2019 оны 4 дүгээр улирал эхлүүлээд байна. | 100 /холбогдох арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн тул хяналтаас хасуулах саналтай/ | |
| | 58 | | 2.. Хотхоны бүтээн байгуулалтад шаардагдах бараа материал, тоног төхөөрөмжийг татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг боловсруулж 2019 оны 5 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт даалгасугай. | Хотхоны өртөг зардлыг бууруулах зорилгоор тус хотхоныг барьж байгуулахад шаардагдах дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй, импортоор оруулж ирэх бараа, материалыг гаалийн албан татвар болон нэмэгдсэн өртгийн албан татвараас хөнгөлөх тухай хуулийн төсөд, хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулан УУХҮ-ийн сайд, ХЗДХ-ийн сайд, Сангийн сайд нараар батлуулан, УИХ-ын холбогдох Байнгын хороодоор хэлэлцүүлэн, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, 2019.11.30-ны өдрийн Улсын Их Хурлын нэгдсэн чуулганы хуралдаанаар хэлэлцэн соёрхон баталсан. | 100 /хууль батлагдсан тул хяналтаас хасуулах саналтай/ | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 59 | | 4.. Хотхоны бүтээн байгуулалтын ажлыг 2019 оны эхний хагас жилд багтаан эхлүүлж, ажлын явц, үр дүнгийн талаар Засгийн газарт улирал тутам танилцуулж байхыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг, орон нутгийн зүгээс шаардлагатай дэмжлэг үзүүлэхийг Дорноговь аймгийн Засаг дарга Т.Энхтүвшин нарт тус тус даалгасугай. | ЗГ-ын 2019.06.05-ны өдрийн 25 дугаар тэмдэглэл гарч Дорноговь аймгийн Сайншанд суманд байгуулах ажилчдын хотхоны барилгын зураг төслийг хэсэгчлэн батлуулах, туслан гүйцэтгэгч байгууллагыг сонгон гэрээ байгуулж, хотхоны бүтээн байгуулалтын ажлыг шуурхай эхлүүлэх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Батлан хамгаалахын сайд, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал нарт даалгасан. ЗГ-аас өгсөн чиглэлийн дагуу барилгын зураг төсөл болон барилга угсралтын ажлыг гүйцэтгэх компанийг сонгон шалгаруулсан бөгөөд зураг төслийн ажлыг 2019 оны 6 дугаар сард багтаан хэсэгчлэн батлуулж, батлагдсан зураг төслийн дагуу газар шороо, суурийн ажлыг хийж гүйцэтгээд байна. | 100 /бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлсэн тул хяналтаас хасуулах саналтай/ | |
| | 60 | | 2.. “Монголын төмөр зам” ТӨХК-ийн гаргасан үнэт цаасыг нэрлэсэн үнээр нь, нүүрс тээвэрлэлтийн төлбөрөөс суутгах зэрэг эргэн төлөх нөхцөлөөр Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн 2018 оны үйл ажиллагааны хуримтлагдсан ашгаас худалдан авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (М.Баяраа)-д даалгасугай. | “Монголын төмөр зам” ТӨХК-ийн гаргасан үнэт цаасыг нэрлэсэн үнээр нь худалдан авах урьдчилгааны хүрээнд “Эрдэнэс Тавантолгой” ХК-иас өнөөгийн байдлаар нийт 156.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг “Монголын төмөр зам” ТӨХК-д олгоод байна. Төслийн урьдчилсан санхүүжилтийг яаралтай шийдвэрлэсний үр дүнд тус чиглэлийн 414.6 км төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг 2019 оны 05 дугаар сарын 24-ний өдөр эхлүүлсэн бөгөөд Зэвсэгт хүчний дугаар ангийн бие бүрэлдэхүүн болон “Монголын төмөр зам” ТӨХК-ийн инженер, техникийн ажилчид бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэж байна. | 100 /уг заалтын хэрэгжилт бүрэн хангагдсан тул хяналтаас хасуулах саналтай/ | |
| 47 | 61 | Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай<br>2019-04-10<br>Дугаар 2019_135 | 3.. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төсөлд шаардагдах хөрөнгийн үлдэгдэл санхүүжилтийг Монголбанкны дэмжлэгээр бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх асуудлыг судалж, шийдвэрлэхийг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт даалгаж, Монголбанкны ерөнхийлөгч Н.Баяртсайханд зөвлөсүгэй. | Засгийн газрын 2019 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 135 дугаар тогтоолоор Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн ТЭЗҮ-д тулгуурлан шаардагдах хөрөнгийн эх үүсврийг шийдвэрлэх зорилгоор нэг удаагийн, хүүгүй урт хугацаатай 750 тэрбум төгрөгийн үнэт цаасыг нэрлэсэн үнээр, хаалттай хүрээнд худалдахаар шийдвэрлэсэн. Тогтоолын дагуу Монголын төмөр зам ТӨХК-ийн гаргасан үнэт цаасыг нэрлэсэн үнээр нь нүүрс тээвэрлэлтийн төлбөрөөс суутгах замаар эргэн төлөх нөхцөлөөр “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн цэвэр ашгаас худалдан авах, үлдэгдэл санхүүжилтийг Монгол банкны дэмжлэгээр бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх асуудлыг шийдвэрлэхээр тусгасан.<br>“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн хувьд тогтоолоор өгөгдсөн үүрэг даалгаврын дагуу “Монголын төмөр зам” ТӨХК-аас гаргах үнэт цаасыг худалдах, худалдан авах гэрээний нөхцөл, холбогдох шаардлагыг тохиролцохоор ажиллаж байгаа ба гэрээний төслийг эцэслэх ажил явагдаж байна. | 70 | |
| | 62 | | 4.. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг холбогдох хууль тогтоомж, олон улсын стандарт, чанарын шаардлагад нийцүүлэн барьж байгуулах ажлыг зохион байгуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Батлан хамгаалахын сайд Н.Энхболд нарт үүрэг болгосугай. | “Эрдэнэс Тавантолгой” ХК-иас өнөөгийн байдлаар нийт 156.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг “Монголын төмөр зам” ТӨХК-д олгосны дүнд тус чиглэлийн 414.6 км төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг 2019 оны 05 дугаар сарын 24-ний өдөр эхлүүлсэн бөгөөд Зэвсэгт хүчний дугаар ангийн бие бүрэлдэхүүн болон “Монголын төмөр зам” ТӨХК-ийн инженер, техникийн ажилчид бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэж байна. | 100 /уг заалтын хэрэгжилт бүрэн хангагдсан тул хяналтаас хасуулах саналтай/ | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 48 | 63 | Төслийн нэгж байгуулах тухай<br>2019-05-01<br>Дугаар 2019_176 | 1.. Газрын ховор элементийн хайгуул, олборлолт, ашиглалтын эрх зүйн орчинг боловсронгуй болгох, нөөц нь бүртгэгдсэн ордын эдийн засгийн үр ашгийн тооцоог гүйцэтгэх, тэдгээрийг өндөр хөгжилтэй орнуудтай хамтран ашиглаж эдийн засгийн эргэлтэд оруулах үүрэг бүхий төслийн нэгжийг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгасугай. | "Эрдэнэс Монгол" ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 05 дугаар сарын 10 өдрийн 16 дугаар Газрын ховор элементийн геологи хайгуул, ашиглалтын талаарх эрх зүйн орчныг боловсронгуй болгох, нөөц бүхий ордуудын төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоох, геологи хайгуул, ашиглалт боловсруулалтын талаар нарийвчилсан судалгаа хийх, эдийн засгийн үр ашгийг тооцох, арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулах чиг үүрэг бүхий төслийн нэгжийг "Эрдэнэс Монгол" ХХК-ийн харъяанд байгуулан үйл ажиллагаа эхлүүлээд байна. | 100 /төслийн нэгжийг байгуулсан тул хяналтаас хасуулах саналтай/ | |
| | 64 | | 3.. Төслийн нэгжийг 5 жилийн хугацаатай ажиллуулж, үр дүнгийн тайланг тухайн жилийн 12 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулж байхыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, "Эрдэнэс Монгол" ХХК (П.Ганхүү)-д даалгасугай. | "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн ТУЗ-ын тогтоолоор байгуулан холбогдох ажлыг зохион байгуулж байна. | /-/ хэрэгжилт тооцох хугацаа болоогүй | |
| 49 | 65 | Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах эрх олгох тухай<br>2019-05-01<br>Дугаар 2019_184 | 4.. Авто зам, замын байгууламжийн барилгын ажил гүйцэтгэх хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу зохих дэмжлэг үзүүлж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт даалгасугай. | Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт олгох хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжих Гачууртын уулзвараас Налайх-Чойрын уулзвар хүртэлх 20.9 км авто замын өргөтгөл, шинэчлэлтийн барилгын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах талбайн солбицлын төслийг боловсруулж, 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 184 дүгээр тогтоолоор батлуулсан. | 100 /тусгай зөвшөөрлийг олгосон, тогтоолын хэрэгжилтийг хангасан тул хяналтаас хасуулах | |
| 50 | 66 | Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн талаар авах арга хэмжээний тухай<br>2019-05-12<br>Дугаар 2019_188 | 2.. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн бүтээн байгуулалтын ажилд шаардагдах ус, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрөөс чөлөөлөх асуудлыг судалж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат нарт даалгасугай. | Монгол Улсын Засгийн Газраас 2019 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр "Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 135 дугаар тогтоолын дагуу Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших Тавантолгойн нүүрсний ордоос Дорноговь аймгийн Зүүнбаян өртөө хүртэл нийт 414.6 км Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн эргэлтийн цэг, солбицлын төслийг боловсруулж, 2019 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 189 дүгээр тогтоолоор батлуулсан. Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайг төмөр замын гол тэнхлэгээс 2 тийш 20 км байхаар тооцсон. Энэ 40 км-ийн радиус доторх түгээмэл тархацтай ашигт малтмалыг ашиглах тохиолдолд борлуулалтын үнэлгээ, нөөц ашигласны төлбөрийг хөнгөлөх асуудлыг Өмнөговь аймгийн ИТХТ-ийн 8-р сарын 07-ны өдрийн 117, Дорноговь аймгийн ИТХТ-ийн 6-р сарын 51-р тогтоолоор хөнгөлүүлсэн. | 100 /тусгай зөвшөөрлийг олгосон, тогтоолын хэрэгжилтийг хангасан тул хяналтаас хасуулах саналтай/ | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 51 | 67 | Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн эргэлтийн цэг, солбицол батлах тухай 2019-05-12 Дугаар 2019_189 | 3.. Төмөр замын суурь бүтцийн барилгын ажил гүйцэтгэх хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу зохих дэмжлэг үзүүлж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт даалгасугай. | Монгол Улсын Засгийн Газраас 2019 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр "Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 135 дугаар тогтоолын дагуу Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших Тавантолгойн нүүрсний ордоос Дорноговь аймгийн Зүүнбаян өртөө хүртэл нийт 414.6 км Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн эргэлтийн цэг, солбицлын төслийг боловсруулж, 2019 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 189 дүгээр тогтоолоор батлуулсан. | 100 / холбогдох шийдвэрийг гаргуулж зохих дэмжлэгийг үзүүлсэн тул хяналтаас хасуулах саналтаай/ | |
| 52 | 68 | Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай 2019-07-03 Дугаар 2017_276 | 3.. Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоосонтой холбогдон гарч болзошгүй нэмэлт зардлыг 2019 оны хувьд батлагдсан төсөвт багтааж, цаашид жил бүрийн улсын төсвийн төсөлд тооцон тусгаж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. | Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай Засгийн газрын 2019 оны 276 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн ажиллаж байна. УУХҮЯ-нд төрийн үйлчилгээний нийт 9 ажилтан ажиллаж байна. ТНБД-ын 2019 оны 9 сарын 26-ны өдрийн А/157 дугаар тушаалын гуравдугаар хавсралтаар шинэчлэн батлав. | 100 /тогтоолын хэрэгжилтийг хангасан тул хяналтаас хасуулах саналтай/ | |
| 53 | 69 | Төв, суурин газрын 2019-2020 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай 2019-07-03 Дугаар 2019_270 | 3.. "Багануур" ХК, "Шивээ-Овоо" ХК, "Шарын гол" ХК-ийн үйлдвэрлэлийн найдвартай ажиллагааг хангах, дизелийн түлш, шатахууны нөөц бүрдүүлэн уурхайн хөрс хуулалт, их засварын ажлыг хугацаанд нь хийж, нүүрсний бэлэн нөөцийг хэвийн хэмжээнд байлгах, аваар ослын үед хэрэглэх техник, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн нөөц бүрдүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, "Эрдэнэс Монгол" ХХК (П.Ганхүү)-д тус тус даалгасугай. | УУХҮЯ-ны ТНбД-ын 2019 оны А/139 дүгээр тушаалаар өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах, шаардагдах нөөцийг бүрдүүлэх үүрэг бүхий ажлыг хэсгийг байгуулж, ажлын хэсэг газар дээр нь ажиллаж дүнг сайдад танилцуулж ажиллав. | 100 /тогтоол нь нэг удаагийн үйлчлэлтэй батлагдсан ба холбогдох арга хэмжээг авч ажиллсан байна./ | |
| | 70 | | 7.. Сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийн түүхий эд (мидлинг)-ийг үйлдвэрийн хашаанд 300.000 тонн, Төв аймаг дахь дундын агуулахад 700.000 тонныг татан төвлөрүүлж, нөөц бүрдүүлэх, сайжруулсан шахмал түлшний бэлэн бүтээгдэхүүн 200.000 тонныг үйлдвэрлэн бэлэн болгох арга хэмжээ авахыг Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн, Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, "Эрдэнэс-Тавантолгой" ХК (Б.Ганхуяг)-д тус тус даалгасугай. | Сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийн түүхий эдийг, төвлөрүүлж, нөөцийг бүрдүүлэн ажилласан. | 100 /тогтоол нь нэг удаагийн үйлчлэлтэй батлагдсан ба холбогдох арга хэмжээг авч ажиллсан байна./ | |
| 54 | 71 | Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай 2019-07-03 Дугаар 2019_275 | 2.. Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалтыг баталсантай холбогдон гарч болзошгүй нэмэлт зардлыг 2019 оны хувьд батлагдсан төсөвт багтааж, цаашид жил бүрийн улсын төсвийн төсөлд тооцон тусгаж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. | Тогтоолын хэрэгжилтийг ханган, ТНБД-ын 2019 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн А/157 тоот тушааалыг батлуулан Төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээг шинэчлэн тогтоосон. Нэмэлт зардлыг 2019 оны хувьд батлагдсан төсөвт багтааж, цаашид жил бүрийн улсын төсвийн төсөлд тооцон тусгаж байхаар шийдвэрлэсэн. | 100 /тогтоолын хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан тул хяналтаас хасуулах саналтлай/ | |
| 55 | 72 | Төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээг шинэчлэн тогтоох тухай 2019-07-03 Дугаар 2019_277 | 2.. Төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээг шинэчлэн тогтооход шаардагдах зардлыг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны батлагдсан төсөвт багтаан зохицуулж, цаашид шаардагдах зардлыг 2020 оноос эхлэн жил бүрийн улсын төсөвт тусгаж байхыг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. | Тогтоолын хэрэгжилтийг хангаң, ТНБД-ын 2019 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн А/157 тоот тушааалыг батлууланТөрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээг шинэчлэн тогтоосон. | 100 /тогтоолын хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан тул хяналтаас хасуулах саналтлай/ | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 56 | 73 | Газрын тос боловсруулах үйлдвэрийн ус хангамжийн талаар 2019-07-03 Дугаар 2019_284 | 1.. Газрын тос боловсруулах үйлдвэрийн технологийн болон унд, ахуйн хэрэгцээнд шаардлагатай 106 л/с усыг Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт орших Бор хөөврийн говийн газрын доорх усны ордоос хангах асуудлыг судалж шийдвэрлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт даалгасугай. | Газрын тос боловсруулах үйлдвэрийн технологийн болон унд, ахуйн хэрэгцээнд шаардлагатай 106 л/с усыг Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт орших Бор хөөврийн говийн газрын доорх усны ордоос хангах асуудлыг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд усны нөөцийн зөвлөлөөр яаралтай хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах талаар саналыг БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга буюу Усны нөөцийн зөвлөлийн дарга Ц.Цэнгэлд 2019.09.07-ны өдрийн 03/2543 дугаар Санал хүргүүлэх тухай албан бичгээр хүргүүлсэн. Албан бичгийн хариуд Газрын тос боловсруулах үйлдвэрийн технологийн болон унд ахуйн хэрэгцээнд 106 л/с усыг Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт орших бор хөөврийн говийн газрын доорх усны ордоос хангах асуудлыг шийдвэрлэсэн Засгийн газрын тогтоол, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллаж, Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4 дэх заалтын дагуу ус ашиглуулах дүгнэлтийг "Монгол Ус" ТӨААТҮГ-аар гаргуулж, Умард говийн гүвээт Халхын дунд талын сав газрын захиргаанаас зөвшөөрөл авч, гэрээ байгуулан ажиллахыг зөвлөсөн зөвлөмжийг Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас 2019.09.23-ны өдрийн 03/6576 дугаар албан бичгээр ирүүлснийг "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-нд 2019.10.07-ны өдрийн 03/2803 дугаар албан бичгээр хүргүүлсэн. | 100 /тогтоолын хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан/ | |
| | 74 | | 1.. 1. "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн иргэд, аж ахуйн нэгжийн эзэмшиж байгаа хувьцааны хоёрдахь зах зээлийн арилжааг хөрөнгийн бирж дээр үе шаттайгаар эхлүүлэхтэй холбогдуулан дараахь ажлыг зохион байгуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг нарт даалгаж, дэмжлэг үзүүлж ажиллахыг Санхүүгийн зохицуулах хороо (С.Даваасүрэн)-нд зөвлөсүгэй:<br><br>1.1. "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн хувьцааны өөрчлөлтийг холбогдох хууль тогтоомж, анхан шатны баримтад тулгуурлан хянаж, нягтлах ажлыг зохион байгуулж, хувьцаа эзэмшиж байгаа иргэдийн бүртгэлийг 2019 оны 12 дугаар сарын эхний 7 хоногт багтаан дуусгаж, үр дүнг танилцуулах;<br><br>1.2. "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн иргэд, аж ахуйн нэгжийн эзэмшиж байгаа хувьцааг гадаад улсын хөрөнгийн биржид давхар бүртгүүлэх, арилжаалах бэлтгэл ажлыг хангуулах. | 1.1.2018 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн ҮЦТХТ-өөс ирсэн 03/2358 тоот албан бичиг дээр бүртгэлийн ажлыг гүйцэтгэж байгаа ба Нийгмийн халамж үйлчилгээний ерөнхий газраас хишиг хувь хүртсэн нийт 984,196 иргэдийн мэдээллийг хүлээн авсан байна. 1 294 302 иргэн нийт 386 416 192 хувьцаагаа зарж, тэдгээр хувьцааг төрийн мэдэлд шилжүүлсэн. "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн нийт 15 000 000 000 ширхэг хувьцаанаас 2018 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар хувьцааны эзэмшлийн бүртгэлд Төрийн мэдэлд-85.20%, 486 аж ахуйн нэгжүүдэд-0,05%, 2 511 332 Монгол улсын иргэдэд- 14.75% хувьцаа байна.<br>1.2.Хувьцааг олон нийтэд санал болгоход хийх гүйцэтгэх шаардлагатай бэлтгэл ажлуудын жагсаалт, тэдгээрийн агуулга, ажлын цар хүрээний талаар ерөнхий мэдээлэл авах зорилгоор "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн холбогдох албан тушаалтнууд Лондон, Хонконгийн хөрөнгийн биржийн удирдлагуудтай уулзалт хийж, хөрөнгийн биржид арилжаа эхлүүлэхэд шаардагдах бэлтгэл ажлын талаар мэдээлэл авсан. | 70 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 57 | 75 | “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай<br>2019-07-09<br>Дугаар 2019_296 | 2.. 2. Тавантолгой нүүрсний ордын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувьцааг зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан гадаад улсын хөрөнгийн биржээр арилжаалахтай холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (А.Ариунболд)-т тус тус даалгасугай:<br>2.1. Олон улсын хөрөнгийн зах зээлээс боломжит богино хугацаанд хамгийн бага зардлаар хөрөнгө босгох зорилгоор холбогдох хууль тогтоомж, олон улсын стандарт, шаардлагад нийцүүлэн “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн охин компаниудыг байгуулах;<br>2.2. Тавантолгой нүүрсний ордын үнэ цэнийг цаашид үе шаттайгаар нэмэгдүүлэх зорилгоор “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн эзэмшлийн тусгай зөвшөөрлүүдээс эхний ээлжинд МҮ-011943 дугаар бүхий Цанхийн зүүн хэсгийн ашиглалтын тусгай зөвшөөрлийг “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн охин компанид эзэмшүүлэх;<br>2.3. “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн охин компанийн хувьцааны 30 хүртэлх хувийг гадаад улсын хөрөнгийн биржээр дамжуулан хөрөнгө оруулагчдад санал болгох, 70 буюу түүнээс доошгүй хувийг “Эрдэнэс-Тавантолгой” ХК эзэмшиж байхаар зохион байгуулах;<br>2.4. Гадаад улсын хөрөнгийн биржээр хувьцаа арилжаалах үйл ажиллагааг богино хугацаанд зохион байгуулах, түүнтэй холбогдсон татвар, зардлын хэмжээг хамгийн бага байлгах чиглэлээр зохих арга хэмжээ авч ажиллах. | 2.Хувьцааг олон нийтэд санал болгоход хийх гүйцэтгэх шаардлагатай бэлтгэл ажлуудын жагсаалт, тэдгээрийн агуулга, ажлын цар хүрээний талаар ерөнхий мэдээлэл авах зорилгоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн холбогдох албан тушаалтнууд Лондон, Хонконгийн хөрөнгийн биржийн удирдлагуудтай уулзалт хийж, хөрөнгийн биржид арилжаа эхлүүлэхэд шаардагдах бэлтгэл ажлын талаар мэдээлэл авсан. 2.1.ЭТТ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019.07.30-ны өдрийн 28 тоот тогтоолоор тус компанийн 100 хувийн охин компани “Эрдэнэс-Тавантолгой Майнинг” ХХК-ийг үүсгэн байгуулах, дүрмийг баталж зохих журмын дагуу бүртгүүлсэн.<br>2.2.ЭТТ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019.07.30-ны өдрийн 29 тоот тогтоолоор охин компани үүсгэн байгуулсантай холбоотойгоор толгой, охин компаниудын үйл ажиллагааны хүрээг зааглан тогтоох, толгой компаниас охин компанид эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх /тусгай зөвшөөрөл/ шилжүүлэх, компанийн баланс хуваах бэлтгэл ажлыг хангуулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж удирдамжийг баталсан.<br>2.3.Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019.02.25-ны өдрийн 05 тоот тогтоолоор “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн НОГДОЛ АШГИЙН ЖУРАМ” –ыг баталсан. Компанийн 2019 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах эсэх шийдвэрийг Компанийн тухай хуулийн 46.5-д заасны дагуу санхүүгийн жил дуусcанаас хойш 50 хоногийн дотор буюу 2020.02.19-ний өдөр дотор ТУЗ хэлэлцэн шийдвэрлэнэ. | 70 | |
| | 76 | | 3.. Тавантолгой нүүрсний ордын үнэ цэнэ, дэд бүтцийн холбогдох төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, улс орны нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл зэргийг харгалзан “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн ногдол ашгийн бодлогыг баталж, компанийн 2019 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах чиглэлийг баримталж ажиллахыг “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (М.Баяраа)-д зөвлөсүгэй. | Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019.02.25-ны өдрийн 05 тоот тогтоолоор “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн НОГДОЛ АШГИЙН ЖУРАМ” –ыг баталсан. Компанийн 2019 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах эсэх шийдвэрийг Компанийн тухай хуулийн 46.5-д заасны дагуу санхүүгийн жил дуусcанаас хойш 50 хоногийн дотор буюу 2020.02.19-ний өдөр дотор ТУЗ хэлэлцэн шийдвэрлэнэ. | 70 | |
| | 77 | | 4.. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийн явц байдлыг Засгийн газар, Улсын Их Хуралд танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (А.Ариунболд)-т тус тус үүрэг болгосугай. | Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019.02.25-ны өдрийн 05 тоот тогтоолоор “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн НОГДОЛ АШГИЙН ЖУРАМ” –ыг баталсан. Компанийн 2019 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах эсэх шийдвэрийг Компанийн тухай хуулийн 46.5-д заасны дагуу санхүүгийн жил дуусcанаас хойш 50 хоногийн дотор буюу 2020.02.19-ний өдөр дотор ТУЗ хэлэлцэн шийдвэрлэнэ. | 30 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 58 | 78 | Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай<br>2019-07-24<br>Дугаар 2019_304 | 1.. Засгийн газрын 2018 оны 8 дугаар сарын 8-ны өдрийн 242 дугаар тогтоолоор байгуулагдсан “Тавантолгой төмөр зам” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцааны 66 хувийг “Эрдэнэс-Тавантолгой” ХК-д, 34 хувийг “Монголын төмөр зам” ТӨХК-д тус тус эзэмшүүлэх, холбогдох журмын дагуу бүртгүүлэх арга хэмжээ авахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (А.Ариунболд)-т тус тус даалгасугай. | Компанийн зүгээс тогтоолын дагуу “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн 66 хувийг “ЭТТ” ХК эзэмших чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:<br><br>• 19.07.30-нд ЭТТ ХК-ийн ТУЗ хуралдаж 31 дугаар тогтоол гарган гэрээ хэлцэл байгуулахыг зөвшөөрсөн;<br>• 19.08.13-нд ЭТТ ХК-ийн ТУЗ хуралдаж 36 дугаар тогтоол гарган “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хуралд компанийг төлөөлөх этгээдийг томилж /Т.Цогтбаяр/, холбогдох удирдамжийг хавсралтаар баталсан;<br>• Мөн дээрх тогтоолоор төслийн үйл ажиллагааг цаг алдалгүй эхлүүлэх зорилгоор “Тавантолгой төмөр зам” ХХК-д 15 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор шийдвэрлэсэн.<br>• 19.08.15-нд ЭТТ ХК-ийн ТУЗ хуралдаж 41 дүгээр тогтоол гарган “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн ТУЗ-д нэр дэвшигчдийг баталсан;<br>• 19.08.15-нд “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн ХЭХурал болж компанийн дүрэм болон ТУЗ гишүүдийг хэлэлцэж шийдвэрлэсэн. | 100 /Хяналтаас хасуулах саналтай/ | |
| | 79 | | 2.. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барьж байгуулах, ашиглахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг техник, эдийн засгийн үндэслэлд заасан дүнгээр нүүрс урьдчилан борлуулах замаар болон бусад эх үүсвэрээр санхүүжүүлэх арга хэмжээ авахыг “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (М.Баяраа)-д зөвшөөрч, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (А.Ариунболд)-т даалгасугай. | “ЭТТ” ХК-иас гүйцэтгэх захирлын 2019.08.29-ны өдрийн А/438 тоот тушаалаар Засгийн газрын 304 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хэсгийг “МТЗ” ТӨХК-ийн төлөөллийг оролцуулан байгуулсан. Тус тушаалаар ажлын хэсэгт “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн дараах хүмүүс орсон. Үүнд:<br><br>• Стратеги, хөгжлийн газар хариуцсан дэд захирал Т.Цогтбаяр, Ажлын хэсгийн дарга<br>• Үнэт цаас бүртгэлийн хэлтсийн ахлах шинжээч С.Тулгаа, нарийн бичиг<br>• Бизнес төлөвлөлт, инновацийн хэлтсийн дарга С.Ашидмөнх<br>• Хууль зүйн хэрэгжилт, зохицуулалтын хэлтсийн дарга М.Батбаяр<br>• Эдийн засаг, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга М.Гэрэл<br>• Төслийн удирдлагын хэлтсийн ахлах шинжээч Ц.Анх-Од | 70 | |
| | 80 | | 4.. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийн барилгын ажлыг 2019 оны 8 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн үргэлжлүүлж, 2021 онд ашиглалтад оруулах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт үүрэг болгосугай. | Ажлын хэсгийн бүрэлдэхүүн хэд хэдэн удаа уулзалт зохион байгуулсны үр дүнд “Монголын төмөр зам” ТӨХК болон “Эрдэнэс-Тавантолгой” ХК-иуд “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн гэрээг 19.09.07-ны өдөр байгуулсан. | 70 | |
| | 81 | | 6.. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, ажлын явц, үр дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулж байхыг Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт даалгасугай. | Одоогоор “Эрдэнэс-Тавантолгой” ХК-иас төслийн санхүүжилтийг шийдвэрлэхээр ажиллаж байна | 30 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 59 | 82 | Дүрэм батлах тухай<br>2019-08-07<br>Дугаар 2019_313 | 2.. Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, хэрэгжилтэд хяналт тавихыг Монгол Улсын Шадар сайд Ө.Энхтүвшинд тус тус үүрэг болгосугай.<br>*Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм* | Хэрэгжилтийг зохион байгуулах ажлын хүрээнд цагдаа, тагнуул, онцгой байдал, мэргэжлийн хяналт, зэвсэгт хүчний жанжин штаб болон мэргэжлийн холбоодтой хамтран ажиллаж байна. | 100 | |
| 60 | 83 | Үндэсний хөтөлбөр батлах тухай<br>2019-08-14<br>Дугаар 2019_317<br>*Алтны бичил уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй мөнгөн усны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр* | 2.. Хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгаж, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжид хамруулах замаар санхүүжүүлж хэрэгжүүлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн сайд Д.Сумъяабазар, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. | Алтны бичил уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй мөнгөн усны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний төслийг боловсруулан Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын хамтарсан тушаалаар батлуулахаар Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас 2019.12.31-ний өдрийн 01/9186 тоот албан бичгийг илгээд байгааг судалж байна. | 70 | |
| | 84 | | 3.. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хамтран баталж, хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн I улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт тус тус даалгасугай. | Алтны бичил уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй мөнгөн усны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний төслийг боловсруулан Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын хамтарсан тушаалаар батлуулахаар Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас 2019.12.31-ний өдрийн 01/9186 тоот албан бичгийг илгээд байгааг судалж байна. | /-/ хэрэгжилт тооцох хугацаа болоогүй | |
| 61 | 85 | Байгалийн нөөц газрын хилийн заагийг тогтоох тухай<br>2019-08-14<br>Дугаар 2019_319 | 3.. Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутаг дэвсгэрт орших Тост, Тосон бумбын нуруу орчмын нутаг дэвсгэрийг бүхэлд нь улсын тусгай хамгаалалтад авах асуудлыг судлан 2019 оны IY улиралд багтаан Засгийн газарт танилцуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумьяабазар нарт тус тус даалгасугай. | Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутаг дэвсгэрт орших Тост, Тосон бумбын нуруу орчмын нутаг дэвсгэрийг бүхэлд нь улсын тусгай хамгаалалтад авах асуудлыг судлан Тост, тосон бумын Байгалийн нөөц газрын хилийн заагийг 153469 га талбайгаар нэмэгдүүлж, талбайн хэмжээ нийт 896540,37 га талбайтай болсон. Тус хилийн заагийг Байгаль орчны мэдээллийн төвийн мэдээллийн сан /www.eic.mn/ -нд бүртгэж авсан. | 100 /хяналтаас хасуулах саналтай/ | |
| 62 | 86 | Журам батлах тухай<br>2019-09-04<br>Дугаар 2019_342<br>*Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг тооцох, төлбөр ногдуулах, тайлагнах, төлөх журам"-ыг 1 дүгээр хавсралт, "Гадаадын зах зээлд борлуулсан нүүрс, төмрийн хүдэр, төмрийн хүдрийн баяжмалд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулах борлуулалтын үнэлгээ тооцох журам* | 3.. Энэ тогтоолыг мөрдөж ажиллахыг Татварын ерөнхий газар (Б.Заяабал), Гаалийн ерөнхий газар (Б.Асралт), Ашигт малтмал, газрын тосны газар (Х.Хэрлэн), Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Н.Цагаанхүү)-т, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт тус тус үүрэг болгосугай. | Журмын хэрэгжилтийг хангах хүрээнд Сангийн сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд нарын 2018.07.27-ны өдрийн 200/А/177 дугаар хамтарсан тушаалаар Гадаадын зах зээлд борлуулсан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг тогтоох олон улсын зах зээлийн үнийг тогтоох ажлын хэсгийг байгуулан ажиллаж, сар бүрийн 10-ны өдрийн дотор жишиг үнийг тогтоож, нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулан, журмын хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллав. | 100 /журмыг асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд хамтран баталсан тул хяналтаас хасуулах саналтай/ | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 63 | 87 | Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай<br>2019-09-18<br>Дугаар 2019_355 | 1.. 1.2. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох талаар тогтоосон журмыг зөрчиж олборлолт явуулсан талбайд Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжид заасан журмын дагуу нөхөн сэргээлтийг хийлгэж, талбайг хүлээн авахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар болон аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт; | Байгаль орчин, аялал жуулчлалын сайдаар ахлуулсан ажлын хэсэг 2019 оны 9 дүгээр сарын 17 болон 12 дугаар сарын 17-ны өдрүүдэд сард Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт хяналт шалгалт хийж хууль бусаар алт олборлож байсан үйл ажиллагааг таслан зогоох арга хэмжээг авч зөрчил гаргасан 48 үйлдэлд хамаарах зарим иргэн, аж ахуйн нэгжийг цагдаагийн байгууллагад шилжүүлсэн болно. Уг ажлын хэсэгт Уул Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар зэрэг байгууллагуудын төлөөлөл ажилласан болно. | 70 | |
| | 88 | | 1.. 1.4. Бичил уурхайгаар ашигт малтмал хууль бусаар олборлоход ашигласан болон ашиглахаар бэлтгэсэн техник, тоног төхөөрөмжийг талбайгаас гаргаж, харуул хамгаалалт зохион байгуулах, холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг олон нийтэд сурталчлан таниулах арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Цагдаагийн ерөнхий газар (С.Баатаржав), Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Н.Цагаанхүү) болон аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нар нарт; | Байгаль орчин, аялал жуулчлалын сайдаар ахлуулсан ажлын хэсэг 2019 оны 9 дүгээр сарын 17 болон 12 дугаар сарын 17-ны өдрүүдэд сард Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт хяналт шалгалт хийж хууль бусаар алт олборлож байсан үйл ажиллагааг таслан зогоох арга хэмжээг авч зөрчил гаргасан 48 үйлдэлд хамаарах зарим иргэн, аж ахуйн нэгжийг цагдаагийн байгууллагад шилжүүлсэн болно. Уг ажлын хэсэгт Уул Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар зэрэг байгууллагуудын төлөөлөл ажилласан болно.<br>Ажлын хэсэг 12 дугаар сарын 17-ны өдөр Сэлэнгэ аймгийн Баянгол, Ерөө сумын нутагт хяналт, шалгалт хийж, шалгалтын мөрөөр хууль бусаар алт олборлох зорилгоор ашиглаж байгаа болон ашиглахаар ууланд, ойд нуусан байгаа техникийг албадан буулгах ажлыг зохион байгуулах, алт олборлох зориулалтаар ашигладаг том оврын техник, тээврийн хэрэгслийн бүртгэлийн гэрчилгээ шалгаж бүртгэлгүй тохиолдолд нэвтрүүлэхгүй байх арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг аймгийн удирдлага, холбогдох албан тушаалтан нарт үүрэг болгосон. Ажлын хэсгээс хууль бусаар алт олборлох үйл ажиллагааг таслан зогсоох, холбогдох арга хэмжээг газар дээр нь хэрэгжүүлэх зорилгоор Сэлэнгэ аймагт 10 ажлын хэсэг 1 сарын хугацаатай ажиллуулахаар төлөвлөн холбогдох зардлыг Засгийн газрын 2019 оны 341 дүгээр тогтоолоор батлагдсаныг 2020 онд шилжүүлэх тухай Засгийн газрын шийдвэрийн төслийг бэлтгэсэн болно. | 100 | |
| | 89 | | 1.. 1.6. Бичил уурхайн зориулалтаар ашигт малтмал олборлох дүгнэлтийг 2019 оныг дуусталх хугацаанд гаргахгүй байхыг Ашигт малтмал, газрын тосны газар (Х.Хэрлэн)-т, | Тогтоолын хэрэгжилтийг хханган ажилласан. | 100 /Хяналтаас хасуулах саналтай/ | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 90 | | 2.. Энэ тогтоолын 1.2 болон 1.5-д заасныг хэрэгжүүлэхэд шаардагдах үйл ажиллагааны зарим зардлыг Засгийн газрын нөөц сангаас гаргахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, уг зардлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар болон аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт; | Засгийн газрын 2019 оны 341 дүгээр тогтоолын дагуу тусгай зөвшөөрөл цуцалсан талбайн байгаль орчны хохирлыг барагдуулах, нөхөн сэргээлтийг албадан хийлгэх, хяналт хамгаалалтыг хэрэгжүүлэхэд 3 сарын хугацаанд нийт 767,3 сая төгрөгийн санхүүжилт зарцуулсан. Харин хууль бусаар алт олборлох үйл ажиллагааг таслан зогсоох, холбогдох арга хэмжээг газар дээр нь хэрэгжүүлэх зорилгоор Сэлэнгэ аймагт 10 ажлын хэсэг 1 сарын хугацаатай ажиллуулахаар төлөвлөн холбогдох зардлыг Засгийн газрын 2019 оны 341 дүгээр тогтоолоор батлагдсаныг 2020 онд шилжүүлэх тухай саналыг боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулах төслийг боловсруулсан. | 100 | |
| | 91 | | 3.. Энэ тогтоолын 1 дэх заалтад заасны дагуу холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах төслийг боловсруулж 2019 оны IY улиралд багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт үүрэг болгосугай. | Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Улсын Их хурлын гишүүн, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбатын боловсруулсан Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд санал дүгнэлт авах тухай Хууль, зүй дотоод хэргийн сайдаас ирүүлсэн албан бичигт 2019.10.18 ны өдрийн 01/2960 тоотоор хариу хүргүүлсэн. | 100 | |
| 64 | 92 | Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицол батлах тухай<br>2019-10-09<br>Дугаар 2019_377 | 4.. Авто зам, замын байгууламжийн барилгын ажил гүйцэтгэх хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу зохих дэмжлэг үзүүлж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт даалгасугай. | Эрхлэх асуудлын хүрээнд холбогдох дэмжлэгийг тухай бүр үзүүлж, хэрэгжилтийг хангаж, ажилласан. | 100/Хяналтаас хасуулах саналтай/ | |
| | 93 | | 6.. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгасугай. | | 100/Хяналтаас хасуулах саналтай/ | |
| 65 | 94 | Газрын тосны бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэх тухай<br>2019-11-19<br>Дугаар 2019_409 | 2.. Энэ тогтоолын хавсралтад заасан газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөцийг 2020 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн дотор бүрдүүлэх арга хэмжээ авч, нөөцийн бүрдүүлэлт, бүтээгдэхүүний чанарт хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Ашигт малтмал, газрын тосны газар (Х.Хэрлэн)-т тус тус даалгасугай. | Тогтоолын хавсралтад заасан газрын тосны бүтээгдэхүүний 22 компанийн нөөцийг 2020 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн дотор бүрдүүлэх арга хэмжээ авч, нөөцийн бүрдүүлэлт, бүтээгдэхүүний чанарт хяналт тавьж ажиллах талаар чиглэлийг 2019.01.08-ны өдрийн 01/41тоотоор АМГТГ-т хүргүүсэн. АМГТГ-аас 2019.12.31 өдрийн 1/8440 тоотоор нэр бүхий компаниуд нөөц бүрдүүлэх гэрээ байгуулах тухай мэдэгдэл хүргүүлээд байна. | 100 /компанийн нөөц бүрдүүлэх ажлыг зохион байгуулсан тул хяналтаас хасуулах саналтай/ | |
| | | | Ерөнхий сайдын захирамж | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 66 | 95 | Үндэсний зөвлөл, салбар зөвлөлийн бүрэлдэхүүн батлах тухай<br>2014-05-16<br>Дугаар 08_2014_61 | 2. Нээлттэй засгийн түншлэлийн ажлын албаны чиг үүргийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, Үндэсний зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг нарийн бичгийн даргад даалгасугай. | Ерөнхий сайдын 2014 оны 5 дугаар сарын 16 -ны өдрийн 61 дүгээр захирамжаар Нээлттэй засгийн түншлэлийн бодлого, төлөвлөгөөг хэрэгжүүлэх, Монгол Улсын Нээлттэй засгийн түншлэлийн Ажлын албаны ажлыг хянан зохицуулах, нэгтгэн дүгнэх үүрэгтэйгээр байгуулсан бөгөөд Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд 2015 оны 10 дугаар сарын 23-ны өдөр Монгол Улсын Ерөнхий сайдын 207 дугаар захирамжаар өөрчлөлт оруулсан. Одоогоор тус бүрэлдэхүүнд Үндэсний зөвлөлийн даргаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, дэд даргаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга, гишүүдээр Сангийн яам, Хууль зүйн яам, Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга нар, болон Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын ерөнхийлөгч, Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн ерөнхийлөгч, Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын Судалгааны төвийн ерөнхий захирал, Нээлттэй нийгэм хүрээлэнгийн гүйцэтгэх захирал нар, Нарийн бичгийн даргаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт, шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга ажиллаж байна. УУХҮЯ-аас НЗТ-ийн үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө-/2016-2018/-ний биелэлтийг хүргүүлж ажилласан. | 100 /УУХҮЯ-ны зүгээс хамаарах ажлыг хийсэн тул хяналтаас хасуулах саналтай/ | |
| 67 | 96 | Ажлын хэсэг байгуулах тухай"Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр" барьж байгуулах төслийн хөрөнгө оруулагчтай хамтран ажиллах талаар хэлэлцээ хийж, санал, дүгнэлт боловсруулах<br>2016-11-22<br>Дугаар 2016_113 | 2. Ажлын хэсгийн баримтлан ажиллах удирдамжийг хавсралт ёсоор баталж, төслийн хөрөнгө оруулагчтай хэлэлцээ хийж санал, дүгнэлт боловсруулан, дүнг 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор Засгийн газарт танилцуулахыг Ажлын хэсэг (Ц.Дашдорж)-т даалгасугай. | МУ-ын ЗГ-ын 2016.09.28-ны өдрийн 107 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд УУХҮС-ын 2016 оны А/43 дугаар тушаалаар УУХҮЯ-ны дэргэд "Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр барих" төсөл хэрэгжүүлэх нэгж байгуулан ажиллаж Дэлхийн банкны стандарт шаардлагад нийцсэн ТЭЗҮ, БНБОҮ болон БОННБҮ-ний тайлангуудыг боловсруулж бэлэн болгоод байна.<br>УУХҮС-ын зөвлөлийн 2019.1.30-ны өдрийн хуралдааны 02 дугаар шийдвэрийн дагуу "Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр барих" төслийн нэгжийг татан буулгаж чиг үүргийг "Эрдэнэс Монгол" ХХК-д шилжүүлэх тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан Засгийн газрын 2019.12.18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж дэмжигдэн ЗГ-ын 2019 оны 451 дугаар тогтоолыг батлаад байна.<br>Төслийн нэгжийн чиг үүргийг "Эрдэнэс Монгол" ХХК-д шилжүүлснээр тус төслийг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хөрөнгө оруулагчийг сонгох, түүнтэй гэрээ хэлэлцээр хийх, газрын болон бусад холбогдох зөвшөөрлийг авч төслийг хэрэгжүүлэх хууль, эрх зүйн нөхцөл бүрдэх юм. | 100 /Төслийн нэгжийн чиг үүргийг ЗГХЭГ-ын харья "Эрдэнэс Монгол" ХХК-д шилжүүлсэн тул хяналтаас хасуулах/ | Төслийн ТЭЗҮ-д тооцоолсон одоогийн хүчин чадлаар үйлдвэрийг барихад 2.5 тэрбум ам.доллар буюу их хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай байгаа нь хөрөнгө оруулагчдын сонирхолыг татахгүй байгаа тул төслийг үе шаттайгаар хэрэгжүүлж зорилтот хүчин чадалд хүргэх боломжийг судлах зорилгоор батлагдсан ТЭЗҮ д нэмэлт тодотгол хийх, мөн төслийг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх хөрөнгө |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 68 | 97 | Ажлын хэсэг байгуулах тухай<br>2016-11-22<br>Дугаар 2016_113 | 2. Ажлын хэсгийн баримтлан ажиллах удирдамжийг хавсралт ёсоор баталж, төслийн хөрөнгө оруулагчтай хэлэлцээ хийж санал, дүгнэлт боловсруулан, дүнг 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор Засгийн газарт танилцуулахыг Ажлын хэсэг (Ц.Дашдорж)-т даалгасугай. | ДАВХАРДСАН | | |
| 69 | 98 | Ажлын хэсэг байгуулах тухай"Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр" барьж байгуулах төслийн хөрөнгө оруулагчтай хамтран ажиллах талаар хэлэлцээ хийж, санал, дүгнэлт боловсруулах<br>2016-11-22<br>Дугаар 2016_114 | 2. Ажлын хэсгийн баримтлан ажиллах удирдамжийг хавсралт ёсоор баталж, төслийн хөрөнгө оруулагчтай хэлэлцээ хийж санал, дүгнэлт боловсруулан, дүнг 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор Засгийн газарт танилцуулахыг Ажлын хэсэг (Ц.Дашдорж)-т даалгасугай. | Ерөнхий сайдын 2016 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" 114 дүгээр захирамжаар "Зэсийн баяжмал боловсруулах үлйдвэр" барьж байгуулах төслийн хөрөнгө оруулагчтай хамтран ажиллах талаар хэлэлцээ хийж, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг ажиллаж дүгнэлт гаргасан. Үүнд: 1.Хатчийн судалгааны тайлан, салбарын яамнаас ирсэн дүгнэлтийг үндэслэн Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийг Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт барих асуудлыг ЗГ-ын хуралдаанаар оруулж шийдвэрлүүлэх;2.Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн нийт хувьцааны 10-аас доошгүй хувийг хөрөнгө оруулалтын зардал гаргахгүйгээр төр эзэмших тухай УУХҮЯ-ны саналыг ЗГ-ын хуралдаанд оруулж шийдвэрлүүлэх; 3.Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн төслийг хэрэгжүүлэх , хөрөнгө оруулагчтай гэрээ хэлцэл хийх ажлыг эрчимжүүлж үр дүнг 2017 оны II улиралд багтаан Засгийн газарт танилцуулах асуудлыг ЗГ-аас гаргах тогтоолд тусгаж шийдвэрлэх. Ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн ЗГ-ын тогтоолын төслийг боловсруулан зохих журмын дагуу ЗГ-ын 2017.03.15-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эрчимжүүлэх тухай" 88 дугаар тогтоол батлагдан бөгөөд тус тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Түүнчлэн тус үйлдвэрийг байгуулах тухай асуудлыг ҮАБЗ-өөр хэлэлцүүлж, зөвлөмж гарсан бөгөөд ЗГ-ын 2019.05.17-ны өдрийн "Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай" 196 дугаар тогтоолоор ЗГ-ын 2017.09.13-ны өдрийн 247 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт"-д хамруулж нэн чухал асуудлаар анхааран ажиллаж байна. /Хэрэгжилт-100%/ | 100 | |
| 70 | 99 | Ажлын хэсэг байгуулах тухай /Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр/<br>2016-11-22<br>Дугаар 2016_114 | 2. Ажлын хэсгийн баримтлан ажиллах удирдамжийг хавсралт ёсоор баталж, төслийн хөрөнгө оруулагчтай хэлэлцээ хийж санал, дүгнэлт боловсруулан, дүнг 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор Засгийн газарт танилцуулахыг Ажлын хэсэг (Ц.Дашдорж)-т даалгасугай. | ДАВХАРДСАН | | |

| | | | |
|---|---|---|---|
| 71 | 100 | Ажлын хэсэг байгуулах тухай“ Гацууртын алтны үндсэн ордыг ашиглах төсөл”-ийн хөрөнгө оруулагчтай Хөрөнгө оруулалтын гэрээбайгуулах талаар хэлэлцээ хийх үүрэг бүхий<br>2017-01-25<br>Дугаар 2017_20 | 2. Хэлэлцээний үр дүнг эцэслэн тохирсон гэрээний төслийн хамт Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдоржид даалгасугай. |

| | | | |
|---|---|---|---|
| | “Гацууртын ордын төрийн эзэмшлийн хувь тогтоох тухай” Улсын Их Хурлын 2016 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 11 дүгээр тогтоолоор Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутагт орших Гацууртын ордын төрийн эзэмшлийн хэмжээг 34 хувиар тогтоосон. Тус ордын нөөц болон техник, эдийн засгийн үндэслэлд тодотгол хийгдэж байна. ТЭЗҮ-ийг хүлээн авсаны дараа Орд ашиглах гэрээ байгуулах ба уг гэрээгээр ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээг тохирч шийдвэрлэх юм. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны А/28 дугаар тушаалаар Ерөнхий сайдын 2017 оны 01 дугаар сарын 25-ны өдрийн 20, 21 тоот захирамжуудаар байгуулагдсан Ажлын хэсгүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, шаардагдах баримт бичгийн төслийг боловсруулах үүрэг бүхий дэд ажлын хэсгийг байгуулан ажиллуулж байна. Дэд ажлын хэсэг “Орд ашиглах гэрээ”-ний төслийг боловсруулан “Сентеррагоулд Монголия” ХХК-нд 2017 оны 03 дугаар сарын 01-ны өдөр санал авахаар хүргүүлсэн. Мөн Хөрөнгө оруулалтын гэрээний төслийг Үндэсний хөгжлийн газраас байгуулсан Ажлын хэсгийн хүрээнд боловсруулж, “Сентеррагоулд Монголия" ХХК-иас санал авахаар 2017 оны 03 дугаар сарын 30-өдөр хүргүүлсэн. Орд ашиглах болон Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулахаас өмнө “Сентеррагоулд Монголиа" ХХК-иас Гацууртын ордын нөөцийг тодотгож батлуулах, орд ашиглах Техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж батлуулах шаардлагтай байгаа тул хүлээгдэж байна. | /-/ | Шүүхийн маргаантай |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 72 | 101 | Ажлын хэсэг байгуулах тухай /Гацууртын алтны үндсэн ордю 2017-01-25 Дугаар 2017_21 | 2. Хэлэлцээний явц, үр дүн, орд ашиглах гэрээний төслийн талаар тухай бүр Засгийн газарт танилцуулж, гэрээг 2017 оны 3 дугаар сард багтаан байгуулах ажлыг удирдан зохион байгуулахыг Ажлын хэсэг (Ц.Дашдорж)-т даалгасугай. | "Гацууртын ордын төрийн эзэмшлийн хувь тогтоох тухай" Улсын Их Хурлын 2016 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 11 дүгээр тогтоолоор Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутагт орших Гацууртын ордын төрийн эзэмшлийн хэмжээг 34 хувиар тогтоосон. Тус ордын нөөц болон техник, эдийн засгийн үндэслэлд тодотгол хийгдэж байна. ТЭЗҮ-ийг хүлээн авсаны дараа Орд ашиглах гэрээ байгуулах ба уг гэрээгээр ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээг тохирч шийдвэрлэх юм. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны А/28 дугаар тушаалаар Ерөнхий сайдын 2017 оны 01 дугаар сарын 25-ны өдрийн 20, 21 тоот захирамжуудаар байгуулагдсан Ажлын хэсгүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, шаардагдах баримт бичгийн төслийг боловсруулах үүрэг бүхий дэд ажлын хэсгийг байгуулан ажиллуулж байна. Дэд ажлын хэсэг "Орд ашиглах гэрээ"-ний төслийг боловсруулан "Сентеррагоулд Монголиа " ХХК-нд 2017 оны 03 дугаар сарын 01-ны өдөр санал авахаар хүргүүлсэн. Мөн Хөрөнгө оруулалтын гэрээний төслийг Үндэсний хөгжлийн газраас байгуулсан Ажлын хэсгийн хүрээнд боловсруулж, "Сентеррагоулд Монголия" ХХК-иас санал авахаар 2017 оны 03 дугаар сарын 30-өдөр хүргүүлсэн.<br>Орд ашиглах болон Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулахаас өмнө "Сентеррагоулд Монголия" ХХК-иас Гацууртын ордын нөөцийг тодотгож батлуулах, орд ашиглах Техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж батлуулах шаардлагатай байгаа тул хүлээгдэж байна.<br>Мөн Гацууртын алтны ордын тусгай зөвшөөрлийн суудал шүүхээр эцэслэн шийдэгдээгүй учир төслийн үйл ажиллагаа тодорхойгүй хугацаагаар хойшлогдож байна. | /-/ | Шүүхийн маргаантай |
| 73 | 102 | Ажлын хэсэг байгуулах тухай /Стратегийн ач холбогдол бүхий Оюутолгойн зэс-алтны ордын төслийн хэрэгжилттэй холбогдуулан 2011 оны 6 дугаар сарын 8-ны өдөр хөрөнгө оруулагч талтай байгуулсан "Нэмэлт, өөрчлөлт оруулж дахин тодотгосон Хувь нийлүүлэ 2018-02-21 Дугаар 2018_27 | 3.. Оюутолгой төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор Өмнийн говийн хөгжил, дэд бүтцийн асуудлаар дэд ажлын хэсэг байгуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт, эрчим хүчний асуудлаар дэд ажлын хэсгийг байгуулахыг Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэнд тус тус хариуцуулж ажлын явц, үр дүнг тухай бүр танилцуулж байхыг даалгасугай. | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны А/74 дүгээр тушаалаар Өмнийн говийн хөгжил, дэд бүтцийн төлөвлөлтийн төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан. Уг ажлын хэсгээс Өмнийн говийн хөгжил, дэд бүтцийн судалгааг хийх шаардлагатай гэж үзсэн бөгөөд Үндэсний хөгжлийн газрын захиалгаар уг ажлын судалгааны ажил хийгдсэн болно. | 100 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 74 | 103 | Ажлын хэсэг байгуулах тухай /Газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэгч болон газрын тосны бүтээгдэхүүний бөөний, жижиглэнгийн худалдаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдийн бүтээгдэхүүнд чанарын хяналт, шалгалт хийж, дүгнэлт гаргах ажлыг зохион байгуулах, хо 2018-12-10 Дугаар 2018_201 | 2.. Газрын тосны бүтээгдэхүүнд чанарын хяналт, шалгалт хийж, дүгнэлт гаргах асуудлаар дэд ажлын хэсэг байгуулан ажиллуулах, ажлын явцад хяналт тавьж, үр дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулж шийдвэрлүүлэхийг Ажлын хэсэг (Ө.Энхтүвшин)-т даалгасугай. | Монгол Улсын Ерөнхий сайдын 2018.12.10-ны өдрийн 201 дүгээр захирамжийн дагуу Монгол Улсын Шадар Сайдын 2019.02.25-ны өдрийн 14 дүгаар тушаалаар "Монгол Улсын газрын тосны бүтээгдэхүүнд чанарын хяналт, шалгалт хийж, дүгнэлт гаргах" дэд ажлын хэсгийг СЯ, УУХҮЯ, БОАЖЯ, ТЕГ, ГЕГ, ОБЕГ, МХЕГ, АМГТГ, СХЗГ, ЦЕГ, ШӨХТГ, МҮХАҮТ, "Улаанбаатар төмөр зам" ХНН болон Монголын шатахуун эрхлэгчдийн холбооны бүрэлдэхүүнтэй байгуулсан. Ажлын хэсгийн хүрээнд зохион байгуулагдсан 5 удаагийн хуралдаанд тухай бүр оролцож, саналаа ажлын хэсгийн төлөвлөгөөнд тусгуулж, холбогдох мэдээ мэдээллээр хангаж ажилласан. /Хэрэгжилт-100%/ | 100 /яамны зүгээс шаардлагатай мэдээ материалыг хүргүүлж ажилласан тул хяналтаас хасуулах саналтай/ | |
| 75 | 104 | Ажлын хэсэг байгуулах тухай 2019-09-16 Дугаар 2019_118 | 2.. 1. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2014 оны 14/06 дугаар зөвлөмж, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.70 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 323 дугаар тогтоолыг тус тус хэрэгжүүлэх хүрээнд Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт байгуулах "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр"-ийг дотоодын түүхий тосоор хангах, газрын тосны нийлүүлэлтийн дэд бүтцийн оновчтой хувилбарыг тодорхойлох, шаардлагатай тооцоо судалгаа хийх, техник технологийн шийдэл, хөрөнгө оруулалтын талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралт, Ажлын хэсгийн удирдамжийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус батлсугай. 2. Санал, дүгнэлтээ 2019 оны IY улирал багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Ажлын хэсэг (Д.Сумъяабазар)-т даалгасугай. | Энэхүү захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг гурван удаа хуралдаж, үйлдвэрт шаардлагатай түүхий эдийг тээвэрлэх дэд бүтцийн боломжит хувилбаруудын талаар мэдээ мэдээлэл, тооцоо судалгаа, хөрөнгө оруулалт, техник технологийн шийдлийг тодорхойлох зорилгоор холбогдох байгууллагуудаас баримт материалуудыг цуглуулсан. Ажлын хэсгийн зүгээс их хэмжээний түүхий тосыг хол зайд тээвэрлэхэд тохиромжтой дэд бүтцийн хувилбар болох төмөр зам болон дамжуулах хоолойн тээвэрлэлтийг манай нөхцөлд тохирох боломжтой гэж үзэн эдийн засгийн үр ашгийн харьцуулсан судалгааг Монголын логистикийн холбоо ТББ-аар хийж гүйцэтгүүлэн тайланг Засгийн газрын 2019.12.18-ний өдрийн хуралдаанаар танилцуулж 55 дугаар тэмдэглэл гаргуулаад байна. | 100 /ЕС-ын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг санал дүгнэлтээ ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлж холбогдох шийдвэрийг гаргуулсан тул хяналтаас хасуулах саналтай/ | |
| ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 76 | 105 | 2014 оны 10 дугаар сарын 4-ний өдөр 51 дүгээр тэмдэглэл 2014-10-04 Дугаар 2014_51 | XYI. . Газрын хэвлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг зөвшөөрч, холбогдох хуулийн дагуу үзэл баримтлалыг батлуулан хуулийн төслийг боловсруулж танилцуулах өргөтгөсөн ажлын хэсэг гарган ажиллуулахыг Уул уурхайн сайд Д.Ганхуягт даалгав. | 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт энэ асуудал дахин туссанаар Газрын хэвлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны А/209 дугаар тушаалаар шинээр байгуулсан. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд салбарын яамнаас гадна Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яам, Байгаль орчин аялал, жуулчлалын яам, Барилга, хот байгуулалтын яам, Зам тээвэр, хөгжлийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, холбогдох агентлагууд болон төрийн бус байгууллагуудын төлөөллийг хамруулан өргөтгөсөн хэлбэрээр зохион байгуулсан. Ажлын хэсэг нь хууль эрх зүйн орчин, хуулийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгааны ажил хийж байна. Мөн Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам нь Хууль эрх зүй, дотоод хэргийн яаманд хандан Газрын хэвлийн тухай хуулийн давхцал, зөрчил, хийдлийн судалгааг хийлгэсэн. Судалгааг хийсэн хуульчдын багтай хуулийн үйлчлэлийн тухай асуудлаар ажлын уулзалтуудыг удаа хийж, судалгааг дахин хийлгэсэн. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд бүтцийн өөрчлөлт хийгдсэнтэй уялдуулан Ажлын хэсгийг шинээр байгуулах шаардлагатай болсон. Ажлын хэсгийг шинээр байгуулах бэлтгэл ажлыг хийж байна. | 30 | |
| 77 | 106 | 2015 оны 03 дугаар сарын 30-ны өдөр 18 дугаар тэмдэглэл 2015-03-30 Дугаар 2015_18 | XXII.2. . Гацууртын ордын хөрөнгө оруулагчтай хийж байгаа хэлэлцээний явцын талаар Үүнтэй холбогдуулан хэлэлцээг эцэслэх чиглэлээр шуурхай ажиллаж, явц, үр дүнг тухай бүр Засгийн газарт танилцуулж байхыг Уул уурхайн сайд Р.Жигжидэд даалгав. | Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутагт орших Гацууртын алтны үндсэн ордын тусгай зөвшөөрлийг эзэмшигч “Сентеррагоулд Монголиа” ХХК-тай орд ашиглах болон хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах ажлын хэсэг Монгол Улсын Ерөнхий сайдын 2016 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн 26, 2016 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн 43 дугаар захирамжуудаар байгуулагдаж, хөрөнгө оруулагчтай тодорхой түвшинд хэлэлцээр хийж, гэрээний төслийг бэлтгэсэн байдаг. Засгийн газар шинээр эмхлэн байгуулагдсантай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайдын 2017 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 20 болон 21 дүгээр захирамжуудаар шинэ ажлын хэсэг байгуулагдаж, дан Орд ашиглах гэрээ болон хөрөнгө оруулалтын гэрээний төслийг бэлтгэн хөрөнгө оруулагч талд хүргүүлээд байна. Гацууртын үндсэн ордыг ашиглах төслийн хувьд Засгийн газрын зүгээс төрийн эзэмшлийн 34 хувийг Ашигт малтмалын тухай хуульд тусгайлан заасан “ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр”-өөр орлуулах зарчмыг баримтлан ажиллаж байна. Шинэ ажлын хэсгийн хүрээнд бэлтгэсэн гэрээнүүдэд Монгол Улсын нэгдсэн орсон олон улсын гэрээ болон Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд хөрөнгө оруулагчийн эрх ашигийг хамгаалах нөхцөлүүдийг бүрдүүлж оруулж өгөхийн зэрэгцээ төслөөс хүртэх Монголын талын үр өгөөжийг | 30 | Шүүхийн маргаантай |
| 78 | 107 | 2015 оны 05 дугаар сарын 4-ний өдөр 24 дүгээр тэмдэглэл 2015-05-04 Дугаар 2015_24 | XXI. 2. . Гацууртын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Сентерра гоулд Монголиа” ХХК-тай тус ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээний талаар хийж байгаа хэлэлцээний явцын тухай Уул уурхайн сайд Р.Жигжид Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан уг хэлэлцээг 2015 оны 5 дугаар сарын 25-ны дотор дуусгахыг Ажлын хэсэг (Г.Тэмүүлэн)-т даалгав. | | 30 | Шүүхийн маргаантай |
| 79 | 108 | 2016 оны 03 дугаар сарын 28-ний өдөр 18 дугаар тэмдэглэл 2016-03-28 Дугаар 2016_18 | XIX.12. . Гацууртын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй орд ашиглах болон хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах талаар хийж байгаа хэлэлцээний явцын талаар Уул уурхайн сайд Р.Жигжид Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан хэлэлцээг цаашид үргэлжлүүлж, санал зөрүүтэй асуудлуудаар тохиролцсоны үндсэн дээр 2016 оны 4 дүгээр сард багтаан орд ашиглах болон хөрөнгө оруулалтын гэрээ байгуулахыг Ажлын хэсэг (Р.Жигжид)-т даалгав. | | 30 | Шүүхийн маргаантай |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 80 | 109 | 2016 оны 04 дүгээр сарын 18-ний өдөр 22 дугаар тэмдэглэл 2016-04-18 Дугаар 2016_22 | XXYIII.4. . Гацууртын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй орд ашиглах болон хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах талаар хийж байгаа хэлэлцээний явцын талаар Уул уурхайн сайд Р.Жигжид Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан хэлэлцээг цаашид үргэлжлүүлж, 2016 оны 4 дүгээр сард багтаан орд ашиглах болон хөрөнгө оруулалтын гэрээ байгуулахыг Ажлын хэсэг (Р.Жигжид)-т даалгав. | тодорхой хэмжээнд нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох өөрчлөлтүүд орсон болно. Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөс Гацууртын ордын нөөцийг дахин тодотгох шаардлагыг "Сентерра Гоулд Монголиа" ХХК-д тавьсаны дагуу нөөцийг шинэчлэн тодотгох ажлыг хийж байна. үний дараа энэхүү төслийн ТЭЗҮ-ийг шинэчлэн боловсруулах бөгөөд уг ТЭЗҮ-д төслийн хөрөнгө оруулалт болон эдийн засгийн тооцоо өөрчлөгдөж болзошгүй тул Хөрөнгө | /-/ | Шүүхийн маргаантай |
| 81 | 110 | 2016 оны 10 дүгээр сарын 26-ны өдөр 52 дугаар тэмдэглэл 2016-10-26 Дугаар 2016_52 | XIII.1. 2.. хөрөнгө оруулагчид, аж ахуй эрхлэгчдэд төрийн захиргааны болон хуулийн байгууллагаас хууль бусаар дарамт учруулсан, хүнд суртал гаргасан, үндэслэлгүйгээр мөрдөн шалгасан асуудлыг судалж гаргасан дүгнэлтэд тусгагдсан асуудлыг шийдвэрлэх ажлыг шуурхай зохион байгуулж, хөрөнгө оруулагчид, аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагаанд саад учруулж байгаа хууль бус дарамт, шаардлагуудыг арилгаж, хүчингүй болгох арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга нарт. | Хөрөнгө оруулагчид, аж ахуй эрхлэгчдэд төрийн захиргааны болон хуулийн байгууллагаас хууль бусаар дарамт учруулсан, хүнд суртал гаргасан, үндэслэлгүйгээр мөрдөн шалгасан асуудал гарч буй эсэхийг тогтмол судалж байгаа ба дурдсан нөхцөл байдал үүсээгүй болно. | 100 Тэмдэглэлийн үйлчлэлийн хугацаа дуусгавар болсон тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |
| 82 | 111 | 2017 оны 3 дугаар сарын 29-ний өдөр 14 дүгээр тэмдэглэл 2017-03-29 Дугаар 2017_14 | 2. Нисэх онгоцны шинэ буудлыг агаарын хөлгийн ТС-1 болон Жет А-1 төрлийн шатахуунаар хангах хос байгууламжтай болгох, Дорноговь аймгийн Замын-Үүд суманд баригдаж байгаа Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламжид агаарын хөлгийн шатахуун шилжүүлэн ачих технологийн шугамын өргөтгөл хийх замаар Жет А-1 төрлийн шатахуун импортоор оруулах боломжийг бүрдүүлэх асуудлыг судлан хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх саналаа Засгийн газарт танилцуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж нарт даалгав. | Замын-Үүд боомтоор агаарын хөлгийн шатахуун импортлохтой холбоотой асуудлаар АМГТГ-аас 2017 оны 02, 03 дугаар саруудад Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж /ШТШАБ/ ТӨҮГ, Иргэний нисэхийн ерөнхий газар /ИНЕГ/-тай хамтарсан уулзалтуудыг зохион байгуулсан. Эдгээр уулзалтуудаар хэлэлцэн тохиролцсоны дагуу АМГТГ, ИНЕГ-ын даргын 2017 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн А/265, а/59 дугаар хамтарсан тушаалаар Замын-Үүд дэх ШТШАБ-ийн өргөтгөлийн ажлын даалгавар боловсруулах, хяналт тавих, батлуулах, хүлээн авах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Тус ажлын хэсэг зургийн даалгавар боловсруулахтай холбогдуулан 2017 оны 05 дугаар сарын 19-22-ний өдрүүдэд Замын-Үүд суманд ажилласан бөгөөд ШТШАБ-ийг өргөтгөлтэй уялдуулан тус байгууламжийн газрын хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай талаарх дүгнэлт гаргасан ба газрын асуудлыг шийдвэрлүүлэхээр Дорноговь аймгийн Засаг даргад холбогдох хүсэлтийг хүргүүлсэн. Үүний үр дүнд байгууламжийн өргөтгөлд шаардлагатай газрын хэмжээг нэмэгдүүлэх асуудал Замын-Үүд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцэгдэж, тус хурлын 2017 оны 17 тоот тогтоолоор батлагдан, Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Засаг даргын 2017.06.12-ны өдрийн А/163 дугаар захирамжаар "ЗҮ-ШТШАБ" ТӨҮГ-т 1 га газрыг 15 жилийн хугацаатай шинээр нэмж олгох шийдвэрийг гаргасан. Мөн ажлын хэсгээс шинээр нэмж өргөтгөх хэсгийн сав, насос станц, технологийн шугам хоолой барих газрыг урьдчилсан байдлаар төлөвлөн, зургийн даалгавар боловсруулах ажлыг хийж гүйцэтгэн батлуулсан. Дорноговь аймгийн Замын-Үүд суманд байрлах Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламжид агаарын хөлгийн шатахуун шилжүүлэн ачих технологийн шугамын өргөтгөл хийх замаар Жет А-1 төрлийн шатахуун импортоор оруулах | 70 // | хэрэгжилт удаашралтай, байгууламжийг өргөтгөх талаар дорвитой ажил хийгдээгүй, тодорхой үр дүнд хүрээгүй, хөрөнгө санхүүжилт шийдэгдээгүй байна. |

| | | | |
|---|---|---|---|
| 83 | 112 | 2017 оны 6 дугаар сарын 28-ны өдөр 31 дүгээр тэмдэглэл<br>2017-06-28<br>Дугаар 2017_31 | XI.3.. Дэлхийн банк болон Япон Улсын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газрын зээлсэн зээлийн өр төлбөрөөс “Багануур” ХК болон “Шивээ-Овоо” ХК-ийг чөлөөлөх асуудлыг судлан санал боловсруулж танилцуулахыг Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Эрчим хүчний сайд П.Ганхүү, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал Ц.Түмэнцогт нарт даалгав. |

| | | |
|---|---|---|
| Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн хуралдааны 31 дүгээр тэмдэглэлийн дагуу “Багануур” ХК, “Шивээ-Овоо” ХК-иудын техник, санхүүгийн хэвийн ажиллагаа, эрчим хүчний үйлдвэрүүдийн найдвартай, тасралтгүй ажиллагааг хангах, нүүрсний хангамжийг сайжруулах зорилгоор “Багануур” ХК, “Шивээ-Овоо” ХК-иудын санхүүгийн хүндрэлтэй нөхцөл байдлыг харгалзан “Монгол Нүүрс” төслийн хүрээнд Дэлхийн банк болон Япон Улсын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газрын зээлсэн зээлийн өр төлбөрөөс “Багануур” ХК-ийн зээлийн үндсэн болон тохируулгын төлбөр 37,729.8 (Гучин долоон тэрбум долоон зуун хорин есөн сая найман зуун мянга) сая төгрөг, “Шивээ-Овоо” ХК-ийн зээлийн үндсэн болон тохируулгын төлбөр 73,036.9 (Далан гурван тэрбум гучин зургаан сая есөн зуун мянга) сая төгрөг, нийт 110,776.7 (Нэг зуун арван тэрбум долоон зуун далан зургаан сая долоон зуун мянга) сая төгрөгийг тухайн төрийн өмчит нүүрсний уурхайнуудад оруулсан хөрөнгө оруулалт болгон тооцох арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтнуудад даалгасан Засгийн газрын 2018 оны 132 дугаар тогтоол батлагдсан болно. | 100/хяналтаас хасуулах саналтай/ | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 84 | 113 | 2018 оны 3 дугаар сарын 27-ны өдөр 15 дугаар тэмдэглэл 2018-03-27 Дугаар 2018_15 | XXIX.14.. Монгол Улсад алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах асуудалтай холбогдуулан хуралдаан дээр Засгийн газрын гишүүдээс гаргасан саналын дагуу үйлдвэр байгуулах төслийг хэрэгжүүлэх үндэслэл, тооцоог гаргасны үндсэн дээр аж ахуйн нэгж байгуулах тухай шийдвэрийн төсөл боловсруулан хууль тогтоомжийн хүрээнд Монголбанк болон яамдын саналыг авч, Засгийн газрын хуралдаанд зохих журмын дагуу оруулж хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгав. | Улсын Их Хурлын Байнгын хорооны 2018 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн "Чиглэл өгөх тухай" 32 дугаар тогтоолд "Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2.69 дэх заалтыг хэрэгжүүлэх хүрээнд 2019 онд багтаан дотооддоо алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Ү.Хүрэлсүх/, Монголбанк /Н.Баяртсайхан/-нд чиглэл болгосны дагуу Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" А-303 тогтоолоор Монгол Улсад алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах ажлын цогц төлөвлөгөө боловсруулах, холбогдох тооцоо судалгаа хийж танилцуулах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Засгийн газрын 2019 оны 02 дугаар сарын хуралдаанаар алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах асуудлаар хэлэлцэж "Стратегийн ач холбогдолтой том төслийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын тэмдэглэл гарсан. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2019 оны 02 дугаар сарын 27-ны өдөр алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах асуудлаар "Эдийн засгийн аюулгүй байдлыг хангах тухай" зөвлөмж гарсан. Тус зөвлөмжийн хэрэгжилтийг хангах хүрээнд Тагнуулын ерөнхий газраас Засгийн газрын хэрэг эрхлэх газарт алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах асуудлыг нууцад хамруулах асуудлаар Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар зохих журмын дагуу хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх тухай албан бичгийг 2019 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр хүргүүлэн Засгийн газрын 2019.05.17-ны өдрийн "Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай" 196 дугаар тогтоолоор Засгийн газрын 2017.9.13-ны өдрийн 247 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт"-д | 100 | |
| | 114 | | 2.. Газрын тосны тухай хууль тогтоомжийн хэрэгжилт болон бүтээгдэхүүн хуваах гэрээтэй холбоотой үйл ажиллагааг бодлогын удирдамжаар хангаж хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Х.Хэрлэнд тус тус үүрэг болгов. | Энэхүү тэмдэглэлтэй холбогдуулан Газрын тосны тухай хуулийн хэрэгжилтийн байдал болон Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны талаарх танилцуулга, мэдээллийг Засгийн газрын 2018.10.03-ны өдрийн хуралдаанд танилцуулсан ба тус хуралдааны 41 дүгээр тэмдэглэлээр цаашид хийж гүйцэтгэх ажлын талаар үүрэг чиглэл өгсөн. Засгийн газрын 2018.10.03-ны өдрийн 41 дүгээр тэмдэглэлийн дагуу хийж гүйцэтгэсэн ажлын талаар тус тэмдэглэлийн биелэлтийн хэсэгт оруулсан болно. | 100 /ЗГ-ын хуралдаанд дахин асуудал хэлэлцүүлж шийдвэр гаргуулсан тул хяналтаас хасуулах саналтай/ | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 85 | 115 | 2018 оны 5 дугаар сарын 2-ны өдөр 20 дугаар тэмдэглэл 2018-05-02 Дугаар 2018_20 | XXII.9. 2. . Засгийн газрын тухай хуулийн 20.5.12-т заасан эрхэлсэн асуудлын хүрээний дагуу газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлын явц, гүйцэтгэл, зээлийн хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад хяналт тавьж, бодлогын болон мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт үүрэг болгов. | "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-ийн өдөр тутмын үйл ажиллагаанд болон дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэлийн тайланг гүйцэтгэгч компаниудаас долоо хоног бүр авч хяналт тавин ажиллаж байна. Мөн УУХҮЯ-ны дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ хэлэлцэх салбар хуралдаанаар "Газрын тос боловсруулах үйлдвэр болон дамжуулах хоолой барих төсөл"-ийн нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэлийг 2018.11.15-ны өдөр хэлэлцэн хүлээн авахаар шийдвэрлэсэн. Сайншанд-Газрын тос боловсруулах үйлдвэр хүртэлх гадна дэд бүтцийн төслүүдийг Хөгжлийн банкны зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн бөгөөд уг төслийн нийт төсөвт өртгөөс 38 орчим тэрбум төгрөгийн хэмнэлт гаргасан. Энэхүү хэмнэсэн мөнгөн хөрөнгийг Засгийн газар хотхоны бүтээн байгуулалтад зарцуулахаар шийдвэрлэсэн. Хотхоны өртөг зардлыг бууруулах зорилгоор тус хотхоныг барьж байгуулахад шаардагдах дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй, импортоор оруулж ирэх бараа, материалын гаалийн албан татварыг хөнгөлж, буцаан олгох тухай хуулийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, Улсын Их Хурлын нэгдсэн чуулганы 2019.11.30-ны өдрийн хуралдаанаар батлуулсан. "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК болон Энэтхэг Улсын "Инженерс Индия Лимитед" төрийн өмчит компаниуд 2019.05.13-ны өдөр газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн менежментийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулсан. Уг гэрээнд төслийн менежментийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх компани гүйцэтгэлийн баталгаа банкинд байршуулах, инженер-геологийн судалгаа хийх болон бусад асуудлуудыг тусган, тус гэрээний нэмэлт, | 100 /үйлдвэр барих төслийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын явц, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллан дэд бүтцийн байгууламжууды г улсын комиссоор байнгын ашиглалтанд хүлээн авсан тул хяналтаас хасуулах саналтай/ | |
| | 116 | | XXII.9. 3. . Монгол Улсын Хөгжлийн банкнаас "Газрын тос боловсруулах үйлдвэр барих" төслийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад зориулан "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-д олгох зээлийн санхүүжилтийг ирээдүйд бий болох хөрөнгөөр барьцаалах замаар олгох асуудлыг судлан шийдвэрлэх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор), Хөгжлийн банкны гүйцэтгэх Б.Батбаяр нарт даалгав. | "Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл"-ийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад зориулан "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК болон Монгол Улсын Хөгжлийн банк хооронд ирээдүйд бий болох хөрөнгийг барьцаалан буцаан төлөх нөхцөлтэйгээр 2018.04.13-ны өдрийн БГ-МГТ-ИХ 2018-44 дугаар "Барьцааны гэрээ" болон мөн өдрийн ЗГ-МГТ-3 2018-43 дугаар "Зээлийн гэрээ"-г тус тус байгуулан ажиллаж байна. Энэхүү зээлийн хөрөнгөөр "Сайншанд-Газрын тос боловсруулах үйлдвэр" чиглэлийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлуудыг гүйцэтгэлийн дагуу үе шаттайгаар санхүүжүүлэн ажиллаж байгаа бөгөөд 2019 оны 06 дугаар сарын байдлаар уг төсөлд "Хөгжлийн банк"-наас нийт 120 гаруй тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгоод байна. /Хэрэгжилт-100%/ | 100 /үйлдвэр барих төслийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын явц, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллан дэд бүтцийн байгууламжууды г улсын комиссоор байнгын ашиглалтанд хүлээн авсан тул хяналтаас хасуулах саналтай/ | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 86 | 117 | 2018 оны 6 дугаар сарын 6-ны өдөр 25 дугаар тэмдэглэл 2018-06-06 Дугаар 2018_25 | XYI.3. . Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-импорт банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төслийн явцыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан газрын тос боловсруулах үйлдвэрийн технологийн сонголт болон бусад асуудлаар Энэтхэгийн талтай хэлэлцэн эцэслэн тохиролцож, дүнг Засгийн газрын дараагийн хуралдаанд танилцуулахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт даалгав. | Төслийн нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэлийг гүйцэтгэх зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр Энэтхэгийн “Инженерс индиа лимитед” компани шалгарч, УУХҮЯ болон “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-тай зөвлөх үйлчилгээ үзүүлэх гурвалсан гэрээг 2017.08.09-ний өдөр байгуулсан. Захиалагч УУХҮЯ, төсөл хэрэгжүүлэгч ”Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК компани болон захиалагчийн инженер Итали Улсын “КТ-Кинетикс” компанийн зүгээс нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэлийн ажлын гүйцэтгэлд хяналт тавин ажилласан бөгөөд эцсийн тайланг УУХҮЯ-ны дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2018.11.15-ны өдрийн өргөтгөсөн хуралдаанаар хэлэлцэн хүлээн авсан. /Хэрэгжилт-100%/ | 100 /ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэр гарсан тул хяналтаас хасуулах саналтай/ | |
| | 118 | 2018 оны 6 дугаар сарын 13-ны | XIX.10. . Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газрын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төслийн явцын талаарх Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын танилцуулгыг Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:<br><br>10.1. Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газрын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-ийн нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэл /ТЭЗҮ/-ээр тооцоолсон хөрөнгө оруулалтын зардлыг холбогдох гэрээ, хэлэлцээрийн хүрээнд бууруулах арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт даалгав. | Төслийн нарийвчилсан ТЭЗҮ-ийн дундын буюу явцын тайланг 2018 оны 02 дугаар сард ирүүлсэнтэй холбогдуулан БНЭУ-ын Зөвлөх түүнд хөндлөнгийн хяналт тавьж буй Итали Улсын “КТ-Кинетикс” компаниуд Монгол Улсад 2018 оны 04 дүгээр сарын 22-26-ны өдрүүдэд албан айлчлал хийж, гурван талт техникийн зөвлөлдөх уулзалтуудыг зохион байгуулсан. Энэхүү уулзалтаар захиалагч буюу УУХҮЯ болон “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн зүгээс БНЭУ-ын Зөвлөхийн гүйцэтгэсэн тайланд санал болгосон технологийн сонголт, төсөвт өртгийн тооцоог дахин нягтлах шаардлагатай байгаа тухай санал, зөвлөмжийг хүргүүлсэн. Түүнчлэн УУХҮСайдаар ахлуулсан ажлын хэсэг БНЭУ-д 2018 оны 06 дугаар сарын 09-12-ны өдрүүдэд албан айлчлал хийж, Энэтхэгийн Гадаад хэргийн яам, Экспорт-Импорт банк болон Зөвлөх үйлчилгээ үзүүлж буй “Инженерс Индиа Лимитед” компанийн удирдлагуудтай уулзалт зохион байгуулж, нарийвчилсан ТЭЗҮ-ийн ажлын явц, үйлдвэрийн технологийн сонголт болон төсөвт өртгийн талаар тус тус санал солилцсон. Гэвч зөвлөх компанийн зүгээс НТЭЗҮ-ийн тооцоололд Монголын талын тавьсан шаардлагын дагуу нэмэлт тооцоо судалгааг тусган ирүүлээгүй тул УУХҮСайдын санаачлагаар Энэтхэгийн талтай дахин зөвшилцөх уулзалтыг Улаанбаатар хотноо 2018.09.27-ны өдрөөс 10 дугаар сарын 02-ны өдрүүдэд зохион байгуулсан. Уг уулзалтаар Энэтхэгийн тал боловсруулах үйлдвэрийн хөрөнгө оруулалтын зардлыг тодорхой хэмжээгээр бууруулах боломжтой талаар дурдан захиалагчийн санал болгосон технологийг сонгохоор болсон бөгөөд түүхий тос дамжуулах хоолойн хувьд Монгол улстай ижил төстэй нөхцөлд буюу ОХУ, БНХАУ-д ашиглагдаж байгаа уламжлалт технологийг судлахаар тохиролцсон. Төслийн менежментийн зөвлөх компаниар | 100 /“Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төслийн явцын талаарх Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын танилцуулгыг Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн 2018.06.13-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж тэмдэглэл гарсан тул хяналтаас хасуулах саналтай/ | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 87 | 119 | 2018 оны 6 дугаар сарын 13-ны өдөр 26 дугаар тэмдэглэл 2018-06-13 Дугаар 2018_26 | XIX.10..2. . Түүхий тос дамжуулах хоолойг нарийвчилсан ТЭЗҮ-ээр тооцоолсон хөрөнгө оруулалтын зардлаас бага өртөгтэйгээр Оросын Холбооны Улс болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсад хэрэглэгдэж байгаа уламжлалт технологийг ашиглан байгуулах санхүүжилтийн болон техникийн боломжийг судалж, танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт үүрэг болгов. | Ерөнхий сайдын 2019 оны 118 дугаар захирамжаар газрын тос боловсруулах үйлдвэрт шаардлагатай дотоодын түүхий тосыг тээвэрлэх дэд бүтцийн оновчтой хувилбарыг тодорхойлох, шаардлагатай тооцоо судалгааг хий, техник технологийн шийдэл, хөрөнгө оруулалтын талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Энэхүү захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг гурван удаа хуралдаж, үйлдвэрт шаардлагатай түүхий эдийг тээвэрлэх дэд бүтцийн боломжит хувилбаруудын талаар мэдээ мэдээлэл, тооцоо судалгаа, хөрөнгө оруулалт, техник технологийн шийдлийг тодорхойлох зорилгоор холбогдох байгууллагуудаас баримт материалуудыг цуглуулсан. Ажлын хэсгийн зүгээс их хэмжээний түүхий тосыг хол зайд тээвэрлэхэд тохиромжтой дэд бүтцийн хувилбар болох төмөр зам болон дамжуулах хоолойн тээвэрлэлтийг манай нөхцөлд тохирох боломжтой гэж үзэн эдийн засгийн үр ашгийн харьцуулсан судалгааг Монголын логистикийн холбоо ТББ-аар хийж гүйцэтгүүлэн тайланг Засгийн газрын 2019.12.18-ний өдрийн хуралдаанаар танилцуулж, холбогдох шийдвэрийг гаргуулаад байна. /Хэрэгжилт-10%/ | 100 /тос дамжуулах тээврийн асуудлаар гарсан тайланг ЗГ-ын 2019.12.18 өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэр гарсан тул хяналтаас хасуулах саналтай/ | |
| | 120 | | 10.4. Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгав. | УУХҮСайдын 2018.12.18-ны өдрийн А/259 дугаар тушаалаар "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-ийн дүрмийг шинэчлэн баталсан бөгөөд тус дүрмийн 12.2-д Өмчлөгчийн хяналтыг Төлөөлөн удирдах зөвлөл хэрэгжүүлэхээр тусгасан. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019.01.15-ны өдрийн А/06 дугаар тушаалаар Төлөөлөн удирдах зөвлөлийг байгуулан газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. /Хэрэгжилт-100%/ | 100 /төслийн хэрэгжилтэд тавих байнгын хяналтыг ТӨХХК-ийн ТУЗ болон гүйцэтгэх удирдлага хэрэгжүүлж байгаа тул хяналтаас хасуулах саналтай/ | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 88 | 121 | 2018 оны 7 дугаар сарын 4-ний өдөр 29 дүгээр тэмдэглэл 2018-07-04 Дугаар 2018_29 | XIY.. Газрын тосны хайгуулын Баянтүмэн-XVII талбайд газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах талаар Газрын тосны газар (хуучин нэрээр) болон “Магнай трейд” XXK-ийн хооронд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний гэрээлэгчийн эрх, үүргийг “Магнай трейд” XXK-аас “Эм Ти ПЛО” XXK-д бүхэлд нь шилжүүлэх тухай асуудлыг хэлэлцээд хуралдаан дээр Засгийн газрын гишүүдээс гаргасан саналын дагуу Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс чиглэл авсны үндсэн дээр дахин хэлэлцүүлэхээр хойшлуулав.<br><br>Үүнтэй холбогдуулан газрын тосны салбарт байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилт, ашигт малтмалын салбарт олгосон хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл авсан болович үйл ажиллагаа явуулалгүй тусгай зөвшөөрөл (гэрчилгээ)-ийг бусдад шилжүүлж (худалдаж) байгаа асуудлыг шийдвэрлэх болон цаашид авах арга хэмжээний талаар тодорхой санал боловсруулан зохих журмын дагуу Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөр хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгав. | Тэмдэглэлийн дагуу газрын тосны хайгуулын Баянтүмэн-XVII талбайд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх, үүргийг “Магнай трейд” XXK-иас “Эм Ти ПЛО” XXK-д шилжүүлэх талаарх танилцуулга, холбогдох бичиг баримтыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхээр УУХҮ-ийн сайдын 2019.02.12-ны өдрийн 01/371 тоот албан бичгээр Монгол Улсын Сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэд хүргүүлсэн. | 70 | |
| 88 | 122 | 2018 оны 7 дугаар сарын 4-ний өдөр 29 дүгээр тэмдэглэл 2018-07-04 Дугаар 2018_29 | XX.4. 2. . Байгалийн өнгөт чулууг хууль бусаар олборлох, улсын хилээр гаргахыг хориглох асуудлыг судлах, байгалийн өнгөт чулууны жишиг үнэлгээг тогтоолгохыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт; | Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 131 дүгээр тогтоол, 2014 оны 220 дугаар тогтоол, 2015 оны 102, 103, 488 дугаар тогтоол , 2016 оны 81 дүгээр тогтоолын дагуу уул уурхайн экспортын дараах бүтээгдэхүүнүүдийн олон улсын зах зээлийн үнийг Сангийн сайд болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд нарын хамтарсан 2018 оны 200/А/177 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг нийтэд мэдээлж байгаа болно. Үүнд: Цайр, зэс, цагаан тугалга, хар тугалга, хөнгөн цагаан, молибдени, алт, мөнгө, нүүрс, төмөр, жонш, гянтболдын хүдэр, манганий хүдэр зэрэг багтаж байна. Мөн Уул уурхайн хүнд үйлдвэрийн яамнаас Монгол Улсад үнэт металл, эрдэнийн чулуугаар бүтээгдэхүүн үйлдвэрлэх, түүхий эдээр хангах болон худалдаалах зэрэг асуудлуудыг олон улсын чиг хандлагад нийцүүлэх зорилгоор "Үнэт металл, эрдэнийн чулууны үйлдвэрлэл, түүний эргэлтийн тухай" хуулийн төслийг үзэл баримтлалын төслийн хамтаар боловсруулж, үзэл баримтлалын төслийг батлуулахаар Хууль, зүй дотоод хэргийн яаманд 2018 оны 7 дуҮ-ийн тооцоолold Монголын талын тавьсан шаардлагын дагуу нэмэлт | 70 | эрчимжүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг авч ажиллах шаардлагатай |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 89 | 123 | 2018 оны 8 дугаар сарын 22-ны өдөр 35 дугаар тэмдэглэл 2018-08-22 Дугаар 2018_35 | XIX.6. . “Тавантолгой” ХК нь “Эрдэнэс-Таван толгой” ХК-ийн уурхайн талбайгаас хууль бусаар нүүрс олборлосон эсэх асуудлыг шалгах үүрэг бүхий Ажлын хэсгийн дүнг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авахыг холбогдох Засгийн газрын гишүүдэд даалгав.<br>-Уул уурхайн компаниудын олборлолтын үйл ажиллагаа уулын ажлын төлөвлөгөө, тайлан, нөөцийн хөдөлгөөн болон ТЭЗҮ-ийн дагуу явагдаж байгаа эсэхэд хяналт тавих, гарсан зөрчил дутагдлыг цаг тухайд нь арилгуулах чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлж байгаа төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг Шадар сайд Ө.Энхтүвшин, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт; | УУХҮ-ийн сайдын 2018.04.20-ны өдрийн А/86 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг “Тавантолгой” ХК нь “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайгаас нүүрс олборлон ашигласан асуудлыг хянан үзэж, дүгнэлт гаргах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах ажлын хүрээнд 2018.04.19-нөөс 05.06-ны өдрүүдэд дараах үе шаттай ажлуудыг гүйцэтгэн, дүгнэлт, саналыг боловсруулсан. | 100 | |
| | 124 | | XIX.6. . -“Эрдэнэс-Таван толгой” ХК-ийн уурхайн талбайгаас хууль бусаар олборлосон нүүрсний хэмжээг хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар эцэслэн нарийвчлан тогтоолгож, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх ажлыг хууль тогтоомжийн хүрээнд шуурхай зохион байгуулж шийдвэрлэх, цаашид компанийн үйл ажиллагааг хууль тогтоомжийн дагуу явуулж, уурхайн олборлолт, экспортын үйл ажиллагаанд хяналт тавьж байхыг “Эрдэнэс-Таван толгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Г.Нандинжаргал)-д, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт; | 1. Тусгай зөвшөөрлийн солбилцлын удаа дараагийн өөрчлөлт, хөдөлгөөн нь тусгай зөвшөөрлийн хил давж нүүрс олборлосон асуудлын үндсэн үүсэл шалтгаан биш болохыг тогтоосон.<br>2. Хил давж олборлогдсон нөөцийн гурван удаагийн тооцооллын зөрүү 0.3%-3.5% байгаа нь тус хоёр аж ахуй нэгжийн харилцан зөвшөөрсөн нөөцийн тооцоо үнэн зөв байх боломжтой гэж үзэв. (а. “Тавантолгой” ХК болон “Эрдэнэс Тавантолгой” ХК-иудын хамтарсан ажлын тооцоо; б.Уламжлалт арга буюу блокын аргаар тооцоолсон хяналтын тооцоо; в.Хөндлөнгийн тусгай зөвшөөрөл бүхий маркшейдерийн компаниар хийлгэсэн хэмжилт, хяналтын тооцоо)<br>3.Ажлын хэсгийн томилолтын үед олборлолтонд өртсөн нүүрсний мөргөцөгүүдээс авсан хяналтын дээжлэлт, лабораторийн шинжилгээний үр дүн нь өмнө нь хийгдсэн “Тавантолгой” ХК болон “Эрдэнэс Тавантолгой” ХК-иудын хамтарсан ажлын хэсгийн тайланд тусгагдсан лабораторийн шинжилгээний үр дүнгүүдтэй ойролцоо үр дүнг илэрхийлж байна.<br>4.Хил давж олборлосон он цагийг нарийвчлан тогтоох ажлыг гүйцэтгэхийн тулд агаар, сансрын зургийг он тус бүрээр гаргуулж, холбогдох суурин боловсруулалтын ажлыг гүйцэтгэх.<br>Мөн Монгол улсын Ерөнхий сайдын чиглэл болгосны дагуу Сангийн сайдын 2018 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 109 тушаал болон Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын баталсан 2018 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 01/174 тоот удирдамжийн дагуу Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт үйл ажиллагаа явуулж байгаа Орон нутгийн өмчит "Тавантолгой" ХК нь өөрийн ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайгаас хил | 70 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 90 | 125 | 2018 оны 10 дугаар сарын 3-ны өдөр 41 дүгээр тэмдэглэл 2018-10-03 Дугаар 2018_41 | XXIII.6. . Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан гэрээлэгч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд Газрын тосны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7-д заасны дагуу холбогдох байгууллагуудтай хамтарсан шалгалт хийж, дүнг Засгийн газрын хуралдаанд 2019 оны 3 дугаар сард танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгав.<br>2. Дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэр барихтай холбогдуулан газрын тосны салбарын талаарх мэдээллийг олон нийтэд сурталчлах, газрын тосны эрэл хайгуулын ажлыг эрчимжүүлж нөөц өсгөх, олборлолтыг нэмэгдүүлэх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Х.Хэрлэн нарт үүрэг болгов." гэжээ. | 1. Тус тэмдэглэлийн холбогдох заалтын хэрэгжилтийг хангах хүрээнд УУХҮ-ийн Сайдын 2018.12.03-ны өдрийн А/250 дугаар тушаалаар "Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан гэрээлэгч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд шалгалт хийх" үүрэг бүхий ажлын хэсгийг БОАЖЯ, ЗТХЯ, МХЕГ, АМГТГ-ын төлөөлөлтэйгээр байгуулан ажилласан ба ажлын хэсгийн хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, санал, дүгнэлтийг УУХҮ-ийн Сайдын зөвлөлийн 2019.03.14-ний хурлаар хэлэлцэн холбогдох шийдвэрийг гаргасан. Хамтарсан шалгалтын дүнг Засгийн газарт танилцуулахаар 2019.03.29-ний өдрийн 01/840 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.<br>2. УУХҮ-ийн сайдын 2018.12.12-ны өдрийн 01/3306 тоот албан бичгээр "дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэр барихтай холбогдуулан газрын тосны салбарын талаарх мэдээллийг олон нийтэд сурталчлах, газрын тосны эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлж, нөөц өсгөх, олборлолтыг нэмэгдүүлэх арга хэмжээ авах" талаар төлөвлөгөө баталж хэрэгжүүлэх, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар тухай бүр яаманд мэдээлж байхыг АМГТГ-т чиглэл болгосон. Мөн сар бүр зохион байгуулдаг "Ил тод уул уурхай" хэвлэлийн хурлаар төслийн явцын талаар олон нийтэд мэдээлэл сурталчилж ажиллаж байна. /Хэрэгжилт-100%/ | 100 /тэмдэглэлээр өгөгдсөн үүргийг бүхэн хэрэгжүүлж ажиллаж байгаа тул хяналтаас хасуулах саналтай/ | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 91 | 126 | 2018 оны 10 дугаар сарын 24-ний өдөр 44 дүгээр тэмдэглэл<br>2018-10-24<br>Дугаар 2018_44 | XXYI.7. . 1. ОХУ-ын Роснефть компанитай хийж байгаа хамтын ажиллагааны хэлэлцээг үргэлжлүүлж, газрын тос боловсруулах үйлдвэрийн төсөлд хамтран оролцох нөхцөл боломжийг судлан танилцуулах;<br><br>2. Дорноговь аймгийн Алтанширээ суманд баригдах газрын тос боловсруулах үйлдвэрээс Тосон-Уул орд хүртэл газрын тос дамжуулах хоолойн техник, технологи болон санхүүжүүлтийн асуудлыг судлан танилцуулах;<br><br>3. Дотоодын зах зээлд нийлүүлэх автобензин, дизелийн түлшний нөөц, хангамжийг нэмэгдүүлэх, тогтворжуулах зорилгоор автобензин, дизелийн түлшний нөөцийн агуулахуудын багтаамжийг нэмэгдүүлэх, гаалийн баталгаат агуулах байгуулах асуудлыг судлан шийдвэрлэх;<br><br>4. Хөшигийн хөндийд баригдаж байгаа нисэх онгоцны шинэ буудлыг түлш, шатахуунаар хангах асуудлыг шийдвэрлэхэд гадаадын хөрөнгө оруулалт, оролцоог судлан танилцуулах. | 1. Үндэсний хөгжлийн газрын даргын 2019.05.29-ний өдрийн А-97 дугаар тушаалаар "Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын шатахуун хангамжийн байгууламжийн менежмент төсөл"-д Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон Зам, тээврийн хөгжлийн яамнаас санал болгосон, мөн төслийг хэрэгжүүлэх сонирхлоо ирүүлсэн "Роснефть" ХК-тай концессийн гэрээний хэлэлцээрийг хийж, дүгнэлт гаргах" үүрэг бүхий ажлын хэсэг ҮХГ, УУХҮЯ, СЯ болон ЗТХЯ, ИНЕГ, АМГТГ-ын бүрэлдэхүүнтэй байгуулагдан ажиллаж байна.<br>2. Дорноговь аймгийн Алтанширээ суманд баригдах газрын тос боловсруулах үйлдвэрээс Тосон-Уул орд хүртэл түүхий тос дамжуулах хоолойг нарийвчилсан ТЭЗҮ-ээр тооцоолсон хөрөнгө оруулалтын зардлаас бага өртөгтэйгээр ОХУ болон БНХАУ-д хэрэглэгдэж байгаа уламжлалт технологийг ашиглан байгуулах санхүүжилтийн болон техникийн боломжийг шийдвэрлэхэд Засгийн газрын баталгаа зайлшгүй шаардлагатай байгаа тул Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн зүгээс түүхий тос дамжуулах хоолойн асуудлыг Засгийн газар болон Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд танилцуулахаар бэлтгэж байна.<br>3. Улаанбаатар хотын Рашаант өртөөнд байрлах улсын нөөцийн газрын тосны бүтээгдэхүүний агуулахын 5000м3-ийн багтаамжтай 9ш савны суурийн цутгалтын ажил 100 хувь хийгдсэн. Улсын нөөцийн агуулахын 671м салаа төмөр замын ажил 100 хувь хийгдээд байна.<br>4. Хөшигийн хөндийд баригдаж байгаа нисэх онгоцны шинэ буудлыг түлш, шатахуунаар хангах асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд ОХУ-ын Роснефть компани санал ирүүлснийг судалж, дээрх ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. | 70 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 92 | 127 | 2018 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр 48 дугаар тэмдэглэл<br>2018-11-21<br>Дугаар 2018_48 | XII.. Дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгав:<br><br>2.1. үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжийн бүтээн байгуулалтын ажлын явцыг Засгийн газарт танилцуулах;<br><br>2.2. үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээг зохих журмын дагуу дүгнэсний үндсэн дээр гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, газрыг зориулалтын бусаар эзэмшиж, ашиглаж байгаа аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг цуцлах, газрыг чөлөөлөх арга хэмжээ авах;<br><br>2.3. ашигт малтмал, газрын тосны салбарт олгосон хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийг бусдад дамжуулан худалдаж байгаа эсэхийг шалгаж, тусгай зөвшөөрөл олголтыг цэгцлэх асуудлаар санал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулж, дүнг Засгийн газарт танилцуулах. | /2.1-2.2/ Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан доорх байгууллагуудаас УУХҮ-ийн сайдтай байгуулсан "Үйлдвэрлэл, технологийн паркийн удирдлагатай байгуулах гэрээ"-ний хэрэгжилт, 2019 онд хэрэгжүүлсэн ажлууд, 2020 оны төлөвлөгөөг хүлээн авсан.<br>Үүнд:<br>1. "Багануур үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨААТҮГ<br>2. "Дархан үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨХХК<br>3. "Эрдэнэт технопарк" ХХК<br>4. "Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨААТҮГ<br>Бүтээн байгуулалтын ажлын явцыг 2020 оны I улиралд багтаан 2019 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар бэлтгэж байна.<br>Яамтай гэрээ байгуулан ажиллаж байгаа үйлдвэрлэл, технологийн паркуудын гэрээг жил бүр зохих журмын дагуу дүгнэн ажиллаж байна. Эдгээр паркууд нь гэрээний хэрэгжилтийг 60-аас дээш хувь хангаж, паркийн зориулалтаар олгосон газрыг зориулалтын дагуу ашиглаж байгаа. 2.3. 2014.07.01-ний өдөр шинэчлэгдэн батлагдсан Газрын тосны тухай хуулийн 7.1.8 болон 14 дүгээр зүйлд заасныг тус тус үндэслэн газрын тосны хайгуулын Борзон ҮII талбайд бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан "М Си | 70 | |
| | 128 | | 2.2. нүүрсний ачилт, тээвэрлэлтийг авто замын даац, техникийн бүрэн байдал, аюулгүй ажиллагааг хангасан автотээврийн хэрэгслийн тоо, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний эрчим, аж ахуйн нэгж тус бүрийн нүүрс олборлолтын хэмжээ, хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадалтай уялдуулан зохион байгуулж, нүүрс тээвэрлэгч аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Зам, тээврийн хөгжлийн сайд Я.Содбаатар, Гаалийн ерөнхий газрын дарга Б.Асралт нарт; | Засгийн газрын тэмдэглэлийн дагуу тус яамнаас Авто тээврийн үндэсний төв ТӨҮГ болон холбогдох төрийн байгууллагуудад хилээр нэвтрэх олон улсын С зөвшөөрлийг замын даац, техникийн бүрэн бүтэн байдал, уурхайн олборлолтын хэмжээтэй уялдуулж олгох тухай чиглэлийг улирал бүр тогтоож өгч байна.<br>Энэхүү ажлын хүрээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдаас 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн 01/20, 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 01/774 тоот албан бичгүүдийг Авто тээврийн үндэсний төв ТӨҮГ болон бусад холбогдох төрийн байгууллагуудад тус тус хүргүүлсэн.<br>Мөн түүнчлэн Засгийн газрын 2019 оны 01 тоот албан даалгавар гарсан бөгөөд уг албан даалгаварын 6-д Уурхайн гадна болон хилийн боомт дээр тээврийн хэрэгслийн үргэлжилсэн дараалал үүсгэхгүйн тулд уурхайн нүүрсний ачилт, зөвшөөрлийн бичгийн олголт, гаалийн бүрдүүлэлтийг хятадын талаас нэг өдөрт хүлээн авах нүүрсний хэмжээ, автомашины тоотой уялдуулан зохицуулж ажиллахыг ГЕГ, "АТҮТ" ТӨҮГ "Эрдэнэс Тавантолгой" ХК, "Тавантолгой" ХК, "Энержи ресурс" ХХК-иудад даалгасан. | 100 | |

| | | | |
|---|---|---|---|
| 93 | 129 | 2018 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр 49 дүгээр тэмдэглэл 2018-11-28 Дугаар 2018_49 | 2.3. нүүрс худалдах, худалдан авах талаар хоёр улсын аж ахуйн нэгж хооронд байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангах, шаардлагатай бол нүүрсийг урт хугацаанд тогтвортой худалдах чиглэлээр гэрээг шинэчлэх болон хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх асуудлаар Хятадын талтай яриа хэлэлцээ хийхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар нарт; |

| | | |
|---|---|---|
| Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайд Д.Загджав БНХАУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд Шин Хайминтай 2017 оны 10 дугаар сарын 12-нд уулзаж, Гашуунсухайт-Ганцмод боомт дээр үүсээд буй Тавантолгойн бүлэг ордоос нүүрс тээвэрлэж буй хүнд даацын автомашины түгжрэлийн асуудлыг шуурхай шийдвэрлэх боломжийн талаар санал солилцож, Гаалийн шалгалтын хугацааг богиносгон, боомт дээрх татан авалтын хурдыг нэмэгдүүлэх тал дээр анхаарлаа хандуулж өгөхийг хүссэн ба уг асуудлыг нааштайгаар шийдвэрлэхийн төлөө хичээн ажиллахаа элчин сайд илэрхийлсэн.<br>2017 оны 11 дүгээр сарын 02-нд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар БНХАУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд Шин Хайминтай уулзалт хийхдээ Тавантолгойн хэлэлцээрийг үргэлжлүүлж, ажлын хэсгийг байгуулан Хятадын талтай хамтран ажиллах, Гашуунсухайт-Ганцмод боомт дээр үүсээд байгаа нүүрс тээвэрлэж байгаа хүнд даацын автомашины түгжрэлийн асуудлыг шийдвэрлэхэд БНХАУ-ын зүгээс анхаарал тавьж ажиллахыг хүссэн.<br>Монгол Улсын Гадаад хэргийн яам ахалсан Монгол, Хятадын хилийн Ганцмод-Гашуунсухайт боомтод үүссэн нөхцөл байдлыг судлан шийдвэрлэх үүрэг бүхий ажлын хэсэгт орж ажиллаж, тухай бүр холбогдох мэдээллийг хүргүүлсэн. Уг ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2018 оны 08 дугаар сарын 28-31-ний өдрүүдэд Улаанбаатар хотод БНХАУ-ын талтай уулзалт хийсэн болно. | 100 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 94 | 130 | 2018 оны 12 дугаар сарын 12-ны өдөр 51 дүгээр тэмдэглэл 2018-12-12 Дугаар 2018_51 | II.2. . "Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх Ажлын хэсгийг холбогдох яам, агентлагийн төлөөлөлтэй байгуулан ажиллуулж, хууль тогтоомж, гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн нь тогтоогдсон хуулийн этгээдээр нөхөн сэргээлт хийлгэх, тусгай зөвшөөрлийг цуцлах хүртэл арга хэмжээ авч, дүнг 2019 оны I улиралд багтаан Засгийн газарт танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Н.Цагаанхүү нарт даалгав. | Уул уурхайн үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг нэмэгдүүлэх, ялангуяа Байгаль орчныг хамгаалах тухай хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй аж ахуйн нэгжид хариуцлага тооцох эрх зүйн үндэс бий болгох зорилгоор "Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль"-ийг УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар 2019 оны 5 дугаар сарын 2-ны өдөр хэлэлцэж баталсан. Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.5-д заасныг үндэс болгон 2019 онд Өмнөговь аймгийн Гурвантэс, Номгон, Архангай аймгийн Цэнхэр сумын нутаг дэвсгэрт нийт 20 аж ахуйн нэгжийн 25 ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг цуцалсан. Уг цуцлагдсан шийдвэрийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2019 оны 8 дугаар сарын 23-ны өдөр Архангай аймгийн Цэнхэр сумын нутагт Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын ахалсан ажлын хэсэгт ажиллаж холбогдох арга хэмжээг газар дээр нь зохион байгуулсан болно. Тухайлбал, ашигт малтмалын тусгай зөвшөөрөл цуцлагдсан талбайд байгаа техник, тоног төхөөрөмжийг нүүлгэн гаргах, олборлолтод өртсөн талбайд техникийн нөхөн сэргээлт хийх ажлыг зохион байгуулсан. Улмаар тусгай зөвшөөрөл цуцлагдсан талбайн эвдэрсэн газрыг нөхөн сэргээх ажлыг албадан гүйцэтгүүлэх, цаашид хууль бусаар алт олборлох зөрчил гарахаас сэргийлэх, хууль бус алт олборлогчдоос талбайг хамгаалах зорилгоор 12 дугаар сарын 1-ийг хүртэл цагдаа болон мэргэжлийн хяналтын байгууллагын хяналтад авах шийдвэр гарган хэрэгжүүлж ажилласан бөгөөд өнөөгийн байдлаар цуцлагдсан тусгай зөвшөөрлийн талбайн техникийн нөхөн сэргээлт 37.4 хувь, биологийн нөхөн сэргээлт 10 хувьтай байна. | 100 | |
| | 131 | | II.3. . Дорноговь аймгийн Улаанбадрах сумын нутагт үйл ажиллагаа явуулж байгаа "Бадрах Энержи" ХХК-ийн "Зөөвч Овоо" туршилтын үйлдвэрийн түр зориулалтын барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссыг 2018 оны 12 дугаар сард багтаан томилж ажиллуулахыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт даалгав. | Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн хуралдааны 51 дүгээр тэмдэглэлийн 3 дахь хэсэгт "Дорноговь аймгийн Улаанбадрах сумын нутагт үйл ажиллагаа явуулж буй "Бадрах энержи" ХХК-ийн Зөөвч овоо төслийн технологийн туршилтын үйлдвэр, барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссыг 2018 оны 12 дугаар сард багтаан томилон ажиллуулахыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт даалгав." хэмээн чиглэл өгсөний дагуу хоёр сайдын хамтарсан 2019 оны А/18/16 тоот тушаалаар ажлын хэсэг байгуулан 2019 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр газар дээр ажиллаж, холбогдох дүгнэлтийг боловсруулсан болно. | 100 | |
| 95 | 132 | 2019 оны 1 дүгээр сарын 9-ний өдөр 2 дугаар тэмдэглэл 2019-01-09 Дугаар 2019_2 | XXIII.5. . "Газрын ховор элемент" хөтөлбөрийг холбогдох хууль тогтоомжийн дагуу боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгав. | Засгийн газраас өгсөн чиглэлийн дагуу Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журамд нийцүүлэн хөтөлбөрийн төслийг боловсруулан 2019 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 01/2151 дугаартай албан бичгээр яамдаас санал авсан. Ирсэн саналын дагуу хөтөлбөрийн нөхцөл байдлын дүн шинжилгээ, нөлөөллийн урьдчилсан үнэлгээг боловсруулан 2019 оны 11 дүгээр сард багтаан яамдаас дахин санал авахаар ажиллаж байна. | 70 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 96 | 133 | 2019 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр 3 дугаар тэмдэглэл | I.. Монгол Улсын Засгийн газраас зарласан “Хариуцлагын жил”-ийн хүрээнд зохион байгуулсан ажлын тайланг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br><br>Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав:<br><br>1.Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг хуулийн дагуу төлөвлөгөө гарган, шилэн дансанд байршуулах замаар 2019 оны I улиралд багтаан олон нийтэд ил тод, шуурхай зохион байгуулах;<br><br>2.Төрийн болон нутгийн удирдлагын бүх шатны байгууллагууд баталсан дүрэм, журамдаа шинжилгээ хийж, иргэд, олон нийтээр хэлэлцүүлэн, байгууллага, иргэдэд хүнд суртал, чирэгдэл үүсгэж байгаа дүрэм, журмыг хүчингүй болгох арга хэмжээ авч, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт мэдээг хагас, бүтэн жилээр ирүүлэх;<br><br>3.Төрийн байгууллагад иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлээгүй төрийн албан хаагч, албан тушаалтанд хариуцлага тооцож, өргөдөл гомдол шийдвэрлэлтийн мэдээнд тусгаж байх;<br><br>4.Төрийн албан хаагч ажлын болон ажлын бус цагаар ажлын байр, томилолтын явцад согтууруулах ундаа хэрэглэхийг хориглох талаар тогтоосон дэг журмыг чанд | . Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын багцаас 2019 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Тендерийн үнэлгээний хороог 2019.01.21-ний өдрийн А/16 дугаар тушаалаар байгуулж, тендерийг зарлан дүгнэж байна. Тендерийн явцын мэдээллийг сар бүр Сангийн яаманд хүргүүлж, Шилэн дансанд байршуулан ил тод байдлыг ханган ажиллаж байна.<br>3. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон Ашигт малтмал, газрын тосны газарт 2019 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 674 өргөдөл, гомдол ирснээс албан бичгээр 674 байна. Эдгээрээс шийдвэрлэж хариуг албан бичгээр өгсөн 619, хугацаа болоогүй 32, хугацаа хэтэрсэн 23 өргөдөл ба шийдвэрлэлт 96.5%-тай байна.Нийт 674 өргөдөл, гомдол, санал хүсэлтээс хүний нөөц, дэмжлэг туслалцаа хүссэн 378 буюу 56%, тусгай зөвшөөрлийн чиглэлээр 57 буюу 8.4%, геологи, уул уурхайтай холбоотой асуудлаар 30 буюу 0.4%, түлш, газрын тосны чиглэлээр 7 буюу 0.1% бусад чиглэлээр 202 буюу 29.9%-тай байна.<br>4. Дээрх заалтыг хөдөлмөрийн дотоод журмын шинэчилсэн найруулгад тусгасан. Одоогоор энэ төрлийн зөрчил илрээгүй байна.<br>5. Салбарын бодлого болоод тусгай зөвшөөрлийн мэдээллийг холбогдох мэргэжилтнүүд хэвлэлийн ажилтанаар дамжуулан тогтмол сайтад байршуулан ажиллаж байна. http://mmhi.gov.mn/ Мөн ил тод хариуцлагатай уул уурхай хэвлэлийн бага хурлыг сар бүр зохион байгуулж байгаа ба хагас жилийн байдлаар нийт 4 удаа зохион байгуулагдсан. | 100<br>/тэмдэглэлээр өгөгдсөн үүргийг хэрэгжүүлсэн, тэмдэглэлийн үйлчлэлийн хугацаа дуусгавар болсон тул хяналтаас хасуулах саналтай/ | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 134 | 2019-01-16<br>Дугаар 2019_3 | II.. Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулсан дүнг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:<br><br>1. Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, хариуцлагатай, мэргэшсэн, тогтвортой төрийн албыг төлөвшүүлэх зорилгоор дараахь арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгов:<br><br>1.1. төрийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардал, хийдлийг арилгах, ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор төрийн бүх шатны байгууллага Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор баталсан "Чиг үүрэг дахин хуваарилах аргачлал"-ын дагуу чиг үүргийн шинжилгээ хийж, чиг үүрэг дахин хуваарилах саналаа 2019 оны 12 дугаар сард багтаан Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлэх;<br><br>1.2. төрийн жинхэнэ албан тушаалд иргэнийг томилох, төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын сул орон тоог нөхөхдөө чадахуйн (мерит) болон шатлан дэвшүүлэх зарчмыг үндсэн шалгуур болгон Төрийн албаны тухай хуулийг чанд баримтлах;<br><br>1.3. төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байгаа албан тушаалтнуудын судалгаанд үндэслэн Төрийн албаны хуульд заасан шаардлага хангаж байгаа албан | 1.1 Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 350 дугаар тогтоолоор баталсан "Төвлөрлийг сааруулах талаар төрөөс баримтлах бодлого"-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төрийн байгууллагын чиг үүргийг дахин хуваарилах аргачлалыг Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор батлан хэрэгжүүлж эхлээд байна.<br>Энэ ажлын хүрээнд тус салбарт Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019.02.19-ны А/33 дугаар тушаалаар Ажлын хэсэг, Төрийн нарийн бичгийн даргын 2019.04.11 А/67 дугаар тушаалаар Дэд ажлын хэсэг /Техникийн ажлын хэсэг/ тус тус байгуулагдан ажиллаж байна. Дэд ажлын хэсгийн зүгээс салбарын ерөнхий чиг үүргийн шинжилгээ, үндсэн чиг үүргийн шинжилгээ, дэд чиг үүргийн шинжилгээг хийж 2019.06.20-ны өдөр удьдчилсан байдлаар дууссан бөгөөд холбогдох хууль, эрх зүйн зохицуулалт, захиргааны эрх хэмжээний шинжилгээ, хэрэгжүүлж байгаа түвшинг тодорхойлох ажлууд хийгдэж байна. Дээрх шинжилгээ, тайлангуудыг үндэслэн холбогдох хууль тогтоомжид оруулах нэмэлт өөрчлөлтийн талаарх саналыг Ажлын хэсэг болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын Зөвлөлийн хуралд танилцуулж, салбарын нэгдсэн санал дүгнэлтийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэхээр ажиллаж байна.<br>1.2 2019 оны эхний хагас жилд тус яамнаас өөрийн хүсэлтээр шилжин ажиллахаар чөлөөлөгдсөн 4, суралцахаар 1, тэтгэвэр тогтоолгохоор 1, нийт 6 төрийн жинхэнэ албан хаагч чөлөөлөгдсөн.<br>Сул орон тоог Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-т заасны дагуу байгууллагын цахим хуудсанд байршуулан олон нийтэд мэдээлж, мөн хуулийн 27 дугаар зүйлийг 27.1.1, 27.1.2-ыг баримтлан нөхөн тангараг өргөсөн 5 төрийн жинхэнэ албан хаагчыг томилсон. | 100<br>/тэмдэглэлээр өгөгдсөн үүргийг хэрэгжүүлсэн, тэмдэглэлийн үйлчлэлийн хугацаа дуусгавар болсон тул хяналтаас хасуулах саналтай/ | |
| 97 | 135 | 2019 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр 4 дүгээр тэмдэглэл<br>2019-01-16<br>Дугаар 2019_4 | XII.1. . Стратегийн ач холбогдолтой том төслийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан стратегийн ач холбогдолтой том төслүүдийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай танилцуулгыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд оруулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгав. | Засгийн газраас өгсөн үүргийн дагуу стратегийн ач холбогдол бүхий газрын ховор элемент, уран, алт зэрэг ашигт малтмалын талаар цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг бэлтгэн Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд 4 сард танилцуулсан /нууцын зэрэглэлтэй/.<br>Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс 2019 оны 2 сарын 27-нд Н05/05 тоот зөвлөмж гарсан ба уг зөвлөмжийг үндэслэн Монгол улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 196-р тогтоолоор Төрийн болон албаны нууцын тухай хуулийн хүрээнд стратегийн ач холбогдол бүхий төслийн жагсаалтад "Алт цэвэршүүлэх үйлдвэр барих төсөл"-ийг хамруулсан. "Алт цэвэршүүлэх үйлдвэр барих төсөл" нь нууцын зэрэглэлтэй төсөл хэрэгжих журмын дагуу Төрийн болон албаны нууцын хуулийн хүрээнд дагаж мөрдөх дүрэм, журмуудыг хатуу чанд мөрдөн хэрэгжүүлж эхлээд байна. | 100 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 98 | 136 | 2019 оны 1 дүгээр сарын 30-ны өдөр 6 дугаар тэмдэглэл 2019-01-30 Дугаар 2019_6 | XXII.5. . "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах эсэх талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br><br>Үүнтэй холбогдуулан "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах эсэх асуудлыг энэ оны эхний улиралд багтаан холбогдох хууль тогтоомжийн дагуу судалж шийдвэрлэхийг тус компанийн төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт даалгав. | "Эрдэнэс-Тавантолгой" ХК байгуулагдсан цагаас хойш нийтдээ 192.2 сая м3 хөрс хуулалтын ажил гүйцэтгэж, нийт 45.92 сая тонн нүүрс олборлосон бөгөөд үүнээс 2018 онд нийт 11.0 сая тонн нүүрс олборлож, 13.1 сая тонн нүүрс борлуулсан байна.Ийнхүү үйл ажиллагааны цар хүрээ нэмэгдсэнээр 2018 оны аудитлагдаагүй тайлангаар борлуулалтын орлогын хэмжээ 1,986.9 тэрбум төгрөгт, улсын төсөвт татвар, хураамж хэлбэрээр нийт 484.7 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, татварын дараах цэвэр ашиг 801.1 тэрбум төгрөгт хүрсэн. Дээрх үзүүлэлтийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал борлуулалтын орлогын хэмжээ 804.5 тэрбум буюу 68 хувиар, цэвэр ашгийн хэмжээ 340 тэрбум төгрөг буюу 74 хувиар тус тус өссөн байна.Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.8 дах хэсэгт "Ногдол ашгийг компанийн татвар төлсний дараах цэвэр ашгаас хуваарилна" гэж, Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 210 дугаар тогтоолоор батлагдсан "Компанийн засаглалын кодекс"-ын 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалтад "Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэрийг нийтэд мэдээлэх ёстой бөгөөд уг мэдээлэл нь ногдол ашгийн хэмжээг тодорхойлсон үндэслэл, төлөх журмын талаар бүрэн ойлголт өгөхүйц байх ёстой." гэж тус тус тусгагдсан байхын зэрэгцээ тус кодект "Компанийн жилийн санхүүгийн тайланд тусгагдсан цэвэр ашгаас бизнес төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгө оруулалт, нийгмийн арга хэмжээний хуваарилалтыг хасаад үлдэх хэсгийг ногдол ашигт хуваарилж байх нь зүйтэй" гэж тайлбарласан байдаг.<br>Энэ хүрээнд "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хурлаар ногдол ашиг хуваарилах асуудлыг | 100 /хяналтаас хасуулах, асуудлыг ЗГ-ын хуралдаанд танилцуулсан./ | |
| | 137 | | XIII.3. . "Таван толгой түлш" ХХК-ийн түүхий эд болох эрчим хүчний баяжуулсан нүүрс (мидлинг)-ийг нөөцлөх дундын агуулах талбайг Улаанбаатар хот, Төв аймгийн нутагт сонгон 1 жилийн хэрэгцээнд зориулан 800.000 хүртэл тонн нөөцийг татан төвлөрүүлэх ажлыг зохион байгуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, "Эрдэнэс Таван толгой" ХК-ийн гүйцэтгэх захирал Б.Ганхуяг нарт даалгав. | "Тавантолгой түлш" ХХК нь Төв аймгийн Сэргэлэн сумын Гүн бүрдийн аманд 12 га газрыг 15 жилийн хугацаатай эзэмших гэрээ байгуулж, дундын бус байгуулсан. Уг дундын бүсэд 427,457 тонн түүхий эд /мидлинг/-ийн нөөцийг татан төвлөрүүлсэн. /Хэрэгжилт-100%/<br><br>2019 оны бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төлөвлөгөөний дагуу түүхий эдийн нөөц, таталт хангалттай байна. | 100 | |
| 99 | 138 | 2019 оны 2 дугаар сарын 20-ны өдөр 8 дугаар тэмдэглэл 2019-02-08 Дугаар 2019_8 | XIII.6. . Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам, авто замын төслүүдийн талаар Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:<br>1. "Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийг эрчимжүүлэх тухай" Засгийн газрын 2018 оны 242 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах арга хэмжээ авч, хэрэгжилтийн явцыг 2019 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн дотор Засгийн газарт танилцуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт даалгав. | Тус яам болон Зам, тээврийн хөгжлийн яамнаас Засгийн газрын тэмдэглэлийн дагуу төмөр замын төслүүдийг эрчимжүүлэх тухай танилцуулга, шийдвэрийн төслүүдийг боловсруулж Засгийн газрын хуралдаанд танилцуулсан болно. Үүний үр дүнд Засгийн газрын 2019 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 135 дугаар тогтоол, 2019 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 189 дүгээр тогтоолууд тус тус батлагдан гарсан болно. | 100 хяналтаас хасуулах | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 139 | | XIII.7. . "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний талаар Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br><br>Үүнтэй холбогдуулан "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн 2018 оны санхүүгийн жилийн ногдол ашиг хуваарилах асуудлыг Засгийн газрын гишүүдийн саналыг авч Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгав. | Засгийн газрын тэмдэглэлийн дагуу Засгийн газрын 2019 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 16 дугаар хуралдаанд "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн 2018 оны санхүүгийн жилийн ногдол ашиг хуваарилах асуудлыг танилцуулсан болно. | 100 | |
| 100 | 140 | 2019 оны 2 дугаар сарын 27-ны өдөр 9 дугаар тэмдэглэл<br>2019-02-27<br>Дугаар 2019_9 | XY.1. . "Эрдэнэс Монгол" ХХК-ийн үйл ажиллагааны талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэ Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br><br>Үүнтэй холбогдуулан "Эрдэнэс Монгол" ХХК-ийн талаар цаашид авах арга хэмжээний талаар тодорхой санал боловсруулан зохих журмын дагуу Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэд, стратегийн орд газруудын нөхцөл байдлын талаар Засгийн газрын дараагийн хуралдаанд танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт тус тус даалгав. | Засгийн газрын 2019.06.12-ны өдрийн хуралдаанд Салхитын мөнгөний орд болон Багануурын хүрэн нүүрсний ордуудын өнөөгийн нөхцал байдлын талаар УУХҮС Д.Сумъяабазар засгийн газрын гишүүдэд танилцуулсан. Үүнтэй холбогдуулан Салхит болон Багануурын ордод хамаарах цуцлагдсан ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлүүдийн талбайд төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээр дамжуулан ашигт малтмал эрэх, хайх, ашиглах зорилгоор тухайн талбайнуудын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэхээр Д.Сумъяабазарт даалгасны дагуу АМГТГ-ын даргад арга хэмжээ авах тухай албан бичгийг 2019.06.26 өдрийн 01/1929 дугаар бичгээр хүргүүлсэн. | 70 | |
| 101 | 141 | 2019 оны 4 дугаар сарын 10-ны өдөр 16 дугаар тэмдэглэл<br>2019-04-10<br>Дугаар 2019_16 | III.. 1. Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн 6, мөн оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 8 дугаар тэмдэглэлээр өгөгдсөн үүргийн дагуу "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн 2018 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах талаар гаргасан тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолыг хүчингүй болгох арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (М.Баяраа)-д даалгав. | Засгийн газрын шийдвэрийн дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллаж байгаа бөгөөд "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 05 тоот тогтоолоор "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн НОГДОЛ АШГИЙН ЖУРАМ" –ыг баталсан. Компанийн 2019 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах эсэх шийдвэрийг Компанийн тухай хуулийн 46.5-д заасны дагуу санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор буюу 2020.02.19-ний өдөр дотор ТУЗ хэлэлцэн шийдвэрлэнэ | 70 | |
| | 142 | | XY.2. . 1. Улаанбаатар хотноо 2019 оны 6 дугаар сарын 4-ний өдөр зохион байгуулах Монгол, Канадын Дугуй ширээний уулзалтын 8 дугаар хуралдаанд оролцох монголын талын төлөөлөгчдийн баримтлах удирдамжийг хэлэлцэн зөвшөөрөв.<br><br>2. Уг хуралдаанд оролцох монголын талын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнийг батлахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд бөгөөд Дугуй ширээний уулзалтын Монголын хэсгийн дарга Д.Сумъяабазарт даалгав. | Монгол-Канадын Дугуй ширээний уулзалтын 8 дугаар хуралдааны мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2019 оны 08 дугаар сарын 07-ны өдөр Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар баталсан бөгөөд хэрэгжилтийг хангаж ажиллах тухай 2019 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 01/2316 дугаар албан бичгийг Гадаад харилцааны яаманд хүргүүлсэн. Тус дугуй ширээний уулзалтыг хоёр жил тутамд зохион хуралдуулдаг тул төлөвлөгөөний хэрэгжилтийн биелэлтийг 2020 оны хоёрдугаар хагас жилд гаргахаар төлөвлөн ажиллаж байна. | 100 хяналтаас хасуулах саналтай | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 102 | 143 | 2019 оны 5 дугаар сарын 29-ны өдөр 24 дүгээр тэмдэглэл 2019-05-29 Дугаар 2019_24 | XX.11. . "Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх Ази, Номхон далайн бүсийн IY конгресс"-ын бэлтгэл ажлын талаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br>Үүнтэй холбогдуулан уг конгрессыг Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор зохион байгуулах ажлын хүрээнд дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд даалгав:<br>1. Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:<br>1.1. конгрессыг угтсан ажлын төлөвлөгөө гарган, шаардагдах хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх;<br>1.2. Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйл, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 128 дугаар зарлиг, Засгийн газрын 2019 оны 111 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг байнгын ажлын байраар хангах санаачилга гаргах;<br>1.3. хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлдвэрлэлийг дэмжих, бараа бүтээгдэхүүний нь худалдан авах;<br>1.4. барилга, байгууламжийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй болгох. | МУ-ын Ерөнхийлөгчийн "Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай" 2018 оны 09 дүгээр 04-ний өдрийн 128 дугаар зарлигийн дагуу УУХҮ-ийн сайдын "Хүний эрх, хүүхдийн эрхийг хамгаалах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжиж ажиллах тухай" 2018 оны 06 тоот албан даалгаврын хэрэгжилтийг 2019 оны эхний хагас жилийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийн 2019 оны 07 дугаар сарын 10-ны өдөр УУХҮ-ийн сайдын зөвлөлийн хуралд танилцуулан сайдаас өгсөн чиглэл дагуу албан даалгаврын хэрэгжилтийг хангах эрчимжүүлж ажиллах талаар агентлаг, аймгуудын Засаг дарга нарт зөвлөмжийг боловсруулан хүргүүлсэн. Жилийн эцсийн байдлаар хэрэгжилт УУХҮЯ-100% АМГТГ-80.5%, 21 аймгууд 73% хэрэгжилттэй ба нийлбэр дүнгээр 84.5%-тай байна. УУХҮЯ болон Ашигт малтмал, газрын тосны газар хамтран салбарт ажиллаж болох хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрны судалгааг хийв. Судалгаанд иргэдийг хөгжлийн бэрхшээлээр ангилан нийт давхардсан тоогоор 69 ажлын байрны урьдчилсан судалгааг гаргав. | 100 хяналтаас хасуулах саналтай | |
| 103 | 144 | 2019 оны 7 дугаар сарын 9-ний өдөр 30 дугаар тэмдэглэл 2019-07-09 Дугаар 2019_30 | XXI.3. 2. . Улсын тусгай хамгаалалтад авах газар нутагт нь ашигт малтмал хайх, ашиглах талбайтай давхцаж байгаа эсэхийг нягталж, шаардлагатай тохиолдолд хууль тогтоомжид заасан зохих арга хэмжээ авахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт даалгав. | Улсын тусгай хамгаалалтад авах 9 газрын асуудлыг БОАЖЯамны боловсруулан УИХ-ын БОХХААБХ-ны хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлсэн. Уг 9 газрыг тусгай хамгаалалтад авах УИХ-ын тогтоолын төслийг чуулганаар хэлэлцэх эсэх асуудлаар 12-р сарын 17-нд хуралдсан. Тусгай хамгаалалтад авах газруудтай ашигт малтмал хайх, ашиглах талбай давхцаж байгаа эсэхийг тодруулж холбогдох саналыг бэлтгэсэн. Дараагийн хуралдаанаар зарим асуудлыг тодруулан танилцуулахаар болсон. | 70 | |
| | 145 | | II.. Улаанбаатар хотноо 2019 оны 6 дугаар сарын 4-ний өдөр зохион байгуулсан Монгол, Канадын Дугуй ширээний уулзалтын 8 дугаар хуралдааны дүнг сайшааж, уг хуралдааны мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд бөгөөд Дугуй ширээний уулзалтын монголын хэсгийн дарга Д.Сумъяабазарт даалгав. | Монгол-Канадын Дугуй ширээний уулзалтын 8 дугаар хуралдааны мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2019 оны 08 дугаар сарын 07-ны өдөр Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар баталсан бөгөөд хэрэгжилтийг хангаж ажиллах тухай 2019 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 01/2316 дугаар албан бичгийг Гадаад харилцааны яаманд хүргүүлсэн. Тус дугуй ширээний уулзалтыг хоёр жил тутамд зохион хуралдуулдаг тул төлөвлөгөөний хэрэгжилтийн биелэлтийг 2020 оны хоёрдугаар хагас жилд гаргана. | 100 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 104 | 146 | 2019 оны 7 дугаар сарын 24-ний өдөр 33 дугаар тэмдэглэл 2019-07-24 Дугаар 2019_33 | III.. ХБНГУ-ын Берлин хотноо 2019 оны 5 дугаар сарын 20-21-ний өдрүүдэд зохион байгуулсан "Ашигт малтмал, аж үйлдвэр, технологийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий Монгол, Германы Засгийн газар хоорондын Ажлын хэсгийн 7 хуралдааны дүнг сайшааж, уг хуралдааны мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, тус Ажлын хэсгийн монголын хэсгийн дарга Д.Сумъяабазарт даалгав. | Ашигт малтмал, аж үйлдвэр, технологийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, ХБНГУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий Монгол, Германы Засгийн газар хоорондын ажлын хэсгийн 7 дугаар хуралдааны мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2019 оны 08 дугаар сарын 07-ны өдөр Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар баталсан бөгөөд төлөвлөгөөг хангаж ажиллах тухай 2019 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 01/2317 дугаар албан бичгийг Гадаад харилцааны яам, ХБНГУ-ын Берлин дэх Элчин сайдын яам, Стандарт, хэмжил зүйн газар зэрэг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн бөгөөд биелэлтийг 2020 оны 03 дугаар сард гаргана. | 100 | |
| 105 | 147 | 2019 оны 8 дугаар сарын 21-ний өдөр 36 дугаар тэмдэглэл 2019-08-21 Дугаар 2019_36 | XYI.8. . Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааны талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт даалгав:<br><br>1. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмыг зөрчиж байгаа, бичил уурхайн нэрийн дор хууль бусаар ашигт малтмал олборлож, байгаль орчныг бохирдуулж буй асуудлыг Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлд танилцуулах;<br><br>2. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааг зохих журмын дагуу цэгцлэх, ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааг зогсоосон талбайг хамгаалалтад авч хууль бус аливаа үйл ажиллагааг дахин гаргуулахгүй байх талаар тодорхой санал боловсруулж Засгийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх. | Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 8 дугаар сарын 21-ны өдрийн хуралдаанаас өгсөн чиглэл, Архангай аймгийн Цэнхэр сумын Орхон багийн нутаг дэвсгэрт нэр бүхий 11 аж ахуйн нэгжийн 13 тусгай тусгай зөвшөөрөл цуцлах тухай Ашигт малтмалын газрын Кадастрын хэлтсийн даргын 2019 оны 8 дугаар сарын 21-ны өдрийн шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын сайд ахалсан ажлын хэсэг 2019 оны 8 дугаар сарын 23-ны өдөр Архангай аймгийн Цэнхэр сумын нутагт ажиллаж холбогдох арга хэмжээг газар дээр нь зохион байгуулсан. Тухайлбал, ашигт малтмалын тусгай зөвшөөрөл цуцлагдсан талбайд байгаа техник, тоног төхөөрөмжийг нүүлгэн гаргах, ухсан нүхийг тэгшилж нөхөн сэргээх, ус хуримтлуулсан даланг сэтэлж усыг гаргаж талбайг түрж тэгшилж аюулгүй болгох зэрэг ажлыг шуурхай зохион байгуулж эхлүүлсэн.<br>Тусгай зөвшөөрөл цуцлагдсан талбайн эвдэрсэн газрыг нөхөн сэргээх ажлыг албадан гүйцэтгүүлэх, цаашид хууль бусаар алт олборлох зөрчил гарахаас сэргийлэх, нинжа нар талбайг ухахаас хамгаалах зорилгоор 12 дугаар сарын 1-ийг хүртэл цагдаа болон мэргэжлийн хяналтын байгууллагын хяналтад авах шийдвэр гарган хэрэгжүүлж ажиллав. 8 дугаар сарын 23-наас 12 дугаар сарын 1-ныг хүртэл Цагдаагийн Ерөнхий газрын Эргүүл тусгай хамгаалалтын тасгийн 160, Архангай аймаг дахь Цагдаагийн газрын 160 нийт 320 алба хаагчид 22 тээврийн хэрэгсэлтэй хамгаалалтыг хэрэгжүүлсэн. Энэ хугацаанд тусгай зөвшөөрөл цуцлагдсан талбайд үйл ажиллагаа явуулж байсан аж ахуйн нэгж, иргэдийн 163 ширхэг техник, тоног төхөөрөмж /Экскаватор 46, утгуурт ачигч 31, автосамосвал 46, алт угаах төхөөрөмж 40/-ийг талбайгаас албадан гаргаж, алт угаах зориулалтаар ашиглаж байсан | 100 /хяналтаас хасуулах саналтай/ | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 106 | 148 | 2019 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр 40 дүгээр тэмдэглэл 2019-09-18 Дугаар 2019_40 | XYI.6. . Үүнтэй холбогдуулан: “Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төслийн хүрээнд үйлдвэрт нийлүүлэх дотоодын түүхий тосыг тээвэрлэх дэд бүтцийн талаар үр ашгийн харьцуулсан тооцоо, судалгаа хийж, боловсруулсны үндсэн дээр Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх арга хэмжээ авахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар болон холбогдох ажлын хэсэгт даалгав. | Ерөнхий сайдын 2019 оны 118 дугаар захирамжаар газрын тос боловсруулах үйлдвэрт шаардлагатай дотоодын түүхий тосыг тээвэрлэх дэд бүтцийн оновчтой хувилбарыг тодорхойлох, шаардлагатай тооцоо судалгааг хий, техник технологийн шийдэл, хөрөнгө оруулалтын талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Энэхүү захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг гурван удаа хуралдаж, үйлдвэрт шаардлагатай түүхий эдийг тээвэрлэх дэд бүтцийн боломжит хувилбаруудын талаар мэдээ мэдээлэл, тооцоо судалгаа, хөрөнгө оруулалт, техник технологийн шийдлийг тодорхойлох зорилгоор холбогдох байгууллагуудаас баримт материалуудыг цуглуулсан. Гэвч дэд бүтэц болгон өөрийн гэсэн давуу ба сул талуудтай байдаг бөгөөд тухайн орны онцлог, бүс нутгийн хөгжилд нөлөөлөх байдал, байгаль орчинд хэрхэн нөлөөлөл үзүүлэх, тээвэрлэлт хийх түүхий эд, бараа материал, эцсийн бүтээгдэхүүн нь тухайн орны эдийн засагт хэрхэн нөлөөлөх, зах зээлийн эрэлт нийлүүлэлт бий эсэх, эрсдэлгүй, тасралтгүй найдвартай тээвэрлэлт хийх боломжтой эсэхийг харгалзан үзэх шаардлага тулгарсан. Ажлын хэсгийн зүгээс их хэмжээний түүхий тосыг хол зайд тээвэрлэхэд тохиромжтой дэд бүтцийн хувилбар болох төмөр зам болон дамжуулах хоолойн тээвэрлэлтийг манай нөхцөлд тохирох боломжтой гэж үзэн эдийн засгийн үр ашгийн харьцуулсан судалгааг Монголын логистикийн холбоо ТББ-аар хийж гүйцэтгүүлэн тайланг 2019.12.18-ний өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулсан. Хэрэгжилт-100% | 100 /тос дамжуулах тээврийн асуудлаар гарсан тайланг ЗГ-ын 2019.12.18 өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэр гарсан тул хяналтаас хасуулах саналтай/ | |
| 107 | 149 | 2019 оны 10 дугаар сарын 2-ны өдөр 42 дугаар тэмдэглэл 2019-10-02 Дугаар 2019_42 | XYI.8. . Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх Ази, Номхон далайн бүсийн 4 дүгээр конгрессыг зохион байгуулсан дүнгийн талаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх Ази, Номхон далайн бүсийн 4 дүгээр конгрессоос баталсан “Улаанбаатарын тунхаглал”-д дурдсан ажлыг жил бүрийн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүдэд даалгав. | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх Ази, Номхон далайн бүсийн 4 дүгээр конгрессоос баталсан “Улаанбаатарын тунхаглал”-д дурдсан ажлыг хэрэгжүүлэхээр 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан. | 100 | |
| 108 | 150 | 2019 оны 10 дугаар сарын 15-ны өдөр 44 дүгээр тэмдэглэл 2019-10-15 Дугаар 2019_44 | I.2. . Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарт 2020-2024 онд хэрэгжүүлэх бодлого, бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээний талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан улсын эдийн засагт чухал ач холбогдол бүхий нэмүү өртөг шингэсэн томоохон бүтээн байгуулалтын асуудлыг судлан шийдвэрлэх талаар холбогдох арга хэмжээ авч дор дурдсан төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар онцгой анхаарч, зохион байгуулж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгав: | Тэмдэглэлээр өгөгдсөн үүргийг хэрэгжүүлэх талаар холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна. | 30 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 109 | 151 | 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр 50 дугаар тэмдэглэл 2019-11-13 Дугаар 2019_50 | YIII.1. . Үүнтэй холбогдуулан Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг яаралтай боловсруулж Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх, хяналт, шалгалтын үр дүнгээр холбогдох хууль тогтоомжид заасан үүргээ биелүүлээгүй нь тогтоогдсон хуулийн этгээдийн ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг зохих журмын дагуу цуцлах арга хэмжээг авч байхыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Х.Хэрлэн нарт даалгав. | Уул уурхайн үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг нэмэгдүүлэх, ялангуяа Байгаль орчныг хамгаалах тухай хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй аж ахуйн нэгжид хариуцлага тооцох эрх зүйн үндэс бий болгох зорилгоор "Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль"-ийг УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар 2019 оны 5 дугаар сарын 2-ны өдөр хэлэлцэж баталсан. Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.5-д заасныг үндэс болгон 2019 онд Өмнөговь аймгийн Гурвантэс, Номгон, Архангай аймгийн Цэнхэр сумын нутаг дэвсгэрт нийт 20 аж ахуйн нэгжийн 25 ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг цуцалсан. | 100 /хяналтаас хасуулах саналтай/ | |
| 110 | 152 | 2019 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр 51 дугаар тэмдэглэл 2019-11-19 Дугаар 2019_51 | XIII.1. . Үйлдвэрлэлийн болон өрөмдлөгийн үйл ажиллагаанаас үүсч байгаа газрын тосны бүтээгдэхүүн, химийн бодис агуулсан шингэн хаягдлыг дахин боловсруулж, байгаль орчинд ээлтэй арга, аргачлалаар устгах буюу саармагжуулах арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт; | Бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайн хайгуул, ашиглалтын ажлын жилийн төлөвлөгөө, төсөвт байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын төлөвлөгөө, төсвийг тогтмол суулган баталж байгаа ба гэрээлэгчид байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх хууль, журмын дагуу байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх менежментийн төлөвлөгөө, хэрэгжилтийн тайланг БОАЖЯ-нд тогтмол хүргүүлэн, дүгнэлт гаргуулан ажиллаж байна. Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагааны үеийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх тухай хууль журмын хэрэгжилтэд хяналт тавьж, заавар, зөвлөгөө өгч, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Газрын тосны хайгуул, олборлолт, ашиглалтын үйл ажиллагаа эрчимжихийн хэрээр байгаль орчныг хамгаалах, газрын тостой холбогдсон үйл ажиллагааны үед ялгарч буй хаягдлын ялгарлыг багасгах, дахин ашиглах, хог хаягдлын талаарх менежментийг сайжруулах, олон улсын дэвшилтэт технологийг нутагшуулах шаардлага зүй ёсоор тулгарч байна. Иймд УУХҮ-ийн сайд болон БОАЖ-ын сайд нарын 2019.03.26-ны өдрийн А/58, А/104 дугаар хамтарсан тушаалаар газрын тосны олборлолт, ашиглалтын үйл ажиллагааны үед ялгарч буй хаягдлыг халгалах, дахин боловсруулах, устгахтай холбоотой асуудлыг судалж санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэг 2019 оны 3 дугаар сарын 26-28-ны өдрүүдэд Дорнод аймгийн нутагт орших газрын тосны ашиглалтын Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайд ажиллан газрын тосны ашиглалт, олборлолтын үйл ажиллагааны үед ялгарч шингэн хаягдлын нөхцөл байдалтай газар дээр нь үзэж танилцан, шингэн хаягдлын далангуудаас дээж авч, шинжлүүлсэн ба шингэн хаягдлыг ялгаруулагч эх үүсвэр, хэмжээг тодорхойлоход шаардлагатай мэдээ [illegible] | 70 | |
| 3Г-ын албан даалгавар | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 111 | 153 | Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлтийг хангуулах зарим арга хэмжээний тухай<br>2019-08-08<br>Дугаар 2019_01 | 2.. Засгийн азрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулиар өөрийн эрхлэх асуудлын хүрээ, тухайн албарын хэмжээнд батлагдсан төсөл, арга хэмжээний ач холбогдол, явц байдал, үр дүнгийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол мэдээлж, нээлттэй өдөрлөг, танилцуулгыг үе шаттайшаар нэгдсэн болон тусгайлсан хэлбэрээр зохион байгуулж, олон нийтэд сурталчилан ажиллахыг Засгийн газрын гишүүд, Аймаг, нийслэлийн Засаг дарга, Агентлагийн дарга нарт; | а/ УУХҮЯ, Нээлттэй нийгэм форум, Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн, Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга(ОҮИТБС)ын ажлын алба, Олон улсын санхүүгийн корпорац зэрэг байгууллага хамтран ажилласны үр дүнд Монгол Улсын хэмжээнд уул уурхай, газрын тосны салбарт байгуулагдсан 14 төрлийн 436 гэрээг нийтэд ил болгосон. б/ 2019 оны байдлаар яамны үйл ажиллагааг 11 сайт, 4 өдөр тутмын сонин, 19 телевиз, 2 радио, 2 сэтгүүл болох хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр цаг тухай бүрт нь гаргасан байна. в/ 2019 оны байдлаар "Ил тод, хариуцлагатай уул уурхай" хэвлэлийн бага хурлыг нийт 5 удаа зохион байгуулсан. Үүнд: "Ил тод" уул уурхайн хэвлийн бага хурлыг 1 сарын 31, 3 сарын 15, 5 сарын 14, 6 сарын 26, 12 сарын 17-нд тус тус зохион байгуулсан. г/ 2019 оны байдлаар яамны цахим хуудсанд цаг үеийн 170 мэдээ, статистик мэдээ 20, видео мэдээ 21, тайлан мэдээ 13, хэлэлцүүлэг 10, тусгай зөвшөөрөл 4, хуулийн тогтоол 2, төсөл хөтөлбөр 5, ил тод байдал 1 мэдээг тогтмол шинэчлэн оруулсан. | 100 /Албан даалгаврын хэрэгжилт бүрэн хангагдсан тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ/. | |
| 112 | 154 | Төрийн үйлчилгээнд цахим төлбөр тооцоог нэвтрүүлэх тухай<br>2019-10-16<br>Дугаар 2019_03 | 1.1. Иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний төлбөр тооцоонд "Цахим төлбөрийн баримтын систем" /ebarimt/ нэвтрүүлэх ажлыг 2019 онд багтаан иргэдэд чиргэдэл үүсгэлгүйгээр шуурхай зохион байгуулах. | УУХҮ-ийн сайдын 2019 оны 11 дүгээр сарын 4-ний өдрийн А/216 дугаар тушаалаар батлагдсан "Үндэсний геомэдээллийн сан үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ны 2.6.2 "Цахим үйлчилгээний төлбөрийн систем нэвтрүүлэх" арга хэмжээг 2020 онд хэрэгжүүлэхээр төлөвлөгөөнд оруулсан. | /-/ хэрэгжилт тооцох хугацаа болоогүй | |
| | 155 | | 1.2. Цахим төлбөр тооцоонд шилжихтэй холбоотойгоор үйлчилгээний ажилтнуудыг сургаж бэлтгэх, төлбөр тооцооны системийн талаар иргэдэд сурталчилан таниулах. | Албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна. | /-/ хэрэгжилт тооцох хугацаа болоогүй | |
| | 156 | | 1.3. Цахим гарын үсгийн хуулийн хэрэгжилтийг хангаж, төрийн үйлчилгээнд тоон гарын үсгийг нэвтрүүлэх. | Албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна. | /-/ хэрэгжилт тооцох хугацаа болоогүй | |
| | 157 | | 1.4. Төрийн үйлчилгээний шимтгэл, төлбөрийн хэмжээг бууруулах. | Албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна. | /-/ хэрэгжилт тооцох хугацаа болоогүй | |
| | 158 | | 1.5. Төрийн үйлчилгээнд цахим төлбөр тооцоог нэвтрүүлэхтэй холбогдуулан шаардлагатай бол эрхлэх асуудлын хүрээнд болон нутаг дэвсгэррийн хэмжээнд мөрдөж байгаа эрх зүйн актуудад зохих өөрчлөлт оруулах. | Албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна. | /-/ хэрэгжилт тооцох хугацаа болоогүй | |
| | 159 | | 3.. Албан даалгаврын хэрэгжилтийг дүгнэж, тайланг улирал бүр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг улирал тутам Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэд. | Албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна. | /-/ хэрэгжилт тооцох хугацаа болоогүй | |
| | | | | | 90.6 | |

| Хяналтаас хасуулах саналтай хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн жагсаалт | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам | | | | | | |
| 2019 оны жилийн эцэс | | | | | | |
| 2020 оны 1 сарын 15 өдөр | | | | | | |
| **Шийдвэрийн д/д** | **Заалтын д/д** | **Шийдвэрийн нэр, огноо, дугаар** | **Холбогдох заалтын агуулга** | **Хэрэгжилтын явц** | **Үнэлгээ, (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал)** | **Тасарсан болон удааширч байгаа шалтгаан** |
| МУ-ын хууль | | | | | | |
| 1 | 1 | Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай (шинэчилсэн найруулга)<br>2013-01-31<br>Дугаар 2013.01.31 | 10.1. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэрийн болон хадгалах байр, агуулах дахь аюулгүй ажиллагааны журмыг геологи, уул уурхайн болон батлан хамгаалахын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мэргэжлийн хяналтын төв байгууллагатай хамтран батална. | Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм"-ийг Засгийн газрын 2019.08.07-ны өдрийн 313 дугаар тогтоолоор батлуулсан. | 100 /хуулийн заалт хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай/ | |
| 2 | 2 | ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ<br>/Шинэчилсэн найруулга/<br>2014-07-01<br>Дугаар 2014_06 | 8.1.3. газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланд тавих шаардлага; газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын анхдагч болон үр дүнгийн тайланд тавих шаардлага; газрын тосны орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тавих шаардлага; гэрээлэгчийг сонгон шалгаруулах тухай; газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын талбайг буцаан өгөх, хүлээн авах; газрын тос, уламжлалт бус газрын тосны чиглэлээр мэргэжлийн зэрэг олгох журмыг батлах; | "Газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланд тавих шаардлага"-ын төслийг боловсруулах ажлыг MINIS төслөөс санхүүжүүлэхээр тохиролцон, ажлын даалгаврыг боловсруулан MINIS төсөлд хүргүүлээд байсан боловч тодорхой шалтгааны улмаас санхүүжилт хийгдэх боломжгүй болсон. Иймд тус журмыг боловсруулахад шаардлагатай суурь судалгаа хийх, олон улсын туршлага, мөрдөж буй арга аргачлалын харьцуулсан судалгаа хийж, манай орны нөхцөлд тохирсон арга, аргачлалын төсөл боловсруулах эрдэм шинжилгээ, судалгааны зөвлөх үйлчилгээ үзүүлэх тендерийн төсвийг УУХҮ-ийн сайдын 2020 оны төсвийн багцад суулган батлаад байна. "Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын анхдагч болон үр дүнгийн тайланд тавих шаардлага" журмыг Уул уурхайн сайд /хуучин нэрээр/-ын 2015.03.10-ны 49 дүгээр тушаалаар, "Газрын тосны орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тавих шаардлага" журмыг мөн Уул уурхайн сайдын 2015.09.04-ний өдрийн 197 дугаар тушаалаар тус тус баталсан ба Захиргааны ерөнхий хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018.01.10-ны өдрийн А/07 дугаар тушаалаар батлан мөрдөж байна. "Гэрээлэгчийг сонгон шалгаруулах тухай журам"-ыг мөн Уул уурхайн сайд /хуучин нэрээр/-ын 2014 оны 202 дугаар тушаалаар, "Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын талбайг буцаан өгөх, хүлээн авах" журмыг сайдын 2015.09.04-ний өдрийн 196 дугаар тушаалаар баталсан. Мөн Захиргааны ерөнхий хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018.01.10-ны өдрийн А/06-р тушаалаар батлан мөрдөж байна. "Газрын тос, уламжлалт бус газрын тосны чиглэлээр мэргэжлийн зэрэг олгох журам"-ыг Уул уурхайн сайд /хуучин нэрээр/-ын 2015.03.12 | 100 /нийт 6 шаардлага, журам батлаж мөрдүүлэхээс 5-ыг баталж хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа ба нэг шаардлагын төслийг боловсруулсан. Хяналтаас хасуулах саналтай/ | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 3 | | 8.1.8. газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг нөхөн сэргээх ажлын үр дүнг хүлээн авах журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах; | Журмыг УУХҮСайд болон БОАЖСайд нарын 2018.02.22-ны өдрийн А/50, А/31 дугаар хамтарсан тушаалаар батлан, Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэдэх Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 2018.03.06-ны өдрийн 3870 дугаарт бүртгүүлсэн. /Хэрэгжилт-100%/ | 100 /журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран баталсан тул хяналтаас хасуулах/ | |
| 3 | 4 | АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ<br>2015-02-18<br>Дугаар 2015 | 472.2.. Энэ хуулийн 472.1-д заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээг Засгийн газар батална. 47.6 | АМТХ-ийн төслийн үзэл баримтлалыг хууль зүй дотоод хэргийн яамаар батлуулж яамдаас санал авсны үндсэн дээр Засгийн газрын 2018.10.24-ний хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжүүлж 2019.03.26-ны өдрийн УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн уг хуулийн төслийг батлуулсан. Засгийн газрын 2019.09.04 өдрийн 342 дугаар тогтоолоор Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг тооцох, төлбөр ногдуулах, тайлагнах, төлөх журам", "Гадаадын зах зээлд борлуулсан нүүрс, төмрийн хүдэр, төмрийн хүдрийн баяжмалд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулах борлуулалтын үнэлгээ тооцох журам"-ыг тус тус батлуулсан. Төлбөрийн хувь хэмжээнд 2019.11.22 өдрийн АМТХ-д нэмэлт өөрлөлт оруулсан. | 100 /АМНАТ-ийн хувь хэмжээг шинэчлэн тогтоосон тул хяналтаас хасуулах саналтай/ | |
| 4 | 5 | Үйлдвэрлэлийг дэмжих тухай<br>2015-07-09<br>Дугаар 2015.07.09 | 6.1.1.. "6 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх 6.1.1. Үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлах, хэрэгжилтийг хангах;" | 2019.11.13-ны өдөр батлагдсан Үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулиар Үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль 2020.01.01-ний өдрөөс хүчингүй болсон. | /-/ хууль хүчингүй болсон тул хяналтаас хасуулах саналтай. | 2019.11.13 өдөр Засгийн газрын тусгай сангийн тухай хууль батлагдаж, Үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль хүчингүй болсон. |
| УИХ-ын тогтоол | | | | | | |

| | | | |
|---|---|---|---|
| | 6 | | 1.2.б. б/хувьцааны 10 хүртэлх хувийг 2010 оны 6 дугаар сарын 30-ны өдөр ба түүнээс өмнө улсын бүртгэлд бүртгэгдэн үйл ажиллагаа явуулж байгаа, татвар төлсөн үндэсний аж ахуйн нэгжүүдэд адил тэнцүү хэмжээгээр, нэрлэсэн үнээр худалдах; |

| | | | |
|---|---|---|---|
| | 2010 оны 6 дугаар сарын 30-ны өдөр ба түүнээс өмнө улсын бүртгэлд бүртгэгдэн үйл ажиллагаа явуулж байгаа, татвар төлсөн үндэсний аж ахуй нэгжүүдэд хувьцааны 10 хүртэлх хувийг худалдаж, нийт 29.2 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн. Гэвч хувьцааг ОУ-ын зах зээлд гаргах зэрэг хөдөлгөөн хийгдээгүй, аж ахуй нэгжүүд удаа дараа хүсэлт гаргасан учраас Засгийн газрын 2013 оны 132, 409 дүгээр тогтоолоор нийт 21.3 тэрбум төгрөгийг буцаан ААН-үүдэд шилжүүлсэн, 1 сая төгрөг авах хүсэлт гаргасан эмзэг бүлгийн хэсэг иргэдэд 1.7 тэрбум төгрөгийг олгож, 6.2 тэрбум төгрөг үлдсэн бөгөөд хувьцаа худалдсанаас төвлөрсөн хөрөнгийг арилжааны банкинд хадгалсаны хүүгийн төлбөр 1.7 тэрбум төгрөгийн хамт нийт 7.9 тэрбум төгрөгийг Хүний хөгжил сангийн тухай хуулийн 3.1.1-т заасны дагуу тус санд төвлөрүүлсэн. Засгийн газрын 2017 оны 154 дугаар "Эрдэнэс Монгол" ХХК болон түүний охин компанийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Сангийн яам, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн мэдээлэлтэй, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-ийн бүртгэл дэх хувьцаа эзэмшийгчийн мэдээллийг тулгаж бүртгэсэн дүнгээр нийт 486 аж ахуйн нэгж 7,065,038 ширхэг хувьцаа буюу “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нийт хувьцааны 0.05 хувийг эзэмшиж байна. | 100 /тогтоолын заалтыг хэрэгжүүлсэн тул хяналтаас хасуулах саналтай/ | |

| | | | |
|---|---|---|---|
| 5 | 7 | Таван толгойн нүүрсний ордыг ашиглах зарим асуудлын тухай<br>2010-07-07<br>Дугаар 02_2010_39 | 1.2.в. хувьцааны 30 хүртэлх хувийг гадаад, дотоодын хөрөнгийн биржээр худалдаж шаардлагатай хөрөнгө оруулалтыг татах;<br>*УИХ-ын 2012 оны 18 дугаар тогтоолоор уг дэд заалтын "30 хүртэлх хувийг" гэснийг "20 хүртэлх хувийг" гэж өөрчилсөн.* |

| | | |
|---|---|---|
| Засгийн газрын 2012 оны 181 дүгээр тогтоолоор "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн хувьцааг иргэн, аж ахуйн нэгжийн хооронд худалдах, худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хүрээнд тус компанийн 1072 хувьцааг 1 сая төгрөгтэй дүйцүүлэн тухайн хувьцааны нэрлэсэн үнийг 933 төгрөгөөр тогтоосон. Харин Засгийн газрын 2016 оны 316 дугаар тогтоолоор "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн хувьцааны хоёрдахь зах зээлийн арилжаа эхлэх хүртэл хугацаанд дээрх хувьцааг саналын эрхгүй, Засгийн газарт нэрлэсэн үнээр нь худалдахаас бусад тохиолдолд аливаа хэлбэрээр захиран зарцуулахгүй байх нөхцөлтэйгээр иргэдэд эзэмшүүлэх, үндэсний аж ахуйн нэгжид худалдах ажлыг зохион байгуулах нь зүйтэй гэж үзсэн. Тус яамаас "Тавантолгойн ордын талаар авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их хурлын тогтоолын төслийг боловсруулж, 2018 оны 6 дугаар сарын 29-ны өдрийн 73 дугаар тогтоолоор батлуулсан. Уг тогтоолд Улсын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоолын 1 дэх заалтын 2 дахь дэд заалтын "б", "в"-д заасны дагуу стратегийн ач холбогдол бүхий Тавантолгойн нүүрсний ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьцааны 30 хүртэлх хувийг гадаад, дотоодын хөрөнгийн биржээр арилжаалан, шаардлагатай хөрөнгө оруулалтыг татсаны үндсэн дээр Тавантолгойн ордын үнэ цэнийг өсгөх хүрээнд холбогдох дэд бүтцийн болон шаардлагатай бусад төсөл, хөтөлбөрийн тодорхой хэсгийг санхүүжүүлэхийг Засгийн газарт үүрэг болгосон. Улсын Их хурлын тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд тус яамнаас "Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын тогтоолыг төслийг боловсруулж, 2019 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн 296 дугаар тогтоолоор батлуулсан. Уг тогтоолоор "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн иргэд, аж ахуйн нэгжийн | 100 /төрийн захиргааны төв байгууллагын зүгээс авч хэрэгжүүлэх арга хэмжээг бүрэн авсан тул хяналтаас хасуулах саналтай/ | |

| | | | |
|---|---|---|---|
| 6 | 8 | Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай<br>2015-02-17<br>Дугаар 2015_36 | 11. 11/энэ тогтоолын 1 дэх заалтын 10 дахь дэд заалтад заасан нэгдсэн бодлогын агуулгад нийцсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах.<br>*10/цахилгаан эрчим хүч, ган, нүүрснээс синтетик байгалийн хий үйлдвэрлэж, экспортлох асуудлаар нэгдсэн бодлого боловсруулж 2015 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор Улсын Их Хуралд танилцуулах* ; |

| | | |
|---|---|---|
| УИХ-ын 2015 оны 6 дугаар сарын 19-ны өдрийн 62 дугаар тогтоолоор батлуулсан. Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогын бичгийн 4.2.3.6, УИХ-ын 2015 оны 36 дугаар тогтоолын 1 дэх заалтын 10 дахь дэд заалтад заасан нэгдсэн бодлогын агуулгад нийцсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд МУ-ын Засгийн газрын 2016 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 107 дугаар тогтоолыг үндэслэн УУХЯ-ны сайдын 2016 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн А/43 тоот тушаалаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны дэргэд "Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр барих" төсөл хэрэгжүүлэх нэгж байгуулан ажиллаж байна. Тус төслийн нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэл (НТЭЗҮ) болон Байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээг Дэлхийн банкны санхүүжилтээр Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл (УУДБХОДТ)-ийн хүрээнд боловсруулсан. БНХАУ-ын Ухуан инженеринг компанийн (Wuhuan engineering) боловсруулсан төслийн НТЭЗҮ-ийг 2017 оны 5 дугаар сард Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцэн баталсан бол Дэлхийн банкны стандарт, шаардлагад нийцсэн Байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний эцсийн тайланг Монгол Улсын "Грийн трендс" ХХК боловсруулан 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдөр УУХҮЯ-д хүлээлгэн өгснөөр тус төслийн санхүүжилт, хөрөнгө оруулалтыг татах, гэрээ хэлцэл хийхэд шаардлагатай олон улсын банк санхүүгийн байгууллагын шаардлагыг хангасан үндсэн баримт бичиг бэлэн болоод байна. Төсөл дээр хамтран ажиллах сонирхолтой гадаад хөрөнгө оруулагчдын зөвлөсний дагуу төслийг бага хөрөнгө оруулалтаар үе шаттайгаар хэрэгжүүлж НТЭЗҮ-д | **100 /төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого УИХ-ын 2015.06.19 өдрийн 62 дугаар тогтоолоор батлагдсан, бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан ажиллаж байгаа тул хяналтаас хасуулах саналтай/** | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 7 | 9 | Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2016-11-17 Дугаар 2017 №69 | 1.2.2. түүхий нефтийн экспортоос нөөц ашигласны төлбөрийг тооцож авах, борлуулалтын орлогыг Монгол Улсад бүртгэлтэй арилжааны банкаар дамжуулан гүйцэтгэх хуулийн шаардлагыг бүтээгдэхүүн хуваах гэрээнд тусгах гэрээ хэлцлийг хийж, дүнг Улсын Их Хуралд танилцуулах. | Засгийн газрын 2018.01.03-ны өдрийн 5 дугаар тогтоолоор "Газрын тосны нөөц ашигласны төлбөр, тусгай зөвшөөрлийн төлбөрийг төлөх, хуваарилах, зарцуулах журам"-ыг батлуулсан. Газрын тосны борлуулалтын орлогоос нөөц ашигласны төлбөрийг тооцож 2017 онд 31.7 тэрбум төгрөг, 2018 онд 33.5 тэрбум төгрөгийг тус тус улсын төсөвт төвлөрүүлсэн. Засгийн газрын 2015 оны 03 дугаар сарын 104 дүгээр тогтоолоор батлагдсан, Бүтээгдэхүүн хуваах гэрээний загварын 15 дугаар зүйлийн 15.1.2-т Газрын тосны тухай хуулийн 11.2.6-ийн "хөрөнгө оруулалт, борлуулалтын орлоготой холбоотой гүйлгээг Монгол Улсад бүртгэлтэй арилжааны банкаар дамжуулан гүйцэтгэх бөгөөд уг гүйлгээг санхүүгийн тайланд ил тод, нээлттэй бүрэн тусгах" заалтыг тусган баталгаажуулсан. Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдахаас өмнө байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдийг дээрх загварт нийцүүлэн шинэчлэх ажлыг зохион байгуулж, гэрээлэгчидтэй хэлэлцээр хийн, газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулж буй нэр бүхий 11 компанитай байгуулсан БХГ-г шинэчлэн, Газрын тосны тухай хуулийн 11.2.6 дахь заалтыг гэрээнд тусган батлаад байна. /Хэрэгжилт-50%/ | 100 /Уг тогтоолын холбогдох заалт нь нэг удаагийн үйлчлэлтэй, 2017 оны санхүүгийн жил дуусгавар болсон байх тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ/ | |
| 8 | 10 | Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 2017-11-14 Дугаар 2017_69 | 1.. 1/Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуульд бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагч нарын багцад "сахилга, хариуцлага, ажлын үр дүнг урамшуулах" зориулалтаар батлагдсан хөрөнгийг зарцуулахтай холбогдуулан төрийн албан хаагчийн сахилга, хариуцлага, үйл ажиллагааны үр дүн болон хөдөлмөрийн гэрээг хагас, бүтэн жилээр үнэлж, дүгнэх, ажлын бүтээмж, гүйцэтгэлийн үр дүнд үндэслэн урамшуулах тогтолцоог бий болгох, энэ талаар холбогдох журам баталж мөрдүүлэх; | Төрийн албан хаагчийн сахилга, хариуцлага, үйл ажиллагааны үр дүн болон хөдөлмөрийн гэрээг хагас, бүтэн жилээр үнэлж, дүгнэх, ажлын бүтээмж, гүйцэтгэлийн үр дүнд үндэслэн урамшуулах тогтолцоог Төрийн албаны тухай хууль Төрийн албаны зөвлөлөөс баталсан дүрэм журамд нийцүүлэн дотоод журамдаа тусган, хэрэгжүүлж ажиллаж байна. 2019 оны жилийн эцсийн байдлаар сахилгын шийтгэл авсан хүн байхгүй байна. | 100 /хуулийн заалтыг хэрэгжүүлсэн, хууль нь нэг удаагийн үйлчлэлтэй байх тул хяналтаас хасуулах саналтаай/ | |
| УИХ-ын байнгын хорооны тогтоол | | | | | | |

| | | | |
|---|---|---|---|
| 9 | 11 | Засгийн газарт чиглэл өгөх тухай<br>2011-01-19<br>Дугаар 2011_01 | II.1.1. МУ-ын Их Хурлын 2009 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн 57 дугаар тогтоолын 3 дахь заалтын биелэлтийг хангах, АМТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль шинээр батлагдсантай холбогдуулан дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг МУ-ын Засгийн газар /С.Батболд/-т чиглэл болгосугай<br>Эрх зүйн орчныг бүрдүүлэх замаар анхны хөрөнгө оруулалтаа нөхсний дараа төрийн эзэмшлийн хувьцааны хэмжээг 50-иас доошгүй хувьд хүргэж нэмэгдүүлэх асуудлаар хөрөнгө оруулагч талтай байгуулсан гэрээний нөхцөлийг сайжруулах талаар хэлэлцээ хийж шийдвэрлэх |

| | | |
|---|---|---|
| 2015 оны 5 дугаар сарын 18-ны өдөр Монгол Улсын Засгийн Газар (Эрдэнэс Оюу Толгой ХХК) болон Туркойс Хилл Ресурсес Лимитед, Ти Эйч Ар Оюу Толгой Лтд, Оюу Толгой Нидерланд Би Ви, Рио Тинто Интернэшнл Холдингс Лимитед болон Оюу Толгой ХХК-ийн хооронд Оюу толгой төслийн 2 дахь шат буюу Далд Уурхайн Бүтээн байгуулалтын,санхүүжилтийн гэрээг байгуулсан.<br>Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын ажил хэвийн явагдаж байна. Мөн Улсын Их хурлын даргын 2018 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 57 дугаар захирамжаар Оюу Толгой ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний хэрэгжилтийг шалгаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Тус яамнаас уг ажлын хэсгийн хүрээнд байгуулагдсан дэд ажлын хэсэгт холбогдох албан тушаалтнууд ажиллаж, холбогдох санал, дүгнэлтийг боловсруулан Улсын Их хурлын даргын 2018 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 57 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт хүргүүлсэн. Ажлын хэсэг холбогдох санал, дүгнэлтийг нэгтгэн Оюу толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай" Улсын Их хурлын тогтоолын төслийг боловсруулж, 2019 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 92 дугаар тогтоолоор батлуусан. Уг тогтоолын 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт "Оюу толгой төслөөс хүртэх Монголын талын үр өгөөжийг Хөрөнгө оруулалтын гэрээ болон 2010 оны техник, эдийн засгийн үндэслэлийн тооцоололд зааснаар нэрлэсэн үнээр 53 хувиас бууруулахгүй байх хүрээнд Монголын талын эзэмшлийн 34 хувийн хувьцаа эзэмшлийг бүтээгдэхүүн хуваах нөхцөл, эсвэл ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулах хувилбаруудыг судлан шийдвэрлэх, шаардлагатай тохиолдолд холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах тухай санал боловсруулан | 100 /яамны зүгээс авч хэрэгжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн/ | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 10 | 12 | Шалгалтын мөрөөр авах зарим арга хэмжээний тухай 2015-04-08 Дугаар 2015-04-08-10 | 1.5. Засгийн газарт болон "Эрдэнэс таван толгой" ХК, "Эрдэнэс монгол" ХХК-д эдийн засгийн байнгын хороо, Үндэсний аудитын газрын хамтарсан шалгалтын ажлын хэсгээс өгсөн чиглэл, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авах | УИХ-ын Эдийн засгийн Байнгын хороо, Үндэсний аудитын газраас "Эрдэнэс Тавантолгой" ХК, "Эрдэнэс Монгол" ХХК-д өгсөн чиглэл, зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар холбогдох чиглэл өгч ажилласан. Тухайлбал, Тавантолгойн Цанхийн Зүүн уурхайн гэрээт олборлолтын ажлын хөлс болон нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийн үнийг бүрэн төлж барагдуулах талаар шуурхай арга хэмжээ авч ажиллах тухай албан тоот /2015.04.28-ны 1/1004/-ыг "Эрдэнэс Тавантолгой" ХК-д хүргүүлсэн. "Эрдэнэс-Тавантолгой" ХК нийт 45.8 сая тонн нүүрс олборлож, 4.6 их наяд төгрөг буюу 2.1 тэрбум ам.долларын борлуулалтын орлоготой ажилласнаас 2017, 2018 онд 3.1 их наяд төгрөг, үүнээс 2018 онд 1.99 их наяд төгрөгийн орлоготойгоор 2010 оноос хойш үүссэн гадаад, дотоод өр төлбөрийг бүрэн төлж барагдуулсан. 2018 онд улсын төсөвт 510 тэрбум төгрөг төвлөрүүлж, компанийн цэвэр ашгийг 720 тэрбум төгрөгт хүргэсэн. 2016 оны 1-р улирлад Чалко компанид нэг тонн нүүрсийг 24.97 ам.доллар нийлүүлж байсан бол 2017 оны 1-р улиралд 59.33 ам.доллар, 2018 оны 2-р улиралд 61.0 ам.доллар, 2019 оны 1-р улирлаас 63.32 ам.доллар болгож нэмэгдүүлснээр үнийг 2.5 дахин өсгөсөн. | 100 /зөвлөмжийн хэрэгжилтийг хангасан тул хяналтаас хасуулах саналтай/ | |
| | 13 | | 3. Оюу толгой ордыг ашиглахтай холбогдуулан хувь нийлүүлэгчдийн хооронд нягтлан бодох бүртгэлийн стандартын зөрүү, уул уурхайн салбарт хуримтлуулсан туршлагын ялгаа зэргээс хамааран үл ойлголцол, хууль тогтоомжийн зөрүү зэргийг арилгах, олон улсын болон Монгол Улсын холбогдох стандарт, дүрэм журмыг нэг мөр болгож цэгцлэх, олон нийтийг үнэн зөв, бодитой мэдээллээр хангах | Хүдрийн далд уурхайн аюулгүй байдлын дүрэм"-ийг шинэчлэн боловсруулж Уул уурхай сайд, Хөдөлмөрийн сайдын 2015 оны 11 дүгээр сарын 19-ны өдрийн 229/А/232 дугаар хамтарсан тушаалаар батлуулж мөрдүүлэн ажиллаж байна. Ингэснээр Оюутолгойн далд уурхайн бүтээн байгуулалтын ажлыг олон улсын стандарт шаардлагад нийцсэн дүрмийн дагуу явуулах боломж бүрдсэн. Мөн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг Монгол Улсад мөрдөж байгаа холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж байна. | 100 /яамны түвшинд авч хэрэгжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн/ | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 11 | 14 | Чиглэл өгөх тухай<br>2015-05-29<br>Дугаар 2015_09 | 4. Оюу толгой ордыг ашиглахад Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм, журмыг гуйвуулалтгүй мөрдүүлэх, цаашид Монгол Улсын томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар анхаарч ажиллах | Оюу толгойн ордыг ашиглах талаар холбогдох хууль (Монгол Улсын Үндсэн хууль, Ашигт малтмалын тухай, Компанийн тухай, Хөрөнгө оруулалтын тухай, Газрын хэвлийн тухай, Байгаль орчны багц хууль гэх мэт) , тогтоомж ("Оюу толгой ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний тухай" УИХ-ын 2009 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн 57 дугаар тогтоол), дүрэм (Хүдрийн далд уурхайн аюулгүй байдлын дүрэм), журмыг (Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай) мөрдүүлж, бараа, ажил, үйлчилгээг Монгол Улсад мөрдөж байгаа холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж байна.<br>Улсын Их хурлын даргын 2018 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 57 дугаар захирамжаар Оюу Толгой ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний хэрэгжилтийг шалгаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Тус яамнаас уг ажлын хэсгийн хүрээнд байгуулагдсан дэд ажлын хэсэгт холбогдох албан тушаалтнууд ажиллаж, холбогдох санал, дүгнэлтийг боловсруулан Улсын Их хурлын даргын 2018 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 57 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт хүргүүлсэн.Улсын Их хурлын даргын 2018 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 57 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг холбогдох санал, дүгнэлтийг нэгтгэн Оюу толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай" Улсын Их хурлын тогтоолын төслийг боловсруулж, 2019 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 92 дугаар тогтоолоор батлуусан.Уг тогтоолын 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Монгол Улсын Засгийн газар болон Айвенхоу майнз Монголиа Инк ХХК, Айвенхоу майнз Лтд, Рио Тинто Интернэшнл Холдингс Лтд компани хооронд 2009 оны 10 дугаар сарын 06-ны өдөр байгуулсан Хөрөнгө | 100 /яамны зүгээс авч хэрэгжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн/ | |
| | | | | | | |
| 12 | 15 | Монгол баатарлаг туульсаа дээдлэн дэлгэрүүлэх тухай<br>2019-01-29<br>Дугаар 2019_13 | 3.. Баатарлаг туульсаа дээдлэн хамгаалах, бүртгэн судлах, өвлөн уламжлуулах, түгээн дэлгэрүүлэх, олон улсад сурталчлан таниулах, туульч, өвлөн уламжлагч, өв тээгчид болон судлаачдыг урамшуулах үйл ажиллагааг дэмжиж ажиллахыг төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтанд үүрэг болгосугай. | УУХҮС Д.Сумъяабазар Монголын геологи ба ашигт малтмал" хэмээх 8 боть бүтээл бүтээн Төрийн соёрхол хүтсэн нэр бүхий 8 эрдэмтдийг хүлээн авч хүндэтгэл үзүүлж үнэ бүхий зүйлээр 2019.01.17-ны өдөр шагнаж урамшуулсан. | 100 /яамны эрхлэх асуудалд хамааралгүй тул хяналтаас хасуулах саналтай/ | |
| | 16 | | 4.. Монгол баатарлаг туульсынхаа агуулга, ач холбогдлыг таньж ойлгох, дэмжин дэлгэрүүлэх, өв соёлоо хүндэтгэн дээдлэх, хадгалах, уламжлуулан хамгаалах үйлсэд идэвх санаачлагтай оролцохыг тбрийн ба төрийн бус байгууллага, иргэд олон нийт, эрдэмтэн судлаачид, шинжлэх ухааны ба хэвлэл мэдээллийн байгууллагуудад уриалсугай. | УУХҮС Д.Сумъяабазар Монголын геологи ба ашигт малтмал" хэмээх 8 боть бүтээл бүтээн Төрийн соёрхол хүтсэн нэр бүхий 8 эрдэмтдийг хүлээн авч хүндэтгэл үзүүлж үнэ бүхий зүйлээр 2019.01.17-ны өдөр шагнаж урамшуулсан. | 100 /яамны эрхлэх асуудалд хамааралгүй тул хяналтаас хасуулах саналтай/ | |
| ҮАБЗ-ийн зөвлөмж | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 13 | 17 | Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг эрчимжүүлэх тухай 2014-10-20 Дугаар 2014_52/30 | 2.5. Нүүрсийг гүн боловсруулах /шингэрүүлэх, хийжүүлэх/, нүүрсний давхаргын метан хийг олборлох технологийг нэвтрүүлж, цэвэр түлш үйлдвэрлэхэд төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрийг сонгон хэрэгжүүлэх | Засгийн газрын 2014 оны 3 дугаар сарын 07-ны өдрийн 74 дүгээр тогтоолоор "БНХАУ-ын Синопек корпорацитай хамтран нүүрсийг хийжүүлэх технологи нэвтрүүлэх төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий" төслийн нэгжийг Уул уурхай яамны дэргэд байгуулсан. Төслийн нэгж БНХАУ-ын Синопек компанитай хамтран хийсэн, Багануурын уурхайг түшиглэн 1-3 тэрбум шоо метр синтетик хий үйлдвэрлэх үйлдвэр барих техник, эдийн засгийн урьдчилсан судалгаагаар Багануурын нүүрс нь чанарын хувьд хангалттай сайн биш, үйлдвэрийг Багануурын нүүрсний уурхайг түшиглэн барих нь эдийн засгийн хувьд үр ашиггүй болохыг тодорхойлсон. Мөн урьдчилсан ТЭЗҮ-д үндэслэн Цайдамнуурын болон Эрдэнэцогтын уурхай дээр тус бүр жилийн 8 тэрбум шоо метр хүчин чадалтай үйлдвэр барих нарийвчилсан ТЭЗҮ-ийн судалгааг хийх байсан боловч санхүүжилт шийдэгдээгүй учир зогссон. Ингээд Засгийн газрын 2016 оны 2 дугаар сарын 29-ны өдрийн 131 дугаар тогтоолоор тус төслийн нэгжийг татан буулгасан. БНСУ-ын КОГАЗ, Австралийн Голден Хорд болон Нордик Гео Солюшн, Элгэн зэрэг компаниудын хийсэн судалгааны тайланд Таван Толгойн ордын нүүрсний давхаргын метан хийн нөөцийг урьдчилсан төсөөллөөр 40 сая.тн буюу 4.7 тэрбум шоо метр гэж тогтоосон байдаг. Номгон-IX талбайд нүүрсний давхаргын метан хийн хайгуул, судалгааны ажил хийж гүйцэтгэх тухай Бүтээгдэхүүн хуваах гэрээг Австрали улсын хөрөнгө оруулалттай "Жи Өү Эйч" ХХК-ийн хооронд 2018.09.18-ны өдөр байгуулсан. Гэрээлэгч компани 2019 онд 1.99 сая ам долларын хөрөнгө оруулалтаар 2 хэмжээст чичирхийллийн судалгаа, 500-1000 м хайгуулын өрөмдлөгийн ажил хийж гүйцэтгэхээр төлөвлөснөөс 2019.11.30-ны байдлаар 210 тууш км 2 хэмжээст | 100 /төрийн захиргааны төв байгууллагын зүгээс шаардлагатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн, / | хэрэгжилт удаашралтай, нүүрснээс түлш гаргаж авах, давхаргын метан хий гаргаж авах талаар дорвитой ажил хийгдээгүй, тодорхой үр дүн хүрээгүй, сүүлийн 3 жилийн хугацаанд ахиц гараагүй байна. Иймд зөвлөмжийн томёоллыг өөрчлөх, тодорхой болгох талаар ҮАБЗ-д санал хүргүүлэх нь зүйтэй. |
| **ҮАБЗ-ийн хуралдааны тэмдэглэл** | | | | | | |
| 14 | 18 | Тавантолгойн нүүрсний ордыг ашиглах талаар 2010-05-18 Дугаар 2010_24/11 | 5. Тавантолгойн уурхайн ашиглалт, дэд бүтэц барьж байгуулах асуудлыг "Өмнийн говь" төсөлтэй уялдуулан Улсын Их Хуралд оруулах. | Тус яамнаас Тавантолгойн ордын талаар авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их хурлын тогтоолын төслийг боловсруулж Засгийн газрын 2018 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаан, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2018 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаар тус тус хэлэлцүүлж, Улсын Их хурлын 2018 оны 6 дугаар сарын 29-ны өдрийн 73 дугаар тогтоолоор батлуулсан. Уг тогтоолын төсөлд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийг тусгасан болно. | 100 /заалтын биелэлт хангагдсан тул хяналтаас хасуулах саналтай/ | |
| ЗГ-ын тогтоол | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 15 | 19 | Таван толгойн ордын талаар авах зарим арга хэмжээний тухай<br>2014-08-20<br>Дугаар 2014_268 | 1.д. Хөрөнгө оруулагч нь улсын төсөвт төлөх татвар, хураамж, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг хариуцахаас гадна борлуулалтын орлогын тодорхой хувийг Хөрөнгө оруулж хамтран ажиллах гэрээний төлбөрт төлөх, шаардлагатай тохиолдолд нэмж төлөх борлуулалтын орлогын тодорхой хэсгийг урьдчилан төлөхөөр хэлэлцэх; | Тавантолгой нүүрсний ордод 2014 онд зарласан хөрөнгө оруулагчийг шалгаруулах уралдаант шалгаруулалтад БНХАУ-ын "Чайна Шенхуа Энержи" ТӨК (цаашид "Шеньхуа" гэх), Японы "Сумитомо корпораци" болон Монголын "Mongolian Mining Corporation" (цаашид "ММС" гэх) компанийн хамтарсан консорциум шалгарсан. Засгийн газраас өргөн мэдүүлсэн "Тавантолгойн нүүрсний ордыг хөгжүүлэх талаар авах арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Тавантолгойн ордыг хөгжүүлэхтэй холбоотой хөрөнгө оруулалтын гэрээ болон хавсралт гэрээнүүдийг Монгол Улсын Их Хурлаар хэлэлцэх эсэхийг шийдвэрлэх талаар дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын даргын 2015 оны 101 дүгээр захирамжаар байгуулсан. Ажлын хэсгийн ахлагчаар УИХ-ын гишүүн Л.Эрдэнэчимэг ажилласан. Ажлын хэсэг Консорциумтай байгуулахаар төлөвлөж байсан "Хамтын ажиллагааны гэрээ", "Хөрөнгө оруулалтын гэрээ", "Ухаа худаг-Гашуун Сухайт чиглэлд төмөр замын суурь бүтцийг барих-өмчлөх-ашиглах-шилжүүлэх гэрээ"-г судлан дүгнэлт гаргаж, саналыг Засгийн газарт буцаах шийдвэр гаргасан. Ажлын хэсгийн саналыг дараах байдлаар судлаж, Засгийн газрын 2012 оны 05 дугаар сарын 30-ийн өдрийн 181 дүгээр тогтоол болон 2014 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 268 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болгох нь зүйтэй гэж үзсэн. Ингэснээр тус компанийн 1072 хувьцаа эзэмшиж байгаа иргэдийн хууль ёсны эрх ашиг хангагдаж, 2010 онд зарласан Таван толгойн нүүрсний ордыг ашиглах уралдаант шалгаруулалтын хураангуй жагсаалтанд багтсан 6 компанийг дахин хууль, тогтоомжид нийцүүлэн сонгох боломж нээлттэй үлдэнэ гэсэн дүгнэлт гаргасан. Монгол Улсын Ерөнхий сайдын 2016 оны 104 дүгээр захирамжаар | 100 /хяналтаас хасуулах саналтай/ | |
| 16 | 20 | Хөрөнгө гаргах тухай<br>2015-04-20<br>Дугаар 2015_159 | 1. Гацууртын алтны ордыг ашигласны улмаас Төв аймгийн Борнуур сумын нутаг дэвсгэрт орших түүх, соёлын үл хөдлөх дурсгал болох Хүннүгийн үеийн Бороогийн сууринд үзүүлж болзошгүй нөлөөллийг судалж, мэргэжлийн дүгнэлт гаргахад зориулан 57,241,000.0 (тавин долоон сая хоёр зуун дөчин нэгэн мянган) төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас гаргахыг Сангийн сайд Ж.Эрдэнэбатад зөвшөөрч, орд ашиглалтад орсон тохиолдолд уг хөрөнгийг төсөвт буцаан төвлөрүүлэхийг Уул уурхайн сайд Р.Жигжидэд даалгасугай. | Ерөнхий сайдын 2015 оны 02 дугаар сарын 24-ны өдрийн 55 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийн хүрээнд Төв аймгийн Борнуур сумын нутаг дэвсгэрт орших түүх, соёлын үл хөдлөх дурсгал болох Хүннүгийн үеийн Бороогийн сууринд үзүүлж болзошгүй нөлөөллийг Шинжлэх ухааны академийн Палеонтологи, Геологийн хүрээлэн судалж тайлан гарган 2016 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн Т/16 дугаартай албан бичгээр палеонтлогийн хайгуул судалгааны ажлын дүгнэлтийг Гацууртын ордын ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшигч "Сентерра гоулд Монголиа ХХК-д хүргүүлсэн байна. Энэхүү судалгааны дүгнэлтэд "палеонтологийн олдвор зөвхөн Голоцены сэвсгэр хурдсаас илрэх магадлалтай харин бусад палезойн хурдсууд ямарч олдвор агуулаагүй гэдгийг дурдсан байна. Холбогдох зардлыг Сентерра гоулд Монголиа ХХК-тай байгуулах орд ашиглах гэрээний төсөлд тусгасан бөгөөд Гацууртын алтны орд ашиглах асуудал шүүхээр эцэслэн шийдэгдээгүй учир төслийн үйл ажиллагаа тодорхойгүй хугацаагаар хойшлогдож байна. | 100 /ямны зүгээс холбогдох арга хэмжээг авсан тул хяналтаас хасуулах саналтай/ | хэрэгжилт удааширсан, орд ашиглах үйл ажиллагаа зогссон, шүүхийн маргаантай байна. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 17 | 21 | Албан татварыг хэсэгчлэн төлүүлэх тухай<br>2015-05-18<br>Дугаар 2015_190 | 2. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан төслүүдийг хэрэгжүүлж байгаа "Монголын алт" ХХК-тай гурвалсан гэрээ байгуулж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Ж.Эрдэнэбат, Уул уурхайн сайд Р.Жигжид, Барилга, хот байгуулалтын сайд Д.Цогтбаатар нарт даалгасугай. | Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан төслүүдийг хэрэгжүүлж байгаа "Монголын алт" ХХК-тай байгуулах гурвалсан гэрээний төсөл одоогоор тус яаманд ирээгүй байна. УИХ-ын 2014 оны 54 дүгээр тогтоолоор тус ордод төр хувь эзэмших шаардлагагүй гэсэн шийдвэр гаргасан бөгөөд Монгол Улсын Засгийн газар болон "Монголын алт" ХХК, "Эрдэнэс Цагаансуварга" ХХК-ийн хооронд 2015 оны 11 сард тус ордыг түшиглэн байгуулах Баяжуулах үйлдвэрийн Хөрөнгө оруулалтын гэрээнд гарын үсэг зурсан. /ХБНГУ-аас "Монголын алт" ХХК-д олгох зээлийн санхүүжилтэд Монгол Улсын Засгийн газраас баталгаа гаргасан/ | 100 /хөрөнгө оруулалтын гэрээг байгуулж, тогтоолын хэрэгжилт хангагдсан тул хяналтаас хасуулах саналтай / | |
| 18 | 22 | Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн эргэлтийн цэг, солбицол батлах тухай<br>2016-04-04<br>Дугаар 2016_196 | 3. Ухаахудаг-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барих хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу зохих дэмжлэг үзүүлж ажиллахыг Уул уурхайн сайд Р.Жигжид, Өмнөговь аймгийн Засаг дарга Д.Бадраа нарт үүрэг болгосугай. | Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд зааснаар /11.2.5.харьяалах нутаг дэвсгэрт нь хамаарах түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох;/ Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрхэд түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг олгож байна. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам дээрх хуулийн хүрээнд бодлогын дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.<br>/Биелэлт 100 хувь, ХЯНАЛТААС ХАСУУЛАХ/ | 100 /яамны зүгээс дэмжлэг үзүүлж ажилласан тул хяналтаас хасуулах саналтай/ | |
| 19 | 23 | "Шивээ-овоо" ХК-ийн техник, технологийг шинэчлэхэд шаардагдах санхүүжилтийг шийдвэрлэх тухай<br>2016-04-18<br>Дугаар 2016_219 | 2. "Шивээ-Овоо" ХК-ийн үйл ажиллагааг тогтворжуулж, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч, зээлийн эргэн төлөлтөд хяналт тавьж ажиллахыг Уул уурхайн сайд Р.Жигжид, Эрчим хүчний сайд Д.Зоригт нарт үүрэг болгосугай. | Эрчим хүчний сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд нарын 2019 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 52/А/25 дугаар хамтарсан тушаалаар Шивээ овоогийн уурхайн үйл ажиллагаа, санхүү, эдийн засгийн байдалд үнэлэлт, дүгнэлт өгч, холбогдох санал дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдаж, ажилласан.<br>Мөн Засгийн газрын 2019 оны 10 дугаар сарын 2-ны өдрийн ээлжит хуралдаанаар Багануур, Шивээ-Овоогийн уурхайн өөвлжилтийг хангах тухай асуудлыг хэлэлцэж, хуралдааны 42 дугаар тэмдэглэлийг гаргасан.<br>Уг тэмдэглэлийн 1-д Багануур, Шивээ-Овоогийн нүүрсний уурхай, дулааны станц хооронд үүссэн өр, авлагын асуудлыг шийдвэрлэх, уурхай болон дулааны станцын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангахад шаардлагатай байгаа санхүүжилт, эргэлтийн хөрөнгийн зээлийн асуудлаар Хөгжлийн банканд зохих журмын дагуу хандаж шийдвэрлэхийг Эрдэнэс Монгол ХХК-д даалгасан. | 100 /яамны зүгээс дэмжлэг үзүүлж ажилласан тул хяналтаас хасуулах саналтай/ | |
| 20 | 24 | Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицол батлах тухай<br>2016-08-03<br>Дугаар 2016_14 | 3. Энэ тогтоолын 2 дугаар зүйлд заасны дагуу түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах хуулийн этгээдэд хууль тогтоомжийн дагуу зохих дэмжлэг үзүүлж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, Дорноговь аймгийн Засаг дарга Т.Энхтүвшин нарт даалгасугай. | Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд зааснаар /11.2.5.харьяалах нутаг дэвсгэрт нь хамаарах түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох;/ Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрхэд түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг олгож байна. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам дээрх хуулийн хүрээнд бодлогын дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.<br>/Биелэлт 100 хувь, ХЯНАЛТААС ХАСУУЛАХ/ | 100 /яамны зүгээс дэмжлэг үзүүлж ажилласан тул хяналтаас хасуулах саналтай/ | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 21 | 25 | Журам батлах тухай<br>2017-02-22<br>Дугаар 2017_61 | 2. Энэхүү журмын хэрэгжилтийг зохион байгуулж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол нарт даалгасугай. | "Үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон үйл ажиллагааны журам" болон "Үүсмэл орд ашиглах үйл ажиллагаанд тавих шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журам"-ын төслийг Засгийн газрын 2017 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, "Журам батлах тухай" Засгийн газрын 2017 оны 61 дүгээр тогтоолоор батлуулсан. Мөн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны А/93 дугаар тушаалаар Ажлын хэсгийг байгуулж Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрийн хэлтсийн даргын 2017 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 613 дугаар шийдвэрээр 2017 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн UN-000001 дугаартай үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрлийг "Ачит Ихт" ХХК-д олгосон. Мөн ЭБМЗ-ийн 2017 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдаанаар "Ачит Ихт" ХХК-ийн Үүсмэл ордын нөөцийн тайланг хэлэлцэж, холбогдох шийдвэрийг гаргасан. Мөн Бороогийн алтны үндсэн ордод үйл ажиллагаа явуулж байгаа "Бороо Гоулд" ХХК-ийн зүгээс өөрийн уусгалтын талбай дахь ядуу агуулгатай хүдрийн овоолгыг үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрлийн үндсэн дээр ашиглах хүсэлтийг ирүүлээд байна. Уг асуудлыг холбогдох байгууллага /АМГТГ/ судлаж байна. | 100 /үүсмэл ордтой холбогдох журмын хэрэгжилт, түүнд тавих хяналтыг хэрэгжүүлж ажиллаж байгаа тул хяналтаас хасуулах саналтай/ | |
| 22 | 26 | Хөрс хамгаалах өдөртэй болох тухай<br>2017-05-24<br>Дугаар 2017_149 | 3.. Энэ тогтоолын 2 дугаар зүйлд заасан арга хэмжээг улсын болон тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж, жил бүрийн 12 дугаар сард нэгтгэн дүгнэж байхыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, Эрүүл мэндийн сайд А.Цогцэцэг, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ж.Батсуурь, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. | Жил бүрийн 5 дугаар сарын эхний 7 хоногийн Бямба гарагийг "Хөрс хамгаалах үндэсний өдөр" болгон тэмдэглэн өнгөрүүлэх бөгөөд АМГТГ-тай хамтран зохион байгуулан ажиллаж байна. | 100 хяналтаас хасуулах | |

| | | | |
|---|---|---|---|
| 23 | 27 | "Эрдэнэс Монгол" ХХК болон түүний охин компанийн талаар авах зарим арга хэмжээний тухай<br>2017-05-30<br>Дугаар 2017_154 | 1.. "Эрдэнэс Монгол" ХХК-ийн үйл ажиллагааг сайжруулж, Оюутолгой, Тавантолгой зэрэг стратегийн ач холбогдол бүхий ордын үр ашгийг иргэн бүрт хүртээмжтэй болгох зорилгоор "Эрдэнэс Монгол" ХХК-ийн дүрэм болон стратегийг шинэчлэн боловсруулж батлуулах, шаардалгтай бол холбогдох зарим хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулан шийдвэрдүүлэх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн  сайд Ц.Дашдорж, "Эрдэнэс Монгол" ХХК-ийн ТУЗ /Б.Даажамба/-д даалгасугай. |

| | | |
|---|---|---|
| "Эрдэнэс Монгол" ХХК-ийн үйл ажиллагааг сайжруулж, Оюутолгой, Тавантолгой зэрэг стратегийн ач холбогдол бүхий ордын үр ашгийг иргэн бүрд хүртээмжтэй болгох зорилгоор "Эрдэнэс Монгол" ХХК-ийн дүрэм болон стратегийг шинэчлэн боловсруулж батлуулах, шаардлагатай бол холбогдох зарим хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Зам тээврийн яам, Эрчим хүчний яам, Үндэсний хөгжлийн газар, Эрдэнэс Монгол ХХК, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК, Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн төлөөллийг оролцуулан байгуулаад байна.<br>Ажлын хэсэг нь "Эрдэнэс Монгол" компанийн үйл ажиллагааны цар хүрээг өргөжүүлэх, уул уурхайг дагасан дэд бүтцийн бүтээн байгуулалтын болон нэмүү өртөг шингэсэн боловсруулах үйлдвэрлэлийн төслийг хөгжүүлэх чиглэлээр дунд хугацааны стратеги, үйл ажиллгааны төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж батлуулах, үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий Дэд ажлын хэсгийг байгуулж ажиллуулсан байна. Эрхлэх асуудлын хүрээнд төрийн өмчит “Эрдэнэс Тавантолгой” ХХК нь Засгийн газрын хэрэг эрхлэх газрын шууд харъяаны “Эрдэнэс Монгол” компанид хамаардаг байсан билээ. Засгийн газрын 2018 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийг УУХҮЯ-ны мэдэлд шилжүүлэхээр шийдвэрлэсэн. Тус яаманд Эрдэнэс Тавантолгой ХК-иас уг компанийн 15 жилийн стратеги, төлөвлөгөөг боловсруулж, 2019 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 01/2706 тоот | 100 /хяналтаас хасуулах саналтай/ | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 24 | 28 | “Гурван тулгуурт хөгжлийн бодлого” батлах тухай 2018-02-06 Дугаар 2018_19 /42/ | 3.. “Гурван тулгуурт хөгжлийн бодлого”-д тусгасан өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд, бодлогын хэрэгжилтийг уялдуулан зохицуулж, гүйцэтгэлийн явцыг нэгтгэн жил бүрийн I улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатарт тус тус даалгасугай. | Зорилт 1. Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх, дагалдах дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлэх, тусгай зөвшөөрөл эзэмшигч ААН-ийн хувьцааны тодорхой хэсгийг гадаад, дотоодын зах зээлд арилжиж, санхүүжилтийг шийдвэрлэх тухай “Тавантолгойн ордын талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын төслийг боловсруулж, УИХ-ын 2018 оны 06 дугаар сарын 29-ны өдрийн 73 дугаар тогтоолоор батлуулсан. Уг тогтоолд Улсын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоолын 1 дэх заалтын 2 дахь дэд заалтын “б”, “в”-д заасны дагуу стратегийн ач холбогдол бүхий Тавантолгойн нүүрсний ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьцааны 30 хүртэлх хувийг гадаад, дотоодын хөрөнгийн биржээр арилжаалан шаардлагатай хөрөнгө оруулалтыг татсаны үндсэн дээр Тавантолгойн ордын үнэ цэнийг өсгөх талаар шуурхай арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт үүрэг болгосон. Мөн 2019 оны Төсвийн тухай хуульд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн орлогоос Ирээдүйн өв санд тодорхой хэмжээний хөрөнгийг хуримтлуулж хувьцааны ногдол ашиг олгох талаар тусгагдсан.<br>Зорилт 2. УУХҮЯ, Монголын уул уурхайн үндэсний ассоциацитай хамтран 2019.06.20-ны өдөр “Хариуцлагатай уул уурхайн сайн дурын кодекс”-т нэгтгэх “Хариуцлагаар нэгд” аяныг эхлүүлсэн. Энэхүү санаачлагын зорилго нь Хариуцлагатай уул уурхайн жишиг шаардлага ба үнэлэх аргачлалын хүрээнд талууд хариуцлагатай уул уурхайн сайн жишгүүдийг дэмжих нэвтрүүлэх юм. Аяны нээлтэд Монголын уул уурхайн үндэсний ассоциаци, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, Аспайр Майнинг” ХХК, “Багануур” ХК, “Саусгоби сэндс” ХХК, “Оюу толгой” ХХК, “Терра Энержи” ХХК, “Энержи Ресурс” ХХК-ийн удирдлагууд оролцож | 100 /бодлогын баримт бичигт УУХҮЯ-ны эрхлэх асуудлаар батлагдсан 37 арга хэмжээний хэрэгжилтийг гаргаж холбогдох журмын дагуу тайланг ҮХГ-т хүргүүлэн ажиллаж байна. ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ/ | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 25 | 29 | "Багануур" ХК, "Шивээ-Овоо" ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай<br>2018-05-16<br>Дугаар 2018_132 | 2.. 2018-2020 онд өсөн нэмэгдэж байгаа эрчим хүчний хэрэглээтэй уялдуулан "Багануур" ХК, "Шивээ-Овоо" ХК-ийн үйлдвэрлэлийн найдвартай, хэвийн үйл ажиллагааг тасралтгүй хангах, хүчин чадлыг нэмэгдүүлэх, техник, технологийн шинэчлэл зайлшгүй хийх хөрөнгө оруулалтад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг судлан шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Бат-Эрдэнэ)-д даалгасугай. | Эрчим хүчний сайдын 2018 оны 110 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн хүрээнд Багануур, Шивээ-Овоогийн уурхайн үйлдвэрлэлийн найдвартай, хэвийн үйл ажиллагааг тасралтгүй хангах, хүчин чадлыг нэмэгдүүлэх, техник, технологийн шинэчилэл зайлшгүй хийх хөрөнгө оруулалтад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг судалж, цаашид авах арга хэмжээний талаар холбогдох санал, дүгнэлт боловсруулж, Сангийн яам болон ЗГХЭГ-т хүргүүлсэн. Эрчим хүчний сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд нарын 2019 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 52/А/25 дугаар хамтарсан тушаалаар Шивээ овоогийн уурхайн үйл ажиллагаа, санхүү, эдийн засгийн байдалд үнэлэлт, дүгнэлт өгч, холбогдох санал дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдаж, ажилласан. Мөн Засгийн газрын 2019 оны 10 дугаар сарын 2-ны өдрийн ээлжит хуралдаанд Багануур" ХК, "Шивээ-Овоо" ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2018 оны 132 дугаар тогтоолын хэрэгжилтийг танилцуулж, хуралдааны 42 дугаар тэмдэглэлийг гаргасан. Уг тэмдэглэлийн 1-д Багануур, Шивээ-Овоогийн нүүрсний уурхай, дулааны станц хооронд үүссэн өр, авлагын асуудлыг шийдвэрлэх, уурхай болон дулааны станцын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангахад шаардлагатай байгаа санхүүжилт, эргэлтийн хөрөнгийн зээлийн асуудлаар Хөгжлийн банканд зохих журмын дагуу хандаж шийдвэрлэхийг Эрдэнэс Монгол ХХК-д даалгасан. | 100 /яамны түгээс дэмжлэг үзүүлж ажилласан тул хяналтаас хасуулах саналтай/ | |
| | 30 | | 5.. "Багануур" ХК-ийн орд газрын тусгай зөвшөөрөлтэй холбоотойгоор хууль хяналтын байгууллагад хянагдаж байгаа маргаантай асуудлыг эцэслэн шийдвэрлүүлэх чиглэлээр эрчимтэй ажиллаж, тус орд газрын хилийн заагийг шинэчлэн тогтоохыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Х.Хэрлэн нарт даалгасугай. | Багануурын нүүрсний ордын маргаантай байгаа "Алтай Гянт" ХХК-ийн эзэмшиж байсан 12959А лицензтэй талбайд 430.2 сая тонн буюу ордын нийт нөөцийн 53% ногдож байна. Ордын хил заагийг тогтоох ажил Ажлын хэсгийн хүрээнд хийгдсэн. | 100 /яамны зүгээс дэмжлэг үзүүлж ажилласан тул хяналтаас хасуулах саналтай/ | |
| | 31 | | 2.. "Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого"-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгасугай. | Монгол Улсын Засгийн газрын 2018.06.06-ны өдрийн 169 дүгээр тогтоолоор баталсан "Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар 2027 он хүртэл баримтлах бодлого"-ыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019.08.08-ны өдрийн А/163 дугаар тушаалаар баталсан ба хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. /Хэрэгжилт-100%/ | 100 /хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталсан тул хяналтаас хасуулах саналтай/ | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 26 | 32 | Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого батлах тухай 2018-06-06 Дугаар 2018_169 | 3.. "Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого"-ын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээг Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлд, түүнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг улсын болон орон нутгийн төсөвт тусгаж, гадаадын зээл, тусламжид хамруулах, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шийдвэрлэх замаар санхүүжүүлж ажиллахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай. | Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд "Газрын тосны бүтээгдэхүүний чанарын хяналтын тогтолцоог сайжруулж, Евро-5 стандартын шаардлага хангасан газрын тосны бүтээгдэхүүний импортыг нэмэгдүүлэх" заалтыг тусгуулан хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж байна. Тус яамны зүгээс Евро-5 стандартын шаардлага хангасан газрын тосны бүтээгдэхүүний импорт, хэрэглээг нэмэгдүүлэхийг дэмжсэн эрх зүйн орчин бүрдүүлэх чиглэлээр Онцгой албан татварын хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл, Агаарын тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төслийг тус тус боловсруулан СЯ, БОАЖЯ-нд тус тус хүргүүлсэн. Мөн манай улсын газрын тосны бүтээгдэхүүний гол ханган нийлүүлэгч ОХУ-ын Роснефть компанийн төлөөлөлтэй 2019 оны 10 дугаар сард уулзалт зохион байгуулан, Евро-5 стандартын шатахууны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх талаар хэлэлцсэн ба энэ талаарх албан бичгийг тус компанид явуулсан. /Хэрэгжилт-20%/ | 100 /2019 оны ЭЗНХҮЧ-д Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн хүрээнд хийгдэх дэд бүтцийн ажлын явц, Евро-5 стандартын шаардлага хангасан шатахууны нэмэгдэх хувь хэмжээний саналыг оруулж батлуулан ажиллаж байна. Хяналтаас хасуулах саналтай/ | |
| 27 | 33 | Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийг эрчимжүүлэх тухай 2018-08-08 Дугаар 2018_242 | 6.. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийг хэрэгжүүлэх "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн төрд ногдохоос бусад хувьд хөрөнгө оруулах этгээдийг урьдчилгаа төлбөр, боомт ашиглалт, дамжуулан тээвэрлэлт хийх боломжтой гадаадын хөрөнгө оруулагч нараас судлан, хэлэлцээ хийж, үр дүнг 2018 онд багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт даалгасугай. | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Эрдэнэс Тавантолгой ХК иуд хамтран Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийг хэрэгжүүлэх "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн төрд ногдох хэсэгт хөрөнгө оруулалтын хувь хэмжээг тохиролцож, Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 304 дүгээр тогтоолоор батлуулсан болно. | 100 /тогтоолын хэрэгжилт хангагдсан тул хяналтаас хасуулах саналтай/ | |
| 28 | 34 | Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах зарим талбайн солбицол батлах тухай 2018-10-03 Дугаар 2018_301 | 3.. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгасугай. | "Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх төсөл"-ийн Багц 3 буюу Хашаатын даваа-Толбо нуур чиглэлийн 60км хатуу хучилттай автозамын барилгын ажлын үед замын далан, гүүр болон бусад туслах материалаар ашиглах түгээмэл тархацтай ашигт малтмал болох дайрганы чулуу, элс шавар зэрэг ашигт малтмалыг ашиглах талбайн хил заагийг энэхүү тогтоолоор зааж өгсөн байна. Энэхүү замын барилгын ажилд дээрх талбайгаас түгээмэл тархацтай ашигт малтмалуудыг ашиглаж буй бөгөөд 2018 оны жилийн эцсийн байдлаар замын ажлын гүйцэтгэл 56%-тай, байна. Урьдчилсан байдлаар Хашаатын даваа-Толбо нуур чиглэлийн 60 км хатуу хучилттай авто замыг 2019 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр Улсын комисс хүлээн авсан. | 100 /яамны зүгээс дэмжлэг үзүүлж ажилласан тул хяналтаас хасуулах саналтай/ | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 29 | 35 | Газрын тосны бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэх тухай<br>2018-10-24<br>Дугаар 2018_322 | 2.. Энэ тогтоолын хавсралтад заасан газрын тосны бүтээгдэхүүний компаний нөөцийг 2019 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн дотор бүрдүүлэх арга хэмжээ авч, нөөцийн бүрдүүлэлт, бүтээгдэхүүний чанарт хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д. Сумъяабазар, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Х.Хэрлэн нарт даалгасугай. | Засгийн газрын 2018 оны 322 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж, компанийн нөөц бүрдүүлэх үүрэг хүлээсэн аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулж, нөөцийн бүрдүүлэлтэд хяналт тавьж ажиллах чиглэлийг АМГТГ-т хүргүүлсэн. АМГТГ нь 2019.01.29-ний өдөр тус тогтоолын жагсаалтад хамрагдсан газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөл эзэмшигч нэр бүхий 26 аж ахуйн нэгжтэй 116,5 мянган тонн газрын тосны бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэх талаар гэрээг байгуулж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. 2019 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар улсын хэмжээнд дунджаар газрын тосны бүтээгдэхүүний ердийн хэрэглээний 26 хоногийн нөөцтэй байгаа бөгөөд үүнээс А-80 автобензин 47, Аи-92 автобензин 28, дизелийн түлш 23, ТС-1 онгоцны түлш 19 хоногийн нөөцтэй байна. /Хэрэгжилт 100%/ | 100 /тогтоолын уг заалт нь нэг удаагийн үйлчлэлтэй, заагдсан хугацаанд нөөц бүрдүүлэлт, чанарт хяналт тавьж ажиллан 2020 онд компанийн нөөц бүрдүүлэх тухай ЗГ-ын 2019 оны 11 сарын 19-ний 409 дүгээр тогтоолыг батлуулсан тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ./ | |
| | 36 | | 4.. Газрын тос боловсруулах үйлдвэрийн түүхий тос дамжуулах хоолойн техник, технологийн шийдлийг сонгох, санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх талаар санал боловсруулж танилцуулахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт даалгасугай. | Ерөнхий сайдын 2019 оны 118 дугаар захирамжаар газрын тос боловсруулах үйлдвэрт шаардлагатай дотоодын түүхий тосыг тээвэрлэх дэд бүтцийн оновчтой хувилбарыг тодорхойлох, шаардлагатай тооцоо судалгааг хийх, техник технологийн шийдэл, хөрөнгө оруулалтын талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Энэхүү захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг гурван удаа хуралдаж, үйлдвэрт шаардлагатай түүхий эдийг тээвэрлэх дэд бүтцийн боломжит хувилбаруудын талаар мэдээ мэдээлэл, тооцоо судалгаа, хөрөнгө оруулалт, техник технологийн шийдлийг тодорхойлох зорилгоор холбогдох байгууллагуудаас баримт материалуудыг цуглуулсан. Ажлын хэсгийн зүгээс их хэмжээний түүхий тосыг хол зайд тээвэрлэхэд тохиромжтой дэд бүтцийн хувилбар болох төмөр зам болон дамжуулах хоолойн тээвэрлэлтийг манай нөхцөлд тохирох боломжтой гэж үзэн эдийн засгийн үр ашгийн харьцуулсан судалгааг Монголын логистикийн холбоо ТББ-аар хийж гүйцэтгүүлэн тайланг Засгийн газрын 2019.12.18-ний өдрийн хуралдаанаар танилцуулж холбогдох шийдвэрийг гаргуулаад байна. | 100 /ажлын хэсэг байгуулж санал дүгнэлтийг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэр гаргуулсан тул хяналтаас хасуулах саналтай/ | |

| | | | |
|---|---|---|---|
| 30 | 37 | | 5.. Бүгд Найрамдах Энэтхэг Улсын хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлэх “Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төслийн менежментийн зөвлөх компанийг сонгон шалгаруулах ажлыг эрчимжүүлж, төслийн үе шатны ажлуудыг шуурхай зохион байгуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгасугай. |

| | | |
|---|---|---|
| Төслийн менежментийн зөвлөх компаниар шалгарсан Энэтхэгийн “Инженерс Индиа Лимитэд” төрийн өмчит компани болон “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК нар зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээг 2019.05.13-ны өдөр байгуулсан. Төслийн менежментийн зөвлөх “Инженерс Индиа Лимитэд” компанитай газрын тос боловсруулах үйлдвэрийн инженерчлэл, ерөнхий зураг төслийн үндсэн өгөгдлүүдийг тохиролцох, зөвлөх үйлчилгээний ажлыг эхлүүлэх уулзалтыг 2019.06.08-14-ний өдрүүдэд Энэтхэг улсын Нью Дели хотод зохион байгуулж, төслийн менежментийн багтай танилцаж, төслийн дараагийн шатны ажлуудыг төлөвлөсөн. Үүнд: Үйлдвэрийн технологийн болон дагалдах байгууламжуудын байршил, хүчин чадал, иргэний барилга, шугам хоолойн трасс, бамбарын систем, ногоон бүс, зам талбай, хашаа хамгаалалт бүхий үйлдвэрийн ерөнхий дэвсгэр зургийг эцэслэн баталж, технологи, техникийн нөхцөлүүд, талбайд хийгдэх нарийвчилсан судалгаа, ус хангамжийн системийн талаар санал солилцож, төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөөг урьдчилсан байдлаар тохиролцсон. - Энгийн болон вакуум нэрлэгийн байгууламжийн зураг төслийн үндэслэлийн Хэсэг “А”-г хянаж, баталсан. - Зураг төслийн үндэслэлийн Хэсэг “Б”-г батлахаар ажиллаж байна. - Үйлдвэрийн талбайд баригдах захиргаа, сургалт, аюулгүй ажиллагааны барилга байгууламжууд, агуулах, засврын цех, гал команд, ажилчдын хоолны газрын хэмжээ, барих материал, байрлах ажилчдын тоог тохиролцсон. - Үйлдвэрийн төлөвлөлтийн ажлын үе шат ахих тусам судалгааны ажлын түвшин нэмэгдэж байгаатай холбогдуулан үйлдвэрийн талбайд хийгдэх геотехникийн болон геофизикийн судалгааны ажлын даалгаврыг “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК боловсруулж Зөвлөх | 100 /зөвлөх компанийг шалгаруулсан, төслийн үе шатны ажлуудыг зохион байгуулан ажиллав/ | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 38 | | 6.. Үйлдвэрийн байршил хүртэлх дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын явц, гүйцэтгэл, зээлийн хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т, төсөл хэрэгжүүлэгч компанийг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт тус тус даалгасугай. | Засгийн газрын 2018.01.03-ны өдрийн "Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 02 дугаар тогтоолоор боловсруулах үйлдвэрийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг Монгол Улсын Хөгжлийн банкны зээлээр санхүүжүүлж, төмөр зам, автозам, цахилгаан дамжуулах агаарын шугам, үйлдвэрийн талбайн газар шорооны ажлуудыг 2018 оны эхний хагас жилд багтаан эхлүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Зам, тээвэр хөгжлийн сайд, Эрчим хүчний сайд, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт даалгасан. Үйлдвэр байгуулахад шаардлагатай гаднах дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлууд болох "Сайншанд-Газрын тос боловсруулах үйлдвэр" чиглэлийн 27 км салаа төмөр зам, 18.2 км цахилгаан хангамжийн 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, 110/10 кВ-ын 6.3 МВ-ын суурилагдсан хүчин чадал бүхий дэд станц болон 16.63 км хатуу хучилттай автозам барих төслүүдийн барилга угсралтын ажлыг энд Дорноговь аймгийн Алтанширээ суманд нэг жилийн өмнө буюу 2018 оны 6 дугаар сарын 22-ны өдөр эхлүүлж байсан. Эдгээр бүтээн байгуулалтыг Батлан хамгаалах яам, Барилга, хот байгуулалтын яам, "Улаанбаатар төмөр зам" ХХН, "Цахилгааны дамжуулах үндэсний сүлжээ" ТӨХК зэрэг байгууллагууд амжилттай гүйцэтгэж, төлөвлөсөн хугацаандаа улсын комисст хүлээлгэн өгч ашиглалтад оруулаад байна. "Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл"-ийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад зориулан "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК болон Монгол Улсын Хөгжлийн банк хооронд ирээдүйд бий болох хөрөнгийг барьцаалан буцаан төлөх нөхцөлтэйгөөр 2018.04.13-ны өдрийн БГ-МГТ-ИХ 2018-44 дугаар "Барьцааны гэрээ" болон мөн өдрийн ЗГ-МГТ-3 2018-43 | 100 /дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын явцад байнгын хяналт тавьж, дэд бүтцийн байгууламжуудыг байнгын ашиглалтанд хүлээн авсан тул хяналтаас хасуулах саналтай/ | |
| 31 | 39 | Гадаадаас 2019 онд авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тогтоох тухай<br>2018-12-12<br>Дугаар 2017_377 | 3.. Аж ахуйн нэгж, байгууллагын гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтнийг эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамруулж байхыг ажил олгогчид, үзлэгийг зохион байгуулахыг Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэлд үүрэг болгосугай. | Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.6 дахь заалтын дагуу гадаадаас ажиллах хүч оруулж ирэх хүсэлт ирүүлсэн нийт 64 ААН-ийн нийт 81 удаагийн хүсэлтийг, холбогдох материалын хамт судлан БНХАУ, Австрали, ХБНГУ, ӨАБНУ, БНЭУ, Канад, Финлянд, Их Британи, Япон, зэрэг Улс орноос нийт 2517 хүнийг түр хугацаанд Монгол Улсад хөдөлмөр эрхлүүлэх талаар санал боловсруулж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газарт уламжилсан. | 100 /УУХҮЯ-ны зүгээс холбогдох арга хэмжээг авсан ба, үзлэгийг зохион байгуулах чиг үүрэг тус яаманд хамааралгүй тул хяналтаас хасуулах саналтай/ | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 32 | 40 | 2019 оныг "Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил" болгох тухай<br>2019-01-16<br>Дугаар 2019_23 | 3. Хавсралтаар төлөвлөгөөг оруулав.. "Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил"-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг эрхлэх ажлын хүрээ, харьяа нутаг дэвсгэртээ зохион байгуулж, ажлын тайланг улирал тутам Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлж байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. Жич: Хавсралтаар оруулсан "ИРГЭН ТӨВТЭЙ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖИЛ"-ИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-ний дагуу өөрийн нэр заасан ажлыг хүснэгтээр гаргаж тайлагнана. | "Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил" болгох тухай Засгийн газрын 2019 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан 20 арга хэмжээний биелэлтийг холбогдох нэгжүүдээс гаргуулан улирал бүр ЗГХЭГ-т хүргүүлж, ХЭГ-ын unelgee.gov.mn сайтад байршуулж ажиллав. | 100 /тогтоолын үйлчлэлийн хугацаа дуусгавар болсон тул хяналтаас хасуулах саналтай/ | |
| 33 | 41 | Дүрэм батлах тухай<br>2019-01-23<br>Дугаар 2019_33 | 2.. Байгууллагын дотоод журмыг энэ тогтоолоор баталсан дүрэмд нийцүүлэн баталж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг төсвийн шууд захирагч нарт даалгасугай. | УУХҮЯ-ны ТНБД-ын 2016 оны Б/52 дугаар тушаалаар баталсан хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг 2019 оны А/12 тушаалаар байгуулан 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөх төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга болон түүнд үндэслэн гарсан бусад шийдвэртэй уялдуулж 2019.08.30-ны өдрийн А/144 дүгээр тушаалаар батлуулсан бөгөөд 2019.12.20-ны өдрийн А/218 дугаар тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулав. | 100 /дүрэмд нийцүүлэн дотоод журмыг батлан хэрэгжүүлж байгаа тул хяналтаас хасуулах саналтай/ | |
| 34 | 42 | 2019 оныг "Эх оронч худалдан авалтын жил" болгох тухай<br>2019-01-30<br>Дугаар 2019_59 | 3.. Энэ тогтоолын 2 дугаар зүйлд заасан төлөвлөгөөнд тусгасан ажлын хүрээнд нарийвчилсан төлөвлөгөө гаргаж, эрхэлсэн салбар, харьяа нутаг дэвсгэртээ хэрэгжилтийг зохион байгуулж, тайланг хагас болон жилийн эцсийн байдлаар Аж үйлдвэржилтийн бодлогын зөвлөлд хүргүүлэхийг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгосугай. | Тогтоолын 2 дугаар зүйлд заасан төлөвлөгөөнд тусгасан ажлын хүрээнд нарийвчилсан төлөвлөгөөг УУХҮ-ийн сайдын 2019.03.17-ны өдрийн А/123 дугаар тушаалаар батлуулж харьяа байгууллагуудад хүргүүлэн, төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас жил, III улирлын байдлаар гаргаж ЗГХЭГ-т тайлагнасан. | 100 /тогтоолын хэрэгжилтийг хангаж ажилласан, тогтоолын үйлчлэлийн хугацаа дуусгавар болсон тул хяналтаас хасуулах саналтай/ | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 35 | 43 | Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын талаар авах зарим арга хэмжээний тухай 2019-03-21 Дугаар 2019_112 | 3.. Авто замын барилгын ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох асуудлыг зохих журмын дагуу Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт үүрэг болгосугай. | Түгээмэл тархацтай ашигт малмалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, Засгийн газрын 2014 оны 222 дугаар тогтоолоор баталсан “Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах тусгай журам”-ын 1.3.2, 1.4-т заасныг тус тус үндэслэн тус яамнаас Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт олгох хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжих Гачууртын уулзвараас Налайх Чойрын уулзвар хүртэлх 20.9 км авто замын өргөтгөл, шинэчлэлт, Азийн хөгжлийн банк, Европын сэргээн босголт, хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар хэрэгжих Улаанбаатар-Дархан чиглэлийн 202.4 км авто замын өргөтгөл, шинэчлэлтийн бүтээн байгуулалтын ажилд тус тус шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлуудыг Засгийн газрын хуралдааны 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 184 дүгээр тогтоолоор батлуулсан.<br>Энэхүү 2 чиглэлийн авто замын бүтээн байгуулалтын ажилд шаардлагатай түгээмэл тархацтай ашигт малтмалын борлуулалтын үнэлгээг 1000 төгрөг, нөөц ашигласны төлбөрийг холбогдох хуулийн дагуу 2.5%-аар тооцож төлбөр авахаар зохицуулсан.<br>Тогтоол батлагдсантай холбогдуулан Гачууртын уулзвараас Налайх Чойрын уулзвар хүртлэх 20.9 км авто замын бүтээн байгуулалтад ашиглах 3 карьер, Дарханы чиглэлд хийгдэх бүтээн байгуулалтын ажилд ашиглах 8 карьерын байршлыг тогтоосон. Мөн бүтээн байгуулалтын ажилд шаардлагатай түгээмэл тархацтай ашигт малтмалын талбай нэмэх саналыг ЗТХЯ-аас ирүүлснийг судалж Засгийн газрын тогтоолд нэмэлт оруулсан. | 100 /яамны зүгээс дэмжлэг үзүүлж ажилласан тул хяналтаас хасуулах саналтай/ | |
| 36 | 44 | Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2019-04-03 Дугаар 2019_129 | 1.. Монгол Улсад газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийн хүрээнд үйлдвэрийн ажилчдыг орон сууцаар хангах зорилгоор Дорноговь аймгийн Сайншанд хотын нутаг дэвсгэрт барих 550 айлын орон сууцны хотхоны бүтээн байгуулалтын ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Батлан хамгаалахын сайд Н.Энхболд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг нарт даалгасугай. | Хотхон нь 550 айлын орон сууц, оффис-үйлчилгээний цогцолбор болон ногоон байгууламжаас бүрдэхээр төлөвлөж байгаа бөгөөд уг төслийг хэрэгжүүлэхэд зориулж Дорноговь аймгийн Сайншанд суманд 8,4 мегаваттын цахилгаан станц болон цэвэр, бохир усны шугам сүлжээнд холбогдсон 11 га газрыг “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-нд 15 жилийн хугацаатайгаар эзэмшүүлэх тухай А/206 тоот захирамжийг Дорноговь аймгийн Засаг дарга 2019.02.20-ны өдөр гаргасан ба хотхоны бүтээн байгуулалтын ажлыг 2019 оны 4 дүгээр улиралд эхлүүлээд байна. | 100 /холбогдох арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн тул хяналтаас хасуулах саналтай/ | |
| | 45 | | 2.. Хотхоны бүтээн байгуулалтад шаардагдах бараа материал, тоног төхөөрөмжийг татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг боловсруулж 2019 оны 5 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт даалгасугай. | Хотхоны өртөг зардлыг бууруулах зорилгоор тус хотхоныг барьж байгуулахад шаардагдах дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй, импортоор оруулж ирэх бараа, материалыг гаалийн албан татвар болон нэмэгдсэн өртгийн албан татвараас хөнгөлөх тухай хуулийн төсөл, хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулан УУХҮ-ийн сайд, ХЗДХ-ийн сайд, Сангийн сайд нараар батлуулан, УИХ-ын холбогдох Байнгын хороодоор хэлэлцүүлэн, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, 2019.11.30-ны өдрийн Улсын Их Хурлын нэгдсэн чуулганы хуралдаанаар хэлэлцэн соёрхон баталсан. | 100 /хууль батлагдсан тул хяналтаас хасуулах саналтай/ | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 46 | | 4.. Хотхоны бүтээн байгуулалтын ажлыг 2019 оны эхний хагас жилд багтаан эхлүүлж, ажлын явц, үр дүнгийн талаар Засгийн газарт улирал тутам танилцуулж байхыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг, орон нутгийн зүгээс шаардлагатай дэмжлэг үзүүлэхийг Дорноговь аймгийн Засаг дарга Т.Энхтүвшин нарт тус тус даалгасугай. | ЗГ-ын 2019.06.05-ны өдрийн 25 дугаар тэмдэглэл гарч Дорноговь аймгийн Сайншанд суманд байгуулах ажилчдын хотхоны барилгын зураг төслийг хэсэгчлэн батлуулах, туслан гүйцэтгэгч байгууллагыг сонгон гэрээ байгуулж, хотхоны бүтээн байгуулалтын ажлыг шуурхай эхлүүлэх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Батлан хамгаалахын сайд, "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал нарт даалгасан. ЗГ-аас өгсөн чиглэлийн дагуу барилгын зураг төсөл болон барилга угсралтын ажлыг гүйцэтгэх компанийг сонгон шалгаруулсан бөгөөд зураг төслийн ажлыг 2019 оны 6 дугаар сард багтаан хэсэгчлэн батлуулж, батлагдсан зураг төслийн дагуу газар шороо, суурийн ажлыг хийж гүйцэтгээд байна. | 100 /бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлсэн тул хяналтаас хасуулах саналтай/ | |
| 37 | 47 | Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2019-04-10 Дугаар 2019_135 | 2.. "Монголын төмөр зам" ТӨХК-ийн гаргасан үнэт цаасыг нэрлэсэн үнээр нь, нүүрс тээвэрлэлтийн төлбөрөөс суутгах зэрэг эргэн төлөх нөхцөлөөр Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн 2018 оны үйл ажиллагааны хуримтлагдсан ашгаас худалдан авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (М.Баяраа)-д даалгасугай. | "Монголын төмөр зам" ТӨХК-ийн гаргасан үнэт цаасыг нэрлэсэн үнээр нь худалдан авах урьдчилгааны хүрээнд "Эрдэнэс Тавантолгой" ХК-иас өнөөгийн байдлаар нийт 156.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг "Монголын төмөр зам" ТӨХК-д олгоод байна. Төслийн урьдчилсан санхүүжилтийг яаралтай шийдвэрлэснийн үр дүнд тус чиглэлийн 414.6 км төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг 2019 оны 05 дугаар сарын 24-ний өдөр эхлүүлсэн бөгөөд Зэвсэгт хүчний дугаар ангийн бие бүрэлдэхүүн болон "Монголын төмөр зам" ТӨХК-ийн инженер, техникийн ажилчид бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэж байна. | 100 /уг заалтын хэрэгжилт бүрэн хангагдсан тул хяналтаас хасуулах саналтай/ | |
| | 48 | | 4.. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг холбогдох хууль тогтоомж, олон улсын стандарт, чанарын шаардлагад нийцүүлэн барьж байгуулах ажлыг зохион байгуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Батлан хамгаалахын сайд Н.Энхболд нарт үүрэг болгосугай. | "Эрдэнэс Тавантолгой" ХК-иас өнөөгийн байдлаар нийт 156.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг "Монголын төмөр зам" ТӨХК-д олгосны дүнд тус чиглэлийн 414.6 км төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг 2019 оны 05 дугаар сарын 24-ний өдөр эхлүүлсэн бөгөөд Зэвсэгт хүчний дугаар ангийн бие бүрэлдэхүүн болон "Монголын төмөр зам" ТӨХК-ийн инженер, техникийн ажилчид бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэж байна. | 100 /уг заалтын хэрэгжилт бүрэн хангагдсан тул хяналтаас хасуулах саналтай/ | |
| 38 | 49 | Төслийн нэгж байгуулах тухай 2019-05-01 Дугаар 2019_176 | 1.. Газрын ховор элементийн хайгуул, олборлолт, ашиглалтын эрх зүйн орчинг боловсронгуй болгох, нөөц нь бүртгэгдсэн ордын эдийн засгийн үр ашгийн тооцоог гүйцэтгэх, тэдгээрийг өндөр хөгжилтэй орнуудтай хамтран ашиглаж эдийн засгийн эргэлтэд оруулах үүрэг бүхий төслийн нэгжийг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгасугай. | "Эрдэнэс Монгол" ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 05 дугаар сарын 10 өдрийн 16 дугаар Газрын ховор элементийн геологи хайгуул, ашиглалтын талаарх эрх зүйн орчныг боловсронгуй болгох, нөөц бүхий ордуудын төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоох, геологи хайгуул, ашиглалт боловсруулалтын талаар нарийвчилсан судалгааг хийх, эдийн засгийн үр ашгийг тооцох, арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулах чиг үүрэг бүхий төслийн нэгжийг "Эрдэнэс Монгол" ХХК-ийн харьяанд байгуулан үйл ажиллагаа эхлүүлээд байна. | 100 /төслийн нэгжийг байгуулсан тул хяналтаас хасуулах саналтай/ | |
| | 50 | | 3.. Төслийн нэгжийг 5 жилийн хугацаатай ажиллуулж, үр дүнгийн тайланг тухайн жилийн 12 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулж байхыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, "Эрдэнэс Монгол" ХХК (П.Ганхүү)-д даалгасугай. | "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн ТУЗ-ын тогтоолоор байгуулан холбогдох ажлыг зохион байгуулж байна. | /-/ хэрэгжилт тооцох хугацаа болоогүй | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 39 | 51 | Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах эрх олгох тухай<br>2019-05-01<br>Дугаар 2019_184 | 4.. Авто зам, замын байгууламжийн барилгын ажил гүйцэтгэх хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу зохих дэмжлэг үзүүлж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт даалгасугай. | Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт олгох хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжих Гачууртын уулзвараас Налайх-Чойрын уулзвар хүртэлх 20.9 км авто замын өргөтгөл, шинэчлэлтийн барилгын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах талбайн солбицлын төслийг боловсруулж, 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 184 дүгээр тогтоолоор батлуулсан. | 100 /тусгай зөвшөөрлийг олгосон, тогтоолын хэрэгжилтийг хангасан тул хяналтаас хасуулах | |
| 40 | 52 | Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн талаар авах арга хэмжээний тухай<br>2019-05-12<br>Дугаар 2019_188 | 2.. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн бүтээн байгуулалтын ажилд шаардагдах ус, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрөөс чөлөөлөх асуудлыг судалж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат нарт даалгасугай. | Монгол Улсын Засгийн Газраас 2019 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр “Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 135 дугаар тогтоолын дагуу Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших Тавантолгойн нүүрсний ордоос Дорноговь аймгийн Зүүнбаян өртөө хүртэл нийт 414.6 км Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн эргэлтийн цэг, солбицлын төслийг боловсруулж, 2019 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 189 дүгээр тогтоолоор батлуулсан. Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайг төмөр замын гол тэнхлэгээс 2 тийш 20 км байхаар тооцсон. Энэ 40 км-ийн радиус доторх түгээмэл тархацтай ашигт малтмалыг ашиглах тохиолдолд борлуулалтын үнэлгээ, нөөц ашигласны төлбөрийг хөнгөлөх асуудлыг Өмнөговь аймгийн ИТХТ-ийн 8-р сарын 07-ны өдрийн 117, Дорноговь аймгийн ИТХТ-ийн 6-р сарын 51-р тогтоолоор хөнгөлүүлсэн. | 100 /тусгай зөвшөөрлийг олгосон, тогтоолын хэрэгжилтийг хангасан тул хяналтаас хасуулах саналтай/ | |
| 41 | 53 | Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн эргэлтийн цэг, солбицол батлах тухай<br>2019-05-12<br>Дугаар 2019_189 | 3.. Төмөр замын суурь бүтцийн барилгын ажил гүйцэтгэх хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу зохих дэмжлэг үзүүлж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт даалгасугай. | Монгол Улсын Засгийн Газраас 2019 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр “Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 135 дугаар тогтоолын дагуу Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших Тавантолгойн нүүрсний ордоос Дорноговь аймгийн Зүүнбаян өртөө хүртэл нийт 414.6 км Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн эргэлтийн цэг, солбицлын төслийг боловсруулж, 2019 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 189 дүгээр тогтоолоор батлуулсан. | 100 / холбогдох шийдвэрийг гаргуулж зохих дэмжлэгийг үзүүлсэн тул хяналтаас хасуулах саналтаай/ | |
| 42 | 54 | Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай<br>2019-07-03<br>Дугаар 2017_276 | 3.. Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоосонтой холбогдон гарч болзошгүй нэмэлт зардлыг 2019 оны хувьд батлагдсан төсөвт багтааж, цаашид жил бүрийн улсын төсвийн төсөлд тооцон тусгаж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. | Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай Засгийн газрын 2019 оны 276 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн ажиллаж байна. УУХҮЯ-нд төрийн үйлчилгээний нийт 9 ажилтан ажиллаж байна. ТНБД-ын 2019 оны 9 сарын 26-ны өдрийн А/157 дугаар тушаалын гуравдугаар хавсралтаар шинэчлэн батлав. | 100 /тогтоолын хэрэгжилтийг хангасан тул хяналтаас хасуулах саналтай/ | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 43 | 55 | Төв, суурин газрын 2019-2020 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай 2019-07-03 Дугаар 2019_270 | 3.. “Багануур” ХК, “Шивээ-Овоо” ХК, “Шарын гол” ХК-ийн үйлдвэрлэлийн найдвартай ажиллагааг хангах, дизелийн түлш, шатахууны нөөц бүрдүүлэн уурхайн хөрс хуулалт, их засварын ажлыг хугацаанд нь хийж, нүүрсний бэлэн нөөцийг хэвийн хэмжээнд байлгах, аваар ослын үед хэрэглэх техник, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн нөөц бүрдүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, “Эрдэнэс Монгол” ХХК (П.Ганхүү)-д тус тус даалгасугай. | УУХҮЯ-ны ТНБД-ын 2019 оны А/139 дүгээр тушаалаар өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах, шаардагдах нөөцийг бүрдүүлэх үүрэг бухий ажлыг хэсгийг байгуулж, ажлын хэсэг газар дээр нь ажиллаж дүнг сайдад танилцуулж ажиллав. | 100 /тогтоол нь нэг удаагийн үйлчлэлтэй батлагдсан ба холбогдох арга хэмжээг авч ажиллсан байна./ | |
| | 56 | | 7.. Сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийн түүхий эд (мидлинг)-ийг үйлдвэрийн хашаанд 300.000 тонн, Төв аймаг дахь дундын агуулахад 700.000 тонныг татан төвлөрүүлж, нөөц бүрдүүлэх, сайжруулсан шахмал түлшний бэлэн бүтээгдэхүүн 200.000 тонныг үйлдвэрлэн бэлэн болгох арга хэмжээ авахыг Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн, Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, “Эрдэнэс-Тавантолгой” ХК (Б.Ганхуяг)-д тус тус даалгасугай. | Сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийн түүхий эдийг, төвлөрүүлж, нөөцийг бүрдүүлэн ажилласан. | 100 /тогтоол нь нэг удаагийн үйлчлэлтэй батлагдсан ба холбогдох арга хэмжээг авч ажиллсан байна./ | |
| 44 | 57 | Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай 2019-07-03 Дугаар 2019_275 | 2.. Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалтыг баталсантай холбогдон гарч болзошгүй нэмэлт зардлыг 2019 оны хувьд батлагдсан төсөвт багтааж, цаашид жил бүрийн улсын төсвийн төсөлд тооцон тусгаж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. | Тогтоолын хэрэгжилтийг ханган, ТНБД-ын 2019 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн А/157 тоот тушаалыг батлуулан Төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээг шинэчлэн тогтоосон. Нэмэлт зардлыг 2019 оны хувьд батлагдсан төсөвт багтааж, цаашид жил бүрийн улсын төсвийн төсөлд тооцон тусгаж байхаар шийдвэрлэсэн. | 100 /тогтоолын хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан тул хяналтаас хасуулах саналтлай/ | |
| 45 | 58 | Төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээг шинэчлэн тогтоох тухай 2019-07-03 Дугаар 2019_277 | 2.. Төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээг шинэчлэн тогтооход шаардагдах зардлыг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны батлагдсан төсөвт багтаан зохицуулж, цаашид шаардагдах зардлыг 2020 оноос эхлэн жил бүрийн улсын төсөвт тусгаж байхыг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. | Тогтоолын хэрэгжилтийг ханган, ТНБД-ын 2019 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн А/157 тоот тушаалыг батлууланТөрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээг шинэчлэн тогтоосон. | 100 /тогтоолын хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан тул хяналтаас хасуулах саналтлай/ | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 46 | 59 | Газрын тос боловсруулах үйлдвэрийн ус хангамжийн талаар<br>2019-07-03<br>Дугаар 2019_284 | 1.. Газрын тос боловсруулах үйлдвэрийн технологийн болон унд, ахуйн хэрэгцээнд шаардлагатай 106 л/с усыг Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт орших Бор хөөврийн говийн газрын доорх усны ордоос хангах асуудлыг судалж шийдвэрлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт даалгасугай. | Газрын тос боловсруулах үйлдвэрийн технологийн болон унд, ахуйн хэрэгцээнд шаардлагатай 106 л/с усыг Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт орших Бор хөөврийн говийн газрын доорх усны ордоос хангах асуудлыг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд усны нөөцийн зөвлөлөөр яаралтай хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллах талаар саналыг БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга буюу Усны нөөцийн зөвлөлийн дарга Ц.Цэнгэлд 2019.09.07-ны өдрийн 03/2543 дугаар Санал хүргүүлэх тухай албан бичгээр хүргүүлсэн. Албан бичгийн хариуд Газрын тос боловсруулах үйлдвэрийн технологийн болон унд ахуйн хэрэгцээнд 106 л/с усыг Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт орших бор хөөврийн говийн газрын доорх усны ордоос хангах асуудлыг шийдвэрлэсэн Засгийн газрын тогтоол, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллаж, Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4 дэх заалтын дагуу ус ашиглуулах дүгнэлтийг "Монгол Ус" ТӨААТҮГ-аар гаргуулж, Умард говийн гүвээт Халхын дунд талын сав газрын захиргаанаас зөвшөөрөл авч, гэрээ байгуулан ажиллахыг зөвлөсөн зөвлөмжийг Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас 2019.09.23-ны өдрийн 03/6576 дугаар албан бичгээр ирүүлснийг "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-нд 2019.10.07-ны өдрийн 03/2803 дугаар албан бичгээр хүргүүлсэн. | 100 /тогтоолын хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан/ | |
| 47 | 60 | Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай<br>2019-07-24<br>Дугаар 2019_304 | 1.. Засгийн газрын 2018 оны 8 дугаар сарын 8-ны өдрийн 242 дугаар тогтоолоор байгуулагдсан "Тавантолгой төмөр зам" хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцааны 66 хувийг "Эрдэнэс-Тавантолгой" ХК-д, 34 хувийг "Монголын төмөр зам" ТӨХК-д тус тус эзэмшүүлэх, холбогдох журмын дагуу бүртгүүлэх арга хэмжээ авахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (А.Ариунболд)-т тус тус даалгасугай. | Компанийн зүгээс тогтоолын дагуу "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн 66 хувийг "ЭТТ" ХК эзэмших чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:<br><br>• 19.07.30-нд ЭТТ ХК-ийн ТУЗ хуралдаж 31 дугаар тогтоол гарган гэрээ хэлцэл байгуулахыг зөвшөөрсөн;<br>• 19.08.13-нд ЭТТ ХК-ийн ТУЗ хуралдаж 36 дугаар тогтоол гарган "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хуралд компанийг төлөөлөх этгээдийг томилж /Т.Цогтбаяр/, холбогдох удирдамжийг хавсралтаар баталсан;<br>• Мөн дээрх тогтоолоор төслийн үйл ажиллагааг цаг алдалгүй эхлүүлэх зорилгоор "Тавантолгой төмөр зам" ХХК-д 15 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор шийдвэрлэсэн.<br>• 19.08.15-нд ЭТТ ХК-ийн ТУЗ хуралдаж 41 дүгээр тогтоол гарган "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн ТУЗ-д нэр дэвшигчдийг баталсан;<br>• 19.08.15-нд "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн ХЭХурал болж компанийн дүрэм болон ТУЗ гишүүдийг хэлэлцэж шийдвэрлэсэн. | 100 /Хяналтаас хасуулах саналтай/ | |
| 48 | 61 | Дүрэм батлах тухай<br>2019-08-07<br>Дугаар 2019_313 | 2.. Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, хэрэгжилтэд хяналт тавихыг Монгол Улсын Шадар сайд Ө.Энхтүвшинд тус тус үүрэг болгосугай.<br>*Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм* | Хэрэгжилтийг зохион байгуулах ажлын хүрээнд цагдаа, тануул, онцгой байдал, мэргэжлийн хяналт, зэвсэгт хүчний жанжин штаб болон мэргэжлийн холбоодтой хамтран ажиллаж байна. | 100 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 49 | 62 | Үндэсний хөтөлбөр батлах тухай<br>2019-08-14<br>Дугаар 2019_317<br>*Алтны бичил уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй мөнгөн усны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр* | 3.. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хамтран баталж, хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн I улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт тус тус даалгасугай. | Алтны бичил уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй мөнгөн усны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний төслийг боловсруулан Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын хамтарсан тушаалаар батлуулахаар Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас 2019.12.31-ний өдрийн 01/9186 тоот албан бичгийг ирүүлээд байгааг судалж байна. | /-/ хэрэгжилт тооцох хугацаа болоогүй | |
| 50 | 63 | Байгалийн нөөц газрын хилийн заагийг тогтоох тухай<br>2019-08-14<br>Дугаар 2019_319 | 3.. Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутаг дэвсгэрт орших Тост, Тосон бумбын нуруу орчмын нутаг дэвсгэрийг бүхэлд нь улсын тусгай хамгаалалтад авах асуудлыг судлан 2019 оны IY улиралд багтаан Засгийн газарт танилцуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумьяабазар нарт тус тус даалгасугай. | Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутаг дэвсгэрт орших Тост, Тосон бумбын нуруу орчмын нутаг дэвсгэрийг бүхэлд нь улсын тусгай хамгаалалтад авах асуудлыг судлан Тост, тосон бумын Байгалийн нөөц газрын хилийн заагийг 153469 га талбайгаар нэмэгдүүлж, талбайн хэмжээ нийт 896540,37 га талбайтай болсон. Тус хилийн заагийг Байгаль орчны мэдээллийн төвийн мэдээллийн сан /www.eic.mn/ -нд бүртгэж авсан. | 100 /хяналтаас хасуулах саналтай/ | |
| 51 | 64 | Журам батлах тухай<br>2019-09-04<br>Дугаар 2019_342<br>*Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг тооцох, төлбөр ногдуулах, тайлагнах, төлөх журам"-ыг 1 дүгээр хавсралт, "Гадаадын зах зээлд борлуулсан нүүрс, төмрийн хүдэр, төмрийн хүдрийн баяжмалд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулах борлуулалтын үнэлгээ тооцох журам* | 3.. Энэ тогтоолыг мөрдөж ажиллахыг Татварын ерөнхий газар (Б.Заяабал), Гаалийн ерөнхий газар (Б.Асралт), Ашигт малтмал, газрын тосны газар (Х.Хэрлэн), Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Н.Цагаанхүү)-т, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт тус тус үүрэг болгосугай. | Журмын хэрэгжилтийг хангах хүрээнд Сангийн сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд нарын 2018.07.27-ны өдрийн 200/А/177 дугаар хамтарсан тушаалаар Гадаадын зах зээлд борлуулсан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг тогтоох олон улсын зах зээлийн үнийг тогтоох ажлын хэсгийг байгуулан ажиллаж, сар бүрийн 10-ны өдрийн дотор жишиг үнийг тогтоож, нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулан, журмын хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллав. | 100 /журмыг асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд хамтран баталсан тул хяналтаас хасуулах саналтай/ | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 52 | 65 | Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай 2019-09-18 Дугаар 2019_355 | 1.. 1.4. Бичил уурхайгаар ашигт малтмал хууль бусаар олборлоход ашигласан болон ашиглахаар бэлтгэсэн техник, тоног төхөөрөмжийг талбайгаас гаргаж, харуул хамгаалалт зохион байгуулах, холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг олон нийтэд сурталчлан таниулах арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Цагдаагийн ерөнхий газар (С.Баатаржав), Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Н.Цагаанхүү) болон аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нар нарт; | Байгаль орчин, аялал жуулчлалын сайдаар ахлуулсан ажлын хэсэг 2019 оны 9 дүгээр сарын 17 болон 12 дугаар сарын 17-ны өдрүүдэд сард Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт хяналт шалгалт хийж хууль бусаар алт олборлож байсан үйл ажиллагааг таслан зогоох арга хэмжээг авч зөрчил гаргасан 48 үйлдэлд хамаарах зарим иргэн, аж ахуйн нэгжийг цагдаагийн байгууллагад шилжүүлсэн болно. Уг ажлын хэсэгт Уул Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар зэрэг байгууллагуудын төлөөлөл ажилласан болно.<br>Ажлын хэсэг 12 дугаар сарын 17-ны өдөр Сэлэнгэ аймгийн Баянгол, Ерөө сумын нутагт хяналт, шалгалт хийж, шалгалтын мөрөөр хууль бусаар алт олборлох зорилгоор ашиглаж байгаа болон ашиглахаар ууланд, ойд нуусан байгаа техникийг албадан буулгах ажлыг зохион байгуулах, алт олборлох зориулалтаар ашигладаг том оврын техник, тээврийн хэрэгслийн бүртгэлийн гэрчилгээ шалгаж бүртгэлгүй тохиолдолд нэвтрүүлэхгүй байх арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг аймгийн удирдлага, холбогдох албан тушаалтан нарт үүрэг болгосон. Ажлын хэсгээс хууль бусаар алт олборлох үйл ажиллагааг таслан зогсоох, холбогдох арга хэмжээг газар дээр нь хэрэгжүүлэх зорилгоор Сэлэнгэ аймагт 10 ажлын хэсэг 1 сарын хугацаатай ажиллуулахаар төлөвлөн холбогдох зардлыг Засгийн газрын 2019 оны 341 дүгээр тогтоолоор батлагдсаныг 2020 онд шилжүүлэх тухай Засгийн газрын шийдвэрийн төслийг бэлтгэсэн болно. | 100 | |
| | 66 | | 1.. 1.6. Бичил уурхайн зориулалтаар ашигт малтмал олборлох дүгнэлтийг 2019 оныг дуусталх хугацаанд гаргахгүй байхыг Ашигт малтмал, газрын тосны газар (Х.Хэрлэн)-т, | Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажилласан. | 100 /Хяналтаас хасуулах саналтай/ | |
| | 67 | | 2.. Энэ тогтоолын 1.2 болон 1.5-д заасныг хэрэгжүүлэхэд шаардагдах үйл ажиллагааны зарим зардлыг Засгийн газрын нөөц сангаас гаргахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, уг зардлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар болон аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт; | Засгийн газрын 2019 оны 341 дүгээр тогтоолын дагуу тусгай зөвшөөрөл цуцалсан талбайн байгаль орчны хохирлыг барагдуулах, нөхөн сэргээлтийг албадан хийлгэх, хяналт хамгаалалтыг хэрэгжүүлэхэд 3 сарын хугацаанд нийт 767,3 сая төгрөгийн санхүүжилт зарцуулсан. Харин хууль бусаар алт олборлох үйл ажиллагааг таслан зогсоох, холбогдох арга хэмжээг газар дээр нь хэрэгжүүлэх зорилгоор Сэлэнгэ аймагт 10 ажлын хэсэг 1 сарын хугацаатай ажиллуулахаар төлөвлөн холбогдох зардлыг Засгийн газрын 2019 оны 341 дүгээр тогтоолоор батлагдсаныг 2020 онд шилжүүлэх тухай саналыг боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулах төслийг боловсруулсан. | 100 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 68 | | 3.. Энэ тогтоолын 1 дэх заалтад заасны дагуу холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах төслийг боловсруулж 2019 оны IY улиралд багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт үүрэг болгосугай. | Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Улсын Их хурлын гишүүн, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбатын боловсруулсан Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд санал дүгнэлт авах тухай Хууль, зүй дотоод хэргийн сайдаас ирүүлсэн албан бичигт 2019.10.18 ны өдрийн 01/2960 тоотоор хариу хүргүүлсэн. | 100 | |
| 53 | 69 | Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицол батлах тухай<br>2019-10-09<br>Дугаар 2019_377 | 4.. Авто зам, замын байгууламжийн барилгын ажил гүйцэтгэх хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу зохих дэмжлэг үзүүлж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт даалгасугай. | Эрхлэх асуудлын хүрээнд холбогдох дэмжлэгийг тухай бүр үзүүлж, хэрэгжилтийг хангаж, ажилласан. | 100/Хяналтаас хасуулах саналтай/ | |
| | 70 | | 6.. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгасугай. | | 100/Хяналтаас хасуулах саналтай/ | |
| 54 | 71 | Газрын тосны бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэх тухай<br>2019-11-19<br>Дугаар 2019_409 | 2.. Энэ тогтоолын хавсралтад заасан газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөцийг 2020 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн дотор бүрдүүлэх арга хэмжээ авч, нөөцийн бүрдүүлэлт, бүтээгдэхүүний чанарт хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Ашигт малтмал, газрын тосны газар (Х.Хэрлэн)-т тус тус даалгасугай. | Тогтоолын хавсралтад заасан газрын тосны бүтээгдэхүүний 22 компанийн нөөцийг 2020 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн дотор бүрдүүлэх арга хэмжээ авч, нөөцийн бүрдүүлэлт, бүтээгдэхүүний чанарт хяналт тавьж ажиллах талаар чиглэлийг 2019.01.08-ны өдрийн 01/41тоотоор АМГТГ-т хүргүүсэн. АМГТГ-аас 2019.12.31 өдрийн 1/8440 тоотоор нэр бүхий компаниуд нөөц бүрдүүлэх гэрээ байгуулах тухай мэдэгдэл хүргүүлээд байна. | 100 /компанийн нөөц бүрдүүлэх ажлыг зохион байгуулсан тул хяналтаас хасуулах саналтай/ | |
| Ерөнхий сайдын захирамж | | | | | | |
| 55 | 72 | Үндэсний зөвлөл, салбар зөвлөлийн бүрэлдэхүүн батлах тухай<br>2014-05-16<br>Дугаар 08_2014_61 | 2. Нээлттэй засгийн түншлэлийн ажлын албаны чиг үүргийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, Үндэсний зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг нарийн бичгийн даргад даалгасугай. | Ерөнхий сайдын 2014 оны 5 дугаар сарын 16 -ны өдрийн 61 дүгээр захирамжаар Нээлттэй засгийн түншлэлийн бодлого, төлөвлөгөөг хэрэгжүүлэх, Монгол Улсын Нээлттэй засгийн түншлэлийн Ажлын албаны ажлыг хянан зохицуулах, нэгтгэн дүгнэх үүрэгтэйгээр байгуулсан бөгөөд Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд 2015 оны 10 дугаар сарын 23-ны өдөр Монгол Улсын Ерөнхий сайдын 207 дугаар захирамжаар өөрчлөлт оруулсан. Одоогоор тус бүрэлдэхүүнд Үндэсний зөвлөлийн даргаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, дэд даргаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга, гишүүдээр Сангийн яам, Хууль зүйн яам, Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга нар, болон Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын ерөнхийлөгч, Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн ерөнхийлөгч, Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын Судалгааны төвийн ерөнхий захирал, Нээлттэй нийгэм хүрээлэнгийн гүйцэтгэх захирал нар, Нарийн бичгийн даргаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт, шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга ажиллаж байна. УУХҮЯ-аас НЗТ-ийн үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө-/2016-2018/-ний биелэлтийг хүргүүлж ажилласан. | 100 /УУХҮЯ-ны зүгээс хамаарах ажлыг хийсэн тул хяналтаас хасуулах саналтай/ | |

| | | | |
|---|---|---|---|
| 56 | 73 | Ажлын хэсэг байгуулах тухай"Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр" барьж байгуулах төслийн хөрөнгө оруулагчтай хамтран ажиллах талаар хэлэлцээ хийж, санал, дүгнэлт боловсруулах<br>2016-11-22<br>Дугаар 2016_113 | 2. Ажлын хэсгийн баримтлан ажиллах удирдамжийг хавсралт ёсоор баталж, төслийн хөрөнгө оруулагчтай хэлэлцээ хийж санал, дүгнэлт боловсруулан, дүнг 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор Засгийн газарт танилцуулахыг Ажлын хэсэг (Ц.Дашдорж)-т даалгасугай. |

| | | |
|---|---|---|
| МУ-ын ЗГ-ын 2016.09.28-ны өдрийн 107 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд УУХҮС-ын 2016 оны А/43 дугаар тушаалаар УУХҮЯ-ны дэргэд “Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр барих” төсөл хэрэгжүүлэх нэгж байгуулан ажиллаж Дэлхийн банкны стандарт шаардлагад нийцсэн ТЭЗҮ, БНБОҮ болон БОННБҮ-ний тайлангуудыг боловсруулж бэлэн болгоод байна.<br>УУХҮС-ын зөвлөлийн 2019.1.30-ны өдрийн хуралдааны 02 дугаар шийдвэрийн дагуу "Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр барих” төслийн нэгжийг татан буулгаж чиг үүргийг “Эрдэнэс Монгол” ХХК-д шилжүүлэх тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан Засгийн газрын 2019.12.18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж дэмжигдэн ЗГ-ын 2019 оны 451 дугаар тогтоолыг батлаад байна.<br>Төслийн нэгжийн чиг үүргийг “Эрдэнэс Монгол” ХХК-д шилжүүлснээр тус төслийг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хөрөнгө оруулагчийг сонгох, түүнтэй гэрээ хэлэлцээр хийх, газрын болон бусад холбогдох зөвшөөрлийг авч төслийг хэрэгжүүлэх хууль, эрх зүйн нөхцөл бүрдэх юм. | 100 /Төслийн нэгжийн чиг үүргийг ЗГХЭГ-ын харьяа “Эрдэнэс Монгол” ХХК-д шилжүүлсэн тул хяналтаас хасуулах/ | Төслийн ТЭЗҮ-д тооцоолсон одоогийн хүчин чадлаар үйлдвэрийг барихад 2.5 тэрбум ам.доллар буюу их хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай байгаа нь хөрөнгө оруулагчдын сонирхолыг татахгүй байгаа тул төслийг үе шаттайгаар хэрэгжүүлж зорилтот хүчин чадалд хүргэх боломжийг судлах зорилгоор батлагдсан ТЭЗҮ-д нэмэлт тодотгол хийх, мөн төслийг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх хөрөнгө |

| | | | |
|---|---|---|---|
| 57 | 74 | Ажлын хэсэг байгуулах тухай"Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр" барьж байгуулах төслийн хөрөнгө оруулагчтай хамтран ажиллах талаар хэлэлцээ хийж, санал, дүгнэлт боловсруулах 2016-11-22 Дугаар 2016_114 | 2. Ажлын хэсгийн баримтлан ажиллах удирдамжийг хавсралт ёсоор баталж, төслийн хөрөнгө оруулагчтай хэлэлцээ хийж санал, дүгнэлт боловсруулан, дүнг 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор Засгийн газарт танилцуулахыг Ажлын хэсэг (Ц.Дашдорж)-т даалгасугай. |

| | | |
|---|---|---|
| Ерөнхий сайдын 2016 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" 114 дүгээр захирамжаар "Зэсийн баяжмал боловсруулах үлйдвэр" барьж байгуулах төслийн хөрөнгө оруулагчтай хамтран ажиллах талаар хэлэлцээ хийж, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг ажиллаж дүгнэлт гаргасан. Үүнд: 1.Хатчийн судалгааны тайлан, салбарын яамнаас ирсэн дүгнэлтийг үндэслэн Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийг Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт барих асуудлыг ЗГ-ын хуралдаанаар оруулж шийдвэрлүүлэх:2.Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн нийт хувьцааны 10-аас доошгүй хувийг хөрөнгө оруулалтын зардал гаргахгүйгээр төр эзэмших тухай УУХҮЯ-ны саналыг ЗГ-ын хуралдаанд оруулж шийдвэрлүүлэх: 3.Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн төслийг хэрэгжүүлэх , хөрөнгө оруулагчтай гэрээ хэлцэл хийх ажлыг эрчимжүүлж үр дүнг 2017 оны II улиралд багтаан Засгийн газарт танилцуулах асуудлыг ЗГ-аас гаргах тогтоолд тусгаж шийдвэрлэх. Ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн ЗГ-ын тогтоолын төслийг боловсруулан зохих журмын дагуу ЗГ-ын 2017.03.15-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эрчимжүүлэх тухай" 88 дугаар тогтоол батлагдан бөгөөд тус тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Түүнчлэн тус үйлдвэрийг байгуулах тухай асуудлыг ҮАБЗ-өөр хэлэлцүүлж, зөвлөмж гарсан бөгөөд ЗГ-ын 2019.05.17-ны өдрийн "Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай" 196 дугаар тогтоолоор ЗГ-ын 2017.09.13-ны өдрийн 247 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт"-д хамруулж нэн чухал асуудлаар анхааран ажиллаж байна. /Хэрэгжилт-100%/ | 100 | |

| | | | |
|---|---|---|---|
| 58 | 75 | Ажлын хэсэг байгуулах тухай" Гацууртын алтны үндсэн ордыг ашиглах төсөл"-ийн хөрөнгө оруулагчтай Хөрөнгө оруулалтын гэрээбайгуулах талаар хэлэлцээ хийх үүрэг бүхий<br>2017-01-25<br>Дугаар 2017_20 | 2. Хэлэлцээний үр дүнг эцэслэн тохирсон гэрээний төслийн хамт Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдоржид даалгасугай. |

| | | | |
|---|---|---|---|
| | “Гацууртын ордын төрийн эзэмшлийн хувь тогтоох тухай” Улсын Их Хурлын 2016 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 11 дүгээр тогтоолоор Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутагт орших Гацууртын ордын төрийн эзэмшлийн хэмжээг 34 хувиар тогтоосон. Тус ордын нөөц болон техник, эдийн засгийн үндэслэлд тодотгол хийгдэж байна. ТЭЗҮ-ийг хүлээн авсаны дараа Орд ашиглах гэрээ байгуулах ба уг гэрээгээр ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээг тохирч шийдвэрлэх юм. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны А/28 дугаар тушаалаар Ерөнхий сайдын 2017 оны 01 дугаар сарын 25-ны өдрийн 20, 21 тоот захирамжуудаар байгуулагдсан Ажлын хэсгүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, шаардагдах баримт бичгийн төслийг боловсруулах үүрэг бүхий дэд ажлын хэсгийг байгуулан ажиллуулж байна. Дэд ажлын хэсэг “Орд ашиглах гэрээ”-ний төслийг боловсруулан “Сентеррагоулд Монголия” ХХК-нд 2017 оны 03 дугаар сарын 01-ны өдөр санал авахаар хүргүүлсэн. Мөн Хөрөнгө оруулалтын гэрээний төслийг Үндэсний хөгжлийн газраас байгуулсан Ажлын хэсгийн хүрээнд боловсруулж, “Сентеррагоулд Монголия" ХХК-иас санал авахаар 2017 оны 03 дугаар сарын 30-өдөр хүргүүлсэн. Орд ашиглах болон Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулахаас өмнө “Сентеррагоулд Монголиа" ХХК-иас Гацууртын ордын нөөцийг тодотгож батлуулах, орд ашиглах Техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж батлуулах шаардлагатай байгаа тул хүлээгдэж байна. | /-/ | Шүүхийн маргаантай |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 59 | 76 | Ажлын хэсэг байгуулах тухай /Гацууртын алтны үндсэн ордю 2017-01-25 Дугаар 2017_21 | 2. Хэлэлцээний явц, үр дүн, орд ашиглах гэрээний төслийн талаар тухай бүр Засгийн газарт танилцуулж, гэрээг 2017 оны 3 дугаар сард багтаан байгуулах ажлыг удирдан зохион байгуулахыг Ажлын хэсэг (Ц.Дашдорж)-т даалгасугай. | "Гацууртын ордын төрийн эзэмшлийн хувь тогтоох тухай" Улсын Их Хурлын 2016 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 11 дүгээр тогтоолоор Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутагт орших Гацууртын ордын төрийн эзэмшлийн хэмжээг 34 хувиар тогтоосон. Тус ордын нөөц болон техник, эдийн засгийн үндэслэлд тодотгол хийгдэж байна. ТЭЗҮ-ийг хүлээн авсаны дараа Орд ашиглах гэрээ байгуулах ба уг гэрээгээр ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээг тохирч шийдвэрлэх юм. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны А/28 дугаар тушаалаар Ерөнхий сайдын 2017 оны 01 дугаар сарын 25-ны өдрийн 20, 21 тоот захирамжуудаар байгуулагдсан Ажлын хэсгүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, шаардагдах баримт бичгийн төслийг боловсруулах үүрэг бүхий дэд ажлын хэсгийг байгуулан ажиллуулж байна. Дэд ажлын хэсэг "Орд ашиглах гэрээ"-ний төслийг боловсруулан "Сентеррагоулд Монголиа " ХХК-нд 2017 оны 03 дугаар сарын 01-ны өдөр санал авахаар хүргүүлсэн. Мөн Хөрөнгө оруулалтын гэрээний төслийг Үндэсний хөгжлийн газраас байгуулсан Ажлын хэсгийн хүрээнд боловсруулж, "Сентеррагоулд Монголия" ХХК-иас санал авахаар 2017 оны 03 дугаар сарын 30-өдөр хүргүүлсэн.<br>Орд ашиглах болон Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулахаас өмнө "Сентеррагоулд Монголия" ХХК-иас Гацууртын ордын нөөцийг тодотгож батлуулах, орд ашиглах Техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж батлуулах шаардлагатай байгаа тул хүлээгдэж байна.<br>Мөн Гацууртын алтны ордын тусгай зөвшөөрлийн суудал шүүхээр эцэслэн шийдэгдээгүй учир төслийн үйл ажиллагаа тодорхойгүй хугацаагаар хойшлогдож байна. | /-/ | Шүүхийн маргаантай |
| 60 | 77 | Ажлын хэсэг байгуулах тухай /Стратегийн ач холбогдол бүхий Оюутолгойн зэс-алтны ордын төслийн хэрэгжилттэй холбогдуулан 2011 оны 6 дугаар сарын 8-ны өдөр хөрөнгө оруулагч талтай байгуулсан "Нэмэлт, өөрчлөлт оруулж дахин тодотгосон Хувь нийлүүлэ 2018-02-21 Дугаар 2018_27 | 3.. Оюутолгой төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор Өмнийн говийн хөгжил, дэд бүтцийн асуудлаар дэд ажлын хэсэг байгуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт, эрчим хүчний асуудлаар дэд ажлын хэсгийг байгуулахыг Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэнд тус тус хариуцуулж ажлын явц, үр дүнг тухай бүр танилцуулж байхыг даалгасугай. | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны А/74 дүгээр тушаалаар Өмнийн говийн хөгжил, дэд бүтцийн төлөвлөлтийн төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан. Уг ажлын хэсгээс Өмнийн говийн хөгжил, дэд бүтцийн судалгааг хийх шаардлагатай гэж үзсэн бөгөөд Үндэсний хөгжлийн газрын захиалгаар уг ажлын судалгааны ажил хийгдсэн болно. | 100 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 61 | 78 | Ажлын хэсэг байгуулах тухай /Газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэгч болон газрын тосны бүтээгдэхүүний бөөний, жижиглэнгийн худалдаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдийн бүтээгдэхүүнд чанарын хяналт, шалгалт хийж, дүгнэлт гаргах ажлыг зохион байгуулах, хо 2018-12-10 Дугаар 2018_201 | 2.. Газрын тосны бүтээгдэхүүнд чанарын хяналт, шалгалт хийж, дүгнэлт гаргах асуудлаар дэд ажлын хэсэг байгуулан ажиллуулах, ажлын явцад хяналт тавьж, үр дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулж шийдвэрлүүлэхийг Ажлын хэсэг (Ө.Энхтүвшин)-т даалгасугай. | Монгол Улсын Ерөнхий сайдын 2018.12.10-ны өдрийн 201 дүгээр захирамжийн дагуу Монгол Улсын Шадар Сайдын 2019.02.25-ны өдрийн 14 дугаар тушаалаар “Монгол Улсын газрын тосны бүтээгдэхүүнд чанарын хяналт, шалгалт хийж, дүгнэлт гаргах” дэд ажлын хэсгийг СЯ, УУХҮЯ, БОАЖЯ, ТЕГ, ГЕГ, ОБЕГ, МХЕГ, АМГТГ, СХЗГ, ЦЕГ, ШӨХТГ, МҮХАҮТ, “Улаанбаатар төмөр зам” ХНН болон Монголын шатахуун эрхлэгчдийн холбооны бүрэлдэхүүнтэй байгуулсан. Ажлын хэсгийн хүрээнд зохион байгуулагдсан 5 удаагийн хуралдаанд тухай бүр оролцож, саналаа ажлын хэсгийн төлөвлөгөөнд тусгуулж, холбогдох мэдээ мэдээллээр хангаж ажилласан. /Хэрэгжилт-100%/ | 100 /яамны зүгээс шаардлагатай мэдээ материалыг хүргүүлж ажилласан тул хяналтаас хасуулах саналтай/ | |
| 62 | 79 | Ажлын хэсэг байгуулах тухай 2019-09-16 Дугаар 2019_118 | 2.. 1. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2014 оны 14/06 дугаар зөвлөмж, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.70 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 323 дугаар тогтоолыг тус тус хэрэгжүүлэх хүрээнд Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт байгуулах “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр”-ийг дотоодын түүхий тосоор хангах, газрын тосны нийлүүлэлтийн дэд бүтцийн оновчтой хувилбарыг тодорхойлох, шаардлагатай тооцоо судалгаа хийх, техник технологийн шийдэл, хөрөнгө оруулалтын талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралт, Ажлын хэсгийн удирдамжийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай. 2. Санал, дүгнэлтээ 2019 оны IY улиралд багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Ажлын хэсэг (Д.Сумъяабазар)-т даалгасугай. | Энэхүү захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг гурван удаа хуралдаж, үйлдвэрт шаардлагатай түүхий эдийг тээвэрлэх дэд бүтцийн боломжит хувилбаруудын талаар мэдээ мэдээлэл, тооцоо судалгаа, хөрөнгө оруулалт, техник технологийн шийдлийг тодорхойлох зорилгоор холбогдох байгууллагуудаас баримт материалуудыг цуглуулсан. Ажлын хэсгийн зүгээс их хэмжээний түүхий тосыг хол зайд тээвэрлэхэд тохиромжтой дэд бүтцийн хувилбар болох төмөр зам болон дамжуулах хоолойн тээвэрлэлтийг манай нөхцөлд тохирох боломжтой гэж үзэн эдийн засгийн үр ашгийн харьцуулсан судалгааг Монголын логистикийн холбоо ТББ-аар хийж гүйцэтгүүлэн тайланг Засгийн газрын 2019.12.18-ний өдрийн хуралдаанаар танилцуулж 55 дугаар тэмдэглэл гаргуулаад байна. | 100 /ЕС-ын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг санал дүгнэлтээ ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлж холбогдох шийдвэрийг гаргуулсан тул хяналтаас хасуулах саналтай/ | |
| ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 63 | 80 | 2016 оны 04 дүгээр сарын 18-ний өдөр 22 дугаар тэмдэглэл 2016-04-18 Дугаар 2016_22 | XXYIII.4. . Гацууртын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй орд ашиглах болон хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах талаар хийж байгаа хэлэлцээний явцын талаар Уул уурхайн сайд Р.Жигжид Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан хэлэлцээг цаашид үргэлжлүүлж, 2016 оны 4 дүгээр сард багтаан орд ашиглах болон хөрөнгө оруулалтын гэрээ байгуулахыг Ажлын хэсэг (Р.Жигжид)-т даалгав. | Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутагт орших Гацууртын алтны үндсэн ордын тусгай зөвшөөрлийг эзэмшигч "Сентеррагоулд Монголиа" ХХК-тай орд ашиглах болон хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах ажлын хэсэг Монгол Улсын Ерөнхий сайдын 2016 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн 26, 2016 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн 43 дугаар захирамжуудаар байгуулагдаж, хөрөнгө оруулагчтай тодорхой түвшинд хэлэлцээр хийж, гэрээний төслийг бэлтгэсэн байдаг. Засгийн газар шинээр эмхлэн байгуулагдсантай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайдын 2017 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 20 болон 21 дүгээр захирамжуудаар шинэ ажлын хэсэг байгуулагдаж, дан Орд ашиглах гэрээ болон хөрөнгө оруулалтын гэрээний төслийг бэлтгэн хөрөнгө оруулагч талд хүргүүлээд байна. Гацууртын үндсэн ордыг ашиглах төслийн хувьд Засгийн газрын зүгээс төрийн эзэмшлийн 34 хувийг Ашигт малтмалын тухай хуульд тусгайлан заасан "ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр"-өөр орлуулах зарчмыг баримтлан ажиллаж байна. Шинэ ажлын хэсгийн хүрээнд бэлтгэсэн гэрээнүүдэд Монгол Улсын нэгдсэн орсон олон улсын гэрээ болон Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах нөхцөлүүдийг бүрдүүлж оруулж өгөхийн зэрэгцээ төслөөс хүртэх Монголын талын үр өгөөжийг тодорхой хэмжээнд нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох өөрчлөлтүүд орсон болно. Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөс Гацууртын ордын нөөцийг дахин тодотгох шаардлагыг "Сентерра Гоулд Монголиа" ХХК-д тавьсаны дагуу нөөцийг шинэчлэн тодотгох ажлыг хийж байна. үний дараа энэхүү төслийн ТЭЗҮ-ийг шинэчлэн боловсруулах бөгөөд уг ТЭЗҮ-д төслийн хөрөнгө оруулалт болон эдийн засгийн тооцоо өөрчлөгдөж болзошгүй тул Хөрөнгө | /-/ | Шүүхийн маргаантай |
| 64 | 81 | 2016 оны 10 дүгээр сарын 26-ны өдөр 52 дугаар тэмдэглэл 2016-10-26 Дугаар 2016_52 | XIII.1. 2.. хөрөнгө оруулагчид, аж ахуй эрхлэгчдэд төрийн захиргааны болон хуулийн байгууллагаас хууль бусаар дарамт учруулсан, хүнд суртал гаргасан, үндэслэлгүйгээр мөрдөн шалгасан асуудлыг судалж гаргасан дүгнэлтэд тусгагдсан асуудлыг шийдвэрлэх ажлыг шуурхай зохион байгуулж, хөрөнгө оруулагчид, аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагаанд саад учруулж байгаа хууль бус дарамт, шаардлагуудыг арилгаж, хүчингүй болгох арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга нарт. | Хөрөнгө оруулагчид, аж ахуй эрхлэгчдэд төрийн захиргааны болон хуулийн байгууллагаас хууль бусаар дарамт учруулсан, хүнд суртал гаргасан, үндэслэлгүйгээр мөрдөн шалгасан асуудал гарч буй эсэхийг тогтмол судалж байгаа ба дурдсан нөхцөл байдал үүсээгүй болно. | 100 Тэмдэглэлийн үйлчлэлийн хугацаа дуусгавар болсон тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ. | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 65 | 82 | 2017 оны 6 дугаар сарын 28-ны өдөр 31 дүгээр тэмдэглэл 2017-06-28 Дугаар 2017_31 | XI.3.. Дэлхийн банк болон Япон Улсын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газрын зээлсэн зээлийн өр төлбөрөөс “Багануур” ХК болон “Шивээ-Овоо” ХК-ийг чөлөөлөх асуудлыг судлан санал боловсруулж танилцуулахыг Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Эрчим хүчний сайд П.Ганхүү, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал Ц.Түмэнцогт нарт даалгав. | Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн хуралдааны 31 дүгээр тэмдэглэлийн дагуу “Багануур” ХК, “Шивээ-Овоо” ХК-иудын техник, санхүүгийн хэвийн ажиллагаа, эрчим хүчний үйлдвэрүүдийн найдвартай, тасралтгүй ажиллагааг хангах, нүүрсний хангамжийг сайжруулах зорилгоор “Багануур” ХК, “Шивээ-Овоо” ХК-иудын санхүүгийн хүндрэлтэй нөхцөл байдлыг харгалзан “Монгол Нүүрс” төслийн хүрээнд Дэлхийн банк болон Япон Улсын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газрын зээлсэн зээлийн өр төлбөрөөс “Багануур” ХК-ийн зээлийн үндсэн болон тохируулгын төлбөр 37,729.8 (Гучин долоон тэрбум долоон зуун хорин есөн сая найман зуун мянга) сая төгрөг, “Шивээ-Овоо” ХК-ийн зээлийн үндсэн болон тохируулгын төлбөр 73,036.9 (Далан гурван тэрбум гучин зургаан сая есөн зуун мянга) сая төгрөг, нийт 110,776.7 (Нэг зуун арван тэрбум долоон зуун далан зургаан сая долоон зуун мянга) сая төгрөгийг тухайн төрийн өмчит нүүрсний уурхайнуудад оруулсан хөрөнгө оруулалт болгон тооцох арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтнуудад даалгасан Засгийн газрын 2018 оны 132 дугаар тогтоол батлагдсан болно. | 100/хяналтаас хасуулах саналтай/ | |
| | 83 | | 2.. Газрын тосны тухай хууль тогтоомжийн хэрэгжилт болон бүтээгдэхүүн хуваах гэрээтэй холбоотой үйл ажиллагаа бодлогын удирдамжаар хангах хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Х.Хэрлэнд тус тус үүрэг болгов. | Энэхүү тэмдэглэлтэй холбогдуулан Газрын тосны тухай хуулийн хэрэгжилтийн байдал болон Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны талаарх танилцуулга, мэдээллийг Засгийн газрын 2018.10.03-ны өдрийн хуралдаанд танилцуулсан ба тус хуралдааны 41 дүгээр тэмдэглэлээр цаашид хийж гүйцэтгэх ажлын талаар үүрэг чиглэл өгсөн. Засгийн газрын 2018.10.03-ны өдрийн 41 дүгээр тэмдэглэлийн дагуу хийж гүйцэтгэсэн ажлын талаар тус тэмдэглэлийн биелэлтийн хэсэгт оруулсан болно. | 100 /ЗГ-ын хуралдаанд дахин асуудал хэлэлцүүлж шийдвэр гаргуулсан тул хяналтаас хасуулах саналтай/ | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 66 | 84 | 2018 оны 5 дугаар сарын 2-ны өдөр 20 дугаар тэмдэглэл 2018-05-02 Дугаар 2018_20 | XXII.9. 2. . Засгийн газрын тухай хуулийн 20.5.12-т заасан эрхэлсэн асуудлын хүрээний дагуу газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлын явц, гүйцэтгэл, зээлийн хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад хяналт тавьж, бодлогын болон мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт үүрэг болгов. | "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-ийн өдөр тутмын үйл ажиллагаанд болон дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэлийн тайланг гүйцэтгэгч компаниудаас долоо хоног бүр авч хяналт тавин ажиллаж байна. Мөн УУХҮЯ-ны дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ хэлэлцэх салбар хуралдаанаар "Газрын тос боловсруулах үйлдвэр болон дамжуулах хоолой барих төсөл"-ийн нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэлийг 2018.11.15-ны өдөр хэлэлцэн хүлээн авахаар шийдвэрлэсэн. Сайншанд-Газрын тос боловсруулах үйлдвэр хүртэлх гадна дэд бүтцийн төслүүдийг Хөгжлийн банкны зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн бөгөөд уг төслийн нийт төсөвт өртгөөс 38 орчим тэрбум төгрөгийн хэмнэлт гаргасан. Энэхүү хэмнэсэн мөнгөн хөрөнгийг Засгийн газар хотхоны бүтээн байгуулалтад зарцуулахаар шийдвэрлэсэн. Хотхоны өртөг зардлыг бууруулах зорилгоор тус хотхоныг барьж байгуулахад шаардагдах дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй, импортоор оруулж ирэх бараа, материалын гаалийн албан татварыг хөнгөлж, буцаан олгох тухай хуулийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, Улсын Их Хурлын нэгдсэн чуулганы 2019.11.30-ны өдрийн хуралдаанаар батлуулсан. "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК болон Энэтхэг Улсын "Инженерс Индия Лимитед" төрийн өмчит компаниуд 2019.05.13-ны өдөр газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн менежментийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулсан. Уг гэрээнд төслийн менежментийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх компани гүйцэтгэлийн баталгаа банкинд байршуулах, инженер-геологийн судалгаа хийх болон бусад асуудлуудыг тусган, тус гэрээний нэмэлт, | 100 /үйлдвэр барих төслийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын явц, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллан дэд бүтцийн байгууламжуудыг улсын комиссоор байнгын ашиглалтанд хүлээн авсан тул хяналтаас хасуулах саналтай/ | |
| | 85 | | XXII.9. 3. . Монгол Улсын Хөгжлийн банкнаас "Газрын тос боловсруулах үйлдвэр барих" төслийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад зориулан "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-д олгох зээлийн санхүүжилтийг ирээдүйд бий болох хөрөнгөөр барьцаалах замаар олгох асуудлыг судлан шийдвэрлэх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор), Хөгжлийн банкны гүйцэтгэх Б.Батбаяр нарт даалгав. | "Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл"-ийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад зориулан "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК болон Монгол Улсын Хөгжлийн банк хооронд ирээдүйд бий болох хөрөнгийг барьцаалан буцаан төлөх нөхцөлтэйгөөр 2018.04.13-ны өдрийн БГ-МГТ-ИХ 2018-44 дугаар "Барьцааны гэрээ" болон мөн өдрийн ЗГ-МГТ-3 2018-43 дугаар "Зээлийн гэрээ"-г тус тус байгуулан ажиллаж байна. Энэхүү зээлийн хөрөнгөөр "Сайншанд-Газрын тос боловсруулах үйлдвэр" чиглэлийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлуудыг гүйцэтгэлийн дагуу үе шаттайгаар санхүүжүүлэн ажиллаж байгаа бөгөөд 2019 оны 06 дугаар сарын байдлаар уг төсөлд "Хөгжлийн банк"-наас нийт 120 гаруй тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгоод байна. /Хэрэгжилт-100%/ | 100 /үйлдвэр барих төслийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын явц, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллан дэд бүтцийн байгууламжуудыг улсын комиссоор байнгын ашиглалтанд хүлээн авсан тул хяналтаас хасуулах саналтай/ | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 67 | 86 | 2018 оны 6 дугаар сарын 6-ны өдөр 25 дугаар тэмдэглэл 2018-06-06 Дугаар 2018_25 | XYI.3. . Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-импорт банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төслийн явцыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан газрын тос боловсруулах үйлдвэрийн технологийн сонголт болон бусад асуудлаар Энэтхэгийн талтай хэлэлцэн эцэслэн тохиролцож, дүнг Засгийн газрын дараагийн хуралдаанд танилцуулахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт даалгав. | Төслийн нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэлийг гүйцэтгэх зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр Энэтхэгийн “Инженерс индиа лимитед” компани шалгарч, УУХҮЯ болон “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-тай зөвлөх үйлчилгээ үзүүлэх гурвалсан гэрээг 2017.08.09-ний өдөр байгуулсан. Захиалагч УУХҮЯ, төсөл хэрэгжүүлэгч ”Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК компани болон захиалагчийн инженер Итали Улсын “КТ-Кинетикс” компанийн зүгээс нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэлийн ажлын гүйцэтгэлд хяналт тавин ажилласан бөгөөд эцсийн тайланг УУХҮЯ-ны дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2018.11.15-ны өдрийн өргөтгөсөн хуралдаанаар хэлэлцэн хүлээн авсан. /Хэрэгжилт-100%/ | 100 /ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэр гарсан тул хяналтаас хасуулах саналтай/ | |
| | 87 | 2018 оны 6 дугаар сарын 13-ны | XIX.10. . Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газрын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төслийн явцын талаарх Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын танилцуулгыг Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:<br><br>10.1. Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газрын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-ийн нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэл /ТЭЗҮ/-ээр тооцоолсон хөрөнгө оруулалтын зардлыг холбогдох гэрээ, хэлэлцээрийн хүрээнд бууруулах арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт даалгав. | Төслийн нарийвчилсан ТЭЗҮ-ийн дундын буюу явцын тайланг 2018 оны 02 дугаар сард ирүүлсэнтэй холбогдуулан БНЭУ-ын Зөвлөх түүнд хөндлөнгийн хяналт тавьж буй Итали Улсын “КТ-Кинетикс” компаниуд Монгол Улсад 2018 оны 04 дүгээр сарын 22-26-ны өдрүүдэд албан айлчлал хийж, гурван талт техникийн зөвлөлдөх уулзалтуудыг зохион байгуулсан. Энэхүү уулзалтаар захиалагч буюу УУХҮЯ болон “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн зүгээс БНЭУ-ын Зөвлөхийн гүйцэтгэсэн тайланд санал болгосон технологийн сонголт, төсөвт өртгийн тооцоог дахин нягтлах шаардлагатай байгаа тухай санал, зөвлөмжийг хүргүүлсэн. Түүнчлэн УУХҮСайдаар ахлуулсан ажлын хэсэг БНЭУ-д 2018 оны 06 дугаар сарын 09-12-ны өдрүүдэд албан айлчлал хийж, Энэтхэгийн Гадаад хэргийн яам, Экспорт-Импорт банк болон Зөвлөх үйлчилгээ үзүүлж буй “Инженерс Индиа Лимитед” компанийн удирдлагуудтай уулзалт зохион байгуулж, нарийвчилсан ТЭЗҮ-ийн ажлын явц, үйлдвэрийн технологийн сонголт болон төсөвт өртгийн талаар тус тус санал солилцсон. Гэвч зөвлөх компанийн зүгээс НТЭЗҮ-ийн тооцоололд Монголын талын тавьсан шаардлагын дагуу нэмэлт тооцоо судалгааг тусган ирүүлээгүй тул УУХҮСайдын санаачлагаар Энэтхэгийн талтай дахин зөвшилцөх уулзалтыг Улаанбаатар хотноо 2018.09.27-ны өдрөөс 10 дугаар сарын 02-ны өдрүүдэд зохион байгуулсан. Уг уулзалтаар Энэтхэгийн тал боловсруулах үйлдвэрийн хөрөнгө оруулалтын зардлыг тодорхой хэмжээгээр бууруулах боломжтой талаар дурдан захиалагчийн санал болгосон технологийг сонгохоор болсон бөгөөд түүхий тос дамжуулах хоолойн хувьд Монгол улстай ижил төстэй нөхцөлд буюу ОХУ, БНХАУ-д ашиглагдаж байгаа уламжлалт технологийг судлахаар [illegible] | 100 /“Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төслийн явцын талаарх Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын танилцуулгыг Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн 2018.06.13-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж тэмдэглэл гарсан тул хяналтаас хасуулах саналтай/ | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 68 | 88 | 2018 оны 6 дугаар сарын 13-ны өдөр 26 дугаар тэмдэглэл 2018-06-13 Дугаар 2018_26 | XIX.10..2. . Түүхий тос дамжуулах хоолойг нарийвчилсан ТЭЗҮ-ээр тооцоолсон хөрөнгө оруулалтын зардлаас бага өртөгтэйгээр Оросын Холбооны Улс болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсад хэрэглэгдэж байгаа уламжлалт технологийг ашиглан байгуулах санхүүжилтийн болон техникийн боломжийг судалж, танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт үүрэг болгов. | Ерөнхий сайдын 2019 оны 118 дугаар захирамжаар газрын тос боловсруулах үйлдвэрт шаардлагатай дотоодын түүхий тосыг тээвэрлэх дэд бүтцийн оновчтой хувилбарыг тодорхойлох, шаардлагатай тооцоо судалгааг хий, техник технологийн шийдэл, хөрөнгө оруулалтын талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Энэхүү захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг гурван удаа хуралдаж, үйлдвэрт шаардлагатай түүхий эдийг тээвэрлэх дэд бүтцийн боломжит хувилбаруудын талаар мэдээ мэдээлэл, тооцоо судалгаа, хөрөнгө оруулалт, техник технологийн шийдлийг тодорхойлох зорилгоор холбогдох байгууллагуудаас баримт материалуудыг цуглуулсан. Ажлын хэсгийн зүгээс их хэмжээний түүхий тосыг хол зайд тээвэрлэхэд тохиромжтой дэд бүтцийн хувилбар болох төмөр зам болон дамжуулах хоолойн тээвэрлэлтийг манай нөхцөлд тохирох боломжтой гэж үзэн эдийн засгийн үр ашгийн харьцуулсан судалгааг Монголын логистикийн холбоо ТББ-аар хийж гүйцэтгүүлэн тайланг Засгийн газрын 2019.12.18-ний өдрийн хуралдаанаар танилцуулж, холбогдох шийдвэрийг гаргуулаад байна. /Хэрэгжилт-10%/ | 100 /тос дамжуулах тээврийн асуудлаар гарсан тайланг ЗГ-ын 2019.12.18 өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэр гарсан тул хяналтаас хасуулах саналтай/ | |
| | 89 | | 10.4. Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгав. | УУХҮСайдын 2018.12.18-ны өдрийн А/259 дугаар тушаалаар "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-ийн дүрмийг шинэчлэн баталсан бөгөөд тус дүрмийн 12.2-д Өмчлөгчийн хяналтыг Төлөөлөн удирдах зөвлөл хэрэгжүүлэхээр тусгасан. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019.01.15-ны өдрийн А/06 дугаар тушаалаар Төлөөлөн удирдах зөвлөлийг байгуулан газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. /Хэрэгжилт-100%/ | 100 /төслийн хэрэгжилтэд тавих байнгын хяналтыг ТӨХХК-ийн ТУЗ болон гүйцэтгэх удирдлага хэрэгжүүлж байгаа тул хяналтаас хасуулах саналтай/ | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 69 | 90 | 2018 оны 10 дугаар сарын 3-ны өдөр 41 дүгээр тэмдэглэл 2018-10-03 Дугаар 2018_41 | XXIII.6. . Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан гэрээлэгч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд Газрын тосны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7-д заасны дагуу холбогдох байгууллагуудтай хамтарсан шалгалт хийж, дүнг Засгийн газрын хуралдаанд 2019 оны 3 дугаар сард танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгав.<br>2. Дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэр барихтай холбогдуулан газрын тосны салбарын талаарх мэдээллийг олон нийтэд сурталчлах, газрын тосны эрэл хайгуулын ажлыг эрчимжүүлж нөөц өсгөх, олборлолтыг нэмэгдүүлэх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Х.Хэрлэн нарт үүрэг болгов." гэжээ. | 1. Тус тэмдэглэлийн холбогдох заалтын хэрэгжилтийг хангах хүрээнд УУХҮ-ийн Сайдын 2018.12.03-ны өдрийн А/250 дугаар тушаалаар "Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан гэрээлэгч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд шалгалт хийх" үүрэг бүхий ажлын хэсгийг БОАЖЯ, ЗТХЯ, МХЕГ, АМГТГ-ын төлөөлөлтэйгээр байгуулан ажилласан ба ажлын хэсгийн хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, санал, дүгнэлтийг УУХҮ-ийн Сайдын зөвлөлийн 2019.03.14-ний хурлаар хэлэлцэн холбогдох шийдвэрийг гаргасан. Хамтарсан шалгалтын дүнг Засгийн газарт танилцуулахаар 2019.03.29-ний өдрийн 01/840 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.<br>2. УУХҮ-ийн сайдын 2018.12.12-ны өдрийн 01/3306 тоот албан бичгээр "дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэр барихтай холбогдуулан газрын тосны салбарын талаарх мэдээллийг олон нийтэд сурталчлах, газрын тосны эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлж, нөөц өсгөх, олборлолтыг нэмэгдүүлэх арга хэмжээ авах" талаар төлөвлөгөө баталж хэрэгжүүлэх, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар тухай бүр яаманд мэдээлж байхыг АМГТГ-т чиглэл болгосон. Мөн сар бүр зохион байгуулдаг "Ил тод уул уурхай" хэвлэлийн хурлаар төслийн явцын талаар олон нийтэд мэдээлэл сурталчилж ажиллаж байна. /Хэрэгжилт-100%/ | 100 /тэмдэглэлээр өгөгдсөн үүргийг бүхэн хэрэгжүүлж ажиллаж байгаа тул хяналтаас хасуулах саналтай/ | |
| | 91 | | 2.2. нүүрсний ачилт, тээвэрлэлтийг авто замын даац, техникийн бүрэн байдал, аюулгүй ажиллагааг хангасан автотээврийн хэрэгслийн тоо, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний эрчим, аж ахуйн нэгж тус бүрийн нүүрс олборлолтын хэмжээ, хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадалтай уялдуулан зохион байгуулж, нүүрс тээвэрлэгч аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Зам, тээврийн хөгжлийн сайд Я.Содбаатар, Гаалийн ерөнхий газрын дарга Б.Асралт нарт; | Засгийн газрын тэмдэглэлийн дагуу тус яамнаас Авто тээврийн үндэсний төв ТӨҮГ болон холбогдох төрийн байгууллагуудад хилээр нэвтрэх олон улсын С зөвшөөрлийг замын даац, техникийн бүрэн бүтэн байдал, уурхайн олборлолтын хэмжээтэй уялдуулж олгох тухай чиглэлийг улирал бүр тогтоож өгч байна.<br>Энэхүү ажлын хүрээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдаас 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн 01/20, 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 01/774 тоот албан бичгүүдийг Авто тээврийн үндэсний төв ТӨҮГ болон бусад холбогдох төрийн байгууллагуудад тус тус хүргүүлсэн.<br>Мөн түүнчлэн Засгийн газрын 2019 оны 01 тоот албан даалгавар гарсан бөгөөд уг албан даалгаварын 6-д Уурхайн гадна болон хилийн боомт дээр тээврийн хэрэгслийн үргэлжилсэн дараалал үүсгэхгүйн тулд уурхайн нүүрсний ачилт, зөвшөөрлийн бичгийн олголт, гаалийн бүрдүүлэлтийг хятадын талаас нэг өдөрт хүлээн авах нүүрсний хэмжээ, автомашины тоотой уялдуулан зохицуулж ажиллахыг ГЕГ, "АТҮТ" ТӨҮГ "Эрдэнэс Тавантолгой" ХК, "Тавантолгой" ХК, "Энержи ресурс" ХХК-иудад даалгасан. | 100 | |

| | | | |
|---|---|---|---|
| 70 | 92 | 2018 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр 49 дүгээр тэмдэглэл 2018-11-28 Дугаар 2018_49 | 2.3. нүүрс худалдах, худалдан авах талаар хоёр улсын аж ахуйн нэгж хооронд байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангах, шаардлагатай бол нүүрсийг урт хугацаанд тогтвортой худалдах чиглэлээр гэрээг шинэчлэх болон хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх асуудлаар Хятадын талтай яриа хэлэлцээ хийхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар нарт; |

| | | |
|---|---|---|
| Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайд Д.Загджав БНХАУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд Шин Хайминтай 2017 оны 10 дугаар сарын 12-нд уулзаж, Гашуунсухайт-Ганцмод боомт дээр үүсээд буй Тавантолгойн бүлэг ордоос нүүрс тээвэрлэж буй хүнд даацын автомашины түгжрэлийн асуудлыг шуурхай шийдвэрлэх боломжийн талаар санал солилцож, Гаалийн шалгалтын хугацааг богиносгон, боомт дээрх татан авалтын хурдыг нэмэгдүүлэх тал дээр анхаарлаа хандуулж өгөхийг хүссэн ба уг асуудлыг нааштайгаар шийдвэрлэхийн төлөө хичээн ажиллахаа элчин сайд илэрхийлсэн.<br>2017 оны 11 дүгээр сарын 02-нд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар БНХАУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд Шин Хайминтай уулзалт хийхдээ Тавантолгойн хэлэлцээрийг үргэлжлүүлж, ажлын хэсгийг байгуулан Хятадын талтай хамтран ажиллах, Гашуунсухайт-Ганцмод боомт дээр үүсээд байгаа нүүрс тээвэрлэж байгаа хүнд даацын автомашины түгжрэлийн асуудлыг шийдвэрлэхэд БНХАУ-ын зүгээс анхаарал тавьж ажиллахыг хүссэн.<br>Монгол Улсын Гадаад хэргийн яам ахалсан Монгол, Хятадын хилийн Ганцмод-Гашуунсухайт боомтод үүссэн нөхцөл байдлыг судлан шийдвэрлэх үүрэг бүхий ажлын хэсэгт орж ажиллаж, тухай бүр холбогдох мэдээллийг хүргүүлсэн. Уг ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2018 оны 08 дугаар сарын 28-31-ний өдрүүдэд Улаанбаатар хотод БНХАУ-ын талтай уулзалт хийсэн болно. | 100 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 71 | 93 | 2018 оны 12 дугаар сарын 12-ны өдөр 51 дүгээр тэмдэглэл 2018-12-12 Дугаар 2018_51 | II.2. . “Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх Ажлын хэсгийг холбогдох яам, агентлагийн төлөөлөлтэй байгуулан ажиллуулж, хууль тогтоомж, гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн нь тогтоогдсон хуулийн этгээдээр нөхөн сэргээлт хийлгэх, тусгай зөвшөөрлийг цуцлах хүртэл арга хэмжээ авч, дүнг 2019 оны I улиралд багтаан Засгийн газарт танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Н.Цагаанхүү нарт даалгав. | Уул уурхайн үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг нэмэгдүүлэх, ялангуяа Байгаль орчныг хамгаалах тухай хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй аж ахуйн нэгжид хариуцлага тооцох эрх зүйн үндэс бий болгох зорилгоор “Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль”-ийг УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар 2019 оны 5 дугаар сарын 2-ны өдөр хэлэлцэж баталсан. Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.5-д заасныг үндэс болгон 2019 онд Өмнөговь аймгийн Гурвантэс, Номгон, Архангай аймгийн Цэнхэр сумын нутаг дэвсгэрт нийт 20 аж ахуйн нэгжийн 25 ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг цуцалсан. Уг цуцлагдсан шийдвэрийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2019 оны 8 дугаар сарын 23-ны өдөр Архангай аймгийн Цэнхэр сумын нутагт Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын ахалсан ажлын хэсэгт ажиллаж холбогдох арга хэмжээг газар дээр нь зохион байгуулсан болно. Тухайлбал, ашигт малтмалын тусгай зөвшөөрөл цуцлагдсан талбайд байгаа техник, тоног төхөөрөмжийг нүүлгэн гаргах, олборлолтод өртсөн талбайд техникийн нөхөн сэргээлт хийх ажлыг зохион байгуулсан. Улмаар тусгай зөвшөөрөл цуцлагдсан талбайн эвдэрсэн газрыг нөхөн сэргээх ажлыг албадан гүйцэтгүүлэх, цаашид хууль бусаар алт олборлох зөрчил гарахаас сэргийлэх, хууль бус алт олборлогчдоос талбайг хамгаалах зорилгоор 12 дугаар сарын 1-ийг хүртэл цагдаа болон мэргэжлийн хяналтын байгууллагын хяналтад авах шийдвэр гарган хэрэгжүүлж ажилласан бөгөөд өнөөгийн байдлаар цуцлагдсан тусгай зөвшөөрлийн талбайн техникийн нөхөн сэргээлт 37.4 хувь, биологийн нөхөн сэргээлт 10 хувьтай байна. | 100 | |
| | 94 | | II.3. . Дорноговь аймгийн Улаанбадрах сумын нутагт үйл ажиллагаа явуулж байгаа “Бадрах Энержи” ХХК-ийн “Зөөвч Овоо” туршилтын үйлдвэрийн түр зориулалтын барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссыг 2018 оны 12 дугаар сард багтаан томилж ажиллуулахыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт даалгав. | Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн хуралдааны 51 дүгээр тэмдэглэлийн 3 дахь хэсэгт “Дорноговь аймгийн Улаанбадрах сумын нутагт үйл ажиллагаа явуулж буй “Бадрах энержи” ХХК-ийн Зөөвч овоо теслийн технологийн туршилтын үйлдвэр, барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссыг 2018 оны 12 дугаар сард багтаан томилон ажиллуулахыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт даалгав.” хэмээн чиглэл өгсөний дагуу хоёр сайдын хамтарсан 2019 оны А/18/16 тоот тушаалаар ажлын хэсэг байгуулан 2019 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр газар дээр ажиллаж, холбогдох дүгнэлтийг боловсруулсан болно. | 100 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 72 | 95 | 2019 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр 3 дугаар тэмдэглэл | I.. Монгол Улсын Засгийн газраас зарласан “Хариуцлагын жил”-ийн хүрээнд зохион байгуулсан ажлын тайланг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br><br>Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав:<br><br>1.Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг хуулийн дагуу төлөвлөгөө гарган, шилэн дансанд байршуулах замаар 2019 оны I улиралд багтаан олон нийтэд ил тод, шуурхай зохион байгуулах;<br><br>2.Төрийн болон нутгийн удирдлагын бүх шатны байгууллагууд баталсан дүрэм, журамдаа шинжилгээ хийж, иргэд, олон нийтээр хэлэлцүүлэн, байгууллага, иргэдэд хүнд суртал, чирэгдэл үүсгэж байгаа дүрэм, журмыг хүчингүй болгох арга хэмжээ авч, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт мэдээг хагас, бүтэн жилээр ирүүлэх;<br><br>3.Төрийн байгууллагад иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлээгүй төрийн албан хаагч, албан тушаалтанд хариуцлага тооцож, өргөдөл гомдол шийдвэрлэлтийн мэдээнд тусгаж байх;<br><br>4.Төрийн албан хаагч ажлын болон ажлын бус цагаар ажлын байр, томилолтын явцад согтууруулах ундаа хэрэглэхийг хориглох талаар тогтоосон дэг журмыг чанд | . Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын багцаас 2019 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Тендерийн үнэлгээний хороог 2019.01.21-ний өдрийн А/16 дугаар тушаалаар байгуулж, тендерийг зарлан дүгнэж байна. Тендерийн явцын мэдээллийг сар бүр Сангийн яаманд хүргүүлж, Шилэн дансанд байршуулан ил тод байдлыг ханган ажиллаж байна.<br>3. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон Ашигт малтмал, газрын тосны газарт 2019 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 674 өргөдөл, гомдол ирснээс албан бичгээр 674 байна. Эдгээрээс шийдвэрлэж хариуг албан бичгээр өгсөн 619, хугацаа болоогүй 32, хугацаа хэтэрсэн 23 өргөдөл ба шийдвэрлэлт 96.5%-тай байна.Нийт 674 өргөдөл, гомдол, санал хүсэлтээс хүний нөөц, дэмжлэг туслалцаа хүссэн 378 буюу 56%, тусгай зөвшөөрлийн чиглэлээр 57 буюу 8.4%, геологи, уул уурхайтай холбоотой асуудлаар 30 буюу 0.4%, түлш, газрын тосны чиглэлээр 7 буюу 0.1% бусад чиглэлээр 202 буюу 29.9%-тай байна.<br>4. Дээрх заалтыг хөдөлмөрийн дотоод журмын шинэчилсэн найруулгад тусгасан. Одоогоор энэ төрлийн зөрчил илрээгүй байна.<br>5. Салбарын бодлого болоод тусгай зөвшөөрлийн мэдээллийг холбогдох мэргэжилтнүүд хэвлэлийн ажилтанаар дамжуулан тогтмол сайтад байршуулан ажиллаж байна. http://mmhi.gov.mn/ Мөн ил тод хариуцлагатай уул уурхай хэвлэлийн бага хурлыг сар бүр зохион байгуулж байгаа ба хагас жилийн байдлаар нийт 4 удаа зохион байгуулагдсан. | 100 /тэмдэглэлээр өгөгдсөн үүргийг хэрэгжүүлсэн, тэмдэглэлийн үйлчлэлийн хугацаа дуусгавар болсон тул хяналтаас хасуулах саналтай/ | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 96 | 2019-01-16<br>Дугаар 2019_3 | II.. Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулсан дүнг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:<br><br>1. Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, хариуцлагатай, мэргэшсэн, тогтвортой төрийн албыг төлөвшүүлэх зорилгоор дараахь арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгов:<br><br>1.1. төрийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардал, хийдлийг арилгах, ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор төрийн бүх шатны байгууллага Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор баталсан "Чиг үүрэг дахин хуваарилах аргачлал"-ын дагуу чиг үүргийн шинжилгээ хийж, чиг үүрэг дахин хуваарилах саналаа 2019 оны 12 дугаар сард багтаан Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлэх;<br><br>1.2. төрийн жинхэнэ албан тушаалд иргэнийг томилох, төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын сул орон тоог нөхөхдөө чадахуйн (мерит) болон шатлан дэвшүүлэх зарчмыг үндсэн шалгуур болгон Төрийн албаны тухай хуулийг чанд баримтлах;<br><br>1.3. төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байгаа албан тушаалтнуудын судалгаанд үндэслэн Төрийн албаны хуульд заасан шаардлага хангаж байгаа албан | 1.1 Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 350 дугаар тогтоолоор баталсан "Төвлөрлийг сааруулах талаар төрөөс баримтлах бодлого"-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төрийн байгууллагын чиг үүргийг дахин хуваарилах аргачлалыг Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор батлан хэрэгжүүлж эхлээд байна.<br>Энэ ажлын хүрээнд тус салбарт Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019.02.19-ны А/33 дугаар тушаалаар Ажлын хэсэг, Төрийн нарийн бичгийн даргын 2019.04.11 А/67 дугаар тушаалаар Дэд ажлын хэсэг /Техникийн ажлын хэсэг/ тус тус байгуулагдан ажиллаж байна. Дэд ажлын хэсгийн зүгээс салбарын ерөнхий чиг үүргийн шинжилгээ, үндсэн чиг үүргийн шинжилгээ, дэд чиг үүргийн шинжилгээг хийж 2019.06.20-ны өдөр удьдчилсан байдлаар дууссан бөгөөд холбогдох хууль, эрх зүйн зохицуулалт, захиргааны эрх хэмжээний шинжилгээ, хэрэгжүүлж байгаа түвшинг тодорхойлох ажлууд хийгдэж байна. Дээрх шинжилгээ, тайлангуудыг үндэслэн холбогдох хууль тогтоомжид оруулах нэмэлт өөрчлөлтийн талаарх саналыг Ажлын хэсэг болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын Зөвлөлийн хуралд танилцуулж, салбарын нэгдсэн санал дүгнэлтийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэхээр ажиллаж байна.<br>1.2 2019 оны эхний хагас жилд тус яамнаас өөрийн хүсэлтээр шилжин ажиллахаар чөлөөлөгдсөн 4, суралцахаар 1, тэтгэвэр тогтоолгохоор 1, нийт 6 төрийн жинхэнэ албан хаагч чөлөөлөгдсөн.<br>Сул орон тоог Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-т заасны дагуу байгууллагын цахим хуудсанд байршуулан олон нийтэд мэдээлж, мөн хуулийн 27 дугаар зүйлийг 27.1.1, 27.1.2-ыг баримтлан нөхөн тангараг өргөсөн 5 төрийн жинхэнэ албан хаагчыг томилсон. | 100<br>/тэмдэглэлээр өгөгдсөн үүргийг хэрэгжүүлсэн, тэмдэглэлийн үйлчлэлийн хугацаа дуусгавар болсон тул хяналтаас хасуулах саналтай/ | |
| 73 | 97 | 2019 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр 4 дүгээр тэмдэглэл<br>2019-01-16<br>Дугаар 2019_4 | XII.1. . Стратегийн ач холбогдолтой том төслийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан стратегийн ач холбогдолтой том төслүүдийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай танилцуулгыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд оруулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгав. | Засгийн газраас өгсөн үүргийн дагуу стратегийн ач холбогдол бүхий газрын ховор элемент, уран, алт зэрэг ашигт малтмалын талаар цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг бэлтгэн Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд 4 сард танилцуулсан /нууцын зэрэглэлтэй/. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс 2019 оны 2 сарын 27-нд Н05/05 тоот зөвлөмж гарсан ба уг зөвлөмжийг үндэслэн Монгол улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 196-р тогтоолоор Төрийн болон албаны нууцын тухай хуулийн хүрээнд стратегийн ач холбогдол бүхий төслийн жагсаалтад "Алт цэвэршүүлэх үйлдвэр барих төсөл"-ийг хамруулсан. "Алт цэвэршүүлэх үйлдвэр барих төсөл" нь нууцын зэрэглэлтэй төсөл хэрэгжих журмын дагуу Төрийн болон албаны нууцын хуулийн хүрээнд дагаж мөрдөх дүрэм, журмуудыг хатуу чанд мөрдөн хэрэгжүүлж эхлээд байна. | 100 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 74 | 98 | 2019 оны 1 дүгээр сарын 30-ны өдөр 6 дугаар тэмдэглэл<br>2019-01-30<br>Дугаар 2019_6 | XXII.5. . "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах эсэх талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br><br>Үүнтэй холбогдуулан "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах эсэх асуудлыг энэ оны эхний улиралд багтаан холбогдох хууль тогтоомжийн дагуу судалж шийдвэрлэхийг тус компанийн төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт даалгав. | "Эрдэнэс-Тавантолгой" ХК байгуулагдсан цагаас хойш нийтдээ 192.2 сая м3 хөрс хуулалтын ажил гүйцэтгэж, нийт 45.92 сая тонн нүүрс олборлосон бөгөөд үүнээс 2018 онд нийт 11.0 сая тонн нүүрс олборлож, 13.1 сая тонн нүүрс борлуулсан байна.Ийнхүү үйл ажиллагааны цар хүрээ нэмэгдсэнээр 2018 оны аудитлагдаагүй тайлангаар борлуулалтын орлогын хэмжээ 1,986.9 тэрбум төгрөгт, улсын төсөвт татвар, хураамж хэлбэрээр нийт 484.7 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, татварын дараах цэвэр ашиг 801.1 тэрбум төгрөгт хүрсэн. Дээрх үзүүлэлтийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал борлуулалтын орлогын хэмжээ 804.5 тэрбум буюу 68 хувиар, цэвэр ашгийн хэмжээ 340 тэрбум төгрөг буюу 74 хувиар тус тус өссөн байна.Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.8 дах хэсэгт "Ногдол ашгийг компанийн татвар төлсний дараах цэвэр ашгаас хуваарилна" гэж, Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 210 дугаар тогтоолоор батлагдсан "Компанийн засаглалын кодекс"-ын 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалтад "Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэрийг нийтэд мэдээлэх ёстой бөгөөд уг мэдээлэл нь ногдол ашгийн хэмжээг тодорхойлсон үндэслэл, төлөх журмын талаар бүрэн ойлголт өгөхүйц байх ёстой." гэж тус тус тусгагдсан байхын зэрэгцээ тус кодекст "Компанийн жилийн санхүүгийн тайланд тусгагдсан цэвэр ашгаас бизнес төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгө оруулалт, нийгмийн арга хэмжээний хуваарилалтыг хасаад үлдэх хэсгийг ногдол ашигт хуваарилж байх нь зүйтэй" гэж тайлбарласан байдаг.<br>Энэ хүрээнд "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хурлаар ногдол ашиг хуваарилах асуудлыг | 100 /хяналтаас хасуулах, асуудлыг ЗГ-ын хуралдаанд танилцуулсан./ | |
| 75 | 99 | 2019 оны 2 дугаар сарын 20-ны өдөр 8 дугаар тэмдэглэл<br>2019-02-08<br>Дугаар 2019_8 | XIII.3. . "Таван толгой түлш" ХХК-ийн түүхий эд болох эрчим хүчний баяжуулсан нүүрс (мидлинг)-ийг нөөцлөх дундын агуулах талбайг Улаанбаатар хот, Төв аймгийн нутагт сонгон 1 жилийн хэрэгцээнд зориулан 800.000 хүртэл тонн нөөцийг татан төвлөрүүлэх ажлыг зохион байгуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, "Эрдэнэс Таван толгой" ХК-ийн гүйцэтгэх захирал Б.Ганхуяг нарт даалгав. | "Тавантолгой түлш" ХХК нь Төв аймгийн Сэргэлэн сумын Гүн бүрдийн аманд 12 га газрыг 15 жилийн хугацаатай эзэмших гэрээ байгуулж, дундын бус байгуулсан. Уг дундын бүсэд 427,457 тонн түүхий эд /мидлинг/-ийн нөөцийг татан төвлөрүүлсэн. /Хэрэгжилт-100%/<br><br>2019 оны бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төлөвлөгөөний дагуу түүхий эдийн нөөц, татаалт хангалттай байна. | 100 | |
| | 100 | | XIII.6. . Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам, авто замын төслүүдийн талаар Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:<br>1. "Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийг эрчимжүүлэх тухай" Засгийн газрын 2018 оны 242 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах арга хэмжээ авч, хэрэгжилтийн явцыг 2019 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн дотор Засгийн газарт танилцуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт даалгав. | Тус яам болон Зам, тээврийн хөгжлийн яамнаас Засгийн газрын тэмдэглэлийн дагуу төмөр замын төслүүдийг эрчимжүүлэх тухай танилцуулга, шийдвэрийн төслүүдийг боловсруулж Засгийн газрын хуралдаанд танилцуулсан болно. Үүний үр дүнд Засгийн газрын 2019 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 135 дугаар тогтоол, 2019 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 189 дүгээр тогтоолууд тус тус батлагдан гарсан болно. | 100 хяналтаас хасуулах | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 101 | | XIII.7. . "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний талаар Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br><br>Үүнтэй холбогдуулан "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн 2018 оны санхүүгийн жилийн ногдол ашиг хуваарилах асуудлыг Засгийн газрын гишүүдийн саналыг авч Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгав. | Засгийн газрын тэмдэглэлийн дагуу Засгийн газрын 2019 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 16 дугаар хуралдаанд "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн 2018 оны санхүүгийн жилийн ногдол ашиг хуваарилах асуудлыг танилцуулсан болно. | 100 | |
| 76 | 102 | 2019 оны 5 дугаар сарын 29-ны өдөр 24 дүгээр тэмдэглэл<br>2019-05-29<br>Дугаар 2019_24 | XY.2. . 1. Улаанбаатар хотноо 2019 оны 6 дугаар сарын 4-ний өдөр зохион байгуулах Монгол, Канадын Дугуй ширээний уулзалтын 8 дугаар хуралдаанд оролцох монголын талын төлөөлөгчдийн баримтлах удирдамжийг хэлэлцэн зөвшөөрөв.<br><br>2. Уг хуралдаанд оролцох монголын талын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнийг батлахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд бөгөөд Дугуй ширээний уулзалтын Монголын хэсгийн дарга Д.Сумъяабазарт даалгав. | Монгол-Канадын Дугуй ширээний уулзалтын 8 дугаар хуралдааны мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2019 оны 08 дугаар сарын 07-ны өдөр Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар баталсан бөгөөд хэрэгжилтийг хангаж ажиллах тухай 2019 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 01/2316 дугаар албан бичгийг Гадаад харилцааны яаманд хүргүүлсэн. Тус дугуй ширээний уулзалтыг хоёр жил тутамд зохион хуралдуулдаг тул төлөвлөгөөний хэрэгжилтийн биелэлтийг 2020 оны хоёрдугаар хагас жилд гаргахаар төлөвлөн ажиллаж байна. | 100 хяналтаас хасуулах саналтай | |
| | 103 | | XX.11. . "Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх Ази, Номхон далайн бүсийн IY конгресс"-ын бэлтгэл ажлын талаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br>Үүнтэй холбогдуулан уг конгрессыг Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор зохион байгуулах ажлын хүрээнд дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд даалгав:<br>1. Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:<br>1.1. конгрессыг угтсан ажлын төлөвлөгөө гарган, шаардагдах хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх;<br>1.2. Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйл, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 128 дугаар зарлиг, Засгийн газрын 2019 оны 111 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг байнгын ажлын байраар хангах санаачилга гаргах;<br>1.3. хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлдвэрлэлийг дэмжих, бараа бүтээгдэхүүний нь худалдан авах;<br>1.4. барилга, байгууламжийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй болгох. | МУ-ын Ерөнхийлөгчийн "Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай" 2018 оны 09 дүгээр 04 ний өдрийн 128 дугаар зарлигийн дагуу УУХҮ-ийн сайдын "Хүний эрх, хүүхдийн эрхийг хамгаалах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжиж ажиллах тухай" 2018 оны 06 тоот албан даалгаврын хэрэгжилтийг 2019 оны эхний хагас жилийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийн 2019 оны 07 дугаар сарын 10-ны өдөр УУХҮ-ийн сайдын зөвлөлийн хурал танилцуулан сайдаас өгсөн чиглэл дагуу албан даалгаврын хэрэгжилтийг хангах эрчимжүүлж ажиллах талаар агентлаг, аймгуудын Засаг дарга нарт зөвлөмжийг боловсруулан хүргүүлсэн. Жилийн эцсийн байдлаар хэрэгжилт УУХҮЯ-100% АМГТГ-80.5%, 21 аймгууд 73% хэрэгжилттэй ба нийлбэр дүнгээр 84.5%-тай байна. УУХҮЯ болон Ашигт малтмал, газрын тосны газар хамтран салбарт ажиллаж болох хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрны судалгааг хийв. Судалгаанд иргэдийг хөгжлийн бэрхшээлээр ангилан нийт давхардсан тоогоор 69 ажлын байрны урьдчилсан судалгааг гаргав. | 100 хяналтаас хасуулах саналтай | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 77 | 104 | 2019 оны 7 дугаар сарын 24-ний өдөр 33 дугаар тэмдэглэл 2019-07-24 Дугаар 2019_33 | II.. Улаанбаатар хотноо 2019 оны 6 дугаар сарын 4-ний өдөр зохион байгуулсан Монгол, Канадын Дугуй ширээний уулзалтын 8 дугаар хуралдааны дүнг сайшааж, уг хуралдааны мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд бөгөөд Дугуй ширээний уулзалтын монголын хэсгийн дарга Д.Сумъяабазарт даалгав. | Монгол-Канадын Дугуй ширээний уулзалтын 8 дугаар хуралдааны мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2019 оны 08 дугаар сарын 07-ны өдөр Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар баталсан бөгөөд хэрэгжилтийг хангаж ажиллах тухай 2019 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 01/2316 дугаар албан бичгийг Гадаад харилцааны яаманд хүргүүлсэн. Тус дугуй ширээний уулзалтыг хоёр жил тутамд зохион хуралдуулдаг тул төлөвлөгөөний хэрэгжилтийн биелэлтийг 2020 оны хоёрдугаар хагас жилд гаргана. | 100 | |
| | 105 | | III.. ХБНГУ-ын Берлин хотноо 2019 оны 5 дугаар сарын 20-21-ний өдрүүдэд зохион байгуулсан “Ашигт малтмал, аж үйлдвэр, технологийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий Монгол, Германы Засгийн газар хоорондын Ажлын хэсгийн 7 хуралдааны дүнг сайшааж, уг хуралдааны мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, тус Ажлын хэсгийн монголын хэсгийн дарга Д.Сумъяабазарт даалгав. | Ашигт малтмал, аж үйлдвэр, технологийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, ХБНГУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий Монгол, Германы Засгийн газар хоорондын ажлын хэсгийн 7 дугаар хуралдааны мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2019 оны 08 дугаар сарын 07-ны өдөр Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар баталсан бөгөөд төлөвлөгөөг хангаж ажиллах тухай 2019 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 01/2317 дугаар албан бичгийг Гадаад харилцааны яам, ХБНГУ-ын Берлин дэх Элчин сайдын яам, Стандарт, хэмжил зүйн газар зэрэг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн бөгөөд биелэлтийг 2020 оны 03 дугаар сард гаргана. | 100 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 78 | 106 | 2019 оны 8 дугаар сарын 21-ний өдөр 36 дугаар тэмдэглэл 2019-08-21 Дугаар 2019_36 | XYI.8. . Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааны талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт даалгав:<br><br>1. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмыг зөрчиж байгаа, бичил уурхайн нэрийн дор хууль бусаар ашигт малтмал олборлож, байгаль орчныг бохирдуулж буй асуудлыг Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлд танилцуулах;<br><br>2. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааг зохих журмын дагуу цэгцлэх, ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааг зогсоосон талбайг хамгаалалтад авч хууль бус аливаа үйл ажиллагааг дахин гаргуулахгүй байх талаар тодорхой санал боловсруулж Засгийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх. | Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 8 дугаар сарын 21-ны өдрийн хуралдаанаас өгсөн чиглэл, Архангай аймгийн Цэнхэр сумын Орхон багийн нутаг дэвсгэрт нэр бүхий 11 аж ахуйн нэгжийн 13 тусгай тусгай зөвшөөрөл цуцлах тухай Ашигт малтмалын газрын Кадастрын хэлтсийн даргын 2019 оны 8 дугаар сарын 21-ны өдрийн шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын сайд ахалсан ажлын хэсэг 2019 оны 8 дугаар сарын 23-ны өдөр Архангай аймгийн Цэнхэр сумын нутагт ажиллаж холбогдох арга хэмжээг газар дээр нь зохион байгуулсан. Тухайлбал, ашигт малтмалын тусгай зөвшөөрөл цуцлагдсан талбайд байгаа техник, тоног төхөөрөмжийг нүүлгэн гаргах, ухсан нүхийг тэгшилж нөхөн сэргээх, ус хуримтлуулсан даланг сэтэлж усыг гаргаж талбайг түрж тэгшилж аюулгүй болгох зэрэг ажлыг шуурхай зохион байгуулж эхлүүлсэн.<br>Тусгай зөвшөөрөл цуцлагдсан талбайн эвдэрсэн газрыг нөхөн сэргээх ажлыг албадан гүйцэтгүүлэх, цаашид хууль бусаар алт олборлох зөрчил гарахаас сэргийлэх, нинжа нар талбайг ухахаас хамгаалах зорилгоор 12 дугаар сарын 1-ийг хүртэл цагдаа болон мэргэжлийн хяналтын байгууллагын хяналтад авах шийдвэр гарган хэрэгжүүлж ажиллав. 8 дугаар сарын 23-наас 12 дугаар сарын 1-ныг хүртэл Цагдаагийн Ерөнхий газрын Эргүүл тусгай хамгаалалтын тасгийн 160, Архангай аймаг дахь Цагдаагийн газрын 160 нийт 320 алба хаагчид 22 тээврийн хэрэгсэлтэй хамгаалалтыг хэрэгжүүлсэн. Энэ хугацаанд тусгай зөвшөөрөл цуцлагдсан талбайд үйл ажиллагаа явуулж байсан аж ахуйн нэгж, иргэдийн 163 ширхэг техник, тоног төхөөрөмж /Экскаватор 46, утгуурт ачигч 31, автосамосвал 46, алт угаах төхөөрөмж 40/-ийг талбайгаас албадан гаргаж, алт угаах зориулалтаар ашиглаж байсан | 100 /хяналтаас хасуулах саналтай/ | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 79 | 107 | 2019 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр 40 дүгээр тэмдэглэл 2019-09-18 Дугаар 2019_40 | XYI.6. . Үүнтэй холбогдуулан: “Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төслийн хүрээнд үйлдвэрт нийлүүлэх дотоодын түүхий тосыг тээвэрлэх дэд бүтцийн талаар үр ашгийн харьцуулсан тооцоо, судалгаа хийж, боловсруулсны үндсэн дээр Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх арга хэмжээ авахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар болон холбогдох ажлын хэсэгт даалгав. | Ерөнхий сайдын 2019 оны 118 дугаар захирамжаар газрын тос боловсруулах үйлдвэрт шаардлагатай дотоодын түүхий тосыг тээвэрлэх дэд бүтцийн оновчтой хувилбарыг тодорхойлох, шаардлагатай тооцоо судалгааг хий, техник технологийн шийдэл, хөрөнгө оруулалтын талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Энэхүү захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг гурван удаа хуралдаж, үйлдвэрт шаардлагатай түүхий эдийг тээвэрлэх дэд бүтцийн боломжит хувилбаруудын талаар мэдээ мэдээлэл, тооцоо судалгаа, хөрөнгө оруулалт, техник технологийн шийдлийг тодорхойлох зорилгоор холбогдох байгууллагуудаас баримт материалуудыг цуглуулсан. Гэвч дэд бүтэц болгон өөрийн гэсэн давуу ба сул талуудтай байдаг бөгөөд тухайн орны онцлог, бүс нутгийн хөгжилд нөлөөлөх байдал, байгаль орчинд хэрхэн нөлөөлөл үзүүлэх, тээвэрлэлт хийх түүхий эд, бараа материал, эцсийн бүтээгдэхүүн нь тухайн орны эдийн засагт хэрхэн нөлөөлөх, зах зээлийн эрэлт нийлүүлэлт бий эсэх, эрсдэлгүй, тасралтгүй найдвартай тээвэрлэлт хийх боломжтой эсэхийг харгалзан үзэх шаардлага тулгарсан. Ажлын хэсгийн зүгээс их хэмжээний түүхий тосыг хол зайд тээвэрлэхэд тохиромжтой дэд бүтцийн хувилбар болох төмөр зам болон дамжуулах хоолойн тээвэрлэлтийг манай нөхцөлд тохирох боломжтой гэж үзэн эдийн засгийн үр ашгийн харьцуулсан судалгааг Монголын логистикийн холбоо ТББ-аар хийж гүйцэтгүүлэн тайланг 2019.12.18-ний өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулсан. Хэрэгжилт-100% | 100 /тос дамжуулах тээврийн асуудлаар гарсан тайланг ЗГ-ын 2019.12.18 өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэр гарсан тул хяналтаас хасуулах саналтай/ | |
| 80 | 108 | 2019 оны 10 дугаар сарын 2-ны өдөр 42 дугаар тэмдэглэл 2019-10-02 Дугаар 2019_42 | XYI.8. . Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх Ази, Номхон далайн бүсийн 4 дүгээр конгрессыг зохион байгуулсан дүнгийн талаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх Ази, Номхон далайн бүсийн 4 дүгээр конгрессоос баталсан “Улаанбаатарын тунхаглал”-д дурдсан ажлыг жил бүрийн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүдэд даалгав. | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх Ази, Номхон далайн бүсийн 4 дүгээр конгрессоос баталсан “Улаанбаатарын тунхаглал”-д дурдсан ажлыг хэрэгжүүлэхээр 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан. | 100 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 81 | 151 | 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр 50 дугаар тэмдэглэл 2019-11-13 Дугаар 2019_50 | YIII.1. . Үүнтэй холбогдуулан Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг яаралтай боловсруулж Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх, хяналт, шалгалтын үр дүнгээр холбогдох хууль тогтоомжид заасан үүргээ биелүүлээгүй нь тогтоогдсон хуулийн этгээдийн ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг зохих журмын дагуу цуцлах арга хэмжээг авч байхыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Х.Хэрлэн нарт даалгав. | Уул уурхайн үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг нэмэгдүүлэх, ялангуяа Байгаль орчныг хамгаалах тухай хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй аж ахуйн нэгжид хариуцлага тооцох эрх зүйн үндэс бий болгох зорилгоор "Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль"-ийг УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар 2019 оны 5 дугаар сарын 2-ны өдөр хэлэлцэж баталсан. Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.5-д заасныг үндэс болгон 2019 онд Өмнөговь аймгийн Гурвантэс, Номгон, Архангай аймгийн Цэнхэр сумын нутаг дэвсгэрт нийт 20 аж ахуйн нэгжийн 25 ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг цуцалсан. | 100 /хяналтаас хасуулах саналтай/ | |
| ЗГ-ын албан даалгавар | | | | | | |
| 82 | 109 | Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлтийг хангуулах зарим арга хэмжээний тухай 2019-08-08 Дугаар 2019_01 | 2.. Засгийн азрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулиар өөрийн эрхлэх асуудлын хүрээ, тухайн албарын хэмжээнд батлагдсан төсөл, арга хэмжээний ач холбогдол, явц байдал, үр дүнгийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол мэдээлж, нээлттэй өдөрлөг, танилцуулгыг үе шаттайшаар нэгдсэн болон тусгайлсан хэлбэрээр зохион байгуулж, олон нийтэд сурталчилан ажиллахыг Засгийн газрын гишүүд, Аймаг, нийслэлийн Засаг дарга, Агентлагийн дарга нарт; | а/ УУХҮЯ, Нээлттэй нийгэм форум, Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн, Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга(ОҮИТБС)ын ажлын алба, Олон улсын санхүүгийн корпорац зэрэг байгууллага хамтран ажилласны үр дүнд Монгол Улсын хэмжээнд уул уурхай, газрын тосны салбарт байгуулагдсан 14 төрлийн 436 гэрээг нийтэд ил болгосон. б/ 2019 оны байдлаар яамны үйл ажиллагааг 11 сайт, 4 өдөр тутмын сонин, 19 телевиз, 2 радио, 2 сэтгүүл болох хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр цаг тухай бүрт нь гаргасан байна. в/ 2019 оны байдлаар "Ил тод, хариуцлагатай уул уурхай" хэвлэлийн бага хурлыг нийт 5 удаа зохион байгуулсан. Үүнд: "Ил тод" уул уурхайн хэвлийн бага хурлыг 1 сарын 31, 3 сарын 15, 5 сарын 14, 6 сарын 26, 12 сарын 17-нд тус тус зохион байгуулсан. г/ 2019 оны байдлаар яамны цахим хуудсанд цаг үеийн 170 мэдээ, статистик мэдээ 20, видео мэдээ 21, тайлан мэдээ 13, хэлэлцүүлэг 10, тусгай зөвшөөрөл 4, хуулийн тогтоол 2, төсөл хөтөлбөр 5, ил тод байдал 1 мэдээг тогтмол шинэчлэн оруулсан. | 100 /Албан даалгаврын хэрэгжилт бүрэн хангагдсан тул ХЯНАЛТААС ХАСУУЛАХ САНАЛТАЙ/. | |
| | | | | | | |